АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ СУДЛАЛ

Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ судалгааны онол, арга зүйн сэтгүүл

№33 (43) 2022

З.Болдбаатар Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд

Б.Содбилэг Батлан хамгаалахын менежментийн төлөв, хандлага

С.Алтанчимэг Төрийн захиргааны төв байгууллага дахь мэдлэг солилцох боломж, нөхцөл

Ш.Паламдорж Цэргийн урлагийн практик, онол, удирдлагын баримт бичиг, сургалтын нэгдмэл байдлыг хангах асуудал

Т.Сүхбаатар Их Засаг хууль дахь цэргийн харилцааны зохицуулалт



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч: Б.Баярмагнай (М.А.)

Эрхлэгч: Б.Эрдэнэбат (Ph.D, профессор)

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Т.Соронзонболд (Ph.D, профессор)

Гишүүд:
О.Үржин (Sc.D, профессор)
Ш.Паламдорж (Sc.D, профессор)
Б.Мөнхсайхан (Ph.D, профессор)
Б.Эрдэнэчимэг (Ph.D, профессор)
Н.Хүдэрбат (М.А.)

Техник редактор: Б.Баярмагнай

ISSN 2220-9115

Өгүүлэлд нийтлэгдсэн тоо, баримт, мэдээлэл, дүгнэлтийн үнэн зөвийг зохиогч өөрөө хариуцна.

Хаяг:
Ш/х-184 Монгол шуудан. 22 дугаар салбар,
Улаанбаатар хот, 13320
Утас: 976-453942
www.mids.gov.mn

Institute for Defense Studies

JOURNAL
of
SECURITY AND DEFENSE STUDIES

№33 (43) 2022

EDITORIAL BOARD:

Editor in Chief: B.Bayarmagnai (M.A.)

Editor: B.Erdenebat (Ph.D, Professor)

Deputy Editor-in-Chief: T.Soronzonbold (Ph.D, Professor)

Editorial Panel:

O.Urjin (Sc.D, Professor)
Sh.Palamdorj (Sc.D, Professor)
B.Munkhsaikhan (Ph.D, Professor)
B.Erdenechimeg (Ph.D, Professor)
N.Khuderbat (M.A.)

Techinical Editor: B.Bayarmagnai

ISSN 2220-9115

The authors will bear the responsibility for facts, information and views expressed in the article.

Address:
Postal box-184, Branch 22, Mongolpost,
Ulaanbaatar city, 13320
Phone: 976-453942
www.mids.gov.mn

АГУУЛГА

Аюулгүй байдал

З.Болдбаатар Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд 5

Д.Сайнбаяр, П.Мөнхтөр Аюулгүй байдлын судалгаанд чанарын шинжилгээний аргыг хэрэглэх нь 15

Х.Орхончимэг Үндэсний био аюулгүй байдлын судалгааны арга зүйн асуудалд ... 23

Д.Энхмаа, С.Наранцэцэг Хүнсний аюулгүй байдал 30

Батлан хамгаалах бодлого

Б.Содбилэг Батлан хамгаалахын менежментийн төлөв, хандлага 40

С.Алтанчимэг Төрийн захиргааны төв байгууллага дахь мэдлэг солилцох боломж, нөхцөл 45

Т.Мөнх-Оргил Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагааны бодлого, чиг хандлага 61

Н.Уранчимэг Монгол Улсын Зэвсэгт хүчний эмэгтэй цэргийн алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургалтанд хамруулах хэрэгцээ, шаардлага 69

Цэргийн урлаг судлал

Б.Мөнхсайхан Их ялалтад Алс Дорнодын төмөр замын гүйцэтгэсэн үүрэг 76

Ш.Паламдорж Цэргийн урлагийн практик, онол, удирдлагын баримт бичиг, сургалтын нэгдмэл байдлыг хангах асуудалд 86

С.Пүрэвдорж Монгол Улсад терроризмоос үүсэх аюулын эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй гадаад, дотоод зарим хүчин зүйлийн нөлөөлөл 96

Зэвсэг, техник технологи

Б.Эрдэнэчимэг, М.Хонгорзул ХАЧА-ийн пуужинт цэргийн шинэчлэл 105

Ц.Батбаяр Хагас дамжуулагч нь цэрэг болон стратегийн чухал бүтээгдэхүүн болох нь 115

Цэргийн түүх, уламжлал

Д.Уламбаяр Монгол, Хятадын харилцаа: Улс төрийн шинэ сэтгэлгээ, хамтын хүчин чармайлт, харилцаа хэвийн болсон нь 121

Х.Шагдар Сталин, Чойбалсангийн уулзалт: Үр дүн 134

Т.Сүхбаатар Их Засаг хууль дахь цэргийн харилцааны зохицуулалт 146

Т.Эрдэнэхишиг, Г.Ханджав Хүннү, Хан улсын хооронд болсон нтө 121, 119 оны байлдаан 154

CONTENTS

Security

Z.Boldbaatar To streamline policies and regulations related to national security 5

D.Sainbayar, P.Munkhtur Qualitative analysis methods in security studies 15

Kh.Orkhonchimeg Research methodology in national bio-security studies 23

D.Enkhmaa, S.Narantsetseg Food Safety 30

Defense Policy

B.Sodbileg Defense management outlook and trends 40

S.Altanchimeg Possibilities of exchanging knowledge between central state administration organizations 45

T.Munkh-Orgil United Nations peacekeeping policies and trends 61

N.Uranchimeg The needs of improving foreign language training and skill for female troops of the Mongolian Armed Forces 69

Military art studies

B.Munkhsaikhan The role of the Far Eastern Railway in the Great Victory 76

Sh.Palamdorj Providing comprehensive and unity in the theory, training, practice of military art 86

S.Purevdorj The impact of some external and internal factors that may increase the risk of terrorism in Mongolia 96

Weapons and technology

B.Erdenechimeg, M.khongorzul Modernization of PLA missile forces 105

Ts.Batbayar Importance of semiconductors in military and strategic production 115

Military History and tradition

D.Ulambayar Mongolian-Chinese relations: New political thinking, joint efforts, normalization of relations 121

Kh.Shagdar The summit meetings and results between Joseph Stalin and Khorloogiin Choibalsan 134

T.Sukhbaatar Regulation of military relations in the Great Government Law 146

T.Erdenekhishig, G.Khandjav The Hunnu - Han war between 121 and 119 BC 154

Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд

З.Болдбаатар.
Доктор (Ph.D), УБХИС-ийн профессор

Abstract

This article addresses the issue of improving the overall policy and regulation to ensure the national security of the country, based on research on the country's internal security vulnerabilities and the risks and challenges we may face in the future. In addition, the National Security Council plays an important role in ensuring the country's national security, and specific proposals have been made in the areas of policies, activities and monitoring to improve the overall policy and coordination of its activities.

Keywords: *National Security, National Security Council`s unified policy and coordination, vulnerabilities of internal security, potential risks and challenges facing the country, fundamental national interests, justice, social protection, unemployment, national unity, civil service leadership, strategic development projects.*

Улс орныхоо аюулгүй байдал, ирээдүйн хөгжлийн асуудалд зохих ёсны санаа тавьж, хяналт удирдлагаар хангаж, цаг үеэ олсон зохицуулалт хийж чадаагүй улс гүрэн, нийгэм, хувь хүмүүс амьдралынхаа хөгжил, дэвшил баталгаагаа алдаж, бусад улс орны ашиг сонирхлын өгөөш болж ашиглагддаг жамтай болох нь олон улсын амьдрал, үйл явцаас тодорхой харагдах боллоо.

Улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо сул дорой, үйл ажиллагаа нь цаг хугацаанаас хоцорсон, аргацаасан, шударга бус байдалтай байх нь тухайн улс оронд олон тулгамдсан асуудлуудыг үүсгэж, нийгэм, ард иргэдийн оршин тогтнох, хөгжин дэвших итгэл найдвар, хүсэл зоригийг мохоож, итгэлгүй болгож, төр, ард түмний холбоосыг ихээхэн сулруулдаг байна.

Аливаа улс бие даан оршин тогтнож, аюулгүй байдлаа хангах үйл явц нь өөрөө их үнэ цэнэтэй, олон талт цогц асуудлуудыг багтаасан аюулгүй байдлын шинжлэх ухааны удирдлагын менежментийн үндсэн чухал асуудлуудын нэг гэж үзэж байна.

Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд ардчилсан улс орны жишгийг баримжаалж хөгжих сонголт хийж, явж ирсэн ч улс орны маань

хөгжил, ард иргэдийн амьдралын төвшин, үндэсний аюулгүй байдал маань үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал[1]-аар дэвшүүлсэн зорилтот хэмжээнд хүрч чадаагүй бөгөөд харин ч үндэсний аюулгүй байдлын язгуур эрх ашгийн зарим үзүүлэлтүүд нэлээд доогуур түвшинд хүрч буурсан аюулгүй байдлын мэдрэмжээ алдсан байдалтай байна гэж дүгнэж болохоор дүр зураг харагдаж байна.



Улс орны аюулгүй байдлыг хангах олон талт хамтын ажиллагааг нэгдмэл бодлого, зохицуулалтаар хангаж, биелэлт, хэрэгжилтийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үр дүнгийн нь тооцох процесст УАБЗ онцгой чухал үүрэгтэй оролцдог байгууллага юм.

Үндэсний үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдэж бий болоход геополитикийн буюу гадаад хүчин зүйлс, үндэсний аюулгүй байдлын талаарх түүх, соёлын уламжлал, аюулгүй байдлын тухай үндэсний философи, улс орны өөрийгөө хамгаалах бүх талын чадавх зэрэг хүчин зүйлүүд маш их нөлөөтэй байдгийг хаа хаанаа олон талаас нь бодолцож байх цаг үед бид ирээд байна. Учир нь өнгөрсөн хугацааны хөгжлийн үйл явцаас харахад олон хүчин зүйлийг бид тооцож харж чадаагүй явж иржээ гэсэн дүгнэлтэд хүргээд байна. Монголын нийгэмд Хятадын ашиг сонирхлыг төр, засгийн бодлого шийдвэрт оруулах гэсэн системтэй үйл ажиллагаа аажим алгуур явагдаж, байгаад одоогоос анхаарч хянуур ажиллах шаардлага бий болж байгаад дүгнэлт хийх

[1] 2010 оны УИХ-ын 48 дугаар тогтоолын хаавсралт. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

хэрэгтэй байгаа юм.

Энэхүү олон хүчин зүйлийн үйлчлэл нь үндэсний аюулгүй байдалд дам болон шууд утгаар хэрхэн нөлөөлөх, түүнээс сөрөг хүчин зүйлсийг тооцож, урьдчилан сэргийлэх, саармагжуулах, арилгаж байхгүй болгох зэрэг зохицуулах, шуурхай шийдвэр гаргахад цаг үеэ олсон мэргэжлийн үнэн бодит мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах ажлыг УАБЗ хариуцан гүйцэтгэж байгаа билээ.

Энэ утгаараа УАБЗ улс орныхоо аюулгүй байдлыг хангаж, бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалт хийж[2], улс орны хэвийн тогтвортой амьдрал үйл ажиллагааг хангаж, хөгжүүлэхэд голлох үүрэгтэй оролцдог.

Өнгөрсөн хугацаанд үндэсний аюулгүй байдлыг дотоод орчин талаас нь дүгнэж үзвэл нийгмийн амьдрал харилцаанд зах зээлийн эдийн засгийн, хүний эрх, эрх чөлөөний, улс төрийн олон намын төлөвшлийн, сошиал мэдээллийн сүлжээ, цахим хэрэглээний, ахуй соёлын харилцаа ёс зүйн, үндэсний уламжлалт соёлын, хөдөлмөрийн харилцааны, шашин зан үйлийн гээд маш олон динамик өөрчлөлтүүд гарч үүнд иргэд дасан зохицож, төлөвших үйл явц ямар ч төрийн бодлогын зохицуулалтгүйгээр өөрийн голдирлоороо удаан явагдаж, олон тулгамдсан асуудлуудыг араасаа дагуулсаар байна.

Дотоодын энэхүү олон эмзэг байдлуудыг ашиглаж, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, тогтворжиж төлөвшөөгүй нийгмийн харилцаа, бэхжиж чадаагүй үндэсний эв нэгдэл, эдийн засгийн сул дорой байдал зэргүүдэд өөрсдийнхөө алс хэтийн ашиг сонирхлыг суулгаж хэрэгжүүлдэг гадны технологиуд шинэ арга хэлбэрүүдээр ажиллаж нөлөөлсөөр байна.

Үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг хангах үйл ажиллагааны сул, идэвхгүй байдал, улс орны дотоод дахь улс төр, нийгмийн талцал, эдийн засгийн хэт хамааралт байдал, хэт их эрх чөлөөтэй хүний эрхээр далайлгасан үйл явцууд нь үндэсний аюулгүй байдал, төрийн бодлогын нэгдмэл байдлыг сарниулж, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд саад болсоор байна гэж үзэх үндэстэй юм.

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн олон хэсгүүдээс УАБЗ-ийн хүрээнд тусгайлан анхаарч ач холбогдол өгөх нь үндэсний язгуур эрх ашгийн бүрдэл хэсгүүд гэж бид үзэж байдаг ч өнөөгийн манай нийгмийн дотоод болон гадаад орчны хувьсал өөрчлөлтөөс харахад шударга эрх зүйт ёс, үндэсний эв нэгдэл, төрийн албаны үлгэрлэн манлайлах чадвар, авлига, ажилгүйдэл, нийгмийн хамгааллын сул бодлогууд, уул уурхай болон стратегийн бүтээн байгуулалтын асуудлууд нь ихээхэн эрсдэл, сорилтуудыг цаашдаа бий болгож болзошгүй төлөвтэй, анхаарал татахуйц байгааг хэлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг ерөнхийд нь томьёолж хэлбэл үндэсний аюулгүй байдал дотоод талдаа их эмзэг[3] түүнийг яаралтай төрийн хуулийн хүрээнд шударгаар шийдэх, бодлого, үйл ажиллагааны зохицуулалтыг хийх шаардлагыг УАБЗ-ийн өмнө

[2] Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль. 1992 он.

[3] Стратеги судалгааны хүрээлэнгийн "Улс орны дотоод аюулгүй байдлын орчин" сэдэвт 2021 оны судалгааны ажлын тайлан. 27х.


нөхцөлдүүлж байна гэж үзэж байна.

Ийм ч учраас Монгол Улсын ерөнхийлөгч, ҮАБЗ-ийн зөвлөлийн тэргүүний албан тушаал хаших хугацааг ч үндсэн хуулиар, ард түмний сонголтоор сунгасан нь тохиолдлын улс төрийн үйл явц биш юм гэж үзэж байна.

Олон улсын байдал асар хурдан өөрчлөгдөж байгаа нь болзошгүй эрсдэлүүдийг урьдчилан тааварлаж, хариу үйлдлээ урьдчилан тооцоолоход нэн төвөгтэй нөхцөл байдлуудыг үүсгээд байна. Үүнийг бид өнөөгийн олон улсын болон өөрийн улс орныхоо улс төр, нийгмийн амьдралаас харж байна.

Үүний зэрэгцээ, хил дамнасан гэмт хэрэг, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодис дамлан худалдах, цахим гэмт хэрэг, мэдээллийн кибер халдлага, нийгмийн бүх бүтцийг хамарсан зөөлөн хүчний идэвхтэй бодлого, стратегийн зориулалттай эрдэс баялгийн төлөөх тэмцэл, мэдээллийн дайн, хүнсний аюулгүй байдал нь ноцтой аюул, сорилтуудыг учруулсан хэвээр байна.

Энэхүү хувьсал өөрчлөлтөөс улбаалж манай улс тусгаарлагдах; эдийн засгийн хараат хамааралтай байх; дотоодын замбараагүй байдлаасаа болоод хөгжлийн гадна үлдэх; улс төрийн тулгалт дарамтад орох; уул уурхай болон ашигт малтмалын аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн талаарх бодлогогүй, тооцоо судалгаагүй байдлаас болж нутаг дэвсгэр газар нутгийн бүрэн бүтэн байдалд сөрөг хүчин зүйлс бий болох; гадны соёл иргэншлийн нөлөөнөөс болж үндэсний өөрийн гэсэн онцлог ёс уламжлалаа алдах; байгаль орчин доройтох; улс орон маань эзэнгүйрэх, хилийн хязгаарлалт, дэлхийн эдийн засгийн шок зэрэг сорилтууд ойрын ирээдүйд гарч магадгүй төлөв байгаад одооноос анхаарч урьдчилсан бодлого, зохицуулалт хийх шаардлага хэрэгцээ ҮАБЗ-д тулгарч болохоор байна гэж харж байна.



Эдгээр эрсдэлт байдлуудын нөхцөлд ямар арга хэмжээ авах, аюулгүй байдлын болон эдийн засгийн ямар бодлогын өөрчлөлтүүд хийгдэх, олон улсын байгууллагууд, гадны улсуудтай яаж харилцаж ямар дэмжлэг

авах, тусгаар, бие даасан байдлаа яаж хамгаалж авч үлдэх вэ? гээд олон шинэ сорилтууд тулгарах болно. Иймд одооноос тооцож, төлөвлөж байх хэрэгцээ ойрын үед бий болж болохоор байна.

Дэлхийн улс орнуудад эдийн засгийн хамтын ажиллагааны тогтолцоо цар тахлын улмаас суларч, цэрэг армийн аюулгүй байдлын асуудлууд сүүлийн үед ихээхэн анхаарал татаж, шинэ агуулгаар баяжигдаж өөрчлөгдсөнөөр улс орнуудын аюулгүй байдлыг хангах тогтолцоонд цэргийн хүчин зүйлийн нөлөө улам бүр хүчтэй болсоор байгааг өнөөгийн олон улсын амьдрал үйл явц харуулсаар байна. Жижиг улсын аюулгүй байдал олон улсын эрх зүйн хэмжээгээр хангагдаж, баталгааждаг байдал үндсэндээ ихээхэн бүдгэрч байгаа нь сүүлийн үеийн цэрэг-улс төрийн үйл явцуудаас харагдаж байна.

Олон улсын амьдрал дах үйл явцаас улбаалж улс орон бүрийн үндэсний аюулгүй байдлын оршин тогтнох, оршин байх үзэл баримтлал, хандлагад ихээхэн өөрчлөлт орж, эрсдэл сорилтууд ч төсөөлж байснаас өөр болж, учирч болзошгүй аюул, заналуудын цаад агуулга, далд зорилго нь зөөлөн хүчний бодлогоор нийгэм, эдийн засаг, мэдээлэл, улс төрийн чиглэлээр орж ирж улс орныг богино хугацаанд хүмүүнлэгийн сүйрэлд хүргэж байгааг бид харж байна

Олон улсын харилцааны байдал, улс төр, эдийн засаг, орон зайн хүчин зүйлээс улбаалж улс орны үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсгүүд, учирч болзошгүй сөрөг хүчин зүйлс бүдгэрч, тодорч байдаг зүй тогтолтой байдгаас гадна аюулгүй байдлыг хангах бодлого ч мөн уян хатан, олон талт байр суурьтай болж өөрчлөгдсөөр байна.

Эдгээр хувьсал өөрчлөлтүүд нь ҮАБЗ-ийн үйл ажиллагааг өргөн хүрээтэй, олон талтай шуурхай, уян хатан болгох нөхцөлийг бий болгоод байна гэж үзэж байна.

ҮАБЗ- ийн үйл ажиллагааны онцлог тал нь үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсгүүд тус тусдаа бие дааж аюулгүй байдлаа хангах боломжгүй харин эдгээрийг нэгдсэн удирдлага, харилцан ажиллагааны зохицуулалтаар хангахад оршиж байгаа юм.



Ийм учраас ҮАБЗ нь үйл ажиллагааны нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нэгдсэн бодлого, нэг зорилго, нэг сувгаар үйлчилгээ үзүүлж, төрийн хар хайрцагны бодлогыг хэрэгжүүлдэг онцгой үүрэгтэй нэгж гэж үзэж түүний эрх, үүрэг, үйл ажиллагааных нь ач холбогдлыг улс орны үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс өргөжүүлж, чадваржуулж, хариуцлагажуулах нь зүйтэй гэж би хувьдаа үзэж байна.

Ингээд ҮАБЗ-ийн бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар та бүхэнтэй нэгдсэн бодлого, эрх зүйн; бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох зохицуулалт; хяналт, хэрэгжилт[4] үр дүн гэсэн хэсгүүдээр санал бодлоо хуваалцъя.

Нэгдсэн бодлого, эрх зүйн хүрээнд:

- Өнгөрч буй хугацаанд үндсэн хуульд хоёр ч удаа өөрчлөлтүүд орж, түүний үзэл санаануудыг аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хуулиудад тусгах ажлууд хийгдээгүй удаашралтай байна. Улс орны аюулгүй байдал, язгуур эрх ашигтай холбоотой асуудлуудыг улс төржүүлэлгүй хурдан шуурхай шийддэг арга замуудыг цаашдаа бий болгох шаардлага байна гэж харж байна. 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэгдээд 10 гаруй жил болж байхад түүнийг ажил хэрэг болгож хэрэгжүүлэх ёстой ''Үндэсний аюулгүй байдлын тухай хууль'' өөрчлөгдөөгүй хуучнаараа явж ирлээ.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны чиг үүргүүдийг хооронд нь нийцүүлж , үндэсний аюулгүй байдлын язгуур эрх ашгуудтай уялдуулах, аюулгүй байдлын эрх ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийг байнга тооцож, урьдчилсан арга хэмжээнүүд авч, харилцан ажиллагааны төлөвлөлт хийж, байнга тодотгож байх шаардлага байна.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын болон салбарын органик хуулиудад ҮАБҮБ болон Аюулгүй байдлыг хангах тухай хуулиудын үндсэн агуулгын үзэл санаа, мөн чанаруудыг суулгаж өгөх нь зүйтэй юм.
- Аюулгүй зөвлөлийн тухай хуульд байгаа зөвлөлийн чиг үүргүүдийн заалтуудыг эргэн харж үзэж тодотгох нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Учир нь нийгэм, гадаад орчны хувьсал өөрчлөлтүүд их хурдтай явагдаж, хувьсаж байна.
- ҮАБЗ-ийн зөвлөлийн бүтцийг 3 хүн байхаар хуульчилж[5] өгсөн байдаг ба шаардлагатай тохиолдолд төрийн тэргүүний санал болгосноор тодорхой албан тушаалтнуудаар нэмж болохоор эрх зүйн үндэс тавигдсан байдаг. Ер нь АЗ-ийн тухай хуульд зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн санал болгосноор УИХ өөрчлөлт оруулна гэснийг цаашдаа өөрчилж төрийн тэргүүн өөрөө шийддэг байх талаар хуульчилж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.
- ҮАБЗ-ийн гишүүдийн бүтцэд Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн

[4] Үдэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 2 дугаар зүйл.

[5] Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 5 зүйлийн 1 заалт.

сайдуудыг албан ёсоор оруулж өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа ба мөн стратегийн бүтээн байгуулалт явагдаж байгаа орон нутгийн засаг дарга нарыг шаардлагатай үед зөвлөлийн илтгэгч маягаар оролцуулж байх нь зүйтэй болов уу гэсэн санал байна.

- Цаашдаа ҮАБҮБ-ын хэрэгжилтийг хангах, улс орны хөгжлийг сайжруулж, хурдасгах зорилгоор Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийг Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн оронд боловсруулж гаргах нь зүйтэй байж болох юм гэж үзэж байна. Учир нь Аюулгүй байдал судлал, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд дэлхий нийтэд эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг тэргүүлэх зэрэгт тавьж, түүний хөгжил, боломжийг тооцон аюулгүй байдлаа хамгаалах, хангах асуудлуудыг авч үздэг хандлага тогтож эхлээд байна.
- УИХ-аар оруулж хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа хуулийн төслүүд, стратегийн ач холбогдолтой том төсөл, хөтөлбөрүүд болон худалдан авалтын том гэрээ, хэлэлцээрүүдийг нэгдсэн чуулганаар орохоос өмнө ҮАБЗ дээр хэлэлцэж, үндэсний язгуур эрх ашгуудад хир нийцэж байгаа болон түүнээс гарах нийгэм, хүмүүнлэгийн болон байгаль орчны, үндэсний аюулгүй байдлын сөрөг үр дагаврыг үнэлж, дүгнэж саналаа хүргүүлж, шаардлагатай бол зогсоох хүртэл арга хэмжээ авч байх хэрэгцээ байсаар байна.
- ҮАБЗ-ийн ажил нь ҮАБҮБ, Аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд тухайн цаг үеийн гадаад, дотоод орчны өөрчлөлтийг хурдан мэдэрч түүнд зохицож, уялдсан үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн нэгдсэн бодлогыг шуурхай гаргаж байх шаардлага байгаа нь одоо болж байгаа ОХУ Украйны хоорондын хямрал, хоёр хөршийн хилийн хязгаарлалт, дэлхийн эдийн засгийн шок, цар тахлын дараах сэргэлт их удаан явагдах эсвэл хойшлогдох зэрэг нөхцөл байдлуудаас тодорхой харагдаж байна.

Бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох зохицуулалтын хүрээнд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг хүлээсэн байгууллагуудын үүргүүдэд шинэ нөхцөл байдалтай холбогдуулан тодотгол хийж, асуудал шийдэх чадамжийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.
- ҮАБЗ болон Засгийн газрын ажлын уялдаа холбоог шинэ шатанд гаргаж, уялдуулах, нэгдмэл зорилго, чиглэлтэйгээр тулгамдсан асуудлуудыг шуурхай шийддэг тогтолцоог бий болгох нь ихээхэн чухал гэж үзэж байна.
- Төр, орон нутгийн захиргааны байгууллагын бүтцэд үндэсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч тодорхой санал боловсруулж байдаг энэ ажлын хариуцсан албан тушаалтныг бий болгох, эсвэл энэ үүргийг хүлээсэн хүнийг сургаж бэлтгэх хэрэгцээ байна гэж харж байна. Өөрөөр хэлбэл ҮАБЗ өөрийн

бүтцийг орон нутагт бий болгож, зөвлөлийн шийдвэрийг заавал биелүүлдэг системийг бий болгох нь зүйтэй байх гэж үзэж байгаа юм.

- Цаашдаа бид эрсдэл, болзошгүй нөхцөл байдалд тулгуурласан судалгаа шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч түүнийг зөв таамаглаж, хариу шуурхай арга хэмжээ авч байх үйл ажиллагааны дэг журмыг бүтцэдээ бий болгох хэрэгцээ байж болох юм гэж үзэж байна. Ер нь улс орны хөгжлийн болон эдийн засгийн, стратегийн том ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүд үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдэлийн үнэлгээ хийж, түүнийх нь үр дүн, нөлөөг зөвлөлөөс хянаж шалгаж, тайлагнаж байвал зүгээр байгаа юм.
- АЗ-ийн өнгөрсөн хугацааны үйл ажиллагаа, сургамжаас харж байхад улс төрийн хүчний аливаа бодлого, үзэл санаанд хөтлөгдөх, улс орны хөгжлийн стратегийн том төслүүдийн үр дүнг зөвхөн санхүү, эдийн засгийн талаас нь харах зэрэг алдаатай зүйлүүд байсныг цаашид анхаарч иймэрхүү төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хяналт тавьж анхаарч байх нь зүйтэй.
- АБЗ зарим тохиолдолд УАБУБ, ГБУБ, Аюулгүй байдлыг хангах тухай хууль зэрэг баримт бичгүүдийн үзэл санаанд баригдаад, УАБ-ийн гол асуудлуудаа барьж авч, өргөн хүрээтэй уян хатан байдлаар ажиллаж чадахгүй тал байгааг цаашид анхаарч байх нь зүйтэй.
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын бодлогыг "бодлого" талаас хянах, үзэл баримтлалын хэрэгжилтийг хангуулах "стратеги" боловсруулах, аюулгүй байдлын асуудлаар нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциудын хэрэгжилт биелэлтийг тооцох, үндэсний аюулгүй байдлаа хангах чадавхыг бүрдүүлэх зэрэг асуудлуудад давхар анхаарч байх нь зүйтэй бөгөөд аливаа асуудлаар төрийн тэргүүн шийдвэр гаргах, олон нийтэд мэдээлэх зэрэг арга хэмжээнээс өмнө аюулгүй байдлын бодлогын зөвлөл хэлэлцсэний дараа төрийн тэргүүнээр батлуулж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хяналт, хэрэгжилт, үр дүнгийн тухайд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах чадавх яг ямар хэмжээнд байна, энэ үзэл баримтлалын хэрэгжилт ямар түвшинд байна, үзэл баримтлалын үзэл санаа улсын их хурлаас баталж гаргадаг хуулиудад яаж тусгалаа олж байна, цаашид юунд анхаарах талаар ямар нэг дүгнэлт, үнэлгээ хийгдэж баримжаалах чиглэл тогтож бий болоогүй байна.
- Аюулгүй байдлын зөвлөлөөс аливаа асуудлыг шийдвэрлэх, хангуулахын тулд зөвлөмж гаргаж биелэлтийг нь хангуулдаг. Биелэлтийг хангуулах хариуцлагын тогтолцоо ихээхэн сул байгаад цаашид анхаарч хуульд энэ талаар тодорхой тусгах нь зүйтэй.
- Цаашдаа төрөөс батлан гаргасан аюулгүй байдлыг хангах талаарх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн эдийн засгийн үндэслэл тооцоог сайн

гаргаж, түүнийг хэрэгжүүлэх үйл явцыг санхүүжилт, эдийн засгийн төсвийн төлөвлөлтэй нь холбон авч үзэж байх нь зүйтэй юм. Учир нь өнгөрсөн хугацаанд аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалалтыг бэхжүүлэх талаар олон хөтөлбөр, төлөвлөгөө батлагдсаны биелэлтийг тооцоход санхүүжилт, төсвийн төлөвлөлтөөсөө болоод маш олон асуудал хэрэгжээгүй үлдсэн байдаг ба энэ байдал бусад салбарт мөн адил байгаа гэж харж байна.

- ҮАБЗ-ийн шийдвэрийг заавал биелүүлдэг байх системийг бий болгож, хяналтыг сайжруулах шаардлагатай ба энэ асуудлыг хариуцдаг, хяналт тавьдаг хүмүүсийг тусгайлан сургаж, бэлтгэх шаардлага байна гэж харж байна.
- ҮАБЗ-ийн ажлын алба нь ҮАБ-ын тинк, танк байх нь зүйтэй ба энэ чиглэлээр ССХ, БХЭШХ, Тагнуулын академи, МУИС-ийн холбогдох сургууль, ШУТИС, ДХИС-уудыг түшиглэн аюулгүй байдлын тусгайлсан сургалт тогтмол явуулдаг тогтолцоог бий болгож болох юм гэж харж байна.
- Цаашдаа ССХ-ийн бүтцэд Орос, Хятад, Зүүн өмнөд ази, Төв ази, Казах судлалаар дагнасан судлаачдын тоог нэмэгдүүлэх, судалгаа хийх ажлын чиглэлүүдийг нь олон улсын амьдралын үйл явц, нөхцөл байдалтай уялдуулан уян хатан байдлаар маш тодорхой гаргаж өгч байх нь чухал байна гэдэг нь өнөөгийн үйл явцаас харагдаж байна.
- АБЗ-өөс өгөгдөж байгаа судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, даалгавар, тавигдах шаардлагыг маш тодорхой болгон өгч байхаас гадна учирч болзошгүй эрсдэл, сорилт түүнийг шийдвэрлэх хувилбар, төрийн үндэсний аюулгүй байдлын бодлого, зөвлөмжийн түвшинд санал дүгнэлт гаргах арга зүйн талаар энэ чиглэлийн мэргэжлийн эрдэмтэд оролцсон сургалтыг зохион байгуулж байх, холбогдох мэдээллийн программуудыг бий болгох, хэрэгцээ байна.
- АБЗ-ийн дэргэд ССХ түшиглэн Аюулгүй байдлын сургалтын төв байгуулах,төрийн болон орон нутгийн албан хаагчдад зориулсан сургалтын материалууд бэлтгэн гаргах, сургалтыг орон нутагт газар дээр нь зохион байгуулах, аюулгүй байдлын асуудлаар эрдмийн зэрэг цол хамгаалж байгаа эрдэмтдийн бүтээл, мэдээллийн баазыг нэгтгэн төвлөрүүлэх зэрэг ажлуудыг холбогдох сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран хийх шаардлага байсаар байна.
- Зөвлөлийн үйл ажиллагаанд байгаа нэг дутагдалтай тал бол манай нийгмийн амьдралын бодит байдлаас хөндий, бодит үнэн байдлыг сайн мэдэрч чадаагүй хэт ерөнхий байдлаар хандаад, улс орны эрх ашигтай холбоотой асуудлаар зоримог шийдвэр гаргахгүй байна гэсэн олон нийтийн шүүмж байгааг энэ дашрамд хэлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэж авч үзэх юм бол товчхондоо үндэсний аюулгүй байдлыг хангах дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдаж чадаагүй байна гэж үзэж болохоор байна.

Гадаад орчин харьцангуй тогтвортой байгаа энэ цаг хугацааг ашиглан дотоод орчин руугаа илүүтэй анхаарч ард иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн зөв төлөвшил, тогтвортой хариуцлагатай хөгжил, эв нэгдлийг бий болгох, эдийн засгийн хөгжлийг шинжлэх ухааны ололт, иноваци, шинэ технологиудаар дэмжиж хөгжүүлэх, үндэсний ёс заншил, уламжлал, байгаль орчин, газар нутгаа бүрэн бүтэн авч үлдэх, улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын нэр хүндийг өргөх талаар цаг хугацаатай уралдан ажиллах хэрэгцээ бий болоод байна.

Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд бид өөрчлөлт, шинэчлэлтийг их ярьж олон арга хэмжээ авч, олон төсөл, хөтөлбөр баталж хэрэгжүүлсэн боловч түүндээ үндэсний аюулгүй байдлын язгуур эрх ашиг, болзошгүй хямрал, хүнд сорилт, нөхцөл байдал үүсвэл яаж тооцож, яаж тусгах, улс орны хөгжлийн том том бүтээн байгуулалт маань аюулгүй байдлыг хангахад ямар нөлөөтэй, холбоотой талаар маш бага бодож, бараг тооцож тусгаж байсангүй гэж хэлэхэд нэг их буруудахгүй биз.

Аюулгүй байдлын судалгаанд чанарын шинжилгээний аргыг хэрэглэх нь

Д. Сайнбаяр
АБДС-ийн ЭТ-ийн багш, доктор

П. Мөнхтөр
АБДС-ийн ЭЗМТ-ийн багш, докторант

Abstract

Mongolia's higher education policy documents state that universities will become research universities, and in the "2030 development strategy of DUM", DUM will become a research university in 2021-2025. The mission of the school is " To become a competitive research university in the region and to reach international standards of defense education" and to establish an "International Center for Security Studies" in 2026-2030. As scientists, researchers, teachers and students evaluating and analyzing our research work is one of the conditions for improving the value of research work and fulfilling our mission. There are quantitative and qualitative analysis methods to evaluating research and development work, and it is more appropriate to use the qualitative analysis methods and methodologies in security and defense studies.

Үндсэн хэсэг

Судалгаа шинжилгээний ажил гэдэг нь аливаа үйл ажиллагаа, үзэгдэл процесс, технологи ажиллагаанд нөлөөлөх янз бүрийн хүчин зүйлээс хамааран судалж байгаа зүйлийн өөрчлөгдөх шинэ үзэгдэл, зүй тогтлыг илрүүлж тэрхүү зүй тогтлыг оновчлолын олон аргаар шинжлэн цаашид амьдрал, практикт ашиглаж болох зорилго бүхий үйл ажиллагаа юм. Иймд судлаач, багш, оюутнууд нь өөрийн явуулж буй технологи ажиллагаа (сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт)-ны тоо ба чанарын үзүүлэлтүүдийг ***математик статистикийн аргаар боловсруулалт хийж цэлдэг, технологи ажиллагааны математик загварыг дэвшүүлдэг, дэвшүүлсэн загвараа оновчлолын олон аргуудаар шинжлэн*** *хамгийн ур ашигтай хувилбараар үйл ажиллагаагаа явуулдаг байх ёстой.*

Судалгааны ажилд үнэлгээ хийх нь судалгаа боловсруулалт, туршилтын ажил үнэн зөв явж байна уу, шаардагдах зорилтыг шийдвэрлэхэд хэрэглэж болох эсэхийг тогтоохоор урьдчилан шинжилгээ хийдэг гэсэн үг юм. Мөн туршилт судалгааны ажлын явцад судалж байгаа зүйлийн тоон ба чанарын өөрчлөлтийн зүй тогтолд нөлөөлөх гол хүчин

зүйл, тэдгээрийн харилцан нөлөөллийг тогтоох боломжийг олгодог.

Судалгааны үр дүнг боловсруулах явцад гаргаж авсан математик загвар нь тухайн технологи ажиллагааны мөн чанар, зүй тогтлыг илэрхийлж, цаашид үйл ажиллагаа хэрхэн өрнөх таамаглалыг харуулдаг бөгөөд үзэгдэл процесст тохирсон загвар болсон эсэхийг математикийн тусгай шалгууураар шалгаж тогтоодог.

Дэвшүүлсэн загвартаа оновчлолын аргуудыг ашиглан шинжилгээ хийх нь үйл ажиллагааг хамгийн үр ашигтай хувилбараар явуулах боломжийг олгодог. Энд гарсан үр дүнг урьд өмнө хийгдсэн юмуу, төсөөтэй судалгааны үр дүн, эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулж дүн шинжилгээг гаргадаг.

Энэхүү өгүүлэлд эхний асуудал болох судалгаа боловсруулалтын ажлыг хэрхэн үнэлэх тухай авч үзье. Судалгаа боловсруулалтын ажилд үнэлгээ хийхдээ тоон болон чанарын шинжилгээний аргыг ашигладаг.

Тоон шинжилгээний арга

Судалгааны ажилд тоон шинжилгээ хийхэд дараах параметрүүдийг хэрэглэдэг. Үүнд:

Математик дундаж, сонгож авсан хэсгийн дундаж, ерөнхий дисперс, сонгож авсан хэсгийн дисперс, квадрат дундаж хэлбийлт, вариацын коэффициент, дундаж утгын алдаа, дундаж утгын харьцангуй алдаа, туршилтын шаардагдах тоо зэргийг тодорхойлдог.

Эдгээр параметрийг ашиглан тоон цуваа дотор:

- Хэт ялгарах хэмжигдэхүүн байгаа эсэх;
- Объектын мөн чанар, бодит дундаж утгыг тогтооход хэдэн удаагийн туршилт, судалгаа ойролцоогоор хэрэгтэй вэ гэдгийг тогтооход;
- Дисперсүүд нэгэн төрөл болох эсэх;
- Тоон цуваа нэгэн төрөл болох эсэх;
- Хэвийн тархалтын хуульд захирагддаг эсэх;
- Хэмжилтийн өөр өөр утгууд хоорондоо корреляци хамааралтай эсэх гэх зэргийг тогтоох явдал юм.

Дээрх шаардлагыг хангасан тоон цуваг судалгаа боловсруулалтын ажилд ашиглан үр дүнг гаргаж болно. Харин шалгуур шаардлагыг хангаагүй тохиолдолд уг өгөгдлийг ашиглаж болохгүй, эс бөгөөс өгөгдлийг дахин засварлаж сайжруулах арга хэмжээг авч болох юм. Дээрх шаардлагуудыг хангаж буй эсэхийг шалгах шалгууруудыг томьёолон гаргасан байдаг[1]. Үүнд:

Хэт ялгарах хэмжигдэхүүнийг орхих: Хэт ялгарч байгаа утгыг авч Стьюдентын болон түүнээс илүү нарийвчлалтай Смирнов-Грабсын шалгуурыг ашиглаж шалгана. Шаардлага хангаагүй утгыг орхих гэх мэтээр тооцоог хийдэг.

Хэмжилтийн утгууд нэгэн төрлийн болох таамаглалыг Фишерийн, Кохрены G, Бартлетын B, Стьюдентийн шалгууруар

[1] Авдай.Ч.,Энхтуяа.Д "Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй" . УБ.2010 он

шалгадаг.

Хэмжилтийн тоон цуваа хэвийн тархалтын хуульд захирагдаж байгаа эсэхийг шалгах хэд хэдэн арга байдгаас Пирсоны шалгуурын арга нилээд өргөн дэлгэрсэн нь юм. Хэмжилтийн тоо цөөн үед Шапиро Уилкагийн, хэмжилтийн тоо их үед Колмогоровын тархалтаар шалгана.

Хэмжилтийн өөр өөр утгууд хоорондоо корреляци хамааралтай эсэхийг тогтоох: Туршилт шинжилгээ, судалгааны ажлын үед хэд хэдэн хэмжигдэхүүний хооронд хамаарал байгаа эсэхийг тогтоохдоо корреляцийн шинжилгээ хийнэ. Энд статистик холбоог тогтоохдоо корреляцийн сонгож авсан коэффициент гэсэн тоон үзүүлэлтийг ашигладаг. Тоон утгууд корреляци хамааралтай болох эсэхийг шалгахаас гадна чанарын хувьд өөр өөр хоёр хэмжигдэхүүний хооронд корреляци хамаарал байгаа эсэхийг тогтоодог.

Эдгээр шаардлагыг хангах тоон өгөгдлийг судалгаа боловсруулалтын ажилд ашиглах нь судалгааны ажлыг чанартай, үнэн зөв, алдаагүй болгох бөгөөд шаардлага хангаагүй тоон өгөгдлөөр гаргасан үр дүн нь судалгааны ажлын чанарыг бууруулж, шинжлэх ухааны буруу дүгнэлтэнд хүргэх болно.

Мэргэжлийн шинжээчдийн үнэлгээг чанарын шинжилгээний аргаар боловсруулах

Зарим судалгааны ажлын үед тоон утгаар өгөгдөөгүй хүчин зүйлүүдийн нөлөөллийг мэргэжлийн шинжээчдийн гаргасан саналаар тооцож үнэлэх хэрэгтэй болдог. Энэ арга нь Зэвсэгт хүчин Батлан хамгаалах болон Аюулгүй байдал судлалаар хийх судалгааны ажилд ч өргөн хэрэглэгдэх боломжтой.

Тухайлбал $x_1, x_2, x_3, ..., x_n$ хүчин зүйл тухайн үйл ажиллагаа, үзэгдэл процесс, технологи ажиллагааны шинж чанарт ямархуу нөлөөтэй болохыг тогтоохоор m шинжээчээс судалгааны санал авсан гэж үзье. Шинжээч бүр объектод нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг зэрэглэж буурах дарааллаар нь дугаарласны дараа хүснэгтэд оруулж улмаар статистик үзүүлэлтийг олдог. Судалгаанд шинжээчдийн саналын үнэмшлийн зэргийг тогтоохдоо конкордацийн W коэффициентийг олдог.

$$W = \frac{12S}{m^3(n^2 - n)} \qquad (1)$$

$$S = \sum_{i=1}^{n}\left[\sum_{i=1}^{m} a_{ij} - \frac{1}{2}m(n+1)\right]^2 \qquad (2)$$

Энд:

m - шинжээчийн тоо, n - нөлөөлөх хүчин зүйлийн тоо.

$\sum_{i=1}^{m} a_{ij}$ - тухайн асуудалд шинжээчдийн өгсөн үнэлгээний нийлбэр.

Конкордацийн коэффициентийн утга $0 \le W \le 1$ хязгаарын хооронд байх ба 1-д ойр бол шинжээчдийн үнэлгээний саналын үнэмшил их, 0-д ойр бол үнэмшил бага гэж үзнэ.

Коэффициентэд үнэлгээ өгөхдөө $n > 7$ үед Пирсоны шалгуурын тооцооны утгыг

$$\chi_T^2 = m(n-1)W \qquad (3)$$

томьёогоор олоод хүснэгтээс[2] $q = 1 - P,\ f = n - 1$ (магадлал, чөлөөний зэрэг) утгаар хүснэгтийн χ_T^2 утгыг олж харьцуулдаг. Энд:

$\chi_T^2 > \chi_\chi^2$ бол шинжээчдийн үнэлгээний санал хоорондоо нийлж байна.

$\chi_T^2 < \chi_\chi^2$ бол шинжээчдийн үнэлгээний санал хоорондоо нийлэхгүй байна гэж үзнэ.

Эндээс тухайн судалгааны асуудалд шинжээч, эрдэмтэд, экспертүүд саналын хувьд нийцтэй, үнэмшилтэй хариулсан тохиолдолд уг технологи ажиллагаа, үзэгдэл процессийн талаар дүгнэлт гаргаж судалгааг цаашдын тооцоонд ашиглаж болно.

Судалгаа боловсруулалтын ажилд тоо ба чанарын шинжилгээний аргаар урьдчилан үнэлгээ хийх нь цааш буруу өгөгдөл дээр судалгааны ажил үргэлжлэн үр дүн гаргахаас сэргийлэх, судлаач өөрийн ажлыг явц дунд нь үнэлэн, зогсоох, засаж сайжруулах боломжийг олгох, мөн шинжлэх ухааны хуулийг үнэн зөв гаргах ач холбогдолтой юм.

Шинжилгээ: Зэвсэгт хүчний анги салбаруудын мэдээллийн аюулгүй байдал (МАБ)-ыг хангахад нөлөөлөх дотоод болон гадаад хүчин зүйлс хэр зэрэг хангагдаж байгааг тодорхойлох зорилгоор зэвсэгт хүчний анги салбарын удирдах албаны штабын дарга, ахлах оператор, холбооны дарга, батальон захирагч, холбооны офицер, төвийн дарга, цахилгаан холбооны төвийн дарга, ажиллагааны офицер, дайчилгааны офицер зэрэг 15 мэргэжилтнээс 20 асуулгаар судалгааг авсан (Хүснэгт 1).

А. Судалгааны өгөдлөөр W-ийн утгыг олвол:

$$W = \frac{12S}{m^3(n^2 - n)} = \frac{12 \cdot 91795}{15^3(20^2 - 20)} = \frac{1101540}{1795500} = 0.6135$$

хязгаарт байгаа бөгөөд W-ийн утга 1-д ойр учир мэргэжилтний үнэлгээний санал үнэмшилтэй гэж тодорхойлогдоно.

Пирсоны шалгуурын тооцооны утгыг олвол:

$$\chi_T^2 = m(n-1)W = 15(20-1) \cdot 0.6135 = 174.8$$

Пирсоны шалгуурын хүснэгтийн утгыг олвол:

$$\chi_x^2[q = 0.05,\ f = n - 1 = 20 - 1 = 19] = 30.143$$

Эндээс $\chi_T^2 = 174.8 > \chi_T^2 = 30.143$ болж мэргэжилтнүүдийн гаргасан **саналууд хоорондоо нийцтэй** байна гэж үзнэ.

Б. Судалгаанд тухайн асуудлыг хариуцаж, мэдэх салбарын мэргэжилтнүүд үнэмшилтэй, нийцтэй санал өгсөн тул судалгааны үр дүнгээр дараах график (Зураг 1)-ийг байгуулж, дүгнэлт гаргаж болно.

[2] Авдай.Ч.,Энхтуяа.Д "Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй" . УБ.2005 он

Хүснэгт 1

Зөвсөгт хүчний анги салбарын мэргэжилтнүүдээс МАБ-д нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулахаар авсан судалгаа

№	Мэргэжилтний тоо / Асуулга	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	$\sum a_{ij}$
1	Интернетийн холболт	1	1	3	7	5	6	8	3	5	3	2	4	5	5	5	63
2	Ашиглагдаж буй программын найдвартай ажиллагаа	1	4	7	8	6	8	5	5	1	3	2	3	8	5	8	74
3	Нууцын зэрэглэлтэй бичиг баримтын хадгалалт, хяналт	5	4	7	8	8	10	3	8	5	8	7	8	9	8	9	107
4	Удирдлагын дэмжлэг туслалцаа	6	5	7	8	8	9	5	8	7	5	7	4	8	5	9	101
5	Баримт бичиг хуулбарлахад тавих хяналт	4	3	8	9	8	8	8	9	7	8	7	6	8	8	7	108
6	Байгууллагын МАБ-ын эрсдэлийн удирдлага	5	2	8	9	8	8	3	9	4	5	7	5	7	7	8	95
7	Байгууллагын ажилчдын МАБ-ын талаарх мэдлэг	5	2	7	9	8	6	7	8	3	5	4	3	7	7	8	89
8	Ашиглаж буй техник хэрэгслийн найдвартай ажиллагаа	3	z	7	8	7	9	6	9	3	5	3	3	4	4	7	80
9	Байгууллагын харилцаа холбооны хэрэгсэл	5	2	4	7	6	6	9	7	5	5	5	6	6	3	8	84
10	Бусад байгууллагатай холбогдсон холболт	5	5	7	6	5	5	9	6	5	6	6	3	4	2	7	81
11	Биет байдлаар нэвтрэн орох цэгүүд (шалган нэвтрүүлэх байрнаас бусад)	5	5	4	6	8	6	9	5	7	7	7	7	9	4	8	97
12	ЗХЖШ-аас гаргасан дүрэм, журам	6	6	9	8	9	9	8	9	8	7	8	8	8	8	7	118
13	Дотоод сүлжээний халдлага	5	4	7	9	3	7	1	9	5	5	6	4	5	9	6	85
14	Албаны болон хувийн компьютерийн аюулгүй байдал	4	3	4	9	5	10	3	5	1	6	3	5	6	3	6	73
15	Сошиал хэрэглээ. (fb, twitter гэх мэт)	10	6	8	10	8	3	4	9	8	6	2	8	8	10	5	105
16	Лицензтэй программ ашиглалт (windows, office, antivirus гэх мэт)	3	2	4	9	7	6	3	8	6	5	5	5	6	4	6	79
17	Ажлын байрны ухаалаг утасны хэрэглээ	8	4	8	9	8	5	10	9	9	5	5	10	3	8	7	108
18	Мэдээллийн хуртээмжтэй байдал	10	3	4	8	7	5	10	9	4	7	4	7	6	3	7	94
19	Сүлжээний түвшний ойлголт	8	4	3	9	5	7	6	4	6	5	6	3	5	4	6	81
20	Мөрдөгдөж буй МАБ-ын журмын хэрэгжилт	7	1	8	9	8	9	8	8	6	6	5	5	8	8	7	103

Судалгааг графикаар үзүүлвэл



Зураг 1. ЗХ-ний анги салбарын мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс хэр хангагдаж байгаа байдал

Үүнд: Судалгаанд хамрагдсан зэвсэгт хүчний анги салбаруудын мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс 80%-иас дээш хангагдаж чадахгүй байгаа бөгөөд интернет холболт, ашиглаж буй программын найдвартай ажиллагаа, албаны болон хувийн компьютерийн аюулгүй байдал зэрэг нь дундаас доогуур түвшинд хангагдаж байна.

В. Энд эрсдэлийн үнэлгээг доорхи матрицын аргачлал (Хүснэгт 2) -аар хийж үзэхэд:

Хүснэгт 2

Эрсдэлийн үнэлгээг нөлөөллийн түвшингээр ангилах

Түвшин	Нөлөөлөл
Маш бага эрсдэлтэй	9,10
Бага эрсдэлтэй	7,8
Дунд зэрэг эрсдэлтэй	5,6
Өндөр эрсдэлтэй	3,4
Маш өндөр эрсдэлтэй	1,2

Судалгааны үр дүн:

1. ЗХ-ний анги салбарын МАБ-д маш өндөр эрсдэлтэй хүчин зүйл байхгүй байна.

2. Өндөр эрсдэлтэй, даруй арга хэмжээ авбал зохистой хүчин зүйлүүд нь:

- Интернет холболт,
- Ашиглаж буй програмын найдвартай ажиллагаа,
- Албаны болон хувийн компьютерийн аюулгүй байдал зэрэг болно.

3. Дунд зэргийн эрсдэлтэй, зохих арга хэмжээг тодорхойлох нь зүйтэй хүчин зүйлүүд нь

- Лицензтэй программ ашиглалт (windows, office, antivirus гэх мэт),
- Ашиглаж буй техник хэрэгслийн найдвартай ажиллагаа,
- Сүлжээний түвшний ойлголт,
- Бусад байгууллагатай холбогдсон холболт,
- Дотоод сүлжээний халдлага,
- Байгууллагын харилцаа холбооны хэрэгсэл,
- Байгууллагын ажилчдын МАБ-ын талаарх мэдлэг,
- Мэдээллийн хүртээмжтэй байдал,
- Байгууллагын МАБ-ын эрсдэлийн удирдлага,
- Биет байдлаар нэвтрэн орох цэгүүд (шалган нэвтрүүлэх байрнаас бусад) зэрэг болно.

4. Үйл ажиллагаанд бага зэргийн эрсдэлтэй, анхааралдаа авах шаардлагатай хүчин зүйлүүд нь

- Удирдлагын дэмжлэг туслалцаа,
- Мөрдөгдөж буй МАБ-ын журмын хэрэгжилт
- Сошиал хэрэглээ,

- Нууцын зэрэглэлтэй бичиг баримтын хадгалалт, хяналт
- Ажлын байрны ухаалаг утасны хэрэглээ,
- Баримт бичиг хуулбарлахад тавих хяналт,
- ЗХЖШ-аас гаргасан дүрэм журмын хэрэгжилт болно.

5. Маш бага эрсдэлтэй хүчин зүйл байхгүй байна.

Эндээс судалгааны үр дүнд үндэслэн тодорхой хүчин зүйлүүдийн хувьд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Чанарын шинжилгээний арга зүйг судалгаанд ашиглахад судлаач дараах асуудлуудыг анхаарах ёстой. Үүнд:

1. Судалгааны ажилд чанарын шинжилгээг хэргэжүүлэхэд мэргэжлийн шинжээч, судлаач эрдэмтэдийг зөв сонгох асуудал их чухал. Учир нь шинжээч нар тухайн судлаж буй асуудлыг сайн мэддэг, мэргэшсэн хүмүүс байх ёстой.
2. Судалгааны асуудал буюу, тухайн үйл ажиллагаа, үзэгдэл процесс, технологи ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхой, хүнд ойлгомжтой, гарцаагүй оносон хариулт шаардах хэмжээнд боловсруулах ёстой.
3. Асуудлыг хэрхэн үнэлэх талаар зааварчилгаа өгч ойлголтыг нэг мөр болгох хэрэгтэй байдаг.

Дүгнэлт, үр дүн:

Судалгаа боловсруулалтын ажилд тоон болон чанарын шинжилгээний аргыг ашиглан үнэлгээ шинжилгээ хийх нь цааш тухайн өгөгдөл, нөхцөлийг ашиглаж судалгааны үр дүн, дүгнэлтийг гаргаж болох эсэхийг шийдэж өгнө өөрөөр хэлбэл судалгааны ажлыг цааш үргэлжлүүлэх, явц дунд нь засварлаж сайжруулах, зогсоох, боломжийг олгодог.

Судлаачид цааш математик тооцооллын аргуудыг ашиглан үйл ажиллагааны загварыг дэвшүүлэх, оновчлолыг хэрэгжүүлэх боломжийг олгох суурь үндэс болно. Иймд судалгаа боловсруулалтын ажилд үнэлгээ шинжилгээ хийх нь өөрийн ажлыг итгэлтэйгээр үргэлжлүүлж зорьсон үр дүнгээ гаргах боломж олгодог.

“Аюулгүй байдлын олон улсын судлалын төв” байгуулах зорилтыг “Хөгжлийн стратеги-2030”-даа дэвшүүлсэн манай сургуулийн эрдэмтэн судлаачдын хувьд судалгаа боловсруулалтын ажилдаа тоон болон чанарын шинжилгээний арга аргачлалыг хэрэглэж байх нь судалгааны ажлын түвшинг дээшлүүлэх, онол арга зүйн хувьд чухал ач холбогдолтой байх болно.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт

1. Ч.Авдай, Д.Энхтуяа “Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй”. УБ., 2005 он.
2. Д.Нарандэлгэр “Удирдлагын ерөнхий онол, математик загварчлал”. УБ., 2000 он.

3. Тихомиров В.Б “Планирование и анализ эксперимента” М., 1974.
4. Ю.П.Адлер “Планирование и эксперимента при поиске оптимальных условий” М., Наука., 1987.
5. Д.Сайнбаяр “Цэргийн аюулыг үнэлэхэд үйлдлийн шинжилгээний аргыг ашиглах нь”. УБ., 2016 он.
6. Д.Сайнбаяр “Судалгаа шинжилгээний ажилд статистик боловсруулалт хийх арга зүйн асуудалд” АБС-ийн эрдэм шинжилгээний бичиг сэтгүүл. №1. 2017 он. х. 14-22.
7. Г.Хулан “Хилийн боомтод хүний аюулгүй байдлыг хангах арга замын судалгаа” сэдэвт докторын диссертаци. УБ., 2020 он.
8. Б.Нэргүй “ҮАБ-ыг хангахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх арга зам” докторын диссертаци. УБ., 2020 он.
9. А.Бүднам. “Арилжааны банкны аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс, түүний сөрөг нөлөөллийг бууруулах боломж”. УБ., 2019он.
10. О.Эрхэмбаяр “Газар дээр нь холих аргаар хөрсийг цементээр бэхжүүлсэн суурийн орц найрлагын судалгаа”. УБ., 2021 он.
11. Б.Мөнгөнхишиг “Аюулгүй байдлын эрсдлийн түвшинг үнэлэх математик аргачлал, тооцооллын алгоритм”. УБ., 2019 он.

Үндэсний био аюулгүй байдлын судалгааны арга зүйн асуудалд

Х.Орхончимэг
БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан доктор (Ph.D), дэд профессор

Б.Анар
УБХИС-ийн докторант

Abstract

The national biosecurity research is the conduct of scientifically based research to prevent, monitor, and protect national security interests in accordance with the law. There is a need to systematically address the methodological issues of national biosecurity research. Therefore, this article aims to address the methodological issues of the national biosecurity research.

Keywords: *biohazards, biosecurity, methodology, research.*

Оршил

Арга зүй нь шинжлэх ухааны хүрээнд хэрэглэгдэж байгаа тодорхой арга барилуудын систем юм. Аргын үндсэн үүрэг бол судалгааны үйл явцыг явуулахад шаардагдах эмх цэгцтэй системтэйгээр үр дүн гаргах явц юм. Арга нь судалгааны үйл явцыг тодорхой үр дүнд хүргэхийн тулд шаардагдаж байгаа систем. Арга зүйг системтэйгээр зөв хэрэглэх эсэхээс тухайн судалгаа үр дүнд хүрэх эсэх нь шалтгаална. Био аюулгүй байдлын судалгаа нь биологийн эрсдэл, аюул заналхийллийн үзэгдэл, шалтгаан, шинж чанарыг судлах, биологийн үйл явдлын улмаас үүсэх эрсдэлийг багасгах, сэргийлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоход чиглэгдэнэ. Үндэсний био аюулгүй байдлын судалгаа нь урьдчилан сэргийлэх, хянах, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа явуулахад оршино. Иймд Үндэсний био аюулгүй байдлын судалгааны арга зүйн асуудлыг системтэй авч үзэж тодорхойлох шаардлага тулгарч байна.

Үндсэн хэсэг

Үндэсний био аюулгүй байдлын шинжлэх ухааны мөн чанарыг оновчтой тодорхойлох, хэрэглээний судалгаа явуулах, үүсэх био аюулаас үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тал бүрийн судалгааг явуулах нь чухал байна.

Даяаршлын нөхцөлд хүмүүс, организм, хүрээлэн буй орчноос бүрдсэн цогц систем дэх аюулгүй байдлын үйл явц, олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг судалж, үр нөлөөг шинжлэхэд үндэсний био аюулгүй байдлын судалгааны арга зүйг тодорхой болгох шаардлагатай. Энэхүү нарийн төвөгтэй системд аюулгүй байдлын субьект нь голчлон хүн байдаг боловч амьтан (мал гэх мэт) эсвэл ургамал байж болно. Амьд организмд зөвхөн эмгэг төрүүлэгч бичил биетэн төдийгүй организмтай холбоотой шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал (хүн гэх мэт) –ийг хамруулж ойлгох хэрэгтэй. Эмгэг төрүүлэгч бичил биетүүдийн хүрээлэн буй орчин гэдэг нь зөвхөн байгалийн орчин төдийгүй нийгмийн орчныг (хууль тогтоомж гэх мэт)-ийг мөн хамааруулж ойлгох хэрэгтэй. Тиймээс үндэсний био аюулгүй байдал нь хэвтээ ба босоо интеграцчилал, олон түвшний интеграц бүхий судалгааны цогц систем юм.

Био аюулгүй байдлын судалгаа явуулахад шинжлэх ухаан судалгааны оновчтой арга зүйг хэрэглэх нь хамгийн тулгамдсан асуудал болж байна. Иймд шинжлэх ухааны судалгааны ямар арга зүйг хэрэглэн био аюулын тооцоолол хийвэл үр дүнтэй болохыг тодруулж үзье.

Био аюулгүй байдлын судалгааны аргууд нь орон зайн динамик шинжүүд болох тоон, эмпирик ба симуляцийн нэгдмэл чанаруудтай байдаг. Био аюулгүй байдлын судалгааны аргууд нь харьцангуй олон янз байдаг бөгөөд үүнд мэдээллийн нөөцийн менежментийн арга, био анагаах ухааны арга, шинжлэх ухааны системчилсэн аргуудыг хамруулж болох юм.

Био анагаах ухааны аргууд нь био аюулгүй байдлын судалгааны үндсэн аргууд юм. Био аюулгүй байдал нь шинээр гарч ирж буй биологийн хамгаалалтын арга хэмжээ бөгөөд үүний цөм нь биологийн үйл явдлаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, эмчилгээ, үйлчилгээний асуудлууд юм. Био аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэхэд эмгэг төрүүлэгч ба бусад организм, тэдгээрийн бүтээгдэхүүнийг туршилтын шинжилгээ, эрсдэлийг тодорхойлох, шинжлэх явдал чухал. Аюул заналхийллийн түвшинг тодорхойлох, хортой организмыг илрүүлэх, оношлох, урьдчилан сэрэмжлүүлэх, вакцин, эм зэргийг турших, био аюулаас урьдчилан сэргийлэх үндэсний аюулгүй байдлын системийг цогцоор нь шийдэх асуудал юм.

Системчилсэн шинжлэх ухааны арга бол био аюулгүй байдлын хуулиудыг судлах, ойлгоход маш чухал арга зүй юм. Цаг хугацаа, орон зайн динамик хуулийг судлах үндсэн арга. Математик, системийн шинжлэх ухаан, цогц систем гэсэн гурван асуудалд анхаарлаа төвлөрүүлдэг. Ерөнхийдөө энэхүү хослол нь хурдацтай хөгжил, интеграцийн үе шатанд байгаа бөгөөд хөгжлийн өргөн боломжийг нээн харуулж болох юм. Энэ арга нь био аюулгүй байдлын судалгаанд хэрэгтэй судалгааны аргуудыг санал болгож байгаа бөгөөд хамгийн чухал нь ойлголт, шийдлийг гаргах боломжийг өгдөг. Асуудлын арга, хэрэгсэл нь био аюулгүй байдлыг судлах, хөгжүүлэх, био аюулгүй байдлын менежментийн үйл ажиллагааны удирдамжид чухал үүрэг гүйцэтгэдэг.

Био аюулгүй байдал ба математикийн шинжлэх ухааны уялдаа холбоо нь суурь шинжлэх ухаан болохын хувьд салбар дундын судалгаанд чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүний цар хүрээ өргөн бөгөөд маш их ач холбогдолтой юм. Францын математикч Лаплас хэлэхдээ: "Математикт бид Үнэнийг олж мэдэх гол хэрэгсэл бол индукц ба симуляци юм. "Математик загварчлал гэдэг нь хэрэглээний практик асуудлыг шийдвэрлэхэд математик аргыг ашиглах явдал юм. Судлаачдын олж тогтоодог юмсын хэмжээ ба хоорондын хамаарлын зүй тогтлыг үр дүнтэй судлахад нь хүмүүст тусалж чадах нэгэн арга бол математик загварчлал юм. Бодит нөхцөл байдалд туршилт хийх боломжгүй судалгааны объект биологийн үйл явдлын хувьд математик, биологийн үйл явдлын агууламжтай холбоогүй хүчин зүйл, биологийн цогц үйл явдлыг хийсвэрлэж үр дүнг тооцож гаргаж болно. Программ хангамжийн хөгжил, хувьслын үйл явцыг харгалзах математикийн бодлогуудад нэгтгэн дүгнэж, үүнд үндэслэн тооцоолол хийж тухайн аргыг ашигладаг. Биологийн үйл явдлыг чанарын эсвэл тоон талаас нь дүрслэн харуулахын тулд гүнзгий дүн шинжилгээ, судалгааг онолын хувьд гаргах, хөгжлийн механизм, асуудлыг үр дүнтэй шийдэх хувилбарыг санал болгох, болзошгүй эрсдэл, хортой үр дагаврыг шинжлэх, үнэлэх, биологийн ослын онцгой байдлын стандарт тогтооход илүү нарийвчилсан мэдээллийн үүсвэр болох эсвэл шийдвэр гаргахад туслах, ингэснээр биологийн хамгаалалтыг сайжруулж үр дүн гаргахад ач холбогдолтой юм. Судалгааны туршлагын хязгаарлалтууд нь тоон, нарийвчлалтай, тооцоолж болохуйц, урьдчилан таамаглах, хянах боломжтой чиглэлд хөгжиж байна.

Санамсаргүй математик нь статистикийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх, судлах, ажиглалтаар санамсаргүй үзэгдлийн угаас тогтсон зүй тогтлыг олж нээх, тодорхой нарийвчлалтай хийх, нарийвчлалын зэргийг дүгнэх, урьдчилан таамаглах, дараа нь эдгээр судалгааны үр дүнг нэгтгэн, математик загварыг бий болгох, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэслэл, зөвлөмжийг өгөх зэрэгт ач холбогдолтой арга юм.

Био аюулгүй байдлын чиглэлээр санамсаргүй математикийн хэрэглээний ердийн жишээ бол биологийн хяналт, урьдчилан сэрэмжлүүлэх явдал юм. Биологийн хяналт, мониторинг ба урьдчилсан сэрэмжлүүлэг гэдэг нь өвчин эмгэг эсвэл эрүүл мэндийн бусад үйл явдлын талаарх мэдээллийг тасралтгүй, системтэйгээр цуглуулахыг хэлнэ. Мэдээлэл өгөх, мэдээллийг шаардлагатай хүмүүс, байгууллагуудад түгээх, тодорхой хүрээнд зохих арга хэмжээг авах, үйл явдлын аюулаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг гаргах арга хэмжээ, ослоос урьдчилан сэргийлэхийн тулд холбогдох түвшний урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэгт хэрэглэхэд тохиромжтой.

Хязгаарлагдмал мэдэгдэж буй өгөгдөл дээр үндэслэн үл мэдэгдэх биотерроризмын халдлагыг аль болох эрт тодорхойлж, түргэн шуурхай арга хэмжээ авах, онцгой байдлын үед үр дүнтэй хариу арга хэмжээ авах нь үндэсний био аюулгүй байдлын үндсэн чадавхыг бэхжүүлэхэд

чухал юм.

Бактерийн биотерроризмын дайралт, эрүүл мэндийн системийн хариу үйлдэл хоцрох тусам эдийн засгийн өндөр өртөгтэй болно.

Биологийн янз бүрийн аюул заналыг урьдчилан таамаглахад ашигладаг компьютерийн шинжлэх ухаан болон бусад холбогдох салбаруудыг хослуулсан статистик шинжилгээний арга чухал үр дүнтэй юм. Хяналт, сэрэмжлүүлэг нь био аюулаас урьдчилан сэргийлэх, хянахад чухал ач холбогдолтой юм. Компьютерийг ашиглан урьдчилан таамаглах, онолын хурдацтай хөгжлийг дагаад олон янзын аргуудыг биологийн хамгаалалтад үр дүнтэй хэрэгжүүлж, амьдралд хариу үйлдэл үзүүлэх цаг нэгэнт болжээ. Хяналтын техникийн арга хэрэгслийг аажмаар сайжруулах, хяналт шинжилгээний өгөгдлийн тайлангийн системийг аажмаар сайжруулах зэрэгт үр дүнтэй юм.

Судалгаанд биологийн батлан хамгаалах чадавхыг бий болгох зорилгоор үр ашигтай, үнэн зөв хяналт, урьдчилсан сэрэмжлүүлэх өгөгдөлд дүн шинжилгээ хийх арга зүйг бий болгох хэрэгтэй. Өнөөдрийн байдлаар хяналт, эрт сэрэмжлүүлэхэд өргөн хэрэглэгддэг санамсаргүй математикийн онолын арга зүйд суурилан голчлон био аюулын тооцоолол хийж байна.

Чанарын аргуудыг био аюулгүй байдлын тархалтыг тооцоход оновчтой юм. Чанарын арга нь түүхэн өгөгдөл эсвэл шинжээчийн өгөгдлийг ашигладаг. Факторын эрчмийн шинжилгээ нь өвчний тархалтын хандлага, хүчийг тодорхойлж чадна. Энэ арга нь оролт, гаралтыг мэдэх шаардлагагүй. Хэмжээ хоорондын функциональ хамаарал, урьдчилсан мэдээлэл хангалтгүй тохиолдолд өвчний тархалт ба холбогдох хүчин зүйлүүдийг авч үздэг. Тухайлбал “Судлаач Пэн Жиксинг нар 1991 оны 1-р сараас 2000 оны 10-р сар хүртэл хижиг өвчний тархалтад дүн шинжилгээ хийхдээ Марковын онолыг ашиглажээ[1]. БНХАУ-д Жиангсу мужид хижигийн халууралтын өвчлөлийн загварыг тогтоож, цэгцтэй кластержуулах аргыг хэрэглэн үр дүнг урьчилан тогтоосон. Энэ нь өвчтний тоо өөрчлөгдөхийг урьдчилан таамаглах, дүн шинжилгээ хийхэд стандартчилсан автокорреляцийн коэффициентийг ашиглан чанарын зэрэг тогтоох стандарт арга юм. Нөхцөл байдал, урьдчилсан таамаглалын урт хугацааны үр нөлөөг тогтоохын тулд 2000 оны 11, 12-р саруудын тохиолдлын мэдээллийг авч үзсэн. Загварын тохирох байдал урьдчилсан таамаглал сайн байсан. Иймд үр дүнгийн тооцоолол хийхдээ тохирох арга зүйг зөв сонгохоос ихээхэн шалтгаална.

Тоон аргуудыг ерөнхийдөө ажиглалтын өгөгдлийг статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийх тусдаа арга гэж үздэг. Урьдчилан таамаглах объект ба нөлөөлөх хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг олж мэдэх энэ төрлийн загвар нь түүврийн хэмжээ, магадлалын тархалтад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Эдгээр аргын урьдчилан таамаглах үр нөлөө нь сайн бөгөөд эпидемийн тогтвортой хүчин зүйл бүхий өвчнийг

[1] 彭志行, 鲍昌俊, 赵杨, 等. 加权马尔科夫链在伤寒副伤寒发病情况预测分析中的应用. 中国卫生统计, 2008,35(3):92~99.

урьдчилан таамаглахад тохиромжтой юм. Тоон аргууд нь үндсэн өгөгдлүүдийн үндсэн дээр асуудлыг чанарын аргуудаас илүү үнэн зөв, бодитой тайлбарлаж чаддаг. Жишээлбэл судлаач Wu[2] өгөгдлийг урьдчилж боловсруулахад долгионы онолыг ашиглаж, дараа нь генетикийн алгоритмуудыг ашиглаж тооцоолол хийсэн. Шинжилгээ хийж, өвчний халууралтыг урьдчилан таамаглах загварыг гаргажээ. Судалгаанаас харахад халуурах тохиолдол дундаж температуртай тохирсон. Улирлын шинж чанарууд хоорондоо нягт уялдаатай бөгөөд 5 жилийн өгөгдлийг боловсруулахад энэ загварыг ашиглах боломжтой болохыг тэмдэглэжээ. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах нь дор хаяж 2 жилийн хугацаанд үнэн зөв урьдчилсан мэдээг өгдөг. Өөр нэг жишээ бол Шу Чин ба бусад[3], Легранд[4] нарын судалгаа юм. Судалгааг ашиглан боом өвчний 10 тохиолдол олох аргыг тооцоолсон. Энэ нь өвчний тархалтаас урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой юм. Био аюулын тооцоолол хийхэд голчлон регрессийн таамаглалын онол, Бокс-Женкинс нарын динамик загвар, долгионы загвар, Бэйсийн онол гэх мэт олон онол, арга зүйг хэрэглэж болох юм.

Бүх талбайн ойролцоо утгыг олох арга зүй нь биотерроризмын үйл ажиллагаанаас үүссэн вирусийн агаар мандлын тархалтын загварт өргөн хэрэглэгддэг. Био аюулын тархалт нь олон янз байдаг бөгөөд үүнээс агаар мандлын тархалт хамгийн өргөн хүрээг хамардаг[5].

“Нэг талаас био аюулын онцгой шинж чанараас шалтгаалан тархалтын нөхцөлийг хянах нь тийм ч хялбар биш юм. Энэ нь үнэтэй бөгөөд судалгаа хийхэд томоохон хэмжээний туршилтын симуляци хийх боломжгүй юм. Нөгөөтэйгүүр агаар мандлын бүтэц нарийн төвөгтэй, физик, химийн шинж чанараас шалтгаалан био аюулын тархалт нь шугаман бус, төвөгтэй асуудалтай байдаг. Био аюулын агаар мандлын тархалт нь эцсийн дүн шинжилгээгээр тасралтгүй орчинд концентрацийн талбайн динамик өөрчлөлтийн процессоос хамаарч байдаг. Тоон симуляци нь тэгшитгэлийг өөрчлөлтийн процесст тохируулан ашиглах, дараа нь дискрет байдлаар ашиглах явдал юм. Тиймээс тархалтын аюулын үнэлгээний үндсэн цэгүүд нь “тасралтгүй” ба “салангид” байдаг. Явагдаж буй процесст тасралтгүй нийцүүлэхийн тулд дифференциал тэгшитгэлийг ашиглах, тэгшитгэлийг үр дүнтэй салангид шийдэл болгох нь энэ үйл явцын онолын гол асуудал юм. Агаар дахь тархалтын загваруудын талаар олон судалгаанууд авч үзсэн байдаг. Үүний зэрэгцээ био аюулын агаар мандлын тархалтын загварыг дараах төрлүүдэд хувааж болно. Тухайлбал Эйлерийн загвар, Гауссын загвар, Лагранжийн загвар, шингэний тооцоолох динамик

[2] Wu Y, Lee G, Soh H,et al. Mining Weather Information in Dengue Outbreak: Predicting future Cases Basedon Wavelet, SVM and GA. Netherlands: Springer Netherlands, 2009.

[3] 许晴, 祖正虎, 张文斗, 等. 基于 MCMC方法的生物气溶胶袭击施放源项参数反演. 军 事医学, 2012,36(10):732~735.

[4] Legrand J,Egan J R,Hall I M,et al. Estimating the location and spatial extent of a covert anthrax release. Public Library of Science Computational Biology, 2009,5(1):e1000356.

[5] 姜庆五. 生物恐怖的威胁及其对策. 疾病控制杂志, 2003,1:16-23

турбулент загвар ба дээрх загварууд дээр суурилсан холболтын загвар[6] гэх мэтээр авч үзэж болох юм.

Хөдөлгөөний чиг хандлагыг урьдчилан таамаглах боломжтой дифференциал тэгшитгэл нь математикийн хамгийн чухал салбаруудын нэгд тооцогдох болжээ. Халдварт өвчний тархах механизмыг загварчлахдаа дифференциал тэгшитгэлийн чанарын онолыг шугаман бус дифференциал тэгшитгэлийн шийдлүүдийн шинж чанарт дүн шинжилгээ хийх, өвчний тархалтад нөлөөлж буй хүчин зүйлийг тоон хэмжээсээр судлах хэрэгсэл болгон ашиглах явдал чухал юм. Өвчин дамжих түвшин, мөн өвчнийг судлах, үүсэх, хөгжих, динамик үйл явц, өвчин дамжих динамик системийн тэнцвэрийг судлах, шинж тэмдгийг онолын хувьд тодруулах болон өвчний тархалтын хуулиуд, дамжуулалтын гол хүчин зүйлүүд эсвэл дамжуулалтын сул талыг тооцоолно. Холбоосууд нь халдвар дамжих замыг үндсээр нь хянах буюу хаах байдлыг харуулдаг. Тиймээс халдварт өвчнийг дамжуулах механизмыг загварчлах нь эпидемиологийн судалгаа, урьдчилан сэргийлэх, хянах практикт онолын ач холбогдолтой юм.

Шинжлэх ухааны онолын хөгжил ба судалгааны арга зүй хоёрын холбоо нь нягт байдаг. Судалгааг онолгүйгээр, арга зүйн тусгай системгүйгээр хийх боломжгүй. Шинжлэх ухааны онол, танин мэдэхүйн аргын харилцан хамаарлыг ухаж ойлгосноор судалгаа амжилттай явагдана. Био аюулгүй байдлын судалгаанд шинжлэх ухааны судалгааны аргуудаас тохирох арга зүйг хэрэглэх нь нэн чухал юм.

Дүгнэлт

Аливаа судалгаа хийхэд танин мэдэхүйн маш нарийн асуудлуудтай тулгардаг. Энэ нь арга зүйн олон түвшин ба түүний хөгжил нь байнга хувьсан өөрчлөгдөж буйтай холбоотой юм. Үндэсний био аюулгүй байдлын судалгааны арга зүйн асуудлыг системтэй авч үзэж, хэрэглэгдэх судалгааны арга зүйг оновчтой тодорхойлохгүйгээр цаашдын судалгааны үр дүн бүрхэг болно. Био аюулгүй байдлын судалгааны арга зүйд системчилсэн шинжлэх ухааны аргууд, математик тооцоололын аргууд чухал үр дүнтэй болохыг олон судалгааны үр дүнгүүд харуулж байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. Majid. A, Bensebaa.F, L' Ecuyer.P , e tal. Modification of the metallic surface of silver by the formation of alkanethiol self-assembled monolayer with subsequent reaction with chlo-rosilanes. Reviewson Advanced Materials Science,2003,4:25-31
2. Legrand.J, Egan J.R, Hall I M,et al. Estimating the location and spatial extent of a covert anthrax release. Public Library of Science Computational Biology, 2009,5(1):e1000356.
3. Wu Y, Lee G, Soh H,et al. Mining Weather Information in Dengue Outbreak:

[6] Majid A, Bensebaa F, L' Ecuyer P , e tal. Modification of the metallic surface of silver by the formation of alkanethiol self-assembled monolayer with subsequent reaction with chlo-rosilanes. Reviewson Advanced Materials Science,2003,4:25-31.

Predicting future Cases Basedon Wavelet, SVM and GA. Netherlands: Springer Netherlands, 2009.
4. 彭志行,鲍昌俊,赵杨,等. 加权马尔科夫链在伤寒副伤寒发病情况预测分析中的应用. 中国卫生统计,2008,35(3):92~99.
5. 许晴,祖正虎,张文斗,等. 基于 MCMC方法的生物气溶胶袭击施放源项参数反演. 军事医学,2012,36(10):732~735.
6. 姜庆五. 生物恐怖的威胁及其对策. 疾病控制杂志,2003,1:16-23

Хүнсний аюулгүй байдал

Д.Энхмаа
ҮАБЗ-ийн Ажлын албаны газрын дарга, доктор (Ph.D)

С.Наранцэцэг
ҮАБЗ-ийн ССХ-ийн Захиргаа, нууц хамгаалах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, докторант

Abstract

National Security Concept of Mongolia states that national security activities should be based on knowledge, cooperation between the government and citizens, a comprehensive security policy, and a principled approach to anything, taking into account globalization factors. However, food security measures do not meet the above principles.

For example, in terms of food security, food quality and hygiene are being lost in the primary agricultural production, food raw material and product storage warehouses, cellars, transportation logistics, food production and service stages. From the food chain stage, the food processing industry is more developed than any other industry. There are many reasons for the positive and negative consequences. One of the main reasons for the negative consequences is the lack of a comprehensive food security policy and an effective system, which has led to insufficient enforcement of relevant laws.

Therefore, the legal environment of the food sector and its implementation since 2010 should be re-analyzed in relation to the current pandemic and post-pandemic situation, and the legal environment and structure of the food sector should be restructured. There may be a need for structural and systemic reforms.

Keywords: *National security, food security, legal environment of the food sector, policy, regulation, food quality and hygiene*

Удиртгал

Монгол Улсын Их Хурлын 2010 оны долоодугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал[1] батлагдсанаар хүнсний салбарын эрх зүйн орчныг шинэчлэх үндэслэл бий болсон. ҮАБ-ын үзэл баримтлалын 3.4.2-т заасан хүнсний аюулгүй байдлыг хангах 9 заалтыг хэрэгжүүлэх гол хууль болох Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг 2012 онд Монгол Улсын Их Хурлаас баталж, дээрх хоёр хууль 10 дахь жилдээ хэрэгжиж байна. Тус хоёр хуулийн хэрэгжилтэд 2020 онд дүн

[1] УИХ, legalinfo.mn, 2010

шинжилгээ хийсэн үнэлгээний дүнгээс[2] харахад, хууль тогтоомжийн хэрэгжилт 2018 онд 69.5 хувь болж 2013 онтой харьцуулахад 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүнсний сүлжээгээр нэгтгэн авч үзвэл анхан шатны үйлдвэрлэлийн шатанд 8.7 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн шатанд 6.4 хувиар, хүнсний худалдаалалтын шатанд 0.3 хувиар тус тус хууль тогтоомжийн хэрэгжилт өссөн дүнтэй байгаа бол хоол үйлдвэрлэлийн шатанд 8.8 хувиар буурсан байна. Эдгээр үзүүлэлт нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээнд оролцож байгаа үе шатандаа хуулиар тогтоосон заавал мөрдөх ёстой зохистой дадлыг нэвтрүүлж байгаа дүр зураг юм.

Хуулийн хэрэгжилтийг хүнсний сүлжээний үе шатанд нарийвчлан үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл мал төхөөрөх үйл ажиллагаанд 44.3 хувь, өрхийн шувууны аж ахуйд 58.8 хувь байгаа нь хамгийн бага үзүүлэлт гарсан бол, мал, амьтны шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн шатанд 80.6 хувь, гурилын үйлдвэрлэлд 76.1 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна. (Б.Энхтуяа & Д.Энхмаа, 2016-12) Ургамлын гаралтай жижиглэн савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хуулийн хэрэгжилт 61.3 хувь, нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 61.7 буюу хамгийн бага хувьтай гарчээ[3].

Тодотгон судлахад Хүнсний тухай хуулийг дагаж гарсан 5 журам, 1 заавар, 2 зөвлөмжийн хэрэгжилт 2013-2018 онд дунджаар 65.9 хувьтай үзүүлэлт гарсан байна[4]. Мөн тус тайланд зарим нэг эрх зүйн баримт бичгүүд өөр хоорондоо уялдаа холбоогүй, шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй гэсэн дүгнэлт гарсан. Тухайлбал нийтийн хоол, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын үед хүнсний баталгаат байдлыг хангах, хуурамч хүнсний бүтээгдэхүүн, транс тосны хэрэглээ, стратегийн хүнсний хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тусгай, нэмэлт эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хүнсний хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй гэж үнэлсэн байна.

Цаашид бид даяаршлын хүчин зүйлийг харгалзан үзэн, Монгол Улсын хүнсний хангамжийн 46.6 хувийг[5] бүрдүүлж байгаа импортын хүнс, ялангуяа хүн амын дундах хүнсний хэрэглээний дийлэнх хувийг эзэлж буй таримал ургамлын гаралтай хүнсний түүхий эдийг 100 хувь өөрсдөө тариалдаг, бэлтгэдэг болох, улмаар дотооддоо боловсруулах үйлдвэрийг төгөлдөржүүлэх замаар импортын хамаарлыг эрс бууруулах бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

---

[2] Д.Энхмаа & Ч.Тунгалаг, Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020) (Д.Энхмаа & Ч.Тунгалаг, 2020

[3] Д.Энхмаа & Л.Гэрэлмаа, Хүнсний хууль эрх зүйн орчин, хяналтын үйл ажиллагаа, тогтолцоонд хийсэн үнэлгээ, 2017

[4] Д.Энхмаа & Ч.Тунгалаг, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020

[5] Үндэсний статистикийн хороо 2020

Иймд төр иргэний хамтын ажиллагаатай, аюулгүй байдлын цогц бодлоготойгоор мэдлэгт суурилан, даяаршлын хүчин зүйлийг харгалзан аливаа зүйлд бодитоор хандах зарчимд тулгуурласан хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, цогц бодлогыг шинэчлэн боловсруулж, оновчтой тогтолцоо, үйл ажиллагаагаар бодлогын хэрэгжилтийг ханган хүн амаа эрүүл, аюулгүй, баталгаат хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүнсний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд

ҮАБ-ын үзэл баримтлалын 3.4.2.1 дэх заалтад "Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ" гэж тусгасан.

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтээр 2020 оны байдлаар хүнсний хангамжийн 53.4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 46.6[6] хувийг импортоор бүрдүүлж байгаа нь хүнсний бие даасан байдал эрсдэлтэй түвшинд байна.

Хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь импортын хамаарлыг тооцвол мах, гурил, сүү, буудай, төмсний хэрэгцээний хангалтаар хүнсний баталгаат байдлын "бие даасан", хүнсний ногоо, өндгөөр "эрсдэлтэй", харин төрөл бүрийн будаа, чихэр, жимс, жимсгэнэ, ургамлын тос, загасны махны хувьд "импортоос хамааралтай" хүнсний бие даасан байдал алдагдсан түвшинд хэвээр байна.

Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээнээс[7] харахад хүн амын хүнсний хэрэглээний 75 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, төмс, хүнсний ногоо, буурцагт ургамал, жимс, жимсгэнэ, ургамлын тос, сахар чихрийн зүйлс эзэлж байна[8].

Дээр дурдсан хоёр үзүүлэлтийг харьцуулан дүгнэхэд хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээс таримал ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хамаарал их байна. Хэдийгээр хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл сайжирч импортын хэмжээ буурч байгаа ч импортын хамааралтай байсаар байна.

ҮАБ-ын үзэл баримтлалын[9] 3.4.2.2-т "Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна" гэж заасан[10].

Тэгвэл Монгол Улс газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх,

[6] ҮСХ-ны Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд урьдчилсан тооцоогоор 2020
[7] ЭМЯ, 2017
[8] ҮСГ, 2020
[9] Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
[10] УИХ, legalinfo.mn, 2010

ялангуяа таримал ургамал, ургамлыг дотооддоо тариалж, дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүнээр хангамжаа бүрдүүлж импортын хамаарлын хувь хэмжээг эрс бууруулах, импортын хамаарлаас ангижрахад үйл ажиллагааг чиглүүлэх нь зүйтэй гэж харж байна. Нөгөө талаас газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид технологийн горимын дагуу мэргэжлийн удирдлага дор газар тариалангийн үйлдвэрлэлээ явуулж, дараагийн шатны боловсруулах үйлдвэрлэлд чанартай түүхий эд нийлүүлж, хэрэглэгчдийг аюулгүй, чанартай бүтээгдэхүүнээр хангах шаардлагатай байна.

Ялангуяа газар тариалангийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай зүйл бол улаан буудайн үр юм. Жилийн дунджаар тооцоход Монгол Улсын хэмжээнд дотоодын хэрэгцээнд нийт 55,0-60,0 мянган тонн улаан буудайн үр шаардлагатай[11] байгаа тул цаашид үрийг системтэйгээр дотооддоо үржүүлэн, нөөцийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнгээр нийт өрхийн 35 хувь нь хүнсний хангамжийн баталгаат байдал хэвийн хангагдаж байна. Харин нийт өрхийн 14 хувь хүнсний хангамжийн баталгаат байдал бага алдагдсан, 28 хувь нь дунд зэрэг алдагдсан, 23 хувьд ноцтой алдагдаж, өлсгөлөнгийн байдалд байгаа судалгааны дүн гарсан боловч манай улсын 15-49 насны эрэгтэйчүүдийн 49 хувь, эмэгтэйчүүдийн 46 хувь илүүдэл жин ба таргалалттай байгааг тогтоосон[12].

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтээр 2021 оны байдлаар улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, төмс, сахар, чихрийн зүйлийн хүртээмж хангалттай, бусад хүнсний бүтээгдэхүүний хүртээмж хангалтгүй буюу дутагдалтай байна[13].

Харин эсрэгээрээ, 2021 оны жилийн эцсийн дүнгээр Монгол Улсын хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй спиртийн 5, архины 21, шар айргийн 7, дарсны 6 үйлдвэр тус тус үйл ажиллагаагаа явуулж байна[14]. Улсын хэмжээнд хоногт 45 мянган литр спирт, 168 мянган литр архи, 231 мянган литр пиво, 4.8 мянган литр дарс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүд байна. Улсын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй согтууруулах ундаа 2020 оны байдлаар нэг хүнд хоногт 8.8 литр архи, дарс, 30.4 литр шар айраг ноогдож байна[15] гэсэн статистикийн тоон мэдээ байгаа[16] хэдий ч сүүлийн жилүүдэд согтууруулах ундааны зах зээлийн бүтцэд өөрчлөлт орж, спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундааны эзлэх хувь багасаж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас архи, согтууруулах ундааны

[11] ХХААХҮЯ, 2021
[12] ЭМЯ, Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний тавдугаар судалгаа, 2017
[13] ҮСГ, 2020
[14] ХХААХҮЯ, Архи болон согтууруулах ундааны үйлдвэрийн тоо, байршил, хүчин чадлын тухай мэдээ, 2021
[15] Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт 2020
[16] ҮСГ, 2020

эргэлтийг хязгаарлах, хэтрүүлэн хэрэглэснээс үүдэлтэй эмгэгээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хор хөнөөлийг багасгах зорилгоор таван үндсэн чиглэлийг санал болгосны нэг нь архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх газруудын байршил болон тоо хэмжээг зохистой байдлаар хязгаарлах зохицуулалт байдаг.

Улс орнуудын туршлагаас харахад согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгийн тоог тухайн нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа хүн амын тоонд, эсвэл газар нутгийн хэмжээнд үндэслэн тогтоодог байна. Тухайлбал, АНУ-ын мужуудад 1200-7500 хүн амд 1 цэг байхаар өөр өөрөөр тогтоосон хэдий ч зөвшөөрөлтэй ажиллаж байгаа 1 цэгт дунджаар 10204 хүн ноогдож байна. Франц улсад 450 хүн тутамд 1 цэг байхыг зөвшөөрдөг боловч хүн амын нягтшил ихтэй том хотуудын хувьд 3000 хүн тутамд 1 цэг байхаар тогтоосон байдаг. Исланд улсын хувьд 1 км2 нутаг дэвсгэрт 1-5 цэг байхыг зөвшөөрдөг байна.

Улс орнууд дээрх маягаар тогтоосон нормативын хүрээнд архи, согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгохдоо тухайн нутаг дэвсгэрт ижил үйл ажиллагаа явуулдаг цэгийн тоо, байршил, замын хөдөлгөөний байдал, тухайн нутаг дэвсгэрт байгаа байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн зай, тухайн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, зөрчлийн тоог харгалзан үздэг байна.

2014 оноос эхлэн Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт гаргадаг болсон нь хүнсний аюулгүй байдалтай холбоотой албан ёсны мэдээллийг нэгдсэн нэг ойлголтод хүргэн, холбогдох байгууллагууд нэг тоогоор мэдээлдэг, харилцдаг болсон.

Статистикийн мэдээнд дурдсанаар Монгол Улсын хүн амын хүнсний хэрэгцээ нь үндсэндээ мах, махан бүтээгдэхүүн, сүү, гурил зонхилон хангагдсан хэвээр байсаар байгаа нь эрүүл, шимт тэжээллэг хоол, хүнсний хэрэглээ иргэдийн дунд маш хангалтгүй байна гэж дүгнэхээр байна.

Олон улсын түвшинд хүн амын дундах нийт өвчлөлийн 70 гаруй хувь нь хоол, хүнснээс шалтгаалдаг болохыг судалгаагаар тогтоосон байдаг.

Манай улсын хувьд хүн амын дундах өвчлөлд амьсгал, зүрх судас, хоол боловсруулах тогтолцооны өвчин 2021 оны урьдчилсан дүнгээр хүн амын нийт өвчлөлийн 40.7[17] хувийг эзэлж[18], хоол, хүнснээс гаралтай хордлогот халдварт өвчлөлийн тоо сүүлийн 5 жилд буурахгүй байгаа бөгөөд[19] эдгээр өвчнийг үүсгэдэг нэг гол шалтгаан нь хоол, хүнсний буруу, зохисгүй хэрэглээ, хүний биед хэрэгтэй амин дэм, эрдсийн дуталдалтай холбоотой гэж үзэж байна.

Монгол Улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхэд дүн шинжилгээг хийхдээ үүсэж байгаа болон үүсэж болзошгүй

[17] ЭМЯ-ны албаны 2021 оны урьдчилсан дүн
[18] ЭМЯ, Хүн амын нийт өвчлөл, төрлөөр, 2021
[19] ҮСГ, 2020

эрсдэлт хүчин зүйлсийг тооцон хүнсний сүлжээгээр нь авч үзэхэд:

Мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд хамааралтай малын эрүүл мэнд, удмын сан, мал бэлтгэлийн тогтолцоо, бүртгэл, мал төхөөрөх үйлдвэрийн сул зогсолт, газар тариалангийн салбарт хоршоолол хөгжөөгүй, логистикийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, үйлдвэрлэлийн механикжуулалд, технологийн шийдэл дутмаг, импортын болон дотоодын хүнсний түүхий эд, туслах материал, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын тогтолцоо, түүний хэрэгжилт хангалттай түвшинд хүрээгүй, аюулгүй байдал хангагдаагүй байгаа нь хүнсний сүлжээний анхан шатанд үүсэж байгаа эрсдэлт хүчин зүйлс юм[20]. Хүнсний сүлжээний анхан шатны үйлдвэрлэл нь ийнхүү баталгаагүй байдалтай байгаа нь хэрэглэгчийн гар дээр аюулгүй, эрүүл хүнс очиж байгаа гэж дүгнэж хэлэхэд хэцүү байна.

Гэхдээ манай улсад малын удмын сан, сүргийн бүтцийг сайжруулах, үржил селекцийн ажлыг шинэ түвшинд гаргах, бэлчээр усжуулалт, малын тэжээлийн тариалалт, хөрс хамгаалалт, газар зүйн байршилд тохирсон үрийн нөөцтэй болох, усалгаатай тариаланг хөгжүүлснээр нэг га-гаас авах ургацын хэмжээ, нэг малаас авах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх боломж байгаа гэж үзэж байна.

Дотооддоо газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чанаржуулснаар хүнсний хангамжийн асуудлыг тодорхой түвшинд шийдэх боломжтой. Үүний тулд газар тариалангийн талбайн хөрсний үржил шим нөхөн сэргэх, нэг га-гаас авах ургацын тоо хэмжээ нэмэгдэх, чанарыг сайжруулах, агуулах, зоорины багтаамжийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан байгальд ээлтэй нүүдлийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэлийг даатгал, бүртгэл, мэдээлэлд суурилсан ухаалаг тогтолцоотой холбон, тогтвортой хөгжүүлэх "Эрсдэлгүй ХАА" хөтөлбөрийг[21] гарган хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэж, зориулалтын бус агуулах, зооринд хадгалж байгаа нь мөн л хүнсний сүлжээний гол үе шат болох логистикийн тогтолцооны эмх замбараагүй хөгжилтэй[22] холбоотой. Иймд хүнсний сүлжээний 2 дахь гол үе шат нь мөн л баталгаатай байна гэж дүгнэх боломжгүй. Мал эмнэлгийн ерөнхий газраас малын гарал үүслийг баталгаажуулах бүртгэлийн системийг нэвтрүүлэн ажиллаж байгаа хэдий ч хэрэглэгчийн зүгээс хүнсний бүтээгдэхүүнийхээ гарал үүслийг хэрхэн яаж танин мэдэх, хэрэглэгчдэд зориулан бүтээсэн аппликейшнийг хэрхэн яаж ашиглах талаар иргэдийн дунд ойлголт байхгүй байна.

Мөн хот, орон нутгийн иргэдийг байгалийн гаралтай цэвэр хүнсний

[20] (ҮСГ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Мал аж ахуйн статистикийн мэдээ, 2021

[21] Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, 2021

[22] "Мах, хүнсний ногооны хангамжийн баталгаат байдал" хэлэлцүүлгийн эмхэтгэл, 2019-5-6

бүтээгдэхүүнээр тогтмол хүртээмжтэй хангах бодлогын хүрээнд хүнсний зоорь, хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх "Органик хүнсний зоорь" хөтөлбөрийг[23] батлуулж хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Хүнсний сүлжээний анхан шат болох хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хамаарагдах бүх хүчин зүйлсийг тооцон үйл ажиллагааг жигдрүүлэх, сайжруулах арга хэмжээ авснаар дараагийн хүнсний сүлжээний баталгаа хангагдах учиртай.

Иймд "Малчны хотноос хэрэглэгчийн ширээ" хүртэл хүнсний сүлжээний үйл явцад стандартын шаардлагад нийцсэн хүнсний түүхий эд нийлүүлэх тогтолцоог бий болгон ажиллахад хүнсний аюулгүй байдлын нэлээн асуудлыг шийдэх боломжтой.

2020 оны байдлаар эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 19 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас 10 нь хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO22000 стандартыг, 9 нь эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо /HACCP/ нэвтрүүлсэн байна[24]. Харин хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлсэнд баталгаажуулсан нэг ч аж ахуйн нэгж байгууллага байхгүй нь уг баталгаажуулалтыг хийх тогтолцоо манай улсад хараахан бүрдээгүйтэй холбоотой. Иймд энэхүү тогтолцооны гажуудлыг яаралтай засаж залруулах нь зүйтэй.

2021 оны байдлаар хүнсний салбарт үндэсний 676 стандарт мөрдөж байгаагаас 252 буюу 37.3 хувь нь олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартыг орчуулан үндэсний болгон боловсруулсан стандарт байна[25]. Харин 2021 онд хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн 66 лаборатори үйл ажиллагаа явуулсан байна[26].

Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь харьцангуйгаар хүнсний сүлжээн дотроо жигдэрсэн, сүүлийн үеийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, олон улсын хөгжилтэй эн зэрэгцэх хэмжээнд хөгжиж байгаа боловч тухайн хүнсний боловсруулах үйлдвэрт хэрэглэгддэг хүнсний түүхий эд, туслах болон нэмэлт бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхойгүй, стандартын дагуу анхан шатны үйлдвэрлэлээ явуулдаггүй газраас мах, сүү нийлүүлж авч байгаа нь боловсруулах үйлдвэрээс гарч байгаа эцсийн бүтээгдэхүүн баталгаатай гэж хэлэхэд хүндрэлтэй юм.

Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдааны эрх зүйн зохицуулалт байхгүйгээс зах зээл дээр худалдан борлуулагдаж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний, туслах болон нэмэлт хүнсний бүтээгдэхүүн нь төрийн хяналт, шалгалтад бараг хамрагдахгүй зарагдаж байна. Хувь хүн хүнс импортлохыг хуулиар хориглосон боловч хяналтгүй орж ирдэг, хулгайн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэх

[23] Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, 2021
[24] СХЗГ, 2020
[25] СХЗГ, Хүнсний салбарын стандартын тоон мэдээ, 2021
[26] ҮИТ, 2021

хандлагатай байгаагаас тусгай ажиллагаа явуулж хилээр бүртгэлгүй, хяналтад хамрагддаггүй орж ирдэг хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрөл, тоо хэмжээгээр нь тогтоох нэн шаардлагатай байна. Учир нь энэхүү албан ёсны судалгааны дүнг Үндэсний статистикийн хороонд тооцон гаргадаг Хүнсний баланс бодоход ашигласнаар Монгол Улсын хэмжээнд хүнсний хангамж, хүртэмжийн баланс үнэн бодитоор гарахад хувь нэмэр болно.

Хүнсний сүлжээнд хамгийн их асуудал үүсгэж байгаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний баталгаат байдал маш хангалтгүй түвшинд байна. Улсын хэмжээнд 2019-2020 оны байдлаар нийт 27 объектод 27 хоол, хүнсээр дамжих хоолны хордлогот өвчний дэгдэлт бүртгэгдэж нийт 1601 хүн өвдсөн[27]. Хордлого гарсан эх сурвалжийг дурдвал 59.3% нь нийтийн хоолны газарт, 18.5% нь сургууль, цэцэрлэгт, 18.5% нь өрх гэрт, 3.7% нь буяны арга хэмжээний үед гарсан байна[28]. Харин 2021 оны жилийн эцсийн дүнгээр хоол, хүнсээр дамжих хоолны хордлогот өвчний 5 дэгдэлт бүртгэгдэж нийт 264 хүн өвдсөн байна[29].

Сүүлийн үед хоолны хордлого ихээр гарах үед улсын хэмжээнд лабораторийн түвшинд хоолны хордлогыг үүсгэж байгаа эх сурвалжийг үнэн бодитоор тогтооход лабораторийн хүчин чадал, мэргэжлийн хүний нөөцийн чадавх хангалттай биш, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох лабораторийн бэлэн байдал хангагдахгүй байгаатай холбоотой.

Цаашид лабораторийн техникийн болон мэргэжлийн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлснээр манай улс хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүд болон органик хүнсийг тодорхойлох хүчин чадалтай, мэргэжлийн ур чадвартай болох нь улс орны хувьд нэн шаардлагатай байна.

Хүнсний сүлжээний бүх үе шатанд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид хүнсний технологич, мал зүйч, агрономич зэрэг мэргэжлийн хүний нөөцийн дутагдал, гачигдалд орсон тул хөдөө аж ахуй болон хүнсний үйлдвэрлэл технологийн дагуу тэр бүр явагдахгүй байна. Энэ нь нэгж талбайгаас авах ургацын хэмжээ, нэг малаас авах ашиг шимийн хэмжээ норм хэмжээнээс бага, үйл ажиллагаа нь зардал өндөртэй, тухайн бүтээгдэхүүний өөрийн өртөг өндөр гарч ур ашиггүй, алдагдалтай ажилладаг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Улмаар арьс шир, ноос ноолуурын чанар үйлдвэрлэлийн стандартын шаардлагыг хангахгүй, үнэгүйдэх байдал гарсаар байна.

Иймд малын гаралтай түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, импортыг орлох, эцсийн бүтээгдэхүүнийг чанартай үйлдвэрлэх "Хөнгөн, хүнсний үйлдвэрийн цогцолборууд"-ыг сэргээх, Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүс тус бүрд үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр

[27] ҮСГ, Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт, 2020

[28] Д.Энхмаа & Ч.Тунгалаг, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020

[29] ЭМЯ, Хүн амын дундах хоол, хүнсээр дамжих хоолны хордлогот өвчний дэгдэлт, 2021

логистикийн төв бүхий “Үндэсний кластер”-ууд байгуулах[30] бодлогыг хэрэгжүүлэхэд төр болон хувийн хэвшлийн зүгээс хамтран ажиллах нь зүйтэй.

Олон улсын хэмжээнд үнэлдэг хүнсний аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн нэг болох тухайн орон “Хүнсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоотой эсэх”-д Монгол улсын хувьд нэгдсэн тогтолцоо байхгүй, шинжлэх ухаанд суурилсан бодлого, зарим үйл ажиллагааг явуулдаггүй гэж дүгнэгдэхээр байна.

Учир нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байсан “Хүнсний эрдэм, шинжилгээ, судалгааны институт”-ыг 2001 онд хувьчлалаар байхгүй болгосноор хүнсний бодлого тодорхойлоход хамтран оролцдог байсан уг хүрээлэн, түүний эрдэмтэд, судлаач тарж алга болсон. Иймд хүнсний салбарт аливаа бодлогын шийдвэр гаргалтад шинжлэх ухаанчаар хандахын тулд хүнсний чиглэлийн эрдэм, шинжилгээ судалгааны байгууллагыг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь төрөөс дэмжих нэн шаардлагатай байна.

Хүнсний талаарх зар сурталчилгаанд оролцогчдын эрх, үүргийг оновчтой тодорхойлох, хүнсний талаарх мэдээ, мэдээлэл өгөх, хүнсний чиглэлийн зар сурталчилгаанд тавигдах ерөнхий шаардлага болон тусгай шаардлагыг хэрэгжих боломжтой байдлаар тогтоох, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа түгээх хэлбэрт тавигдах шаардлагыг тусгай шаардлагаас ялгах, шинэ төрлийн зар сурталчилгаа түгээх хэлбэрт буюу цахим орчин дах хоол, хүнсний талаарх зар сурталчилгаанд тавигдах шаардлагыг томьёолж хуульчлах нь зүйтэй байна.

Дүгнэлт

Хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь төр иргэний хамтын ажиллагаатай, аюулгүй байдлын цогц бодлоготойгоор мэдлэгт суурилан, даяаршлын хүчин зүйлийг харгалзан аливаа зүйлд бодитоор хандах зарчимд суурилж явагдаж чадахгүй байна.

Хүнсний салбарын эрх зүйн орчны хэрэгжилт ойролцоогоор 60 гаруй хувьтай байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, шинжлэх ухаанд суурилсан цогц бодлого, үйл ажиллагаа явуулдаггүй, мэргэжлийн удирдлагын чадавх сул, оновчтой бус шийдвэр гаргаж байгаатай холбоотой юм. Тодруулбал салбарын хэмжээнд хүний нөөцийн бодлого 1990 оноос хойш алдагдсан, хүнсний салбарт эрдэм шинжилгээний хүрээлэн байхгүй байгаа нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжилд сөрөг үр дагаврыг бий болгосон.

Олон улсын хэмжээнд хүнсний хангамжийн хараат байдлыг тухайн улсын импортын эзлэх хувиар илэрхийлдэг. Манай улсын хувьд хүнсний хангамжийн 46,6 хувийг импортын бүтээгдэхүүнээр бүрдүүлж байгаа нь хүнсний бие даасан байдал “эрсдэлтэй” түвшинд байна. Хүнсний нэр төрөл тус бүрээр нь импортын хамаарлыг тооцоход хүн амын хүнсний хэрэглээний 75 хувийг эзэлж буй ургамлын гаралтай хүнсний

[30] Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, 2021)

бүтээгдэхүүн тухайлбал төрөл бүрийн будаа, хүнсний ногоо, буурцагт ургамал, жимс, жимсгэнэ, ургамлын тос, сахар чихрийн зүйлс нь 70-аас дээш хувиар импортын хамааралтай байна. Иймд юуны түрүүнд манай улс таримал ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хамаарлыг үе шаттайгаар бууруулах шаардлагатай байна.

Ядуу эмзэг өрхийн хүн амын хүнсний хангамжийн баталгаат байдал алдагдахаас хамгаалах, далд өлсгөлөнд өртөх эрсдэлийг бууруулах, ялангуяа улирлын чанартай хүнсний хомсдол, байгаль, цаг уурын гамшиг бэрхшээлийн үед тэдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг авах шаардлагатай байна.

Өрхийн түвшинд хоол, хүнсийг зөв сонгох, архи, тамхины хэрэглээг багасгах, хүнсний зөв, зохистой хэрэглээний соёл, дадал хэвшил эзэмшүүлэхэд ээж болон хүүхдүүд маш их үүрэгтэй байдаг. Иймд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийг суралцагчдын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсрол олгох сургалтын хөтөлбөртэй холбон хүүхдүүддээ бага наснаас нь хоол, хүнсний талаарх зөв ойлголтыг өгч, хоол, хүнсэндээ хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зөв сонгох арга барилыг эзэмшүүлж, хоолны жор, технологийг зааж олон удаагийн давтамжтайгаар дадлагажуулан төлөвшүүлэх нь зүйтэй.

Өнөөдрийн үүсч буй цар тахлын болон цар тахлын дараах нөхцөл байдалтай уялдуулан хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаанд дахин дүн шинжилгээ хийн, шаардлагатай тохиолдолд хүнсний салбарын эрх зүйн орчин болон бүтэц зохион байгуулалт, тогтолцооны шинэчлэл хийх шаардлагатай байна.

Батлан хамгаалахын менежментийн төлөв, хандлага

Б.Содбилэг
БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан доктор (Ph.D), дэд хурандаа

Abstract

The nature of modern defense management is determined by its ability to set specific goals and achieve them effectively. In particular, it emphasizes the management model that achieves the expected results and goals at the lowest cost, without overstating resources. Such a model of defense activity is the basis for civilian oversight of the decision-making process and policy implementation.

Keywords: *Defense management, structure, resource, organization, command*

Батлан хамгаалах төсвийн хязгаарлалт болон хөгжиж буй улс орнуудын стратегийн тэргүүлэх чиглэлүүд өөрчлөгдөж буй энэ үед батлан хамгаалах хэрэгцээнд зориулж буй хөрөнгө, нөөц, хүч хэрэгслийг хамгийн үр ашигтай зарцуулах явдал батлан хамгаалахын менежментийн гол зорилтын нэг болоод байна.

Үндэсний батлан хамгаалах бүтцийн өөрчлөлт, хөгжлийн бодлого нь үзэл баримтлалын гүн гүнзгий агуулгатай. Улс орнуудын туршлагаас үзвэл батлан хамгаалах бүтэц нь тухайн улсын улс төр, эдийн засгийн онцлогоос хамааран өөрийн гэсэн хөгжлийн замыг туулсан байдаг хэдий ч ерөнхий зохион байгуулалт, хөгжлийн зангилаа асуудлууд бүх оронд ижил байдаг учраас тэдгээрийг менежментийн нийтлэг хандлага гэж үзэж болох юм.

Батлан хамгаалах үзэл баримтлалын шинэчлэл хийхдээ үндэсний соёл, уламжлал, улс төр, гүйцэтгэх засаглал хийгээд макро түвшний менежерийн туршлага, хувийн хэвшлийн оролцоо, боловсролын салбарын хөгжил, мэргэжлийн бэлтгэл, түүнчлэн шинэчлэл, огцом өөрчлөлтийг хүлээн авахад нийгмийн бэлтгэгдсэн байдал зэрэг асуудлуудыг сайтар харгалзах үзэх нь чухал юм. Түүнчлэн улс орны зэвсэгт хүчний босоо удирдлага, батлан хамгаалах асуудлаар шийдвэр гаргах үйл явц, батлан хамгаалах нөөцийн бүрдүүлэлт болон зардлын хэмжээ, зэвсэгт хүчний зохион байгуулалтын бүтэц, байрлал зэрэг нь цэргийн аюулд хандах үндэсний (нийгэм, цэргийн) хандлагаас үлэмж хэмжээгээр хамаардаг байна. Өөрөөр хэлбэл батлан хамгаалах салбарын

хөгжил аюулыг ухамсарлан ойлгож хүлээн авах нийгмийн сэтгэл зүйн түвшингээс хамаардаг гэсэн үг юм. Хэрэв аюул занал хангалттай өндөр байгаа бол батлан хамгаалах шийдвэрийг хүлээн авах үйл явц хурдан байх ба батлан хамгаалах салбарын ил тод байдалд төдийлөн ач холбогдол өгдөггүй, тиймээс батлан хамгаалах бүтэц илүү цэрэгжсэн байдаг бөгөөд иргэний байгууллага үүнд хүлээцтэй ханддаг байна. Харин улс орон гадаад, дотоод аюулгүй байдлын орчин харьцангуй тогтворжсон, стратегийн тогтвортой байдал хангагдсан тохиолдолд батлан хамгаалах салбар нийгмийн бусад салбаруудтай ижил түвшинд үнэлэгддэг байна.

Тэнцвэржүүлэгч үр ашигтай тогтолцоо нь аливаа ардчиллын нэг чухал шинж байдаг бөгөөд улс төрийн засаглалын эрх мэдэл төвлөрсөн бус байж, засаглалын ямарваа нэг монополчлол гарах боломжгүй, төрийн (захиргааны) удирдлагын хяналтыг хэрэгжүүлэх боломж юм.

Тэнцвэржүүлэгч үр ашигтай тогтолцоо нь эрх мэдэл ба үүрэг, хариуцлагаа жигд хуваарилахад түлхүү анхаардаг. Энэ нь батлан хамгаалах бодлогыг тодорхойлох болон хэрэгжүүлэх механизмыг зөв төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм[1]. Ийм орчинд эрх мэдлийн давуу болон хүчтэй тал нь захиран тушаах боломж гэхээсээ илүү баримт нотолгоо, итгүүлэн үнэмшүүлэх бололцоонд оршиж байгаа юм. Магадгүй энэ тогтолцоо нь хугацаа зарцуулдаг, нарийн төвөгтэй, зардал ихтэй үрэлгэн байж болох ч эрх мэдлээр далимдуулан өөрийн хүсэл зоригийг тулган хүлээлгэх болзошгүй хандлагаас хамгаалж байгаа хэрэг юм.

Энэ хүү тогтолцоог хэрэгжүүлэх гол үндэс суурь “сайн засаглал” бөгөөд сайн засаглал (good governance) нь эдийн засаг болон нийгмийн хөгжлийн бүхий л салбарт үр нөлөөгөө өгдөг. Сайн засаглалын үзэл баримтлал нь эдийн засгийн тогтвортой байдал, улс төрийн дэглэм (заавал ардчилсан байх албагүй), хууль ёс, төр ба иргэний нийгмийн тогтоосон хүрээг багтаадаг байна[2]. Сайн засаглалыг хэрэгжүүлэхийн тулд дараах асуудлыг зайлшгүй харгалзвал зохино. Үүнд:

- **Оролцоо:** бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс шийдвэр гаргах үйл явцад шууд болон шууд бус хэлбэрээр өөрсдийн хүлээн зөвшөөрсөн институцээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангагдсан байх. Энэхүү оролцоо нь үг хэлэх, хурал цуглаан зохион байгуулах болон тэдгээрт оролцох эрх дээр тулгуурласан байдаг.
- **Стратегийн алсын хараа:** нийгмийн хөгжлийн урт хугацааны бодлогод хүнийг хөгжүүлэх асуудлын тэргүүн зэрэгт тавих асуудал юм. Хөгжлийн энэ хэтийн төлөвийг хэрэгжүүлэхтэй холбоотой түүх-

[1] "The Art of Defense Policy": Scope, Components, Relationships (but no Algorithms)», Connections: The Quarterly Journal 5, No. 1 (Spring-Summer2006); 15-34; http://consortium.pims.org/ the-art-of-defense-policy-scope-components-relationships-but-no-algorithms. Joan Corkery, ed., Governance: Concepts and Applications (Brussels: IIAS Working Group, International Institute for Administrative Studies, 1999), 368-371. Paul Hirst, «Democracy and Governance», in Debating Governance: Authority, Steering, and Democracy, ed. Jon Pierre (Oxford: Oxford University Press, 2000), 13-35.

[2] United Nations Development Program (UNDP), Governance and Sustainable Human Development(1997)., UNDP and Governance, Experiences and Lessons Learned, http://mirror. Undp.org/magnet/docs/gov/Lessons1.htm

соёлын болон нийгмийн асуудлыг үүнд хамааруулан үздэг байх,
- **Уян хатан байдал:** төрийн болон олон нийтийн институцүүд харилцан ойлголцож, харилцаандаа тодорхой дүрэм журам баримтлах,
- **Үр ашиг ба хэмнэлт:** Хамгийн бага зардлаар хүлээгдэж буй үр дүнд хүрэх,
- **Тайлагналт:** Засгийн газрын болон хувийн секторын түвшинд эсхүл төрийн бус байгууллагуудад шийдвэр гаргаж буй этгээд үйл ажиллагаагаа тайлагнах,
- **Тунгалаг байдал:** мэдээллийг олж авах эрх чөлөөгөөр хангагдсан байдлаар тодорхойлогдох,
- **Шударга ёс:** иргэд нийгмийн бүхий л үйл ажиллагаанд тэгш оролцох боломжтой байх,
- **Хууль, эрх зүй, ёс суртахууныг дээдлэх:** эрх зүйн хэм хэмжээ, ялангуяа хүний эрхийн талаарх хууль тогтоомж бүх хүнд адил тэгш үйлчлэх.

Эдгээрийг батлан хамгаалах менежментийн хүрээнд харгалзан үзэх учиртай. Яагаад гэвэл батлан хамгаалах тогтолцоо өөрөө нийгмийн нэг бүрэлдэхүүн, эд эс мөн бөгөөд бодлогын, нийгмийн хөгжлийн үйл явцад идэвхтэй оролцдог институц юм. Нөгөө талаар батлан хамгаалах бодлого бол зөвхөн батлан хамгаалах бүтцийн хүрээнд төдийгүй төр ба нийгмийн өөр бусад олон субъектийн үйл ажиллагаанд хэрэгжиж байдаг. Гэхдээ батлан хамгаалах салбар нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой учраас иргэний байгууллагад хэрэглэдэг нийтлэг практикийг ашиглахдаа сайтар тунгаан бодсон байх учиртай[3].

Энэ бүх үүргүүдийг харгалзан батлан хамгаалах салбарын удирдлагын зохион байгуулалтын тодорхой бүтцийг бий болгох шаардлагатай. Энэ нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд: улс төрийн удирдлага, цэргийн удирдлага болон батлан хамгаалах менежментийн асуудлыг хамааруулж авч үздэг. Эдгээр нь хоорондоо нягт уялдаатай байх боловч тус бүрдээ үзэл баримтлал, мэргэжлийн онцлог, манлайлах чадварыг шаарддаг байна. Нэг ижил үзэл баримтлал, загварыг удирдлага болгон дээрх гурван үүргийг бүгдийг нэгэн зэрэг гүйцэтгэх боломжгүй бөгөөд батлан хамгаалах салбарын үр ашигтай, тунгалаг, хяналттай байдлыг хангах нь дээрх бүтцийн үйл ажиллагааны зохицол хэрхэн бүрдсэн байдлаас хамаардаг[4].

Зарим шинжээчид батлан хамгаалах салбарыг хувийн салбарыг удирдаж болдог шиг “томоохон бизнес бүтэц” гэж үзэхийг санал болгодог. Үзэл баримтлалын үүднээс үзвэл энэ нь үүргийн шинжээр нөхцөлдсөн томоохон үйлдвэрлэлийн байгууллагын үзэл баримтлал ба туршлагад суурилсан "батлан хамгаалах менежментийн үзэл баримтлал"-ыг

[3] Jason Dempsey, Jay Parker, and Thomas Sherlock, «Introduction to Civil-Military Symposium: Public Administration and Management», Public Administration and Management10, no. 2 (2005): 57-60.

[4] Gary Miller, «Above Politics: Credible Commitment and Efficiency in the Design of Public Agencies», Journal of Public Administration Research and Theory10, no. 2 (2000): 289-328, cited by Tansu Demir and Ronal Nyhan, ibid

нэвтрүүлэх хандлага юм. Бодит байдал дээр "батлан хамгаалах салбарын бүтээгдэхүүн"-ий нарийвчилсан шинжилгээ нь улс төр, нийгэм-сэтгэл зүйн үүднээс үзвэл дээрх агуулгад төдийлөн нийцэхгүй нь харагдаж байна. Батлан хамгаалах салбарын "бүтээгдэхүүн" гэдэгт зөвхөн зэвсэгт хүчний байлдах чадварыг багтааж болохгүй юм[5]. Гэхдээ нийгэм улс төрийн аюулгүй байдлын мэдрэмжийн хувьд улс орны статус, үндэстний шинж чанар, бусад орнуудтай тогтоосон харилцаа, ардчилал болон ардчилсан засаглалыг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байдал нь чухал үзүүлэлт болдог. Ийм шаардлагыг хэрэгжүүлэх нь батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд цогц ба ялгавартай хандлагыг хэрэглэх ёстой болохыг харуулж байна.

Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа нь боловсон хүчний, зэвсэг, цэргийн техникийн нийлүүлэлт ба үйлчилгээний, дэд бүтэц ба эд хөрөнгийн, батлан хамгаалах хөтөлбөр ба эрсдэлийн менежментүүдээс бүрддэг байна.

Төрийн бусад байгууллага ба батлан хамгаалах салбар нь харилцан шүтэлцээтэй байдаг. Өөрөөр хэлбэл иргэний нийгэмтэй нийтийн удирдлага болон батлан хамгаалах байгууллага адил түвшинд холбогддог.

Батлан хамгаалах салбарын хувьд нийтийн удирдлагын үзэл баримтлал нь улс төрчид болон захиргааны ажилтнуудаас гадна цэргийн мэргэжилтнүүд удирдлагын субъект болж байгааг харгалзах учиртай. Эдгээр гурван тал нь цэргийн байгууллагын хувьд "үхлийн гурвалжин" болдог. Энэ пирамидын дээр улс төрийн удирдлага байна гэдэг нь логик утгын хувьд зөрчилгүй боловч зарим орнуудад үүнд эргэлзээтэй ханддаг тал харагддаг бөгөөд цэргийн удирдлагыг Жанжин штаб шууд эсхүл хэлбэр төдий төрийн тэргүүн (батлан хамгаалахын сайдад биш) хэрэгжүүлдэг байна. Энэ тохиолдолд Жанжин штабын сонирхол нь улс төрчдөд батлан хамгаалах асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөгч цорын ганц байгууллага байх, төрийн байгуулалтын шатлалаар аль болох цөөн тооны институцид захирагдах хүсэлтэй (наад зах нь батлан хамгаалах яамны захиргаанд биш байх) байдаг. Энэ нөхцөл байдал нь иргэн-цэргийн харилцаа болон батлан хамгаалах үр ашигтай тогтолцоог бий болгоход дараах асуудлыг үүсгэдэг байна. Үүнд:

- Цэргийн мэргэжлийн удирдлага болон төрийн захиргааны удирдлагын хоорондын харилцааны тэнцвэрийн хангах дотоод механизм суларна;
- Цэргийн мэргэжлийн дээд удирдлагад батлан хамгаалах асуудлаар хоёрдмол санаа бодол гарч болзошгүй;
- Иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учрах;
- Штаб болон боловсон хүчний бүтэц, үүргийн давхардал гарах;
- Менежментийн орчин үеийн арга хэрэгслийг хэрэглэх боломжгүй байдаг (Жанжин штаб цэвэр захиргааны үүргийг гүйцэтгэхдээ дайны үеийн штаб шиг ажилладаг).

[5] (Department of Public Administration, University of Kansas) и мэр Джон Налбандян нар уг «Reflections of a 'Pracademic' on the Logic of Politics and Administration», Public Administration Review54, no. 6 (November-December 1994): 531-536

Өөр нэг хувилбар бол цомхон батлан хамгаалах яамны бүтцийг ашиглах явдал юм. Энэ нь тайван цагт болон дайны үед зэвсэгт хүчний командлагч нь улс төрийн албан тушаалтан байх ба гол төлөв ерөнхийлөгч эсхүл батлан хамгаалахын сайд энэ үүргийг гүйцэтгэдэг байна. Цэргийн мэргэжлийн удирдлагын үүрэг нь тодорхой эрх бүхий улс төрчдөд зориулан зөвлөмж боловсруулах, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд оршино. Энэ үед цэргийн мэргэжлийн ба төрийн захиргааны удирдлагын үйл ажиллагааны зохистой харьцааг тогтоох замаар дотоодын тэнцвэрийг хангадаг байна. Цэргийн болон иргэний удирдагчдын санал бодол нэгдээгүй тохиолдолд эл маргааныг шийдвэрлэх үүргийг батлан хамгаалахын сайд хүлээдэг нийтлэг хандлага байна.

Улс төрийн болон захиргааны удирдлагын үүрэг, хариуцлагын хоорондын зөрчлийг арилгах зорилгоор батлан хамгаалахын сайд өөрөө улс төрийн агуулгаар томилж болох албан тушаалтнуудын тоог хуулиар тогтоосон хэм хэмжээний хүрээнд тодорхойлох нь бий. Улс төрийн сэдлээр томилогдсон бүх албан тушаалтнууд батлан хамгаалахын сайдтай хамт томилогдож, сайдыг огцроход хөдөлмөрийн хууль, эрх зүйн зохицуулалтаас үл хамааран мөн нэгэн зэрэг уг албанаас чөлөөлөгддөг байна. Гэвч аль ч тохиолдолд улс төрийн томилгоонуудын энэ загвар хуулийн зохицуулалтыг шаарддаг.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. «The Art of Defense Policy»: Scope, Components, Relationships (but no Algorithms)», Connections: The Quarterly Journal 5, No. 1 (Spring-Summer2006); 15-34; http://consortium.pims.org/ the-art-of-defense-policy-scope-components-relationships-but-no-algorithms.
2. Joan Corkery, ed., Governance: Concepts and Applications (Brussels: IIAS Working Group, International Institute for Administrative Studies, 1999).
3. Paul Hirst, «Democracy and Governance», in Debating Governance: Authority, Steering, and Democracy, ed. Jon Pierre (Oxford: Oxford University Press, 2000), 13-35.
4. United Nations Development Program (UNDP), Governance and Sustainable Human Development(1997). UNDP and Governance, Experiences and Lessons Learned, http://mirror. Undp.org/magnet/docs/gov/Lessons1.htm
5. Jason Dempsey, Jay Parker, and Thomas Sherlock, «Introduction to Civil-Military Symposium: Public Administration and Management», Public Administration and Management10, no. 2 (2005): 57-60.
6. 30. Richard H. Kohn, «An Essay on Civilian Control of the Military», American Diplomacy2, no. 1 (1997), www.unc.edu/depts/diplomat/AD_Issues/amdipl_3/kohn.html
7. Gary Miller, «Above Politics: Credible Commitment and Efficiency in the Design of Public Agencies», Journal of Public Administration Research and Theory10, no. 2 (2000): 289-328, cited by Tansu Demir and Ronal Nyhan, ibid
8. (Department of Public Administration, University of Kansas) «Reflections of a 'Pracademic' on the Logic of Politics and Administration», Public Administration Review54, no. 6 (November-December 1994): 531-536

Төрийн захиргааны төв байгууллага дахь мэдлэг солилцох боломж, нөхцөл

С.Алтанчимэг
УАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэнгийн
шинжээч, доктор (Ph.D)

Abstract

Mongolia has to improve its competitiveness in the international arena and ensure security, economy, and social development. There is an urgent need for knowledge management to be introduced in the public administration which implements the policy.

In knowledge management, there are many processes, such as creation, storage, sharing, and application of knowledge but knowledge sharing is the clue in knowledge management (Scarbrough, 2003) and the most paramount factor in organizational success (Davenport T., 1996).

The purpose of this research article is to examine the current state of knowledge sharing among civil servants and how it is influenced by knowledge-sharing opportunities.

The survey covered officials from some ministries and used a combination of quantitative and qualitative research methods to collect data. The data obtained from the questionnaire, which is a quantitative survey method, was processed using spss 22 software and performed reliability analysis, identification statistical analysis, and factor analysis.

The results of the quantitative analysis were confirmed by focus group discussions and documentary research as a qualitative research method.

In this paper, an attempt would have taken to discuss the barriers and benefits of knowledge sharing in Mongolian ministries.

Keywords: *Administrative management, development of key knowledge, knowledge sharing, knowledge management, knowledge sharing opportunities.*

Оршил

Улсын Их Хурал (УИХ)-ын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим нь “мэдлэгт суурилах” гэж заасан байдаг.

Монгол Улс төрийн бодлогын баримт бичгүүддээ мэдлэгт суурилсан хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон бөгөөд “мэдлэг, мэдлэгийн удирдлага эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилд суурь хүчин зүйл

болно” гэж үздэг боловч бодит байдалд энэ нь төдийлөн биеллээ олохгүй байна. Тухайлбал, “Дэлхийн өрсөлдөх чадварын судалгааны төв” буюу “IMD World Competitiveness Center” хүрээлэнгээс жил бүр дэлхийн 63 улсын ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, тэтгэх, хөгжүүлэх боломжийг үнэлж, жагсаадаг бөгөөд Монгол Улс 2016 онд 60 дугаарт жагсаж байсан бол, 2017, 2018 онуудад 62 дугаарт, 2019, 2020 онуудад 63 дугаарт жагсжээ.

Дэлхийн Банкнаас 2020 оны есдүгээр сард хийсэн “Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг институци болон хүний хөгжилд чиглүүлэх нь” сэдэвт эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгааны тайланд “Монгол Улс хүн болон институци гэх мэт өгөгдсөн суурь баялгаа дутуу ашиглаж байгаагаас үйлдвэрлэл болон экспортыг төрөлжүүлж чадахгүй, улмаар дэлхийн түүхий эдийн зах зээлээс улам хараат болж, үнийн савалгаанд улам өртөмтгий болж байгаа бөгөөд энэ мухардмал байдлаас гарахын тулд уул уурхайд хөрөнгө оруулдаг шигээ “оюун ухаан” буюу хүн болон институцээ хөгжүүлэхэд дорвитой хөрөнгө оруулдаг болох хэрэгтэй” гэж дүгнэсэн байна.

Улс орны хөгжилд олон хүчин зүйлс нөлөөлдөг боловч төрийн захиргааны үйл ажиллагаа нь мэргэшсэн, тогтвортой байх зарчимд тулгуурлан мэдлэгийг оновчтой удирддаг улс орнууд хөгжлийн өндөр түвшинд хүрч, дэлхийн тавцанд өрсөлдөх чадвар нь нэмэгдэж, ард иргэд нь чинээлэг, аз жаргалтай, аюулгүй амар тайван амьдарч байгааг олон улс орны бодит хөгжлийн туршлага харуулж байгаа билээ.

Монгол Улс олон улсын тавцан дахь өрсөлдөх чадвараа сайжруулах, улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжил, аюулгүй байдлыг хангахын тулд төрийн бодлого оновчтой, тогтвортой байх явдал чухлаар тавигдаж байна. Энэ үүднээс төрийн бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зохицуулалт хийх, бодлогыг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага (ТЗБ)-д мэдлэгийг үр дүнтэй удирдах зайлшгүй шаардлага тулгарч байна. Гэтэл ТЗБ-д мэдлэгийг удирдах үйл ажиллагаа хангалттай биш байгааг тодорхой судалгааны үр дүнгүүдээс харж болох юм. Тухайлбал,

Удирдлагын академийн судалгааны баг 2010 онд ТЗБ-ын менежментийн чадамжийн индексийг тодорхойлох судалгаа хийж, шинжээчийн үнэлгээ хийлгэхэд мэдлэг инновацийн менежмент 49.3 оноогоор үнэлэгдсэн байсан нь менежментийн чадамжийн бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн бага үнэлгээ байжээ.

2017 онд доктор Д.Байгалын удирдсан УА-ийн судалгааны багийн ”ТЗБ дахь гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилт” судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн захиргааны албан хаагчийн үр дүнгийн гэрээний агуулгад багтсан мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтыг дүгнэхэд төвөгтэй, шалгуур үзүүлэлтгүй байсан байна.

Түүнчлэн Монгол Улсад Засгийн газар солигдох болгонд улс төрийн нөлөөгөөр төрийн байгууллагуудыг үндэслэл сайтай судалгаагүйгээр

бүтцийн өөрчлөлт нэрээр нэгтгэх, салгах, шинээр байгуулах болон татан буулгаж, удирдлага болон албан хаагчдыг сольж өөрчлөн улмаар нэгэнт бүрдсэн мэдлэгийг сарниулж байгаа (Төрийн албаны зөвлөлийн ажлын тайлан, 2015) төдийгүй мэдлэг солилцох боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал, ТЗБ-ын бүтцийн өөрчлөлтөөр янз бүрийн баримт, материалууд болох ил мэдлэг устаж үгүй болдог төдийгүй албан хаагчид тогтвортой ажиллахгүй тохиолдолд зөвхөн тухайн албан хаагчдад байдаг далд мэдлэг байгууллагад дахин хэрэглэгдэх боломжгүй болдог байна.

Мэдлэгийн удирдлагын хувьд мэдлэгийг бүтээх, хадгалах, солилцох, хэрэглэх зэрэг олон үйл явц байдаг боловч мэдлэг солилцох нь мэдлэгийн удирдлагын гол үйл явц (Scarbrough, 2003) бөгөөд байгууллагын амжилтын чухал хүчин зүйл нь (Davenport T., 1996) болдог.

2015 онд хийсэн "Төрийн байгууллагын бүтээмж"[1] судалгааны хүрээнд хийсэн "Төрийн захиргааны албан хаагчид (ТЗАХ)-ын ажлын гүйцэтгэлийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлс"-ийн индексийн дүнгээс үзэхэд "мэдлэгээ дээшлүүлэх" гэсэн хүчин зүйл нь ажлын гүйцэтгэлд хамгийн их нөлөөтэй хүчин зүйл байсан бөгөөд мэдлэгийг дээшлүүлэхэд мэдлэг солилцоо чухал үүрэгтэй байна.

Мэдлэг солилцоог амжилттай хэрэгжүүлэхэд байгууллага нь албан хаагчдын мэдлэгийг байгууллагын мэдлэг болгохын төлөө хичээдэг байх, байгууллагын гишүүд харилцан бие биетэйгээ мэдлэгээ солилцох боломж, нөхцөлийг хангаж ажиллах ёстой юм.

1. Төрийн захиргааны төв байгууллага дахь мэдлэг солилцоо

Мэдлэгийн менежмент нь хэрэгтэй мэдлэг, мэдээллийг зөв хүнд нь оновчтой цаг хугацаанд нь хүргэх системийг бүрдүүлэх, байгууллагын хувьд хуучирсан мэдлэгийг хурдан танин мэдэж оношлодог байх, түүнчлэн ажилтнууд шинэ мэдлэг бий болгож түүнийгээ байгууллагын зорилгод идэвхтэй ашиглах, өөрчлөгдөж буй орчинд хурдан дасан зохицохыг дэмждэг.

Мэдлэг нь хөгжлийн түлхүүр бөгөөд нэг талаас хүний тархинд бий болсон ойлголт, үзэл баримтлалын нэгдэл, нөгөө талаас хүмүүсийн тархинаас цаасан дээр буусан эсвэл комьютерт цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа аливаа үйл ажиллагаанд шууд ашиглах боломжтой системтэй, нотолгоотой мэдээллээс бүрддэг.

Байгууллагын мэдлэг нь хувь хүний мэдлэгийг албан хаагчдад хүргэх чадвараас хамаардаг бөгөөд энэ үйл ажиллагааг мэдлэг солилцоо

[1] Судалгааг ССХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан С.Алтанчимэг доктор С.Энхсайханы удирдлагын дор хийж гүйцэтгэсэн болно. Судалгаанд ТЗБ-ын төлөөлөл болгон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудыг хамруулсан. Үүнд: Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөрийн яамдуудаас нийт 95 албан хаагч, Төрийн захиргааны орон нутгийн төлөөлөл болгон Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүргээс 121 албан хаагч,Сэлэнгэ, Дархан, Баянхонгор, Дорнод аймгуудаас 87 албан хаагч, хороодын 56 албан хаагч болон төрийн захиргаанд ажиллахын зэрэгцээ Удирдлагын академид суралцаж байгаа 60 сонсогч буюу нийт 419 ТЗ-ны албан хаагчид буюу 19000 ТЗ-ны албан хаагчдын төлөөллийг хангах түүврээс санал асуулгаар судалгаа авсан.

дэмжиж өгдөг (Szulanski, 1996) байна. Байгууллага нөөц бололцоогоо өөр өөр цаг үед ижил төстэй ажлуудад ашиглах нь нэмэлт зардлыг бий болгож, орлого буурахад хүргэдэг бөгөөд энэ байдлаас гарахад мэдлэг солилцоо чухал үүрэгтэй байдаг.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан «Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх» журамд албан хаагчийн төлөвлөгөө нь гүйцэтгэлийн зорилт, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт гэсэн хэсгээс бүрдэхээр заагаад мэдлэг чадварыг хандлага, ёс зүй, ур чадвараас тусад нь үнэлэхээр тусгажээ. Энэхүү эрх зүйн баримтад тусгасан бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны албан хаагчдын мэдлэг солилцоо гэсэн ойлголтыг тодорхойлох шаардлагатай гэж үзлээ.

Төрийн байгууллагууд шаталсан бүтцэд тулгуурлаж үйл ажиллагаа нь явагддаг бөгөөд хэвтээ болон босоо чиглэлд мэдлэг солилцох боломжтой. ТЗБ дахь мэдлэг солилцоог мэдлэгийг хуримтлуулах болон түгээх гэсэн харилцан хамаарал бүхий үйл явцын нэгдэл гэж үзсэн болно. Төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдын мэдлэг солилцоог Төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал ба товч тодорхойлолтод[2] суурилан загварчиллаа (Зураг 1).



Зураг 1. Төрийн албан хаагчийн мэдлэг солилцоо

Эх сурвалж: Судлаачийн хийсэн судалгааны үр дүн

Загварчлалын дагуу туслах түшмэл хэвтээ чиглэлд буюу адил түвшний албан хаагчидтай салбарын холбогдох хууль, эрх зүйн мэдлэг, захиргааны ажил хэргийн мэдлэг, менежментийн мэдлэгийг солилцох боломжтой. Харин босоо чиглэлд буюу дэс түшмэлээс салбарын хөгжлийн бодлого, үзэл баримтлалын мэдлэгийг хуримтлуулах боломжтой юм.

Дэс түшмэлийн хувьд хэвтээ чиглэлд буюу адил түвшний албан хаагчидтай салбарын хөгжлийн бодлого, үзэл баримтлалын мэдлэгийг солилцох боломжтой. Харин босоо чиглэлд туслах түшмэлд салбарын

[2] Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт

хөгжлийн бодлого, үзэл баримтлалын мэдлэгийг түгээх, ахлах түшмэлээс тухайн салбарын мэргэжлийн нарийвчилсан мэдлэгийг хуримтлуулах боломжтой.

Ахлах түшмэлийн хувьд хэвтээ чиглэлд буюу адил түвшний албан хаагчидтай тухайн салбарын мэргэжлийн нарийвчилсан мэдлэгээ солилцох боломжтой. Харин босоо чиглэлд эрхэлсэн түшмэлээс тухайн газар эсвэл хэлтсийн түвшин дэх нарийвчилсан мэдлэгийг хуримтлуулах, дэс түшмэлд тухайн салбарын мэргэжлийн нарийвчилсан мэдлэгээ түгээх боломжтой юм.

Эрхэлсэн түшмэлийн хувьд хэвтээ чиглэлд буюу адил түвшний албан хаагчидтай тухайн газар эсвэл хэлтсийн түвшин дэх нарийвчилсан мэдлэгийг солилцох боломжтой. Харин босоо чиглэлд тэргүүн түшмэлээс улс орны хөгжлийн бодлогын мэдлэгийг хуримтлуулах, ахлах түшмэлд тухайн газар эсвэл хэлтсийн түвшин дэх нарийвчилсан мэдлэгийг түгээх боломжтой байна.

Тэргүүн түшмэлийн хувьд хэвтээ чиглэлд буюу адил түвшний албан хаагчидтай улс орны хөгжлийн бодлогын мэдлэгийг солилцох боломжтой. Харин босоо чиглэлд эрхэлсэн түшмэлд улс орны хөгжлийн бодлогын мэдлэгийг түгээх боломжтой.

2. Төрийн захиргааны төв байгууллага дахь мэдлэг солилцох боломж, нөхцөл:

Байгууллагын зүгээс албан ёсоор буюу дотоод дүрэм, журмаар мэдлэг солилцох боломж, нөхцөлийг зохицуулж өгсөн тохиолдолд тухайн байгууллага, түүний нэгж, хэсгүүд, байгууллагын гишүүдийн мэдлэг солилцох үйл ажиллагааны нэгдэл хангагддаг байна.

Мэдлэгийг үр ашигтай солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын үйл явцыг уялдуулах нь маш чухал бөгөөд байгууллагын хүрээнд албан хаагчид мэдлэг нь байгууллагын хувьд ач холбогдолтой гэдэгт итгэл үнэмшилтэй байх хэрэгтэй (De Long, 1997).

Байгууллагын мэдлэг солилцох орчин бий болгох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд байгууллага нь бүх нэгжийн түвшинд уялдаатай, нээлттэй байх ёстой бөгөөд байгууллага нь албан хаагчдыг хуучин болон шинэ мэдлэгээ солилцох, хэрэглэхэд түлхэц өгч, дэмжих ёстой (Riege, 2005) байна.

Төрийн захиргааны байгууллагад мэдээллийн урсгал дээрээс доош, эсвэл доороос дээш чиглэлтэй байх бөгөөд удирдлагын гол зангилаа хамгийн дээд хэсэгт оршдог. Хэдийгээр төрийн байгууллагуудын бүтэц ихэвчлэн шаталсан, пирамид хэлбэртэй байдаг бөгөөд дээрээсээ доошоо зааварчлага өгч ажил гүйцэтгүүлж, доороосоо дээшээ ажлынхаа тайланг бичиж мэдээлэх үүрэг хүлээсэн тогтолцоо үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн нарийн хуваарьтай, удирдлагын шатлал, хэлхээ сайтар хөгжсөн, ажилтнуудын ажлын уялдаа холбоо хатуу тогтсон дүрэм журам, стандартаар зохицуулагддаг учраас албан тушаалын ялгаанаас шалтгаалаад зарим тохиолдолд мэдлэг солилцох явцад хүмүүст янз бүрийн

бэрхшээл тулгардаг байна. Байгууллагын зүгээс албан хаагчдад гардаг бэрхшээлийг анхаарч, хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай юм.

Мэдлэг солилцоход дараах бэрхшээлүүд гардаг байна. Үүнд:

- Албан хаагч аливаа мэдлэгийн талаар тодорхой ойлголтгүйгээр түүний талаар лавлах боломжгүй байдаг.
- Аливаа байгууллагын хувьд зарим албан хаагч нь хангалттай мэдлэгтэй, зарим нь дулыхан мэдлэгтэй байдаг. Мэдлэгийн нөөц нь хязгаарлагдмал тул мэдлэгтэй хүмүүс бусадтай харилцан мэдлэг солилцоно гэж найддаггүй учраас өөрсдийнхөө мэдлэгийг солилцохын тулд цаг хугацаа зарцуулж, хүчин чармайлт гаргахыг хүсдэггүй.
- Мэдлэг солилцох нь сайн дурын үндсэн дээр явагддаг ба үр дүнтэй мэдлэг солилцох нь хувь хүмүүс эзэмшсэн мэдлэгээ тодорхойлох хүсэл эрмэлзлэл болон мэдлэгээ солилцох шаардлагаас хамаардаг.
- Мэдлэг солилцох нь түгээгч ба хуримтлуулагчийн аль алиных нь хүчин чармайлтаас хамаардаг. Хэрэв боломжит мэдлэг түгээгч байгууллага дотор хэн нэгэн түүний эзэмшсэн мэдлэгийг сонирхох болно гэдгийг мэдэхгүй бол мэдлэгээ идэвхтэй солилцохгүй . Үүнтэй адилаар, хэрэв боломжит хүлээн авагч нь тухайн мэдлэгийн талаар мэдэхгүй тохиолдолд тухайн мэдлэгийг эрэлхийлж чадахгүй.
- Хүний зан чанар нь харилцан адилгүй байдаг учраас ёс суртахууны гажуудал нь мэдлэг солилцоход сөрөг байдлаар нөлөөлөх магадлалтай байдаг бөгөөд энэ нь шинэ мэдлэгийг үнэлэх чадвартай холбогддог.

Байгууллагад мэдлэг солилцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь дээрх бэрхшээлийг даван туулахад чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь дараах үзүүлэлтүүдээр тодорхойлогддог байна. Үүнд:

1. **Мэдлэгээ сайжруулах бололцоо.** Мэдлэгээ сайжруулах нь байгууллагын албан хаагчдын өсөлт, хөгжил болон мэдлэг чадварыг нэмэгдүүлэх боломжоос хамаардаг. Энэ нь албан хаагчид мэргэжлээрээ суралцах, ажилдаа өсөж дэвжих байдлаар тодорхойлогдоно.
2. **Уялдаа холбоо.** Байгууллага ажилтныг ажлын байранд үр дүнтэй ажиллахад шаардлагатай мэдлэг, туршлага, байгууллагын бодлого, шийдвэрийн талаарх ойлголт, мэдлэгийг албан болон албан бус байдлаар олж авах нөхцөлөөр хангаж өгөх шаардлагатай. Мэдлэг олж авах нь ажилтанд шийдвэр гаргах, шуурхай ажиллах боломжийг олгохоос гадна ажилтан шаардлагатай мэдлэгээ олж авснаар бусад ажилтнуудад хэрэгтэй мэдлэгийг дамжуулах нөхцөлийг бий болгодог.
3. **Нөөцийн хүртээмж.** Мэдлэг солилцоонд нөөцийн хүртээмж нөлөөлдөг бөгөөд энэ нь мэдлэг солилцоход шаардагдах нөөц (мэдлэг, санхүү, материал гэх мэт) болон цаг хугацааны хангамжаар тодорхойлогдоно.
4. **Дэмжлэг туслалцаа.** Мэдлэг солилцоонд дэмжлэг туслалцаа чухал үүрэгтэй. Энэ нь албан хаагчид, хамтран ажиллагсад болон удирдлагын эргэх холбоо, санал хүсэлт, удирдамжийг хамардаг бөгөөд ердийн болон ердийн бус эрсдэлтэй нөхцөл байдалд албан

бус байдлаар арга хэмжээ авах чадвараар илэрхийлэгддэг байна (Kanter, 1993).

Төрийн захиргааны төв байгууллага дахь мэдлэг солилцох боломж, нөхцөлийг тодорхойлох нь:

Өнөөгийн Төрийн захиргааны төв байгууллагын мэдлэг солилцох боломж, нөхцөлийн бодит байдлыг тодорхойлохын тулд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 69, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 92, Эрүүл мэндийн яамны 65, Зам, тээврийн хөгжлийн яамны 90, Сангийн яамны 47, Хууль зүй, дотоод хэргийн яамны 48 албан хаагч буюу нийт 411 албан хаагчийг оролцуулан судалгааг[3] хийсэн.

Уг судалгааны хүрээнд түүврийн тоог бодитой тооцоолохын тулд Үндэсний статистикийн хорооноос 2018 онд гаргасан "Монгол Улсын төрийн албан хаагчдын тоо, бүтэц, өөрчлөлт (1995-2017 он)" гэсэн бичиг баримтыг үндэслэн Төрийн захиргааны төв байгууллагын нийт 1539 албан хаагчдыг судалгааны эх олонлог гэж үзэж тооцооллыг хийв (Хүснэгт 1).

Судалгааны түүврийн хэмжээг (https://www.surveysystem.com/ss-calc.htm) интернетийн хаягаар хандаж, түүврийн тооцооллын нээлттэй програмыг ашиглан тодорхойлов.

Хүснэгт 1. Түүврийн тооцооллын дүн

Үзүүлэлт	Тэмдэглэгээ	Утга
Түүврийн хэмжээ	n	363
Итгэх төвшин	α	0.05
Алдааны зөвшөөрөх хэмжээ	e	4.5%
Эх олонлогийн хэмжээ	N	1539[4]

Эх сурвалж: (Г.Жаргал, Н.Сэлэнгэ , 2020)

Судалгааны оновчтой түүвэр олонлогийг тодорхойлохын тулд Монгол Улсын Засгийн газрын бүтцийг 1992 оноос 2020 оны 4 сар хүртэлх хугацааг хамруулж, харьцуулан авч үзлээ.1992-2020 онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний дагуу бүтэц нь харьцангуй тогтвортой байсан гэж үзээд Ерөнхий чиг үүргийн яамдын төлөөлөл болгон Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг, Чиглэлийн яамдын төлөөлөл болгож Эрүүл мэндийн яамыг, харин 1992-2020 онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний дагуу бүтэц нь харьцангуй тогтворгүй буюу өөрчлөгдөж байсан гэж үзээд Ерөнхий чиг үүргийн яамдын төлөөлөл болгон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг, Чиглэлийн яамдын төлөөлөл болгож Зам, тээврийн хөгжлийн яамыг уг судалгаанд хамруулахаар сонгож авсан (Хүснэгт 2).

[3] 2020 онд ҮАБЗ-ийн ССХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан С.Алтанчимэг тус судалгааг хийсэн байна.

[4] Үндэсний статистикийн хороо - "Монгол Улсын төрийн албан хаагчдын тоо, бүтэц, өөрчлөлт (1995-2017 он)", 2018

Хүснэгт 2. Мужилсан түүвэр

	Ерөнхий чиг үүргийн яам	Чиглэлийн яам
1992-2020 онд засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний дагуу бүтэц нь харьцангуй тогтвортой яамд	• Байгаль орчин, аялал жуулчлалын яам • Батлан хамгаалах яам • Гадаад харилцааны яам • Сангийн яам • Хууль зүй, дотоод хэргийн яам	• Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам • Эрүүл мэндийн яам • Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1992-2020 онд засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний дагуу бүтэц нь харьцангуй тогтворгүй яамд	• Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	• Зам, тээврийн хөгжлийн яам • Барилга, хот байгуулалтын яам • Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам • Эрчим хүчний яам

Эх сурвалж: "Монгол Улсын төрийн албан хаагчдын тоо, бүтэц, өөрчлөлт (1995-2017 он)"

Судалгаанд хамрагдсан ТЗБ-ын мэдлэг солилцох боломж, нөхцөлийг тодорхойлохын тулд мэдлэг солилцох боломж, нөхцөл хувьсагчийн тодорхойлолт болон шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, асуулгын анкетыг боловсруулж тоон судалгааг хийсэн. (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Мэдлэг солилцох боломж, нөхцөл хувьсагч

Тодорхойлолт	**Шалгуур үзүүлэлт**	**Хэмжүүр**
1. Мэдлэг солилцох боломж, нөхцөл (БХЗ)		
Албан хаагчийн мэдлэг солилцоонд байгууллагын зүгээс нөлөөлөх хүчин зүйлс.	**Мэдлэгээ сайжруулах бололцоо** 1. Би ажлаасаа урам зориг авдаг. 2. Би ажил дээрээ шинэ мэдлэг олж авдаг. 3. Би бүхий л мэдлэгээ ажилдаа дайчилдаг. **Уялдаа холбоо** 1. Байгууллагын газар, хэлтсийн ажил уялдаатай. 2. Шууд удирдлагын эрх мэдэл сайн. 3. Байгууллагын газар, хэлтсүүд нээлттэй. **Дэмжлэг, туслалцаа** 1. Би ажлаа сайжруулах боломжтой саналыг авдаг. 2. Би хэрэг болохуйц санаа эсвэл асуудал шийдвэрлэх зөвлөгөөг авдаг.	5 - Санал бүрэн дүүрэн нийлнэ. 4 - Санал нийлнэ. 3 - Зарим талаар санал нийлнэ. 2 - Санал нийлэхгүй. 1 - Мэдэхгүй.

	Нөөцийн хүртээмж 1. Надад ажил гүйцэтгэх цаг хугацаа хүрэлцээтэй. 2. Шаардлагатай тохиолдолд ажилд хэрэг болох мэдлэгийг бусад албан хаагчдаас богино хугацааны дотор авах боломжтой.	

Эх сурвалж: Мэдлэг солилцох боломж, нөхцөл (Kanter, 1993)

Уг судалгааны хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Зам, тээврийн хөгжлийн яамдын эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах яамны газрын дарга, ахлах түшмэлийн ангилалд хамаарах яамны хэлтсийн дарга нар болон албан хаагчдыг хамруулсан ярилцлагын материалд агуулгын шинжилгээ хийж, тоон судалгааг баталгаажуулав. Үүнд:

Судалгаанд хамрагдсан яамдын газар, хэлтсийн дарга нартай ярилцлага хийхээр төлөвлөсний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 9, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 10, Эрүүл мэндийн яамны 6, Зам, тээврийн хөгжлийн яамны 8 нийт 33 газар, хэлтсийн дарга нартай ярилцлага хийсэн.

Албан хаагчидтай ярилцлага хийхээр төлөвлөсний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 11, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 6, Эрүүл мэндийн яамны 5, Зам, тээврийн хөгжлийн яамны 7 нийт 29 ахлах мэргэжилтэнтэй ярилцлага хийв.

Түүнээс гадна Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Зам, тээврийн хөгжлийн яамны баримт материалуудад агуулгын шинжилгээ хийж, тоон судалгааны дүнг баталгаажуулав.

Тоон шинжилгээ:

Найдвартай байдлын шинжилгээ

Хувьсагч 10-аас дээш үзүүлэлттэй байх тохиолдолд кронбах альфа коэффициентийн утга >0.7 байх ёстой (Wong,K.Y. & Aspinwall,E., 2005).

10 үзүүлэлттэй мэдлэг солилцох боломж, нөхцөл хувьсагчийн кронбах альфа коэффициентийн утга 0.861 буюу “1” утга руу дөхсөн сайн үзүүлэлттэй гарсан бөгөөд үзүүлэлтүүд хувьсагчаа илэрхийлж чадаж байгаагаас гадна хувьсагчийн дотоод уялдаа нь найдвартай болох нь нотлогдсон.

Тодорхойлох статистик шинжилгээ

Мэдлэг солилцох нөхцөл, боломж хувьсагчийг 10 үзүүлэлтээр тодорхойлж хэмжихээр өгөгдлийг цуглуулсан.Тодорхойлох статистик шинжилгээний дүнгээс үзэхэд мэдлэг солилцох боломж, нөхцөлийн үнэлгээ дунд зэрэг гарсан байна (Хүснэгт 4).Үүнд:

Хүснэгт 4. "Мэдлэг солилцох боломж, нөхцөл" хувьсагчийн дундаж утга, стандарт хазайлт, хэлбийлт, оройн хэлбэр

№	Үзүүлэлт	Дундаж утга	Стандарт хазайлт	Хэлбийлт	Оройн хэлбэр
1	Би ажлаасаа урам зориг авдаг.	3.74	0.807	-0.247	-0.100
2	Би ажил дээрээ шинэ мэдлэг олж авах боломжтой.	3.78	0.868	-0.433	0.131
3	Би бүх мэдлэгээ дайчилж ажлаа хийдэг.	4.14	0.763	-0.812	1.202
4	Манай яамны газар, хэлтсүүдийн ажил үүргийн хуваарилалт нь тодорхой бөгөөд уялдаатай	3.23	0.985	-0.128	-0.403
5	Би ажилдаа хэрэгтэй баримт, бичгийг шууд удирдлагын зөвшөөрөлтэйгөөр байгууллагын аль ч газар, хэлтсээс хэдийд ч авах бүрэн боломжтой.	3.34	0.984	-0.376	-0.263
6	Манай байгууллагын газар, хэлтсүүд мэдээллээ харилцан солилцож ажилладаг.	3.14	0.945	-0.111	-0.138
7	Миний онцгой чадварын талаарх мэдээлэл манай байгууллагад байдаг.	3.07	1.095	-0.366	-0.429
8	Би ажилдаа хэрэг болохуйц санаа болон асуудлыг зөв шийдвэрлэх зөвлөгөөг бусдаас авах боломжтой.	3.63	0.858	-0.840	1.357
9	Миний хувьд оногдсон ажлаа гүйцэтгэх цаг хугацаа хүрэлцээтэй байдаг.	3.36	0.907	-0.175	-0.341
10	Би шаардлагатай тохиолдолд ажилдаа богино хугацааны дотор яаралтай тусламж авах боломжтой.	3.34	0.971	-0.443	0.249

Эх сурвалж: Судлаачийн хийсэн шинжилгээний үр дүн

1. Мэдлэгээ сайжруулах бололцоонд 1-3 дугаар үзүүлэлт буюу ажлаасаа урам зориг авах, ажил дээрээ шинэ мэдлэг олж авах боломж, бүх мэдлэгээ дайчилж ажлаа хийдэг гэсэн үзүүлэлтүүдийг багтааж үзэж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүд санал асуулгаар 3.74-4.14 оноогоор үнэлэгдсэн бөгөөд эхний хоёр үзүүлэлт дунд зэрэг үнэлэгджээ.
2. Уялдаа холбоонд 4-6 дугаар үзүүлэлт буюу манай яамны газар, хэлтсүүдийн ажил үүргийн хуваарилалт нь тодорхой бөгөөд уялдаатай, би ажилдаа хэрэгтэй баримт, бичгийг шууд удирдлагын зөвшөөрөлтэйгөөр байгууллагын аль ч газар, хэлтсээс хэдийд ч авах бүрэн боломжтой, манай байгууллагын газар, хэлтсүүд мэдээллээ харилцан солилцож ажилладаг гэсэн үзүүлэлтүүдийг багтааж үзэж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүд нь санал асуулгын дүнгээр 3.14-3.44 оноогоор дунд зэрэг үнэлэгдсэн байна.
3. Дэмжлэг туслалцаанд 7-8 дугаар үзүүлэлт буюу миний онцгой чадварын талаарх мэдээлэл манай байгууллагад байдаг, би ажилдаа хэрэг болохуйц санаа болон асуудлыг зөв шийдвэрлэх зөвлөгөөг бусдаас авах боломжтой гэсэн үзүүлэлтүүдийг багтааж үзэж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүд нь санал асуулгын дүнгээр 3.07-3.63 оноогоор дунд зэрэг үнэлэгдсэн байна.
4. Нөөцийн хүртээмжэд 9-10 дугаар үзүүлэлт буюу миний хувьд оногдсон ажлаа гүйцэтгэх цаг хугацаа хүрэлцээтэй байдаг, би шаардлагатай тохиолдолд ажилдаа богино хугацааны дотор яаралтай тусламж авах боломжтой гэсэн үзүүлэлтүүдийг багтааж үзэж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүд нь санал асуулгын дүнгээр 3.34-3.36 оноогоор дунд зэрэг үнэлэгдсэн байна.

Судалгаанд оролцсон яамдын мэдлэг солилцох боломж, нөхцөл хувьсагчдын нэгдсэн дүнг харьцуулав (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Яамдын мэдлэг солилцох боломж, нөхцөлийн харьцуулалт

Мэдлэг солилцох боломж, нөхцөл	**Эрүүл мэндийн яам**	**Зам, тээврийн хөгжлийн яам**	**Байгаль орчин, аялал жуулчлалын яам**	**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам**	**Сангийн яам**	**Хууль зүй, дотоод хэргийн яам**
Би ажлаасаа урам зориг авдаг.	3.62	3.74	3.80	3.61	4.11	3.60
Би ажил дээрээ шинэ мэдлэг олж авах боломжтой.	3.77	3.71	3.79	3.52	4.17	3.88

Би бүх мэдлэгээ дайчилж ажлаа хийдэг.	**4.23**	**4.09**	**4.09**	**3.97**	**4.49**	**4.15**
Манай яамны газар, хэлтсүүдийн ажил үүргийн хуваарилалт нь тодорхой бөгөөд уялдаатай.	**2.83**	3.16	3.21	3.20	3.89	3.38
Би ажилдаа хэрэгтэй баримт, бичгийг шууд удирдлагын зөвшөөрөлтэйгөөр байгууллагын аль ч газар, хэлтсээс хэдийд ч авах бүрэн боломжтой.	3.23	3.39	3.20	3.41	3.68	3.27
Манай байгууллагын газар, хэлтсүүд мэдээллээ харилцан солилцож ажилладаг.	3.05	3.14	**2.97**	3.22	3.68	**2.96**
Миний сайн хийдэг зүйлийн талаарх мэдээлэл манай байгууллагад байдаг.	2.86	**3.01**	3.12	**2.88**	3.47	3.10
Би ажилдаа хэрэг болохуйц санаа болон асуудлыг зөв шийдвэрлэх зөвлөгөөг бусдаас авах боломжтой.	3.46	3.64	3.65	3.60	4.02	3.50
Миний хувьд оногдсон ажлаа гүйцэтгэх цаг хугацаа хүрэлцээтэй байдаг.	3.15	3.59	3.34	3.32	**3.30**	3.31
Би шаардлагатай тохиолдолд ажилдаа богино хугацааны дотор яаралтай тусламж авах боломжтой.	3.08	3.50	3.35	3.36	3.57	3.21
Дундаж	**3.3**	**3.5**	**3.4**	**3.4**	**3.8**	**3.4**

Эх сурвалж: Судлаачийн хийсэн шинжилгээний үр дүн

Хүснэгт 5-аас үзэхэд Сангийн яамны албан хаагчдын үзүүлэлт

хамгийн өндөр 3.8 оноотой байхад Эрүүл мэндийн яамны албан хаагчдын үзүүлэлт хамгийн бага 3.3 оноо авчээ.

Тодорхойлох статистик шинжилгээний дүнг харьцуулан үзэхэд 1992-2020 онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний дагуу бүтэц нь өөрчлөгдөөгүй яамдын төлөөлөл болох Сангийн яамны албан хаагчдын мэдлэг солилцох боломж, нөхцөл хамгийн сайн, харин Эрүүл мэндийн яамны албан хаагчдын мэдлэг солилцох боломж, нөхцөл хамгийн сул байна.

Чанарын шинжилгээ:

Судалгаанд хамрагдсан яамдын мэдлэг солилцох боломж, нөхцөлийн бодит дүр зургийг тодорхойлохын тулд удирдах ба гүйцэтгэх түвшний албан хаагчдын ярилцлага болон баримт бичгийн агуулгын шинжилгээнд тулгуурлан чанарын шинжилгээг хийлээ.

Ярилцлагад хамрагдсан удирдлага болон албан хаагчид "мэдлэг солилцох боломж, нөхцөлийг байгууллагын зүгээс албан ёсоор анхаарч ажиллах хэрэгтэй" гэж үзэж байна.

Ярилцлагад оролцсон удирдах түвшний албан хаагчид "байгууллагын зүгээс албан хаагчдын мэдлэг солилцооны уялдааг хангах хэрэгтэй" гэж үзэж байлаа(Шигтгээ 1).

Шигтгээ 1:

Мэдлэгээ тууштай, хуримтлуулахдаа урам зориг авдаг байх хэрэгтэй, ажлыг зөв зохион байгуулах, ажлын уялдааг хангах, багаар ажиллах, орон тоог зохицуулах, хамтын ажиллагааг хангах хэрэгтэй.

Албан хаагчийн сайн хийдэг зүйлийн талаарх мэдээлэл байгууллагад байх хэрэгтэй боловч байдаггүй, цаг хугацааны бэрхшээл ихтэй, байгууллагын зүгээс албан хаагчдын мэдлэг солилцооны уялдааг хангах хэрэгтэй байна.

Эх сурвалж: Ярилцлагын судалгаанд хамрагдсан удирдах түвшний албан хаагчид

Ярилцлагад оролцсон гүйцэтгэх түвшний албан хаагчдын зүгээс мэдлэг солилцоог байгууллагын зүгээс албан ёсоор зохицуулсан механизм байхгүй, ажлын ачаалал их байдаг, байгууллага дотор төдийгүй гаднаа ч мэдлэг солилцох боломж, нөхцөл хязгаарлагдмал байна" гэж үзэж байна (Шигтгээ 2).

Шигтгээ 2:

Мэдлэг солилцоог байгууллагын зүгээс албан ёсоор зохицуулж өгөхгүй болохоор ажлын цр дүн, бүтээмж муудаж, хүмүүс өөрийгөө хөгжүүлье, суръя гэсэн тэмүүлэлгүй болдог.

Яамны түвшинд мэдлэг солилцох цйл ажиллагаа харьцангуй нээлттэй биш байдаг, хувь хүний ажиллах цаг хязгаарлагдмал учраас мэдлэг, мэдээллийг нээлттэй солилцох боломж муутай, хязгаарлагдмал байна.

Байгууллагын албан хаагчдад мэдлэг солилцох арга туршлага байхгүй, мэдээлэл олж авахад хэцүү байдаг, тайлангаа авахад төрийн албан хаагчдын

тогтвортой бус байдлаас болж хүмүүс ажлаа мэдэхгүй байна, газар, хэлтсийн удирдлага тогтворгүй байна, дарга, мэргэжилтэн бүгдээрээ өмнө нь ажиллаж байсан хүнээс мэдээлэл очиж авдаг, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөс болж хүндэрдэг, харьяа байгууллагаас мэдээлэл авахад нууц гээд өгдөггүй, байгууллагаараа мэдлэг солилцох цед мэдээлэл нь хязгаарлагдмал, удирдлага, байгууллагын зүгээс нэгдсэн арга хэмжээ байдаггүй, удирдлага ажлыг жигд хуваарилдаггүй, ажлаар дардаг, ажлын байрны дарамт, мэдээллээ хуваалцдаггүй, даргад мэдээлэл нь байдаг боловч өгдөггүй, юу хүсээд байгаагаа тодорхой мэдээлдэггүй, ажлаар дараад байхаар заримыг нь хагас дутуу хийнэ, хагас, бүтэн сайнд сууж ажилладаг, та л хийх ёстой гэдэг, зарим тохиолдолд мэдлэгээ солилцоход удирдлага болон мэргэжилтнүүд хойрго ханддаг, хоорондоо уялдаа холбоо муу.

Тухайн ажилтанд чаддаг, чадвартай зүйл их байгаа түүнийг нь үнэт зүйл гэж хараад түүнийг нь яаж байгууллагад үр дүнтэй хэрэглэх вэ? гэдэг дээр хүний нөөцийн стратеги боловсруулах хэрэгтэй. Мэдлэг солилцох асуудал дээр менежментээ сайжруулах шаардлагатай, хязгаарлагдмал байна.

Эх сурвалж: Ярилцлагын судалгаанд хамрагдсан гүйцэтгэх түвшний албан хаагчид

Тус судалгаанд хамрагдсан яамдын баримт бичигт агуулгын шинжилгээ хийж үзэхэд “байгууллагын дотоод дүрэм, журамд мэдлэг солилцох боломж, нөхцөлийг тодорхой тусгаж өгөөгүй байгаа нь мэдлэг солилцох боломж, нөхцөл сайн хангагдахгүй байх шалтгаан болжээ” гэж үзэхээр байна.

Дүгнэлт:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим нь “мэдлэгт суурилах” гэж заасан байдаг. Түүнчлэн Монгол Улс төрийн бодлогын баримт бичгүүддээ мэдлэгт суурилсан хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон бөгөөд “мэдлэг, мэдлэгийн удирдлага эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилд суурь хүчин зүйл болно” гэж үздэг боловч бодит байдалд үр дүн нь хангалтгүй байна.

Монгол Улс олон улсын тавцан дахь өрсөлдөх чадвараа сайжруулах, улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжил, аюулгүй байдлыг хангахын тулд төрийн бодлого оновчтой, тогтвортой байх явдал чухлаар тавигдаж байна. Төрийн бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зохицуулалт хийх, бодлогыг хэрэгжүүлдэг төрийн захиргааны төв байгууллага (ТЗТБ)-д мэдлэгийг үр дүнтэй удирдах зайлшгүй шаардлага тулгарч байгаа боловч энэ үйл ажиллагаа хангалттай биш байна.

ТЗТБ нь мэдлэг солилцох боломж, нөхцөлийг албан ёсоор анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санал:

ТЗТБ болох яамд мэдлэг солилцох боломж, нөхцөлийг хангахдаа

дараах үйл ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Албан хаагч ажлаасаа урам зориг авах, ажил дээрээ шинэ мэдлэг олж авах боломжийг хангаж өгөх,
- Яамдын газар, хэлтсүүдийн ажил үүргийн хуваарилалтыг маш тодорхой, уялдаатай болгох,
- Албан хаагч ажилдаа хэрэгтэй баримт, бичгийг шууд удирдлагын зөвшөөрөлтэйгөөр байгууллагын аль ч газар, хэлтсээс хэдийд ч авах бүрэн боломжийг хангах,
- Яамдын газар, хэлтсүүд мэдлэг, мэдээллээ харилцан солилцож ажиллах боломжийг хангах,
- Яамдын албан хаагчдын онцгой чадварын талаарх мэдээллийг албан ёсоор баримтжуулж эргэлтэнд оруулах,
- Албан хаагч ажилдаа хэрэг болохуйц санаа болон асуудлыг зөв шийдвэрлэх зөвөлгөөг бусдаас авах боломжийг хангах,
- Албан хаагчийн мэдлэг солилцох албан ба албан бус үйл ажиллагааг дэмжиж ажиллах шаардлагатай байна.

ТЗТБ нь нэн ялангуяа “албан хаагч ажлаасаа урам зориг авах, ажил дээрээ шинэ мэдлэг олж авах” боломж, нөхцөлийг хангасан заалтыг байгууллагын дотоод дүрэм, журамдаа тусгаж, мөрдүүлэх хэрэгтэй байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

УИХ-ын тогтоол

1. УИХ-ын 2010 оны 48 дүгээр тогтоол

Засгийн газрын тогтоол

2. ЗГ-ын 2020 оны 218 дугаар тогтоол
3. ЗГ-ын 2019 оны 275 дугаар тогтоолын хавсралт

Төрийн албаны зөвлөлийн тайлан

4. ТАЗ-ийн ажлын тайлан, 2015

Монгол эх сурвалжууд

5. Байгал Д. (2017). Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилт’’ судалгаа. Улаанбаатар.
6. Жаргал Г., Сэлэнгэ Н. (2020). Судалгааны арга зүйд суралцах нь . УБ: Арилдал ХХК.
7. Удирдлагын академи (2010). ТЗБ-ын менежментийн чадамжийн индексийг тодорхойлох судалгаа
8. Энхсайхан С., Алтанчимэг С. (2015). “Төрийн байгууллагын бүтээмж”

Гадаад эх сурвалжууд

9. Davenport, T. (1996). Working knowledge:How organizations manage what they know. Boston: Harvard Business School Press.
10. De Long, D. (1997). Building the knowledge- based organization: How culture drives knowledge behaviors. Centers for Business Innovation- Working Paper.
11. IMD World Competitiveness Center,2016-2020

12. Kanter, R. (1993). Men and women of corporation(2-ed). New York: Basic Books.
13. Riege, A. (2005). Three - dozen knowledgesharing barriiers managers must consider. Journal of Knowledge Management 9(3), 18-35.
14. Scarbrough, H. (2003). Knowledge management.
15. Szulanski, G. (1996). Exploring internal stickiness: Impediments to the transfer of best practice within the firm. Strategic Management Journal 17, 27-43.
16. Wong,K.Y. & Aspinwall,E. (2005). An empiral study of the important factors for knowledge- management adoption in the SME sector. Journal of Knowledge Management,9(3).
17. World Bank, "Mining and Intelligence: Focusing Natural Resources on Institutional and Human Development," 2020

Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагааны бодлого, чиг хандлага

Т.Мөнх-Оргил
БХЭШХ-ийн Энхийг дэмжих олон улсын судалгааны төвийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа

Abstract

UN policy documents define the foreign and domestic policy positions and trends of UN member and non-member countries. In particular, UN peacekeeping policies have a direct and indirect impact on member states' roles and responsibilities to the community. Mongolia became a full member of the United Nations in 1961. Since 2002, he has served as a military and police officer in UN peacekeeping missions. This is evidence of the successful implementation of the state policy to ensure Mongolia's national security through political and diplomatic means. In recent years, the international security environment has changed at an unpredictable rate, making it difficult to predict cooperation and foreign relations between countries, leading to changes in international peacekeeping policy and its traditional activities. This calls for some countries to reconsider their security and defense policies.

Therefore, Mongolia should be more sensitive to changes in international relations, be more sensitive to the interests of cooperating foreign countries in participating in international peacekeeping operations, and give priority to Mongolia's national security and fundamental interests in any level of solution. It is also important to expand the opportunities, advantages and benefits of international relations within the legal framework.

Keywords: *United Nations, peacekeeping, policy and cooperation, security.*

Үндсэн хэсэг

НҮБ-ын үндсэн зорилго дэлхийн улс орнуудын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, түүнийг зөрчигчдийн эсрэг хамтын арга хэмжээ авах, үндэстэн хооронд нөхөрсөг харьцааг бий болгох, олон улсын хамтын ажиллагаа, үүний дотор эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэг, хүний эрхийг хүндэтгэх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээс гадна эдгээр зорилгыг биелүүлэхэд гишүүн улс орнуудыг холбогч үндсэн цөм нь болдог. Энэ ч утгаараа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа бол олон улсын аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. НҮБ-аас энхийг сахиулах ажиллагааг чадавхжуулах, үр дүнтэй болгох нэлээдгүй

арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдаг. Ялангуяа 1990-ээд оноос хойш НҮБ хүйтэн дайны дараах дэлхийн улс төрийн шинэ нөхцөл байдалд дэлхийн энх тайван аюулгүй байдлыг хангахад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны гүйцэтгэх үүргийн талаар тодорхой санал, санаачилгыг дэвшүүлж ажилласан. Энэхүү санал, санаачилгууд нь НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын томилсон "Хараат бус бие даасан ажлыг хэсэг"-ийн шалгалтын дүнд үндэслэгдэж тухайн үеийн бодлогуудыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага байгааг тодорхойлж байсныг шинжилж дараах байдлаар цаг хугацааны хувьд тоймлон танилцуулж байна.

Нэг. 1999 онд НҮБ-ын нарийн бичгийн дарга асан Кофи Аннан энхийг сахиулах ажиллагааны явц, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх цаашид баримтлах бодлогыг тодорхойлох зорилгоор "Хараат бус бие даасан ажлыг хэсэг"-ийг томилон ажиллуулсан. Энэ ажлын хэсгийн илтгэлд 1995 оноос өмнөх энхийг сахиулах ажиллагаа сөргөлдөгч талуудын зэвсэгт мөргөлдөөнийг хянадаг байсан бол 1995 оноос хойших ажиллагаа бол зэвсэгт мөргөлдөөнийг хянах болон зогсоох үүрэгтэйгээр явагддаг болсон нь энхийг сахиулах гэхээсээ илүүтэй энхийг бүтээх чиглэлтэй болсон нь НҮБ стратегийн түвшний бодлогыг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна гэсэн саналыг дэвшүүлсэн. Тухайлбал Босни Херцеговина, Хайти, Сьерра Леон зэрэг улс орнууд тэнд үүрэг гүйцэтгэж байсан энхийг сахиулагчдаас тухайн улсын төр засгийг босгох, хууль тогтоох болон аюулгүй байдлыг хангах салбарт шинэчлэл хийхэд дэмжлэг туслалцаа үзүүлж өгөхийг хүссэн нь НҮБ-ын уламжлалт энхийг дэмжих ажиллагааны арга барил, түүний тогтоосон зарим хууль, дүрэм, журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа талаар санал дэвшүүлсэн[1] байдаг.

Хоёр. 2000 онд "Хараат бус бие даасан ажлыг хэсэг"-ийг дахин НҮБ-ын хээрийн ажиллагаануудад илгээж энхийг сахиулах ажиллагаанд үнэлгээ хийсэн. Энэхүү үнэлгээг "Брахимын илтгэл" гэж нэрлэдэг бөгөөд уг илтгэлд олон талт энхийг сахиулах ажиллагааг хөгжүүлэх шаардлага байгааг хэд хэдэн үндэслэлээр тодорхойлсон байдаг. Тухайлбал орчин үед болж байгаа зэвсэгт мөргөлдөөнд НҮБ хэрхэн хүний аюулгүй байдлыг хангах, энгийн иргэдийг хамгаалахад гүйцэтгэх үүрэг, тухайн ажиллагааны газар оронд тухайн улсын хууль ёсны засаг захиргааны нэгжийг бий болгох, мөн түүнчлэн орон нутагт нь бие даасан хууль ёсны засаг захиргааны нэгжийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд энхийг сахиулах үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатайг илтгэсэн.

Гурав. 2009 онд энхийг сахиулах ажиллагааны өмнө тулгамдаж буй хүндрэлүүдийг тодорхойлж, тэдгээрийг даван туулах арга хэмжээг тусгасан "Шинэ хэтийн төлөв" хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрт дараах арга хэмжээг онцлон тусгасан байдаг. Үүнд:

- Энхийн үйл явцыг хамгаалах, дотоодын хямралын дараа засаглалын чадавхыг сэргээх үйл явцад дэмжлэг үзүүлэх;

[1] Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. 35 ISBN 978-3-319-99105-4

- Ажиллагааны эхний шатанд бий болсон энх тайван, тогтвортой байдлыг урт хугацааны энхийг цогцлоох зорилтуудтай уялдуулан холбох;
- Хямрал, мөргөлдөөний үед энгийн иргэдийг аюул, заналаас хамгаалах;
- Энхийн үйл явцад оролцогч бусад байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааны чиглэлүүдийг тусгасан байдаг[2].

Дөрөв. 2014 онд НҮБ-ын нарийн бичгийн дарга Бан Ки Мүн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа болон улс төрийн тусгай ажиллагаануудад үнэлэлт дүгнэлт хийх Хараат бус Ажлын хэсгийг томилон ажиллуулсан. Энэ ажлын хэсэг 2013 оны 4 сард эхэлсэн Мали дахь ЭСА (MINUSMA), 2014 оны 4 дүгээр сараас эхэлсэн Төв Африкийн Нэгдсэн улс дахь ЭСА (MINUSCA) гэсэн 2 хээрийн ажиллагаанд хяналт, шалгалт явуулж үнэлгээ хийсэн байдаг. Уг ажлын хэсгийн тайланд НҮБ-ын төв штабын алдаатай төлөвлөлт, оновчтой бус мандат, буруу томилгоонууд зэргээс болж энхийг сахиулагчид ажиллагааны газар оронд амь насаа алдсан гэж дүгнэсэн байдаг. Мөн түүнчлэн Бүгд Найрамдах Өмнөд Судан болон Ардчилсан Конго зэрэг аюулгүй байдлын эрсдэлийн зэрэг өндөртэй улс оронд НҮБ-ын том бүтэц, зохион байгуулалттай ажиллагааг дэлгэн үйл ажиллагаа явуулахад цаг хугацаа алдах, үүрэг гүйцэтгэлтийн хувьд уян хатан биш байсан зэрэг сорил, бэрхшээлтэй тулгарч байгааг онцолж НҮБ өөрөө энхийг сахиулах ажиллагааны бүтэц, энхийг сахиулагчийн гүйцэтгэх үүргийг орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний онцлогтой уялдуулан өөрчлөн шинэчлэх нь зүйтэй гэж үзсэн байдаг.

Дээр дурдсан 4 удаагийн ажлын хэсгийн тайлангуудад тусгагдсан асуудлууд бусад бие даасан хараат бус судлаачид, судалгааны байгууллагуудын судалгаа шинжилгээний ажлын тайлангуудаар бататган дурдагдаж, хоорондоо ижил төсөөтэй ажиглалт, шүүмж, үнэлгээ, дүгнэлтэй байсан нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд хийсэн үнэлгээг бодитой болохыг харуулсан. Тиймээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд дараах 4 чухал шинэчлэлийг зайлгүй хийх шаардлагатайг тодорхойлсон байдаг. Үүнд;

- *Улс төрийн аргаар шийдвэрлэх*. Энэ нь энх тайвныг цэрэг техникийн хүчээр биш, улс төрийн аргаар шийдвэрлэх нь чухал болохыг онцолдог. Үүний тулд сөргөлдөгч талуудтай, улс болон улс бус тоглогчидтой нээлттэй ил тод шударга хэлэлцээрийг явуулах, зэвсэгт мөргөлдөөн болж байгаа үед энгийн иргэдэд учрах хохирлыг аль болох хамгийн бага байлгах арга замуудыг сонгох, ингэхдээ энгийн иргэд болон дайсагнагч этгээдийн улс төр, итгэл үнэмшил, шашин шүтлэг, гарал угсаа, цэргийн хамаарал зэргийг үл харгалзан хүний эрхийг хүндэтгэх;
- *Энхийг сахиулах ажиллагааны цар хүрээг зөв тодорхойлох*. Энхийг

[2] http://www.un.org/en/peacekeeping/operations/newhorizon.shtml.

сахиулах ажиллагаа нь тухайн ажиллагааны газар орон дээрх цагийн байдалд богино хугацаанд эрх зүйн хүрээнд хариу арга хэмжээ авахын тулд уян хатан, мэргэшсэн цомхон хүн хүч, зэвсэгт техникийг сонгон үүрэг гүйцэтгүүлэх;

- *Энх тайван, аюулгүй байдлын төлөөх дэлхийн болон бүс нутгийн туншлэлийг хөгжүүлэх*. Тухайн үүссэн хямралд хурдан, үр дүнтэй хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх гишүүн орнууд болон бүс нутгийн байгууллагуудтай түншлэлийн харилцааг зохистойгоор өргөжүүлэх.
- *НҮБ-ын бодлогын тувшин дэх баримт бичгүүд тухайн ажиллагааны газар орон руугаа чиглэсэн, энхийг сахиулах ажиллагаа нь хүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байх*. НҮБ-ын Төв удирдлага нь ажиллагааны газар орон дээр явагдаж байгаа үйл ажиллагаа зохих хууль, дүрэм журмын дагуу үр дүнтэй, богино хугацаанд явуулахад дэмжлэг үзүүлж, чиглүүлэн удирдахад анхаарах ёстой. Ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагч зэвсэгт мөргөлдөөний хөлд нэрвэгдсэн хүмүүст туслахад мандатаар хүлээсэн үүргийнхээ дагуу амжилттай үүрэг гүйцэтгэх гэж тусгажээ.

Хараат бус Ажлын хэсгийн үнэлгээний тайланд тусгагдсан дээрх саналуудыг НҮБ-ын ЭДА-ны НҮБ-ын Нарийн бичгийн дарга, төдийгүй гишүүн улс орнууд сайшаалтайгаар хүлээн авсан байдаг.

Дээр дурдагдсан шалгалтуудын үр дүнгээр гарсан санал, зөвлөмжийн дагуу энхийг сахиулах ажиллагаануудыг дараах тогтоолын хүрээнд тусгайлсан мандатаар явуулж байна. Үүнд;

- Аюулгүй байдлын зөвлөлийн 1325 (2000) тогтоолоор эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал;
- Аюулгүй байдлын зөвлөлийн 1612 (2005) тогтоолоор хүүхэд ба зэвсэгт мөргөлдөөн;
- Аюулгүй байдлын зөвлөлийн 1674 (2006) тогтоолоор зэвсэгт мөргөлдөөнд энгийн иргэдийг хамгаалах зэрэг болно.

Тав. 2017 онд томилогдсон НҮБ-ын Нарийн бичгийн дарга Антонио Гутерришийн ажлын мөрийн хөтөлбөрт НҮБ-ын төв штабаас боловсруулж байгаа стратегийн түвшний үнэлгээ төлөвлөлтийг сайжруулах, энхийн дэмжих болон аюулгүй байдал хариуцсан албадуудын орон тооны бүтцийг өөрчлөх, НҮБ-ын нэр хүндийг унагааж байгаа сахилга бат, ёс зүйтэй холбоотой асуудал, ялангуяа бэлгийн дарамт болон хүчирхийлэлтэй холбоотой асуудалд хариуцлага тооцох арга хэмжээг чангатгахад анхаарч ажиллах[3] асуудал тусгасан байдаг. Мөн тэрээр өмнөх Нарийн бичгийн дарга нарын адил Хараат бус Ажлын хэсэг томилон Мали, Конго, Төв Африк болон Өмнөд Суданд явагдаж байгаа энхийг сахиулах ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгүүлсэн. Ажлын хэсгийн шалгалтын дүгнэлтэд үндэслэн

[3] Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. ISBN 978-3-319-99105-4

стратегийн, операцын болон тактикийн түвшинд өөрчлөлт шинэчлэлт хийх зайлшгүй шаардлага байгааг онцолсон. Тухайлбал НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа нь мандатаар хүлээсэн үүргийг биелүүлэхэд улс төрийн түвшинд шийдлүүд тодорхой биш, ажиллагааны мандат бүрхэг, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хангалттай хийгддэггүйгээс болоод энхийг сахиулагчид ажиллагааны газар оронд эрсдэлд ордог, хүн хүчний дутагдалтай, техник тоног төхөөрөмж, зэвсэглэлийн хуучирсан байдал зэрэг нь энхийг сахиулах ажиллагааны бодлогод өөрчлөлт, шинэчлэл зайлшгүй хийх шаардлагатай байгааг илэрхийлсэн байдаг.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд тулгараад байгаа дээр дурдагдсан бэрхшээлүүдийг даван туулахын тулд НҮБ-ын нарийн бичгийн дарга Антонио Гутерриш 2018 оны 3 дугаар сард Аюулгүйн Зөвлөлд "Энхийг сахиулах ажиллагаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ" (A4P) санаачилгыг танилцуулсан. Антонио Гутерришийн тодорхойлсноор энэ санаачилга нь энхийг сахиулах ажиллагааны шинэчлэлд улс төрийн үйл ажиллагааг илүүтэй дайчлах шинэ оролдлогын нэг хэсэг гэж үзсэн. A4P нь НҮБ-ын энх тайван, аюулгүй байдлын төлөөх бодлогыг боловсронгуй болгохын зэрэгцээ НҮБ-ын ажиллагааны тогтсон хэв маягийг шинэчлэн сайжруулах боломжийг эрэлхийлсэн байна. Энэхүү санаачилгад энхийг сахиулах ажиллагааны шинэчлэлийг явуулахад дараах 3 үндсэн зорилтод тулгуурлана гэж үзсэн байна. Үүнд:

Нэгд, Энхийг сахиулах ажиллагааны мандатыг үүссэн тухайн цагийн нөхцөл байдалд тулгуурлан ажиллагааны газар оронд бодитой хэрэгжих үндэслэлтэй боловсруулах;

Хоёрт, Энхийг сахиулах ажиллагааг мэргэжлийн өндөр ур чадвартайгаар аюулгүй байдлыг ханган явуулах;

Гуравт, Энхийг сахиулах ажиллагаанд чиглэсэн улс төрийн шийдвэрүүд зөв байхын зэрэгцээ, сайн зохион байгуулалттай, сайн тоноглогдсон сайн сургагдсан хүчээр ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэж тодорхойлсон.

Дээрх зорилтуудын хүрээнд "Энхийг сахиулах ажиллагаанд харилцан үүрэг хүлээх тунхаглал" гаргасныг 154 гишүүн орон дэмжиж гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэ тунхаглалд талууд энхийг сахиулах ажиллагааны шинэчлэл, цаашдын хандлагыг 8 чиглэлд тодорхойлсон. Үүнд:

1. Зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн аргаар шийдвэрлэх, энхийг дэмжих ажиллагаанд улс төрийн нөлөөллийг эрчимжүүлэх;
2. Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх болон энх тайван аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;
3. Хамгаалалтын арга хэмжээ. Энхийг сахиулах ажиллагааны хамгаалалтын арга хэмжээнүүдийг тодорхой болгох;
4. Энхийг сахиулагчдын аюулгүй байдал болон хамгаалалтыг сайжруулах;
5. Үр дүнтэй үүрэг гүйцэтгэлт болон хариуцлага хүлээх тогтолцоог

боловсронгуй болгох;
6. Энхийг бүтээн босгох болон тогтвортой тайванд энхийг сахиулагчдын байр суурь, нөлөөг бэхжүүлэх;
7. Хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд түншлэлийг хөгжүүлэх;
8. Энхийг сахиулах ажиллагааны холбогдох эрх зүй болон бие бүрэлдэхүүний ёс зүйг сайжруулах зэрэг болно.

Дээрх үүргүүдийн хүрээнд НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар дангаар, эсхүл гишүүн орнууд дангаар хийж гүйцэтгэх болон Нарийн бичгийн дарга нарын газар болон гишүүн орнууд хамтран авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг[4] боловсруулсан байна.

Гэхдээ энэхүү төлөвлөгөө операцын болон тактикийн түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээг илүүтэйгээр хөндсөн байгаа нь нэг талаар учир дутагдалтай гэж үзэж байна. Энхийг сахиулах ажиллагааны бодлого нь стратегийн түвшинд асуудлыг цогцоор авч үзэн оперативын болон тактикийн түвшинд амжилттай үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж өгөх нь энхийг сахиулах ажиллагааны өмнөө тавигдсан мандатаар хүлээсэн үүргийг амжилттай биелүүлэх үндэс болох юм.

Тиймээс НҮБ-ын энхийн ажиллагааны бодлого, цаашдын хандлагыг тодорхойлоход түүнд нөлөөлж болох дараах хүчин зүйлийг анхаарах нь чухал байна. Үүнд;

Нэгд, сүүлийн үед явагдаж байгаа зэвсэгт мөргөлдөөн, хямралт байдал илүү хурцадмал төвөгтэй болж байгаа нь НҮБ-ын систем болон бусад олон улсын тоглогч нарыг цэргийн арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс илүүтэйгээр тухайн нөхцөл байдалд тохирсон цэргийн бус ажиллагааны арга хэрэгслийг уян хатан байдлаар сонгож ашиглах хэрэгтэйг харуулж байна.

Хоёрт, энхийг сахиулах ажиллагааны үе шатуудыг цогцоор авч үзэн түүний бүхий л түвшний арга хэмжээг харилцан уялдуулах, залгамж халаатай байлгахад олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын хамтын оролцоог идэвхжүүлэх;

Гуравт, зэвсэгт мөргөлдөөн хямралаас урьдчилан сэргийлэхийн тулд бүхий л түвшинд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Хэрэв энхийг сахиулах хээрийн ажиллагааг ажиллагааны тухайн улс, газар оронд дэлгэн эхлүүлэх шийдвэр гаргаж байгаа бол эхнээс нь дуусгах хүртэлх стратегийг бодит үр дүнтэй арга хэмжээ байхаар төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг бодитоор тооцож тогтмол үнэлгээ хийж байх;

Дөрөвт, дайны дараах энхийг бүтээн босгох ажиллагааг НҮБ-ын бүхий л салбар байгууллагууд болон тухайн улс орны засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүчин чармайлтын үр дүнгээр бий болгох;

Тавд, операцын түвшинд энх тайван байдлыг тогтвортой байлгахын тулд хэлэлцээр хийх Улсын баг (Country team) үндсэн холбогч

[4] https://www.un.org/en/A4P/

зохицуулагч болж стратегийн болон тактикийн түвшинд сул, идэвхгүй, хариуцлагагүй байгаа нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үр дүнтэй болгох;

Зургаад, тогтвортой энх тайван байдлыг хангахад бүхий л түвшний нийгмийн харилцаанд оролцогчдод хүрч ажиллах, хүн төвтэй, хүн рүү чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ирээдүйд итгэх итгэлийг бий болгоход анхаарах;

Долоод, НҮБ олон талт бүс нутгийн болон дэд бүсийн тоглогчид болон иргэний нийгэмтэй түншлэх нь илүү үр дүнтэй байхыг тооцоолох зэрэг болно.

НҮБ-ын явуулсан энхийг сахиулах ажиллагааны амжилт, давуу талыг үнэлж баршгүй. Гэхдээ сүүлийн үед аюулгүй байдлын орчин таамаглашгүйгээр хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа нөхцөлд зохих хариу арга хэмжээ авахын тулд бүхий л түвшинд шат дараалсан хяналт, шинжилгээ, үнэлгээний багуудыг томилон ажиллуулж тэдгээрийн гаргасан үнэлгээнд ач холбогдол өгч эрх зүй болон зохион байгуулалтын өөрчлөлтийг хийх шаардлага урган гарсаар байна. НҮБ-ын үйл ажиллагааны үр дүн нь стратегийн түвшинд гаргаж байгаа шийдвэр, операцын түвшинд гаргаж байгаа шийдлүүд, болон тактикийн түвшний ажиллагааны амжилтаар үнэлэгдэх учраас НҮБ-ын бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжилтийг хангах нь гишүүн орнуудын олон талт оролцоогоор хэмжигдэх юм.

Гэхдээ сүүлийн үеийн олон улсын аюулгүй байдлын орчинд бий болж байгаа нөхцөл байдлаас харахад их гүрнүүдийн цэрэг улс төр, нийгэм, эдийн засгийн бодлогоос НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны ирээдүйн хандлага шууд хамаарахаар байна.

Тиймээс НҮБ энхийн ажиллагаанд тухайн бүс нутгийн түншлэлийн оролцоог нэмэгдүүлэх, операцын болон тактикийн түвшний ажиллагаанд их гүрнүүдийн оролцоог түлхүү байлгах нь их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчилдөөнийг бууруулах давуу талтай байж болох юм. Иймд НҮБ-аас бүс нутгийн болон дэд бүсийн байгууллагуудын энхийн ажиллагааны оролцоо, эрх, үүрэг, болон хариуцлагын талаарх эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгоход хамтарч ажиллах, гишүүн орнуудтай илүү ахисан түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ өөрийн бодлого, байр суурь, нөлөөллийг олон улсад бэхжүүлэх нь чухал байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. ISBN 978-3-319-99105-4
2. Emily J.Munro. Geneva Papers; Multidimensional and integrated Peace Operations: Trends and Challenges.Norwegian Ministery of Foreign Affairs.
3. Emily J.Munro. Geneva Papers; Multidimensional and integrated Peace Operations: Trends and Challenges.Norwegian Ministery of Foreign Affairs.

4. Catherine Lutz, Matthew Gutmann, and Keith Brown, Conduct and Discipline in UN Peacekeeping Operations: Culture, Political Economy and Gender Report submitted to the Conduct and Discipline Unit, Department of Peacekeeping Operations United Nations October 19, 2009, https://www.researchgate.net/publication/272243585_Conduct_and_discipline.
5. https://peacekeeping.un.org/en/action-for-peacekeeping-a4p
6. https://www.un.org/en/A4P/dashboard.shtml

Монгол Улсын Зэвсэгт хүчний эмэгтэй цэргийн алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургалтанд хамруулах хэрэгцээ, шаардлага

(Франц хэлний сургалтын жишээн дээр)

Н.Уранчимэг
УБХИС-ийн ГХСТ-ийн Франц хэлний багш, магистр

Abstract

The purpose of this study is to increase the effectiveness of foreign language training for military personnel, improve the foreign language skills of female military personnel, increase the number of female officers and sergeants with in foreign languages, to increase their participation in peacekeeping operations, and to promote gender equality

Keywords: *foreign language training, female military personnel, vocational schools, selection, military, gender equality, peacekeeping*

Оршил

Монгол Улс гадаадын олон улс оронтой батлан хамгаалах салбарын харилцаа холбоогоо улам бүр өргөжүүлэн хөгжүүлж улмаар манай орны Зэвсэгт хүчний албан хаагчид дэлхийн өнцөг булан бүрт цэргийн төрөл мэргэжлийн сургалт дамжаанд хамрагдах үүд хаалга нээлттэй болж, түүнчлэн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх болсноор тэдэнд гадаад хэлний мэдлэг, чадварын хэрэгцээ, шаардлага зайлшгүй урган гарсаар байна.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар бүхий "Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал" тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд НҮБ-ын Энхийн ажиллагааны газар (DPO)-аас 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог 15 хувьд хүргэх тухай" албан даалгаврыг цэрэг илгээгч нийт улс орнуудад ирүүлсэн болно[1].

Цэргийн мэргэжлийн эмэгтэй албан хаагчдын гадаад хэлний

[1] https://gsmaf.gov.mn/gsmaf/onePost/1175 Д.Наранжаргал: Эмэгтэй Энхийг сахиулагчдын тоо нэмэгдэнэ 2020-05-28/

мэдлэг чадварын тухай асуудал нь нэг талаар дээрх албан даалгаврын хэрэгжилтийг хангах үүднээс тухайн бодлоготой уялдан, нөгөө талаар дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа эмэгтэйчүүдийн тэгш эрх, жендерийн тэгш оролцоотой холбоотойгоор гарч ирж байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Нэг. Зэвсэгт хүчинд гадаад хэлний мэдлэгтэй эмэгтэй офицер, ахлагч нарын тоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага

Цэргийн албаны хуулийн[2] 2-р бүлгийн 10.5-д "Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана" 11.5-д "Эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаана" 11.4-д "Офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл хаана" гэж тусгажээ. Энэ хуулийн дагуу цэргийн албанд ажилладаг эмэгтэйчүүд энгийн салбарт ажилладаг эмэгтэйчүүдийг бодвол эрт тэтгэвэрт гардаг бөгөөд мэргэжил нэгтэй эрэгтэй албан хаагчидтай харьцуулахад мэргэжлийн хувьд өсөн дэмжих бололцоо цаг хугацааны хувьд тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал болох нь харагдаж байна.

Мөн түүнчлэн Монгол улсын "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн[3] 4.1.2-д "... жендэрийн эрх тэгш байдал» гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг; ойлгоно" гэсэн нь тухайн салбарт ажилладаг эмэгтэй албан хаагчдын мэргэжилдээ өсөн дэвжих үйл ажиллагааг дэмжих нь зайлшгүй чухал бөгөөд дэмжлэг үзүүлэх нэг томоохон хэлбэр бол гадаад хэлний сургалтанд хамрагдах,хамруулах тоог өсгөх явдал гэж харж байна. Ингэснээр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар бүхий "Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал" тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд НҮБ-ын Энхийн ажиллагааны газар (DPO)-аас 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог 15 хувьд хүргэх тухай" албан даалгавар биелэгдэх, биелүүлэх нэг том алхам болно.

Цаашлаад олон улсын судалгаа, хөтөлбөрүүдийг судалж үзвэл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг "Хүний хөгжлийн илтгэл"[4]-д амьдралын нөхцөл байдлыг объектив талаас нь голчлон авч үздэг. Хүний хөгжлийн гол үзүүлэлтүүд нь дундаж наслалт, бичиг үсэг тайлагдалтын түвшин, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого зэрэг байдаг (Монгол Улс 99-д эрэмбэлэгддэг).

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн хорооноос жил бүр гаргадаг "Дэлхийн аз жаргалын тайлан"-д[5] мөн л дундаж наслалт,

[2] Монгол улсын "Цэргийн албаны хууль" Уб.,\ 2016-09-01

[3] Монгол улсын "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль" Уб.,2011-02-02

[4] Эмэгтэйчүүдийн амьдралын чанар 2021 /Судалгааны тайлан/, Хамгийн сүүлд гарсан хүний хөгжлийн илтгэлтийг http://hdr.undp.org/en/2020-report хуудас 19

[5] Уг тайланг http://worldyappiness.report/archive/ линкээр үзэх боломжтой

нийгмийн халамж, авлигын түвшин, нэг хүнд ногдох ДНБ, иргэний эрх чөлөө,эрүүл мэнд зэрэг хэд хэдэн үзүүлэлтийг харгалзан улс орнуудыг жагсаадаг байна (Монгол Улс 69 эрэмбэлэгддэг).

“Numbeo” сан “Амьдралын чанарын индекс”[6]-ийг тодорхойлохдоо худалдан авалтын чадамжийн индекс, аюулгүйн индекс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний индекс, агаарын бохирдол, уур амьсгалын индекс зэргийг харгалздаг байна (2022 онд уг жагсаалтад 87 орон оролцжээ).

Дээрх судалгааны үзэхэд хүний амьдрал, аз жаргал индексийг дундаж наслалт, амьдралын чанарын тухай голчлон авч үздэг нь тодорхой харагдаж байна.

Үүнээс үндэслэн монгол хүний дундаж наслалт статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас[7] эмэгтэй 75.3 жил (эрэгтэй 67.3) гэснээс харахад харьцангуй эрт тэтгэвэрт гарч буй цэргийн мэргэжлийн эмэгтэй албан хаагчдын хувьд гэр бүлийн ашиг орлогоо нэмэгдүүлэх, өөр ажил эрхлэх, хувь хүний хөгжлийн асуудал зэргийг яаж хэрхэн зохицуулах вэ? гэдэг асуудал тавигдана..

ҮБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төв 1974 онд анх байгуулагдсан цагаасаа хойш гадаад хэлтэй цэргийн алба хаагчдыг бэлтгэж, Монгол Улсын Зэвсэгт хүчнийг чадавхжуулахад үнэтэй хувь нэмэр оруулсаар байна. Тус төв жил бүр 100 гаруй цэргийн албан хаагчдыг элсүүлэн суралцуулдаг ч эмэгтэй цэргийн алба хаагчдын тоо эрэгтэй цэргийн алба хаачидтай харьцуулахад чамлалттай байдаг. Тухайлбал, ГХСТ-ийн франц хэлний дамжааны сүүлийн 12 жилийн тоон мэдээнээс нарийвчлан судалж үзэхэд сонирхолтой судалгаа ажиглагдаж байгаа юм.

Хүснэгт 1. Франц хэлний дамжаанд суралцсан эмэгтэй албан хаагч (2010-2022)

№	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Хичээлийн жил	2010-2011	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	**нийт**
Нийт суралцагч	14	13	5	11	12	8	6	13	12	5	7	11	**117**
Эмэгтэй	**1**	**4**	**3**	**-**	**3**	**1**	**1**	**1**	**2**	**1**	**2**	**1**	**20**
Хувь	7	30	60	0	25	12.5	16.6	7.6	16.6	20	28.5	9	**17%**

Судалгаанаас харахад 2010-2022 оны хооронд франц хэлний дамжаанд 117 офицер ахлагч нар суралцаснаас 20 нь эмэгтэй цэргийн албан хаагч байгаа нь нийт суралцагсдын ердөө 17% эзэлж байна. Өөрөөр хэлбэл, жил

[6] Уг тайланг http://numbeo.com линкээр үзэх боломжтой

[7] https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_030V1&1399900м. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

бүрийн арав гаруй суралцагчдаас 1-2 эмэгтэй албан хаагч тус дамжаанд суралцсан байна. Мөн 2011-2012 оны хичээлийн жилд хамгийн өдөр буюу 4, 2013-2014 оны хичээлийн жилд хамгийн бага буюу эмэгтэй албан хаагч огт суралцаагүйг судалгаанаас харьцуулж харж болохоор байна.

Дээр дурдсан цэргийн эмэгтэй албан хаагчдаас 8 офицер (40%), 11 ахлагч (55%), 1 энгийн (5%) тус тус суралцан амжилттай төгсчээ.



Зураг 1. Франц хэлний дамжаанд суралцсан эмэгтэй офицер ахлагч (2010-2022)

Өмнө хийгдсэн болон дээрх судалгаанаас энхийг дэмжих ажиллагааны болон удирдлагын бие бүрэлдэхүүнд ажиллах эмэгтэй офицеруудын тоог нэмэгдүүлэх үүднээс гадаад хэлний сургалтанд хамрагдах бололцоо нөхцөлийг судлах тал дээр онцгой анхаарал хандуулах шаардлагатай нь харагдаж байна. Франц хэлний дамжааг амжилттай суралцан төгссөн эмэгтэй офицер ахлагч нараас сурсан франц хэлээрээ тус хэлний мэдлэгээ дээшлүүлэх болон мэргэжлийн ур чадвараа ахиулах зорилгоор гадаад улсын сургалт дамжаанд шалгаран суралцсан байдлыг судлан үзвэл, цэргийн мэргэжлийн эмэгтэй албан хаагчдын 40% (давхардсан тоогоор) Канад болон Франц улсад мэргэжил дээшлүүлсэн бол эрэгтэй албан хаагчдын тус хэлээр гадаадад суралцсан дүн 32.9 % байгаа бөгөөд энэ нь эрэгтэй албан хаагчдаас даруй 7.1%-аар илүү байгааг дараах судалгаа харуулж байна.

Хүснэгт 2. Франц хэлний дамжаанд суралцсан эрэгтэй,эмэгтэй суралцагчдын гадаад улсад мэргэжлийн болон хэлний сургалтанд суралцсан тоог харьцуулсан судалгаа

№	Суралцагч нар	ГХСТ	Эзлэх хувь	Гадаад улс	Эзлэх хувь
1	Эмэгтэй	**20**	**17.1**	**8**	**40**
2	Эрэгтэй	97	82.9	32	32.9
НИЙТ		117	100	40	34.2

Дээрх судалгаанаас үзэхэд эмэгтэй цэргийн албан хаагчдын ур чадвар, гадаад хэл сурах эрмэлзэл, хандлага сайн байгаа нь харагдаж байна.

Хоёр. Зэвсэгт хүчний эмэгтэй цэргийн албан хаагчдын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдал

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 2002 онд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд анх удаа хоёр эрэгтэй цэргийн албаа хаагч үүрэг гүйцэтгэхээр мордож байсан бол 2006 онд анхны эмэгтэй офицерыг Баруун Сахар дахь MINURSO ажиллагаанд цэргийн ажиглагчаар үүрэг гүйцэтгүүлснээр эмэгтэйчүүдийн оролцоо эхэлсэн байна.

2022 онд Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ой тохиож байна.

"...Эмэгтэй цэргийн албаа хаагчдыг энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх боломжтой гэдэг ойлголтыг баталж үүргээ нэр төртэй гүйцэтгэж ирснээс хойш өнөөдрийг хүртэл энхийг дэмжих ажиллагаанд 700 гаруй эмэгтэйчүүд оролцсон нь нийт бүрэлдэхүүний 4 хувийг, мотобуудлагын батальоны 7 хувь нь, олон улсын ажиллагаанд оролцож буй цэргийн хамгаалалтын ротын 5 хувь нь, цаашлаад цэргийн ажиглагч болон штабын офицероор 50 гаруй эмэгтэй офицер үүрэг гүйцэтгэсэн байна. Энэ тоо цаашид ч өсөх болно."гэж Энхийг дэмжих цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн Энхийг дэмжих ажиллагааны төлөвлөлтийн мэргэжилтэн дэд хурандаа Д.Наранжаргал хэвлэлд өгсөн ярилцлагадаа өгүүлжээ[8].

"НҮБ-ын мэдээллээснээр 2020 оны байдлаар 95,000 гаруй энхийг сахиулагч эмэгтэйчүүд цэргийн багт үүрэг гүйцэтгэж байгаа нь нийт энхийг сахиулагчдын 4,8% бөгөөд энэ тоог 2028 он гэхэд 15% хувьд хүргэхээр ажиллаж байна" хэмээн дурджээ.

"...Монгол Улс НҮБ-д цэрэг хандивлагч орнуудаас эмэгтэй энхийг сахиулагчдын тоогоор 26 дугаар байрт эрэмбэлэгддэг. Одоогоор 800 гаруй цэргийн албаа хаагч энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байна. Өнгөрсөн 20 жилд 13 мянга гаруй цэргийн албаа хаагч үүрэг гүйцэтгээд байгааг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал С.Ганбямба штабынхаа өнгөрсөн оны үйл ажиллагааг хэвлэлийнхэнд танилцуулах уулзалтын үеэр тодотгов"[9].


Дээрх мэдээлэлээс харьцуулан судлан үзэхэд манай улсаас 20000 гаруй цэргийн албан хаагчид энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэснээс 800 гаруй нь эмэгтэй цэргийн албан хаагчид гэж үзвэл нийт үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний 8% эмэгтэй цэргийг албан хаагчид эзэлж байна.

Энэхүү тоон үзүүлэлт нь манай орны хүн амтай харьцуулахад чамлахааргүй тоон үзүүлэлт мэт боловч дээр дурдсан "НҮБ-ийн энхийг дэмжих ажиллагааны эмэгтэй цэргийн албаа хаагчдын тоог 15 хувьд хүргэх тухай" албан даалгаврыг биелүүлэх тухайд анхаарал хандуулмаар

[8] https://gsmaf.gov.mn/gsmaf/onePost/1175 Д.Наранжаргал: Эмэгтэй Энхийг сахиулагчдын тоо нэмэгдэнэ2020-05-28/

[9] https://www.montsame.mn/mn/read/286815 Эмэгтэй энхийг сахиулагчдын тоогоор 26 дугаар байрт эрэмбэлэгдэж байна Оюундэлгэр.Б 2022-01-13

санагдана. Энэ албан даалгаварын хэрэгжилт, ЗХ-ний эмэгтэй албан хаагчдад гадаад хэлний мэдлэг олгох асуудалтай холбоотой юм. Гадаад хэлний мэдлэгтэй цэргийн эмэгтэй албан хаагчдад мэргэжлийн хувьд өсөн дэвших том боломж байгааг харуулсан жишээ тус төвийн даргаар ажиллаж байсан Бригадын генерал Г.Болор юм. Тэрээр НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны төв штабын энхийг сахиулах ажиллагааны газарт мэргэжилтнээр ажилласан анхны монгол офицер юм.



Зураг 2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон эмэгтэй албан хаагчид

Дүгнэлт

Дээрх бүх асуудалд гарц гаргалгаа болох нэг том боломж бол гадаад хэлний мэдлэг, чадварын асуудал байж болох юм. Эмэгтэй албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх тал дээр БХЯ болон ЗХЖШ-ын удирдах албан хаагчид онцгой анхаарах нь зайлшгүй чухал асуудлын нэг мөн бөгөөд ҮБХИС-ийн ГХСТ-д хичээллэдэг долоон төрлийн гадаад хэлний дамжаанд суралцах эмэгтэй офицер, ахлагч нарын тоог нэмэгдүүлэх тал дээр улам санаачлагатай ажиллаасай хэмээх саналыг дэвшүүлж байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Зэвсэгт хүчинд ажиллаж буй эмэгтэй офицер, ахлагч нарын гадаад хэлний сургалтанд хамрагдалтыг дэмжих нь батлан хамгаалах салбарт чадавхтай, үнэтэй боловсон хүчний тоог нэмэх, цаашилвал дээр дурдсан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325-р тогтоолын хэрэгжилтийг хангах төсөл төлөвлөгөө болохоос гадна эмэгтэй цэргийн албан хаагчдын ажил үүрэгтээ өсөн дэвжих болоцоог улам нээж тэдний карьерт эерэгээр нөлөөлөөд зогсохгүй цаашид тэдний нийгмийн болон эдийн засгийн асуудлаа шийдвэрлэх насан туршийн боловсрол, том боломж болох нь харагдаж байна гэж дүгнэж байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. Монгол улсын “Цэргийн албаны тухай хууль” Уб., 2016-09-01
2. Монгол улсын “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” Уб.,2011-02-02
3. “Гадаад хэлний сургалтын төвийн товч түүх” Уб., 2019
4. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь Уб., 1966
5. Бигэрмаа Р. Албан бичиг боловсруулах арга зүй Уб., 2009

6. Бямбадорж Ж. Эмэгтэйчүүдийн эрх ба жендэрийн тэгш байдал хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан гарын авлага Уб., 2014
7. Цолмон Б., Долгион А. Монгол улс дахь жендэрийн тэгш байдлын талаарх үзэл хандлага: Олон нийтийн тандалтын судалгаа-ны төслийн тайлан Уб.,\2014
8. Эмэгтэйчүүдийн амьдралын чанар 2021 /Судалгааны тайлан/,
9. Дэлхийн аз жаргалын тайлан"- http://worldyappiness.report/archive/
10. "Numbeo" сан "Амьдралын чанарын индекс" тайлан http://numbeo.com
11. Уранчимэг Н.Цэргийн гадаад хэлний сургалтын тогтолцоо, туршлага, сургамж, үр дүн I. Эрдэм шинжилгээний илтгэл Уб., 2021
12. ГХСТ-ийн франц хэлний дамжааны судалгаа 2010-2021
13. https://www.montsame.mn/mn/read/286815 Эмэгтэй энхийг сахиулагчдын тоогоор 26 дугаар байрт эрэмбэлэгдэж байна Оюундэлгэр.Б 2022-01-1
14. https://gsmaf.gov.mn/gsmaf/onePost/1175 Д.Наранжаргал: Эмэгтэй Энхийг сахиулагчдын тоо нэмэгдэнэ 2020-05-28
15. https://www.facebook.сот/ Энхийн-төлөө-эмэгтэйчүүд
16. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_030V1&1399900м Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Их ялалтад Алс Дорнодын төмөр замын гүйцэтгэсэн үүрэг

Б.Мөнхсайхан
БХЭШХ-ийн Дайн, цэргийн урлаг, судлалын төвийн дарга, доктор (Ph.D), профессор, хурандаа

Abstract

We will tell about the state of the railway and its network in the region and in the Far East (Easter), about the preparation of the railway in the theater of combat operations at the end of the World War II, how it passed through it a convoy of military and military-laden trains traveling all the way from the western border of the Soviet Union to the Pacific Ocean, and about its contribution to the great victory.

Keywords*: Far East (Easter), end of World War II, main railway line, transport.*

Оршил

Төмөр замыг дайны амин судас гэж нэрлэх нь тохиолдлын асуудал ч биш юм. ЗХУ-ын Эх орны дайны үед түүгээр ар талаас фронт руу цэрэг, байлдааны техник, галт хэрэгсэл болон шатах тослох материалыг татан авч, эсрэг чиглэлдээ хүн ам, улс ардын аж ахуйн ачаа бараг фронт орчмоос ар тал руу тээвэрлэн, дотоод тээврийг зохион байгуулж байв.

ЗХУ-д автозамын болон агаарын тээвэр нь тухайн үед төмөр замаас ч сул хөгжсөн байлаа. Дайны жилүүдэд төмөр замаар нийт тээврийн 70-аас дээш хувийг гүйцэтгэж байсан бөгөөд төрөл бүрийн тээврийг хослуулахдаа ялангуяа төмөр зам, усан (тэнгисийн) тээвэрт чухал ач холбогдол өгч байв.

1. Манжуурын цэргийн дэд бүтэц дэх төмөр зам

XX зууны эхнээс Алс дорнодын гүрнүүд Монголыг түүхий эдийн арвин эх булаг, 1920-оод оноос улс төрийн нөлөөгөө тэлэх газар нутаг, 1930-аад онд цэргийн чухал түшиц хэмээн үзэж байв.

Коминтерны шинжээч С.Дашинский 1932 онд өгүүлэхдээ "Манжуурын стратегийн ач холбогдол нь тэрээр ЗХУ-ын алс дорнодын бүс нутаг, БНМАУ-ыг түрэмгийлэх түшиц газар болж байгаад оршино. Манжуурт төмөр зам барих асуудал нь Манжуурын асуудлыг шийдэх гол түлхүүр болдог юм. Ийм ч учраас өнгөрсөн онд Японы империализмаас гадаад бодлогынхоо энэхүү чухал асуудлаар Хятадад үлэмж шахалт үзүүлэв. Японоос Манжуурт төмөр зам барихыг Хятад "эсэргүүцсэн"-ээс Манжуурт туйлын түгшүүртэй байдал үүсэв.

Төмөр замын стратегийн ач холбогдол нь Японы цэргийг далайн

боомтоос Манжуур, Хянганы нурууны стратегийн чухал газруудад тээвэрлэх явдлыг богиносгож, Японоос Харбины дүүрэгт цэрэг аваачих явдлыг 40 цагаар багасгана. "АНУ-тай дайн хийх тохиолдолд энэ нь Японыг аж үйлдвэрийн түүхий эд, хүнсээр хангах аюул багатай зам болно"[1] гэж үзэж байв.

Японы генерал К.Сато" "Хэрэв япончууд өөрийн гараар Манжуур, Монгол, Сибирийг ашиглая гэж байгаа бол Дорнод хятадын төмөр зам (ДХТЗ), Сибирийн төмөр замыг авах ёстой.

Тохиромжтой үед Орос, Хятадын засгийн газартай эдгээрийг худалдан авах яриа хэлэлцээг эхлэх хэрэгтэй. Монголыг ашиглахын тулд Мукденгээс Өргөө хүртэл эхлээд төмөр зам тавих хэрэгтэй. Энэхүү зам нь Мукденгээс эхэлж Тунляо, бага Хянганаар дайран Ар Монголд нэвтрэх ёстой юм. Дараа нь тус зам Сэцэн ханаас Өргөөг дайрч улмаар Эрхүү хүрч Сибирийн төмөр замтай холбогдоно. Энэхүү замыг тавивал Жехе, Цахар болон Өргөөгөөс баруун зүгт орших Алтайн сав газрын эрдэс баялгийг ашиглах боломжтой болно. Боломжтой бол Мукден-Өргөө-Эрхүүгийн төмөр замыг умард зүгт Агнуурын тэнгисийн эрэг дээрх Охотск хүртэл сунгах хэрэгтэй. Төмөр замын энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлбэл Монгол бүхэлдээ мөн Сибирийн зарим хэсэг Японы нөлөөнд орно"[2] гэж бичиж байв.

Манжуур Квантуны армид эзлэгдэх үед 6140 км урт төмөр замтай байсан бол Манжуурыг 25 мянган км төмөр замтай болгох, үүнээс 4 мянган км замыг ирэх 1943 он хүртэл тавих бодлогоо Япон 1933 оны 3 дугаар сарын 1-нд зарлажээ. Энэ нь Манжуурыг колоничлох бодлогын бүрэлдэхүүн хэсэг байв.

Энэ зорилгоор Хянганы нурууг баруун талаар нь ороосон төмөр замын шугамыг Хайлаар хүртэл тавих төлөвлөгөө гарчээ. 1934 оны 12 дугаар сард Солунь-Халуун рашааны зам барих гэрээ байгуулагдаж, 1935 онд Солунь-Өмнөд Хянганы 130,8 км, 1937 онд өмнөд Хянган-Халуун рашааны 15,4 км төмөр замыг тус тус тавьжээ.

1940 онд Жуков Халуун-Аршаан-Ганьчжур чиглэлийн төмөр замын шугам тавих тухай японы Жанжин штабын төлөвлөгөөний талаар бичихдээ, энэ зам Номонхааны нутаг дэвсгэрээр дамжин БНМАУ болон Өвөр Байгаль руу давших цэргийн хөдөлгөөнийг хангах бөгөөд барих шинэ төмөр замын гол шугамаа халхлахад Халхын гол түшиц болох ёстой гэж үзэж байв. Калинины асуусан "Таны бодлоор японы засгийн газар түрэмгийлэл хийх үндсэн зорилго, шалтгаан юу байсан бэ" гэсэн асуултад Жуков хариулахдаа: "Ойрын зорилго бол Халхын голын ойролцоох БНМАУ-ын нутаг дэвсгэрийг эзлэх, дараа нь стратегийн зориулалт бүхий төмөр замын хоёрдугаар шугамыг байгуулах ажиллагааг халхалж Халхын голд бэхлэлт байгуулан манай Өвөр Байгаль болон ДХТЗ-ын

[1] Р.Болд "Халхын голын байлдааны өмнөх Алс дорнодын олон улсын харилцаа. БНМАУ. УБ. "Өрнө-Дорно" сэтгүүл 1992 №2 т.5

[2] Р.Болд "Ограниченная война: военно-дипломатическая история сражения у реки Халхин-гол" Москва, Изд."Весь мир" 2019г. С.460

баруун хэсгийн хил рүү дөхөж очиход оршиж байв”[3].

Бие даасан тусгаар улс гэгдэж байсан Манж-го улсыг үнэн хэрэг дээрээ япончууд, бүр тухайлбал Квантуны армийн удирдлага удирдаж байсан бөгөөд цэргийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд түлхүү анхаарсан байдаг. Японучууд хөдөө аж ахуй, газар тариалангийн эрчимтэй хөгжсөн хятадын Сибирь гэгддэг өргөн уудам нутагтай хойд Хятадын хэсгийг эзлэн авсны дараа тэнд аж үйлдвэрлэлийг хөгжүүлсэн байдаг. Манжуурын аж үйлдвэрлэл нь үндсэндээ японы цэргийн эрх ашиг, сонирхлын үүднээс өөдлөн хөгжих болсон байна.

1942 оны 7 дугаар сард Синьцзинд анхдугаар 5 жилийн төлөвлөгөөний үр дүнг хэлэлцсэн хурал болсон байна. Ерөнхийдөө төлөвлөгөө 80 хувь биелсэн гэж дүгнэсэн ч хэд хэдэн заалтууд маш сайн үр дүнтэй гарсан байв. Ширэм цутгалт 219 хувь, ган хайлуулалт 159 хувь, ган бэлдэц 264 хувь, нүүрс олборлолт 178 хувь, зэс цутгалт 517 хувь, цайр 397 хувь, хар тугалга 1223 хувь, хөнгөн цагаан 1666 хувь тус тус нэмэгдэж гарчээ. Үүнийг сонссон Квантуны армийн генерал Умэдзу Ёсидзиро: “Манайд хүнд үйлдвэрлэл байгаагүй байсан бол одоо бидэнд байна.”[4] гэж бардамнах болсон гэдэг.



Зураг 1.Квантуны армийн генерал Умэдзу Ёсидзиро


Японы цэргийн хүчин Манжуур, Солонгосын материаллаг болон хүнсний баялаг нөөц, Манжуурын аж үйлдвэрийн сууринд тулгуурлаж байв. Квантуны армийн цэргийн эзэлсэн нутаг дэвсгэрт 13700 км төмөр зам, 22 мянган км автозам, 133 нисэх буудал, 200 гаруй буух талбай, 870 томоохон цэргийн агуулах болон сайтар төхөөрөмжилсөн цэргийн хотхон байрлаж байв.

ЗХУ болон БНМАУ-ын хил залгаа нутаг дэвсгэрт японы эзлэн түрэмгийлэгчид 17 бэхлэлтийн төхөөрөмжлөл бүхий бэхлэгдсэн районууд, тэдгээрээс 8 нь Зөвлөлтийн Приморьск орчмын нутаг дэвсгэрт байрлаж байв. Солонгост 4 бэхлэлтийн район, Сахалинд нэг бэхлэлтийн

[3] Жуков Г.К. “Воспоминания и размышления” С.183.

[4] Верхотуров Д.Н. “Маньчжурские пятилетки японской военщины”

районыг байгуулсан байна. Куриллын цуврал арлуудыг удаан хугацааны хориглолтын төмөр бетон бэхлэлтийн байгууламжаар далдалсан цэргийн гарнизонууд байрлуулан, эргийн артиллерийн батарейгаар халхалж байв.



Зураг 2. Манж-Го улс болон бүс нутгийн газрын зураг

2. Байлдааны ажиллагааны театр дахь төмөр замын сүлжээг бэлтгэсэн нь

Зөвлөлтийн төмөр замын хөгжил анхдугаар таван жилийн үед ЗХУ-ын хил орчмын, тэр тусмаа Алс Дорнодод геополитикийг бэхжүүлэх, эдийн засгийг сайжруулахад чиглэгдэж байв.

XX зууны 30-аад эхэнд Япон Манжуурыг эзэлсэнтэй холбогдуулан тухайн бүс нутагт цэрэг улс төрийн байдал хурцдан, Манж-Го улс шинээр бий болов.

ДХТЗ-ын сүлжээг ашиглах боломж хязгаарлагдаж, улс ардын аж ахуйн болон цэргийн ачааны тээвэрлэх багтаамж эрс өсөн нэмэгдсэнээр эдийн засгийг шинэчлэлтийн эргэлтэд оруулах хуулиар шинэ чиглэлд төмөр зам болон байгууламжийг өөрчлөн байгуулах шаардлага бий болсон ажээ.

Өвөр Байгальд болон Алс Дорнодод Трансибирийн төмөр замын хоёрдугаар гол шугамыг Карымскийн өртөөнөөс Уссур өртөө хүртэл (нийт урт 2217 км) байгуулах ажил эхэлж 1938 онд байнгын ашиглалтад оруулж чаджээ. Энд 25 том депог сайжруулан барьсан байдаг.

XX зууны 20 оны сүүлч 40 оны эхэнд Волочаевкагаас Комсомольск, Известковая өртөөнөөс Урал хүртэлх шугам, Владивостокоос Находкагийн чиглэлд хэд хэдэн хэсгүүд байгуулж чадсан нь хамгийн чухал бүтээн байгуулалт болжээ.

Хил орчмын харилцаа холбоог хүчжүүлж, сайжруулах зорилгоор хэд

хэдэн шугам барьсан бөгөөд Байгал-Амурын төмөр зам, Комсомольскоос Совгавань чиглэлийн шугамын барилгын ажлыг эхлүүлж чадсан байна.

1929-1941 онд Алс Дорнодод нийтдээ 1376 км урт (Транссибирийн хоёрдугаар зам орохгүйгээр) 16 шинэ шугам байгуулсан байна. Хоёр замтай хэсгийн урт 2304,2 км[5] хүрчээ.

1937 онд Хабаровск хотын ойролцоо Амур мөрөн доогуур туннелын барилгын ажил эхэлсэн бөгөөд энэ нь Амурын төмөр замын гүүрэн гарцыг орлоод зогсохгүй бүс нутгийн тээврийн том зангилааны орчим гол шугамын нэвтрэн өнгөрүүлэх чадварыг хүчжүүлж өгөх ёстой байв. Эх орны дайн эхэлснээс хойш сарын дараа тус туннелээр анхны галт тэрэг өнгөрөн гарсан боловч 1942 оны 10 дугаар сард дөнгөж ашиглалтад өгсөн байдаг.

Улс орон, бүс нутаг дахь төмөр замын зүтгүүрийн болон вагоны паркууд шинэчлэгдэж ирсэн бөгөөд дайны эхэнд 1,5 мянган уурын галт тэрэг байснаас 60 хувь нь шинэ төрлөөр солигдож амжсан байна.

Ардын комиссарын 1941 оны 6 дугаар сарын 23-ны тушаалаар 6 дугаар сарын 24-ны 18 цагаас эхлэн төмөр замын 44 чиглэлд галт тэрэгний хөдөлгөөний цэргийн хуваарийг мөрдөж эхэлсэн бөгөөд зорчигчдыг хязгаарлаж, цэргийн цуваа болон тээврийн ачаалах хэм хэмжээг тогтоож өгсөн байна. Объектын хамгаалалтыг чангатгах, тээвэрлэж буй зүйлийн баримт, мэдээллийн нууцыг хадгалах талаарх арга хэмжээнүүдийг авсан байдаг.

1943 оны хавраас улс орон даяар төмөр замыг дайны байдалд шилжүүлж, зам дээр ажиллагсдыг дайчилсанд тооцохоор болж, тээврийн салбарыг ажилчдаар бэхжүүлж өгсөн байна. Дайны үед тээвэр урьд байгаагүй их шилжилт урсгалтай болж, төмөр замын ажил, ачаалал ч хүндрэлтэй болжээ.

Дорнод Сибирьт албан байгууллагуудын 5,12 хувь нь ар тал руу татагдсан байдаг. Түүнээс гадна дайны өмнө Алс Дорнодын хэд хэдэн район руу иргэд, эд хөрөнгийг нутгийн гүнээс нүүлгэн шилжүүлэх (хоногт ойролцоогоор 5 цуваа байхаар) төлөвлөгөө гаргасан байв.

Ажилчин тариачны улаан армид Алс Дорнодын төмөр замд ажиллагсдаас цэрэгт татагдсанаас улбаалан 1941 оны 1 дүгээр сараас 1943 оны 1 дүгээр сарын хооронд төмөр замын ажиллагсдын тоо 12,5 хувь, харин Амурын төмөр замынх 14 хувиар тус тус багассан байна.

Эрчүүд дайнд явснаар тэдгээрийн оронд бүсгүйчүүд орлон ажиллах болжээ, тухайлбал 1941 оны 11 дүгээр сард Амурын төмөр замд 3884 эмэгтэй (12,3 хувь) ажиллаж байснаас, тэдгээрийн ихэнх нь доод албан тушаалын ажилд (597 хүн замчин, 40 хүн зүтгүүрийн бригадад тус тус) ажиллаж байв.

Алс Дорнодын төмөр зам 1941 онд 1942 эмэгтэй, 1942 онд 3618 эмэгтэй тус тус ажилд авсан байна. 1945 оны хавар гэхэд Амурын төмөр замын

[5] Яшин С.В.,"Железнодорожные перевозки в годы Великой Отечественной войны" Вопросы истории. 2004. № 5. С. 127.

гол шугамд нийтдээ 13 мянга илүү эмэгтэйчүүд ажиллаж байсан ба 59 хувь нь ажилчид байв. Түүнчлэн эмэгтэйчүүдээс гадна өсвөр үеийнхэн, тэр тусмаа сургууль төгсөгчид эзэлж байв.

1942 он болон 1943 оны 1 дүгээр сард Приморскийн төмөр замын вагонзасварын газруудад ажлын шаардлагаар 684 хүн байхаас 576 хүний 70 хувь нь сургууль дөнгөж төгссөн залуу ажилчид байв. Европоос Зөвлөлтийн цэргийг Алс Дорнодод болон Монгол руу шилжүүлэх асуудал бол болох давшилтын бэлтгэлийн чухал үе шат байлаа. Тухайн маневр өөрөө маш их өвөрмөц ажиллагаа байв.

Эхний ээлжид зайн хэмжээ нь бүхий л хүчийг дайчлахад хүргэсэн. Байлдааны техник зэвсэглэл бүхий бие бүрэлдэхүүнтэй цуваг 10-12 мянган км зайг туулах асуудал байв. Алс Дорнодын фронтуудыг хүчжүүлж, бэхжүүлэх ажиллагааг маш нууцлаг явуулах шаардлага гарч байв.

3. Их ялалтад Алс дорнодын төмөр замын гүйцэтгэсэн үүрэг

Алс Дорнодод Зөвлөлтийн цэргийн Ерөнхий командлагчаар маршал А. М. Василевский томилогдсон бөгөөд түүний хажууд Улаан армийн Ар талыг удирдах шуурхай бүлэг (дарга-генерал В.И.Виноградов) байгуулагдсан байдаг. Энэхүү бүлэгт Транссибирийн (Иркутскээс Владивосток хүртэл) төмөр замын гол шугам хамаарагдаж байв.

Фронтууд Транссибирийн гол шугамаас салаалсан тусдаа хэд хэдэн төмөр замын хэсгүүдийг ашиглаж байв. Үүнд: Өвөр Байгалийн фронт - 12, Алс Дорнодын I фронт - 8, Алс Дорнодын II фронт - 9 хэсгээс бүрдэж байв.

Үндсэн цохилтыг Өвөрбайгаль талаас Манжуурын нийслэл Чан чунь (Синь цзян) руу хийхээр төлөвлөсөн. Өвөрбайгалийн фронтын бүрэлдэхүүнд ерөнхий цэргийн 39 болон 53-р арми, 6-р гвардын танкны арми багтаж байв. Фронт Карымская-Борзя-Чойбалсан (Баян-Түмэн-үндсэн бааз) чиглэлийн төмөр замын хэсэгт байрлаж байсан ба хангалттай нэвтрэн өнгөрүүлэх чадвартай (хоногт 7 хос галт тэрэг) байв.

Шинээр 13 зөрлөг байгуулснаар замын нэвтрэн өнгөрүүлэх чадвар хоногт 18 хос хүртэл галт тэрэг болж нэмэгдсэн. Приморьскийн орчмын нутаг дэвсгэрт байрлах 1-р Алс Дорнодын бүрэлдэхүүнд Дорнод Пруссээс татагдан ирсэн 5-р арми багтаж байв.

Алс Дорнодын байлдааны ажиллагааны театрт цэргийг шилжин байрлуулах ажиллагаа өргөн далайцтай явагдсан бөгөөд 2 фронт, 4 армийн, 19 корпусын удирдлага, бараг 100 гаруй нэгтгэл, ангиуд, тэдгээрийн бусад хүч хэрэгсэл (бие бүрэлдэхүүн 403 355, танк болон өөрөө явагч артиллерийн хэрэгсэл 2119 (САУ), их буу болон миномёт 1137, автомашин 1734 тээвэрлэгдсэн нь Алс Дорнодын фронт ямар их орон зай, хүч хэрэгсэлтэй байсныг харуулна. 1945 оны 5 дугаар сараас 8 дугаар сард Алс Дорнод болон Өвөрбайгальд цэрэг, ачаатай бараг 136 мянган галт тэрэг өнгөрсөн байдаг. Тэдгээрийн тал орчим нь (46 хувь) 6 дугаар сард явсан байдаг.

Ялангуяа БНМАУ-ын нутаг дэвсгэр дэх төмөр замын нэвтрэн өнгөрүүлэх чадвар хязгаарлагдмал байсан тул цэргийг нүүлгэн шилжүүлэхдээ богино хугацаанд цувааны зарим хэсгийг Чит орчмын районд буулгахад хүргэсэн. Үүний дараагаар цэрэг өөрийн хөлөөр цаашид 1000 хүртэл км газрыг маршаар үйлдэх болж байв. Хилийн зурвас орчмын газар зөвхөн шөнийн цагаар дөхөж тэдгээрийг буулгаж байв. 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд Алс Дорнод болон Монголд байлдааны техник, галт хэрэгсэл, бие бүрэлдэхүүн бүхий бараг 1700 гаруй цуваа өнгөрсөн байдаг.

Зам харилцааны ардын комиссар Новосибирскээс Владивосток чиглэлд 1945 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн хоногт 24 хос цуваа, 8 дугаар сарын 1-нээс 30 хос цуваа, Карымскгаас Борзя, цааш нь Отпор чиглэлд 16 хос цуваг өнгөрүүлэх үүрэгтэй байлаа.

Алс Дорнодын төмөр замд уурын зүтгүүрийн паркийг нэмэх үүднээс бусад гол шугамаас болон нөөцөөс 800 уурын зүтгүүрийг татан авсан байлаа.Мөн цаашилбал, хүний нөөцөөр ч хангагдав. 1945 оны II хагаст машинистын тоо 2400, туслах машинистын тоо 2900, уурын зүтгүүрийн засварчны тоо 3100 хүнээр нэмэгдсэн байна.

Алс Дорнодын тойрогт 4 дүгээр сард захирамж гарч, төмөр замын ашиглалтын 3 хороо, цэргийн ашиглалтын 3 тасаг болон Зам харилцааны ардын комиссарын Онцгой нөөцөөс уурын зүтгүүрийн 5 цувааг шилжүүлэн өгсөн байдаг. Мөн Алс Дорнодоос баруун чиглэлд илгээсэн тусгай салбаруудыг бүгдийг буцаан татаж авсан байна. Тэдгээрт нийтдээ 14 мянган хүн тоологдож байсан. Нүүрсний үлэмж нөөцийг бий болгон ус хангалтын байгууламжийг хүчжүүлж, замын аж ахуйг нэмэгдүүлж чаджээ

Сибир болон Алс Дорнодын төмөр замыг бэлтгэх арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө Борзя, Свободный, Берёзовский, Биробиджан II, Гродеково болон бусад төмөр замын станцуудыг хөгжүүлэх асуудлыг хамтатган хэрэгжүүлж иржээ. Алс Дорнод дахь томоохон гол, мөрөн дээгүүр төмөр замын гүүр тавихдаа явган цэргийг аяны цувааанд өнгөрүүлэх боломжтой байхаар тооцоолж хийж байв. Төрөл бүрийн ачаа буулгах буудлыг бэлтгэж чадсан. Замын хэвийн огтлол уулзвар дээр болон нарийн зам дээр дахин ачаалах район, эсвэл буудал бий болгосон.

Алс Дорнодод цэргийг буулгах ачаалах томоохон районуудыг бий болгосон байдаг. Зам салаалж буй газруудад нэвтрэн өнгөрөх чадвар хангалттай хүрдэггүй байв. Алс Дорнодын болон Амурын замын шугамын техникийн хувьд хүчжүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр 1945 оны 4 дүгээр сард төмөр замын 25-р бригадыг тийш нь илгээсэн байв.

Приморскийн төмөр замд Чехословакаас ирсэн УВВР-8, харин Өвөрбайгалын төмөр замд УВВР-14-ыг шилжүүлэн байрлуулав. УВВР-9-ын цэрэг, захирагч нар Свердловскийн болон Өмнөд Уралын төмөр замд хүч нэмэгдүүлэн ирсэн байв. УВВР-1-ын анги болон тусгай томилгоот салбарууд Иркутск-Слюдянкагийн шугамыг барьж байгуулсан байна.

Зам харилцааны Ардын комиссар (ЗХАК)-ын харъяа Өвөрбайгалийн болон Алс Дорнодын районд төвлөрсөн төмөр замын ангиуд болон тусгай томилгоот салбарууд нь маш богино хугацаанд бөөнөөрөө ирж буй цэргийн цувааг буудал дээр хүлээн авах, шугамыг бүрэн бэлтгэх боломжгүй байв. ЗХАК-т тухайн газар оронд ойролцоогоор 80 засварын поездыг дэлгэх шаардлага гарч байв.

Өвөрбайгалийн төмөр зам дээр засвар-сэргээн босголтын гол толгойны поезд, гүүрний поезд, хөдлөгч зүтгүүрийг сэргээн засварлах 3 поезд, мөн тооны ус хангалтыг сэргээн босгох поезд, холбоо сэргээн босгох поезд болон гол толгойны бааз, хэд хэдэн салбарыг байгуулсан. Алс Дорнодын төмөр замд цэргийн ашиглалтын № 33 болон 34 тасгууд, ЗХАК-ийн онцгой нөөцийн зүтгүүрийн № 46 цуваа, холбооны хөдөлгөөнт зангилаа болон сэргээн босгох салбаруудын товч мэдээ хүргэх салбарыг татаж ирсэн байв.

Алс дорнодод байлдааны ажиллагааны эхэнд барилгын материалын 4 баазыг Өвөрбайгалийн зам дээр Карымская, Дорнод Амурын зам дээр Куйбышевка, Алс Дорнодын зам дээр Хабаровск II, Приморскийн зам дээр Перелётный станцад тус тус байгуулжээ. Эдгээр замын бүх нөөцийг хатуу тооцоотойгоор хуваарилсан байв. Замыг сэргээн босгох үед дээд хэсгийн байгууламжийн материалыг ашиглан багавтар зангалаа, салаа зам, мухар замыг ашиглах боломжийг мөн тооцсон. Алс Дорнодод зөвлөлтийн цэргийн ангиуд болон байлдааны техникийг дахин байрлуулахад төмөр замчдаас өндөр зохион байгуулалтыг шаардаж байв.

ЗХУ-ын баруун хилээс Номхон далай хүртэл бүхий л төмөр замаар явж буй цэрэг болон цэргийн ачаатай галт тэрэгний цувааг тэнд ажиллаж буй ажилчид тасралтгүй өнгөрүүлж, Өвөрбайгалийн, Алс дорнодын 1, 2-р фронтын цэргийг хүч хуралдуулах болон дэлгэх районуудад хүргэж байв. ЗХУ-ын Маршал Александр Михайлович Василевский өөрийн дурсамждаа: "...тээвэрлэлтийн төлөвлөгөө дээр олон удаа ажилласан ч өөрийн зурсан үзүүлэлтийг тооцвол тэр маань үнэндээ бол аугаа эд байсныг хэлж чадна. Эдгээр тээвэрлэлтийг байгаа ганц төмөр замын гол шугамаар тийм богино хугацаанд, тэгээд 9-12 мянган км их зайнд гүйцэтгэнэ гэдэг маш том хүндхэн ажил байв. Тэд л дэлхийн хоёрдугаар дайны түүхэнд өмнө нь хэзээ ч байгаагүйг гайхамшигтай гүйцэтгэж чадсанаараа энэ стратегийн давших операцийг сургамж болгомоор операц болгож чадсанд оршино."

Зөвлөлтийн цэргийн шургуу давшилтыг дайсан бараг гүйцэж чадахгүй байв. Тэрээр төмөр замд их хэмжээний хохирол учруулж амжаагүй юм. Түүнд зөвхөн зарим хэсэг дээр л гүүр, холбооны шугам болон ус хангалтын байрыг эвдлэх, хэд хэдэн туннелийг тэсэлж чаджээ.

Гол болон буудлын дагуух замууд харьцангуй бага эвдэрсэн байв. Зарим тохиолдолд япончууд дэр мод эвдэгч «индүү-каток» ашиглахыг оролдсон байдаг. Тэр нь дээнч боловсронгуй болж чадаагүйгээс үр дүн багатай байв. Сайн чанартай дэр модонд «индүү-каток» онцгой хохирол учруулсангүй, зөвхөн бүдэг мөр үлдээж л байв.

Гэвч Манжуурын ган холбоостой хэсэгт бий болсон багавтар эвдрэлүүдэд төмөр замчид ихээхэн цаг зарцуулж, ажиллах болсон байдаг. 1524 мм-ийн өргөнтэй замыг солих, эвдэрсэн замыг сэргээн босгох, засварын ажлуудыг хийх шаардлагатай болсон байна.

Японучууд Манжуурын зам дахь ялзарсан дэр модыг огт сольдоггүй байв. Ихэнх хэсэгт дэр модны бараг тал нь манай галт тэргийг өнгөрүүлэхэд шаардлага хангахгүй байв. Тийм байдал бас рельсийн хувьд адилхан байв. Тэд хүчтэй гэмтсэн, элэгдсэн заавал солих шаардлагатай байв. Манжуур, Харбин, Пограничная чиглэлд л зөвхөн 485 мянган дэр мод болон 3166 рельсийг зайлшгүй солих шаардлага байв. Нийт засвар шаардлагатай гол болон буудлын замын нийт урт 1786 км болж байв.

Өвөрбайгалийн фронтод 1945 оны 8 дугаар сарын 10-наас эхлэн төмөр замын 4-р бригадын анги, салбарууд замыг сэргээн босгож царигаа тогтоож эхэлсэн. Замчид Нонни гол дээгүүрх 853 м-ийн гүүр, Тжамау гол дээгүүрх 128 м-ийн гүүр, Имин гол дээгүүрх 253 м-ийн гүүрийг тус тус сэргээн босгожээ. Тэд ажлын багтаамж ихтэй бусад ажлыг ч гүйцэтгэж байв. Энэ бригадын цэрэг, офицерууд Пограничная- Мугден-Харбин чиглэлд замаа сэргээн босгож, 672 км замыг засаж сэлбэн, 42 гүүрийг сэргээн босгосон байна. Замыг засч сэлбэх үед ойролцоогоор 240 мянган дэр модыг сольсон байдаг. Ажлын хоногийн дундаж хурд бэлэн замаар 29 км[6] хүрч байв.

Милитарист Японтой хийх дайн удаан үргэлжилсэнгүй. 8 дугаар сарын 17-нд Квантуны армийг хэсэгчлэн хуваж, 8 дугаар сарын төгсгөлд бүрэн устгаж чадсан юм. Квантуны армийн шилэгдмэл анги, салбартай хийсэн дайнд Зөвлөлтийн зэвсэгт хүчний байгуулсан ялалтад зөвлөлтийн төмөр замчид үнэтэй хувь нэмэр оруулсан нь дамжиггүй.

1945 оны 8 дугаар сарын 10-наас 9 дүгээр сарын 30-ны өдрүүдэд төмөр замын ангиуд, тусгай томилгоот салбарууд 3600 км гол шугамын болон буудал орчмын замыг засч, 28 том, 11 дунд, 60 бага гүүр, 5 туннелийг сэргээн босгож, бусад ажлыг гүйцэтгэсэн байна.

Манжуурын сэргээн босгосон төмөр замаар галт тэрэг явж эхэлсэн бөгөөд тээвэрлэлтийн хэмжээ нь ч аугаа их байв. Зөвхөн 1945 оны 8 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 20-ны хооронд 112000 вагон явсан тооцоо байдаг.

Дүгнэлт

Төмөр замчид стратегийн болон давших 50 гаруй операцыг бэлтгэх, явуулах нөхцөлийг ханган, шийдвэрлэх тулалдааны газарт бүхэл бүтэн арми, асар их тооны байлдааны техник, зэвсэглэлийг татан авчирч байжээ. Дайны 4 жилийн хугацаанд ЗХУ-ын төмөр замаар 20 сая галт тэрэг зөөвөрлөгдөж, 2500-аас илүү аж үйлдвэр, тоног төхөөрөмж, соёлын бараа, үнэт зүйлс болон сая сая хүнийг нүүлгэн шилжүүлсэн нь урьд

[6] Ципкин Ю.Н.,Тесельская И.П. “Роль железных дорог Дальнего Востока в достижений победы” Дальневосточный государтвенный гуманитарный университет, г.Хабаровск, УДК:947.085+656.2(571.6)

өмнөх түүхэнд байгаагүй үзэгдэл бөгөөд түүнийг гайхамшигтай зохион байгуулсан явдал нь хүн төрөлхтний түүхэнд тэмдэглэгдэх гавьяат үйл хэргийн тоонд багтаан тооцож болно.

Алс Дорнодын төмөр замчид болон цэргийн харилцаа холбооны албанаас гүйцэтгэж явуулсан асар их ажлын үр дүнд операцын амжилт хангагдсан юм. Эх орны агуу их дайн болон милитарист Японыг бут цохиход төмөр замчдын оруулсан хувь нэмрийг үнэлж баршгүй юм.

Халхын голд явагдсан байлдаан нь БНМАУ-д төмөр зам барихад түлхэц болсон бөгөөд Баянтүмэн хүртэл өргөн, Тамсаг булаг хүртэл нарийн цариг бүхий төмөр замын шугамыг барьж эхэлсэн байдаг. Энэ зам нь монголд орчин цагийн зам харилцааны дэд бүтэц бий болгоход нөлөөлсөн юм.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. Р.Болд “Халхын голын байлдааны өмнөх Алс дорнодын олон улсын харилцаа. БНМАУ. УБ. “Өрнө-Дорно” сэтгүүл 1992 №2 т.5
2. Р.Болд “Ограниченная война: военно-дипломатическая история сражения у реки Халхин-гол” Москва, Изд.”Весь мир” 2019г. С.460
3. Жуков Г.К. “Воспоминания и размышления” С.183.
4. Верхотуров Д.Н.”Маньчжурские пятилетки японской военщины”
5. Яшин С.В.,”Железнодорожные перевозки в годы Великой Отечественной войны” Вопросы истории. 2004. № 5. С. 127.
6. Ципкин Ю.Н.,Тесельская И.П. “Роль железных дорог Дальнего Востока в достижений победы” Дальневосточный государственный гуманитарный университет, г.Хабаровск, УДК:947.085+656.2(571.6)
7. Ежеля У.В. “История развития железнодорожного транспорта на Дальнем Востоке России”. Хабаровск, 2005. С. 45.
8. Василевский А. М. “Дело всей жизни: Воспоминания”. М., 1990. Кн. 2. С. 247.
9. Лелеко С.В. “Трудовые подвиги воинов 9 железнодорожного корпуса”
10. «Железнодорожные войска России».Коллектив авторов.
11. http://militera.lib.ru/h/zheleznodorozhnye_voyska_rossii/31.html, кН.4 гл. 2,5
12. Кампания Советских Вооружённых Сил на Дальнем Востоке в 1945 г. (Факты и цифры). // «Военно-исторический журнал»- 1965. -№ 8.
13. Гареев М.А,”Маньчжурская стратегическая наступательная операция: уроки и выводы”,”Военная мысль”№6 2000г.
14. Маньчжурская стратегическая наступательная операция уроки и выводы

Цэргийн урлагийн практик, онол, удирдлагын баримт бичиг, сургалтын нэгдмэл байдлыг хангах асуудалд

Ш.Паламдорж
БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн,
шинжлэх ухааны доктор (S.D), профессор

Abstract

The evolving nature, methods and forms of modern warfare and armed conflict are influencing the theory and practice of martial arts in the countries of the world and are the basis for updating its preparation and training. The nature of these traditional and non-traditional wars and conflicts determines the theory and practice of martial arts, as well as the development trends of traditional and non-traditional.

Keywords: *military art, theory of military art, practice of military art, guiding documents of military administration, to ensure the unity of practical actions.*

Цэргийн урлагийн практик, түүний хөгжлийн уялдаа холбоо: Геополитикийн эрс өөрчлөлт, дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулах шинэ арга, хэлбэр бий болсон зэрэг нь өнөө үед дайн ба энх тайвны асуудлыг судлах, дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс сэргийлэх, тэмцэхэд стандарт бус хандлагыг шаардах боллоо.

Дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулах үндсэн арга ухаан нь улс төрийн бодлогоор тодорхойлогдсон цэргийн урлаг (стратеги, цэргийн операц, тактик) юм.

Монголын цэргийн урлагийн практик нь өөрийн түүхэн болон дэлхийн улс орнуудын цэргийн урлаг дахь туршлага, сургамж, ололт, амжилтад тулгуурлан хөгжиж байна.

Өнөө үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөн уламжлалт болон уламжлалт бус цэргийн аюулын эх сурвалжаас хамаарч стратеги, тактик нь өөр өөрөөр явагдаж байна. Тодруулж хэлэхэд, цэргийн урлаг уламжлалт (сонгодог) болон уламжлалт бус (сонгодог бус) арга хэлбэртэй болсон байна.

Дэлхийн улс орнуудын цэргийн урлаг уламжлалт (сонгодог) болон уламжлалт бус (сонгодог бус) арга хэлбэр хөгжих нь цэргийн байлдааны ажиллагааны удирдлагын баримт бичгийг болон цэргийн байлдааны

бэлтгэл, цэргийн сургалтыг шинэчлэхийг нөхцөлдүүлж байна.

Өнөө үеийн зэвсэгт тэмцэл цэргийн уламжлалт (сонгодог) урлагт хэрхэн нөлөөлж байна вэ? Өнөө үеийн зэвсэгт тэмцэл бол технологийн давуу тал дээр суурилсан нэн өндөр цэцтэй, хэт өндөр хурдтай, нэн эрчимтэй, цохилтыг сонгон хийх, хорлон сүйтгэх тэмцлээр эхэлж байгаа нь орчин үеийн цэргийн урлагийн нэгэн онцлог болж байна. Өнөөгийн цэргийн хүчин чадлын үндсэн элемент бол агаар, сансрын довтолгооны хүч, хэрэгсэл бөгөөд үүнгүйгээр ганц ч дайн, зэвсэгт мөргөлдөөн явагдахгүй байна. Агаар, сансрын цохилтын хэрэгслийг үр дүнтэй эсэргүүцэх чадваргүй тал нь ялагдаж байна. Дайн, зэвсэгт мөргөлдөөнд хамгийн түрүүнд, дайсан улсынхаа агаарын довтолгооноос хамгаалах тогтолцоо, хүч хэрэгсэл, агаарын хүчин, стратегийн нөөц, улс төр, эдийн засгийн удирдлагын дэд бүтэц, түүний харилцаа холбоо, цахим дайны системийг хурдан, шуурхай дарж, эсэргүүцэх чадварыг нь алдагдуулахад онцгой ач холбогдол өгч байна.

Манай эрдэмтэн судлаачид болон энэ чиглэлд судалгаа, шинжилгээний ажил эрхлэгч төв, тэнхим нь орчин үеийн цэргийн мөргөлдөөний туршлагыг судалж, нэгтгэхэд онцгой анхаарлаа хандуулсаар байна. Үүнийг манай судлаачдын хамтын бүтээл[1], эрдэм шинжилгээний олон тооны өгүүлэл, хурлын илтгэлүүд харуулдаг.

Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх урт хугацааны хөтөлбөр нь батлан хамгаалах болон цэргийн байлдааны чадавхыг дээшлүүлэх үндэс суурь болж байна. Улсын батлан хамгаалахын тулгамдсан асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй санал боловсруулахад тодорхой мэдлэг, чадварыг шаардаад зогсохгүй бас практик, зохистой дадлага, санаачилгаа ажил хэрэг болгох хүчин чармайлт, оновчтой арга ажиллагааг шаардаж байна. Бид батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ажиллагааг явуулахдаа юуны түрүүнд өнөө болон ирээдүйд ханддаг бөгөөд хэтийн төлөвийг ажигладаг.

Уламжлалт хэлбэрээр явагдаж буй дайн, зэвсэгт мөргөлдөөнд нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ)-ийн хөгжил, цахим дайн, тагнуул, сансарт суурилсан навигацийн шинэ хэрэгсэл бий болсон явдал ихээхэн нөлөөлж байна. Тэдний нөлөөлөл нь зэвсэгт тэмцлийн шинэ хэлбэр болох алсын зайнаас дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулах, нэн өндөр цэцтэй зэвсгийн цохилтоор дайсныхаа стратегийн болон нөөц хүчийг устгаж байгаа бөгөөд түүний мөн чанар нь газар, далай (далай), агаар, сансар дахь талуудын

[1] Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он. -186х. ISBN- 978-99978-848-3-1; Б.Түмэн. Оперативын урлаг. УБ., 2021 он. – х; Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2017 он.№24(34). т.114-123. Н.Энхбат. Агаарын цэргийг ашиглах онол, практикийн зарим асуудал; Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2019 он.№27(37). т.79-90. С.Пүрэвдорж. Операц, тактикийн урлагт нөлөөлж буй дотоод хүчин зүйлсийн зарим асуудал; Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2020 он.№29(39). т.80-88. Ц.Дашзэвэг. Цэргийн урлагийн хөгжлийн зарим асуудалд; Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2021 он.№32(42). т.51-59. Р.Энхболд. Хориглох операцад бэтгэж, явуулах онолын хөгжлийн үндсэн хандлага; гэх мэт.

ширүүн тэмцлээр давамгайллыг олж авахад оршиж байна. Хуурай газар дээрх байлдааны ажиллагаа нь хориглолт - давшилт, тулгарах байлдаан, тулалдаан (байлдааны ажиллагаа)-аар болон цэргийн операцын байгууламж болон тактикийн байлдааны журамд гүн нэвтэрсэн манлай хүчний ажиллагаагаар явагдаж, гал, цохилтын үр дүнг ашиглах, олсон амжилтаа бататгах, хэрэгжүүлсэн зорилгоо хадгалахын төлөө хүчээ төвлөрүүлж байна. Байлдааны үеэр хүн хүчээ аль болох хадгалах хүсэл эрмэлзэл нь байлдааны робот системийг цэрэгт идэвхтэй нэвтрүүлэхэд хүргэлээ.

Нэн өндөр цэцтэй зэвсэг (НӨЦЗ)-ийн хөгжил, цахим дайн, тагнуул, сансарт суурилсан навигацийн шинэ хэрэгсэл бий болсон явдал нь уламжлалт дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт ихээхэн нөлөө үзүүлж байгаа юм. Тэдний нөлөөлөл нь зэвсэгт тэмцлийн шинэ хэлбэр болох алсын зайнаас дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулах, нэн өндөр цэцтэй зэвсгийн цохилтоор дайсныхаа стратегийн болон нөөц хүчийг устгаж байгаа бөгөөд түүний мөн чанар нь газар, далай (далай), агаар, сансар дахь талуудын ширүүн тэмцлээр давамгайллыг олж авахад оршиж байна. Хуурай газар дээрх байлдааны ажиллагаа нь хориглолт - давшилт, тулгарах байлдаан, тулалдаан (байлдааны ажиллагаа)-аар болон цэргийн операцын байгууламж болон тактикийн байлдааны журамд гүн нэвтэрсэн манлай хүчний ажиллагаагаар явагдаж, гал, цохилтын үр дүнг ашиглах, олсон амжилтаа бататгах, хэрэгжүүлсэн зорилгоо хадгалахын төлөө хүчээ төвлөрүүлж байна.

Уламжлалт цэргийн аюулаас гадна уламжлалт бус цэргийн аюул: олон улсын терроризм; үй олноор хөнөөх зэвсгийн "мөлхөө аюул"; мэдээллийн түрэмгийлэл, дайн; өнгөт хувьсгал, дотоодын бослого үймээн; "холимог дайн" (гибридная война, hybrid war) (эдийн засаг болон дэд суурь бүтэц дэх дайн) явагдах болсон нь цэргийн урлагт нөлөөлж, зэвсгийн хүчний үүргийг нэгдүгээрт биш хоёрдугаар эгнээд оруулж, арга тактикийн ажиллагааг нэгдүгээр эгнээнд гаргаж ирлээ.

Энэ практик байдал нь цэргийн урлагийн онолыг шинээр боловсруулах, цаашид хөгжүүлэх учир шалтгаан болж байна.

Өнөө үеийн цэргийн урлагийн хөгжилд уламжлалт бус цэргийн аюул хэрхэн нөлөөлж байна вэ? Өнөөгийн дайн, зэвсэгт мөргөлдөөний агуулга нь нийгэм-улс төрийн үзэгдлийн хувьд ихээхэн хувирч өөрчлөгдөөд байна. Түүний шинж чанарыг нь урьдчилан таамаглахад хэцүү ч өнөөдөр ямар төлөв байдалтай байгааг тодорхойлох, хандлагыг нь тогтоох боломжтой байна.

Нэгд, дэлхийд олон арван террорист бүлэглэлүүд бий болжээ. "Исламын улс" бүлэглэлийн "Халифат" улс байгуулах зорилго агуулсан олон улсын террорист бүлэглэл, Исламын шашинтай орнуудад төрийн байгууллагуудыг нурааж нэгдсэн нэг «Исламын Их Халифат» улс байгуулах зорилго бүхий "Аль-Кайда", Сири улсын Иргэний дайны үеэр «Аль-Кайда» бүлэглэлээс салбарлан байгуулагдсан "Жэбхад Ан-Нусра" (Ялалтын фронт) бүлэглэл, Афганистан дахь төр засгийн эрхийг

авсан “Талибан” гэх мэт террорист олон байгууллагын үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байна. Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар өөрчлөгдөхөд тэдний үүрэг ихээр нөлөөлөх болжээ.

Дайн, зэвсэгт мөргөлдөөний судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээс харахад, өнөө үеийн дайны субъект ихээхэн өөрчлөгдөж байна. Хэрэв урьд өмнөх үеийн дайнд оролцогч нь зөвхөн улсын эрх мэдлийн армийн асуудал байсан бол өнөө үеийн нөхцөлд террорист байгууллага, хувийн цэргийн кампани, албан бус иргэний цэргийн байгууллага (сайн дурын партизанууд) дайнд оролцогчид болсон гэж үзэж болохоор болжээ. Үүнээс хамаараад тийм дайсантай операц, байлдааныг явуулах тактикийг шинэчлэхээс өөр арга замгүй болж байна.

Гэхдээ ямар ч хэмжээний зэвсэгт мөргөлдөөний гол бүрдэл хэсэг (элемент) нь энэ тохиолдолд зэвсэгт тэмцэл байсан хэвээр байна. Үүний шинж чанарт гарсан өөрчлөлт нь юуны түрүүнд давшилт, хориглолтоор цэргийн ажиллагааны зорилгод хүрэх, бэлэн хүч, хэрэгслийг ашиглах бусад уламжлалт аргуудаас татгалзсантай холбоотой байна.

Хоёрт, үй олноор хөнөөх зэвсгийн “мөлхөө аюул” ихэсжээ. Цөм, хими болон бактерлоги (биологи)-ийн зэвсгийг зохион бүтээх, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглосон олон улсын гэрээ хэлэлцээр байгаа хэдий ч түүнд нэгдэн ороогүй улс орнууд байсаар байна. ҮОХЗ-ийг устгаагүй, зэвсэглэлд хадгалсан хэвээр, харин ч түүнийг боловсронгуй болгосоор цөмийн зэвсгийн их буугаар буудах хэмжээнд хүртэл жижгэрүүлсэн, химийн зэвсгийн ердийн лабораторид бинарын зэвсэг хэлбэрт шилжүүлсэн, бактерлоги (биологи)-ийн зэвсэгт тавих олон улсын хяналт, шалгалт хийх боломж хязгаарлагдмал байдлыг ашиглан түүнийг боловсронгуй болгох технологийг түгээж буй байдал нь ийм төрлийн зэвсгийн аюул оршсоор буйн илрэл бөгөөд түүнийг дайн, зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэх занал буйг харуулж байна.

Цөмийн зэвсгийг том дайн гарахад хэрэглэх үндсэн хэрэгсэл болгож байсан үзэл баримтлал бага зэрэг өөрчлөгдөж, тийм дайныг гаргахгүй байх, тогтоон барих үндсэн хэрэгсэл болгож буй хандлага байгаа ч түүнийг дайн, зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэхгүй гэсэн баталгаа хараахан биш юм.

Цөмийг зэвсэг бүхий улс (АНУ, ОХУ, Их Британи, Франц, БНХАУ)-уудын клубт багтаагүй цөмийн зэвсэгтэй улс орон (Энэтхэг, Пакистан, БНАСАУ, Израиль)-ы тоо өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тийм зэвсэг үйлдвэрлэх технологи эзэмшсэн улс орны тоо ч олширсон байна. Бүр эзэмшихийн төлөө улайран зүтгэж буй улс орон ч байна. Энэ байдал нь цэргийн урлаг дахь ҮОХЗ-ийг хэрэглэх үеийн стратеги, тактикийг өөрчлөн хөгжүүлэх шаардлага байгааг харуулдаг.

Болзошгүй дайсныхаа хэрэглэж болзошгүй зэвсгээс хамгаалах, тийм зэвсэгтэй дайсантай байлдах арга ухаанд бэлтгэхгүй байх нь цэргийн урлагийн үндсэн зарчим – байлдаанд бэлэн байх, бэлтгэгдсэн байхтай зөрчилдөх тул энэ чиглэлд цэргийн урлагаа хөгжүүлэхийг гадаад талаас

шаардаж байгаа юм.

Гуравт, цэргийн хэрэгт мэдээллийн шинэ технологийг өргөн нэвтрүүлж буй нь орчин үеийн цэргийн урлагийн агуулгад онцгой нөлөө үзүүлж байна. Мэдээллийн дайн урьд өмнөх үеийн дайны агуулгыг өөрчилж, дайнд шууд бус оролцогчдын тоог өсгөж, мэдээлэл нь хүн ам болон сөрөг хүчний эсэргүүцлийг зохион байгуулах, чадавхыг нэгтгэх, удирдах зэрэгт хамгийн үр дүнтэй зэвсгийн нэг болжээ. Өнгөрсөн үеийн дайнд ч мэдээллийн нөлөөлөл байсан боловч, өнөө үеийнх шиг тэр нь цэргийн зорилгыг хэрэгжүүлэх, түүнд хүрэх хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх нэн чухал ач холбогдолтой хэрэгсэл байгаагүй юм. Мэдээллийн дайны зорилго нь дайсагнагч улсын мэдээллийн аюулгүй байдлыг алдагдуулах, улсын болон цэргийн удирдлагын тогтвортой ажиллагааг алдагдуулах, нийгмийнх нь ухамсар, оюун санааны төлөвшил, улс төрийн шийдвэр гаргах тогтолцоог эвдлэн бусниулах, өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зэргээр мэдээллийн давамгайллыг бүрдүүлж ялалтад хүрэх явдал юм. Мэдээллийн дайн: мэдээлэл - техникийн хүрээнд, мэдээлэл – сэтгэл зүйн хүрээнд гэсэн хоёр хүрээнд гол төлөв явагдаж байна. Мэдээлэл - техникийн тэмцэл (дайн)-ийн нөлөөллийн болон хамгаалалтын үндсэн объект нь мэдээлэл техникийн систем (өгөгдөл дамжуулах систем, мэдээлэл хамгаалах систем) байна. Харин мэдээлэл - сэтгэл зүйн тэмцэл (дайн)-ийн нөлөөллийн болон хамгаалалтын үндсэн объект нь дайсан улсын улс төрийн шийдвэр гаргагчид болон хүн амын сэтгэл зүй; нийгмийн ухамсар, санаа бодол, гаргах шийдвэр байна.

Мэдээллийн дайн зэвсэгт тэмцлийн шинэ орчин – байлдааны ажиллагааны шинэ театруудад явагдаж байна. Мэдээлэл - техникийн тэмцэл нь кибер орон зай, цахилгаан соронзон спектрыг, мэдээлэл - сэтгэл зүйн тэмцэл нь дайсан улсынхаа цэрэг, дайчид, ард иргэдийн оюун санаа, ухамсар, сэтгэл зүйг тэмцлийн талбар, байлдааны ажиллагааны театр болгож байна.

Практикаас харахад, мэдээллийн нөлөө нь хэдэн он жил, сар, хоногт улс орон, нийгмийн нөхцөл байдлыг өөрчилж, цэргийн ажиллагааны томоохон үр дүнтэй дүйцэхүйц үр дүнд хүргэж байна.

Дөрөвт, дотоод дахь эсэргүүцлийн чадавхыг зохиомлоор нэмэгдүүлэх замаар зэвсэгт мөргөлдөөнийг эхлүүлэх аюултай хандлага давамгайлах боллоо. Террористууд, зэвсэглэсэн гэмт бүлэглэл, олон нийтийн холбоо, хөдөлгөөн зэрэг хууль бус зохион байгуулалт бүхий хүчний чадавхыг идэвхтэй ашиглаж байна. Өнгөт хувьсгал, дотоодын бослого үймээн бол түүний үр дагавар гэж үзэх үндэслэлтэй. ЗХУ-ын дараах орон зай дахь “өнгөт хувьсгал” Гүржийн сарнайн хувьсгал (2003), Украйн дахь “улбар шар хувьсгал” (2004), Киргизийн “алтанзул цэцгийн хувьсгал” (2005) зэрэг үйл явдлын нэгдмэл шинж чанар нь олон нийтийн эсэргүүцлийн үр дүнд эрх мэдэл солигдсон нь хүчирхийллийн бус шинж чанартай байдаг. Эрх мэдлийг өөрчлөх оролдлого эсвэл олон нийтийн эсэргүүцэл, тухайлбал 2005 оны Узбекистан дахь нөхцөл байдал, 2009 онд Молдав дахь олон нийтийн эсэргүүцэл, үймээн самуун зэрэг нь тодорхойгүй

байдаг. 2014 оны 2дугаар сард Украйнд засгийн эрх солигдсоныг мөн л “өнгөт хувьсгал”-тай холбон тайлбарлаж болох талтай. Үүний нэгэн адил “Арабын хавар” ч гэсэн ихэвчлэн тайван бус шинж чанартай олон нийтийн эмх замбараагүй байдал, эсэргүүцлийн хөдөлгөөнүүд багтаж байсан бөгөөд тэдгээр нь Арабын ертөнцийн хэд хэдэн улс оронд дэглэмийг нь өөрчлөхөд хүргэсэн юм. Эдгээр нь үндсэн хуулиар байгуулагдсан төр засгийг унагаах, солиход чиглэсэн төрийн аюулгүй байдлыг алдагдуулахад чиглэсэн хөдөлгөөн, мөргөлдөөн юм. Хүчирхийллийн бус аргаар явагдах “дайн”-ы асуудал нь дэлхийн цэргийн урлагт урьд өмнө хэзээ ч байгаагүй асуудлыг шинээр босгон тавьж байна.

Тавд, “Холимог дайн” (гибридная война, hybrid war)-ны мөн чанар нь өнгөт хувьсгалаас хүссэн үр дүн байхгүй тохиолдолд хатуу (хүчирхийллийн) болон зөөлөн (хүчирхийллийн бус) арга, хүчийг хамтад нь ашигладагт агуулагдаж байна. “Холимог дайн”-ы онцлог шинж чанар нь өнгөт хувьсгалтай харилцан уялдаатай байх, цэрэг, мэдээлэл, эдийн засаг, улс төр, нийгэм соёлын болон бусад салбарт, олон талт тэмцэл зэрэгцэн явагдах, нөхцөл байдалд дасан зохицох чадвар, түүнийг бэлтгэх, явуулах нөхцөл байдлын тасралтгүй шинжээр тодорхойлогдож байна. Энэ дайн, ердийн дайн шиг улс гүрний засаг, төрийн үндэс суурийг эвдэж, эдийн засгийг нь сүйрүүлж, дотоод нийгэм-улс төрийн байдлыг тогтворгүй болгох нэгдмэл төлөвлөгөөний дагуу өрнөж байна. Холимог дайнд ашиглаж буй олон төрлийн арга нь байнгын болон байнгын бус цэргийн бүлэглэл, хөлсний цэрэг, террористуудын үйлдлийн хоорондын зааг ялгааг бүдгэрүүлж, ялгаварлан гадуурхах хүчирхийлэл үйлдэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлээр нэмэлт аван явагдаж байна. “Холимог дайн”-д тодорхой шалгуур байхгүй, ашигладаг арга хэрэгсэл нь: байнгын бус цэргийн бүтцийг бий болгох, эмх замбараагүй байдал үүсгэх, зөрчилдөөнийг урьдчилан таамаглах, бэлтгэхэд ихээхэн хүндрэл учруулж байна.

Дээр дурдсан хувьсан өөрчлөгдсөн цэргийн уламжлалт болон цэргийн уламжлалт бус аюул, занал нь дэлхийн цэргийн урлагийн агуулгыг өргөжүүлэх, цэргийн стратеги, операц, тактикийг өөрчлөн хөгжүүлэх үндсийг тавьж байна.

Бараг XX зууны туршид, дайтагч талуудын нөлөөллийн гол объект нь хүн хүч байсан бол өнгөрсөн зууны төгсгөл, шинэ зууны эхэнд дайтагч талуудын нөлөөлөл нь мэдээллийн салбар, төр, засгийн удирдлага, түүний эдийн засаг руу шилжиж байна.

Томоохон хэмжээний дайныг эс тооцвол хязгаарлагдмал зорилготой бүс нутгийн болон орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд цэргийн хүчийг ашиглах цэргийн урлаг нь уламжлалт болон уламжлалт бус цэргийн аюулыг сөрөх түвшинд боловсруулагдаж байх учиртай.

Зэвсэг, цэргийн технологийн хөгжлөөрөө болон дайн, зэвсэгт мөргөлдөөнийг явуулах стратеги, тактикийн хувьд эрс ялгаатай улсуудын хоорондд дайн, зэвсэгт мөргөлдөөн үүсэж байгаа нь түүнийг цэргийн урлагт харгалзан үзэхийг нөхцөлдүүлж байна.

Стратегийн зорилгодоо хүрэхийн тулд, сонгодог стратеги (дайсныг бут цохих, даран туйлдуулах)-ээс гадна, хүч тэнцвэргүй дайн, зэвсэгт мөргөлдөөний стратеги (шууд бус стратеги) болон холимог дайн (гибридная война,)-ны стратеги - улс хоорондын тэмцлийг явуулах бүх аргуудыг ашиглах стратегийг практик дээр баримталж байна. Цэргийн стратегийн өөрчлөлт нь цэргийн операц, тактикт нөлөөлж байна.

Өнөөдөр цэргийн урлагийн онол нь дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага дээр үндэслэн, улс төр, газар зүй, эдийн засаг болон бусад хүчин зүйлийн нөлөөн дор, үндэсний шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан хөгжиж байна. Гэхдээ, ерөнхийдөө түүний төлөв байдал нь цэргийн хэргийн хөгжлийн түвшин, зэвсэгт тэмцлийн хэрэгслээр тодорхойлогдож байна.

Цэргийн урлагийн онолын боловсруулалтад юуг харгалзан үзэж байна вэ? Юуны өмнө дайн, зэвсэгт мөргөлдөөн дэх зэвсэгт тэмцлийн байлдааны ажиллагааны театрын уламжлалт орчин (газар, далай, агаар, сансарт)- д явуулах ажиллагаанд, нэлээд тохиолдолд эх газар дахь хуурай замын цэргийн байлдаанаас, агаар, сансар дахь байлдаан буюу агаарын цэргийн байлдааны ажиллагааны эзлэх хувь хэмжээ өсөж байна. Түүний үргэлжлэх хугацаа ч ихсэж байна. *Хоёрт*, дайн, зэвсэгт мөргөлдөөн дэх зэвсэгт тэмцлийн байлдааны ажиллагааны театрын уламжлалт бус шинэ орчин (мэдээллийн орчин, кибер орон зай, цахилгаан соронзон спектр)-д явуулах ажиллагааны эзлэх хувь хэмжээ нэмэгдэж байна. *Гуравт*, дайсныг ялахад, өнөө үед агаар, сансрын тагнуул, нисэх онгоц, пуужин, агаарын довтолгооноос хамгаалах болон радио цахим хэрэгсэл, агаарын довтолгооноос хамгаалах систем болон бусад зэвсэг шийдвэрлэх үүрэгтэй байна. Цаашид ч эдгээр нь зэвсэгт тэмцлийн хамгийн чухал чиг хандлага, онцлог шинж чанарыг илэрхийлэхийн хамт робот техник, нисэгчгүй нисэх төхөөрөмж зэргээр тодруулагдах төлөвтэй болжээ. Эдгээрийг харгалзсан онолын боловсруулалт аль эрт эхэлсэн ч, төгс цэгцэрч амжаагүй байна.

Харин АНУ тэргүүтэй барууны улс орон, НАТО-д цэргийн операцын түвшний гарын авлага, дүрэм, зааврыг олноор хэвлэн нийтэлж[2], сургалт, судалгаанд ашиглаж байна.

Зэвсэгт тэмцлийн бүх театрт байлдааны ажиллагаа явуулах чадавхыг нэгтгэх хэрэгцээ нь цэргийн урлагийн онолын хөгжлийн үндсэн асуудал болж байгаа бөгөөд дайсны эсрэг давамгайллыг хэрхэн олж авах, цэрэг, зэвсэгт хүчнийхээ эмзэг байдлыг хэрхэн багасгахад түүний агуулга, мөн чанар төвлөрч байна.

Өнөөгийн олон улсын төлөв байдлыг ажиглаваас: энх тайван цаг дэлхий даяараа багасаж, түүний хаа нэгэн цэгт дайн, зэвсэгт мөргөлдөөн

[2] FM 100-6. Information operations. 1996; FM 3-13 (FM 100-6). Information Operations: Doctrine, Tactics, Techniques, and Procedures. 2003; FM 3-13. Field manual. Information operations. 2016; FM 3-12. Cyberspace and elecrtonic warfare operations. 2017; FM 6-0. C1. Commander and Staff Organization and Operations. 11 May 2015; FM 3-53. Joint Psychological Operations Doctrine. 5 September 2003;

явагдсаар, уламжлал бус дайн, мөргөлдөөний цар хүрээ тэлсээр байна. Эдгээр нь "дайн, энх тайван" байдлын хоорондын зааг ялгааг бүдгэрүүлэх, түүний үр дагаврыг олон улсын хэмжээнд, нийт хүн төрөлхтөн амсаж, зовох төлөв хандлагатай болоод байна.

Байлдааны дүрэм, заавар, гарын авлага: цэргийн урлагийн хөгжлийн практик, онолын боловсруулалтад тулгуурлан бүх цэргийн алба хаагч эх орноо хамгаалах, аюулгүй байдлаа хангахын тулд ямар тактикаар ажиллах, даргалах бүрэлдэхүүн түүнийг хэрхэн зохион байгуулж, удирдаж хэрэгжүүлэхэд удирдамж болох дүрэм, заавар, гарын авлагыг боловсруулан гаргадаг учиртай. Энэ талаар эрдэмтэн судлаачид онол, арга зүйн санал, зөвлөмжөө гаргадаг, түүнийг бодит ажил болгох асуудал нь ЗХЖШ болон төрөл, тусгай мэргэжлийн цэргийн дарга, түүний штабын үндсэн ажил юм.

Манай цэргийн урлаг судлаач эрдэмтэд сүүлийн жилүүдэд цөөнгүй бүтээл туурвилаа хэвлэн нийтлүүлж[3], сургалт, судалгааны эргэлтэд оруулсаар байна. Мөн тактикийн түвшний дүрэм, заавар, гарын авлагыг боловсруулах зөвлөмж, саналаа гаргаж, холбогдох албан тушаалтнууд танилцах боломжийг[4] ч гаргаж байгаа юм.

Өнөөгийн байдлаар уламжлалт бус дайн, зэвсэгт мөргөлдөөнтэй тулгарах, байлдааны ажиллагааны шинэ орчин, театр (мэдээллийн орчин, кибер орон зай, цахилгаан соронзон спектр)-т цэргийн ажиллагааны явуулахад хүрвэл цэргийн алба хаагч эх орноо хамгаалах, аюулгүй байдлаа хангахын тулд ямар тактикаар ажиллах, даргалах бүрэлдэхүүн түүнийг хэрхэн зохион байгуулж, удирдаж хэрэгжүүлэхэд удирдамж болох дүрэм, заавар, гарын авлага байхгүй шахам байгаад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зэвсэгт хүчний жанжин штабын удирдлага дүгнэлт хийх шаардлага, хэрэгцээ бий болсон байна гэж үзэж байна.

Байлдааны бэлтгэл, сургалтын өнөөгийн төлөв байдал: Аливаа урлаг онолын боловсруулалттай, удирдамж, заавартай байсан ч гүйцэтгэх бэлтгэлийг хангаагүй, жинхэнэ ёсоор түүнийг гүйцэтгэх урьдчилсан жигдрэлтийг хангаагүй бол урлаг гэж үнэлэхэд учир дутагдалтай байдаг. Энэ үнэлгээ цэргийн урлагт бүр их хамааралтай. Цэргийн урлаг бол асар их үнэ цэнээр босдог, оролцогчийн тоо, ажиллагааны театрын цар хүрээ зэргээрээ нэн ялгаатай, үр дүн, бүтэмжээрээ эрхэмд тооцогддог учраас бусад урлагаас ихээхэн ялгаатай юм.

Зэвсэгт хүчний өдөр тутмын үндсэн хөдөлмөр бол эх орноо хамгаалах бэлтгэлийг хангахад чиглэсэн байлдааны бэлтгэл, сургалт юм. Цэргийн сургалт бол бусад сургалтаас ихээхэн ялгаатай, улс, нийгэм, нийт ард түмний эрх ашгийн төлөөх сургалт, цэргийн урлагийн хөгжлийн бодит

[3] Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. -400х. ISBN 978-99978-1-454-8; Цэргийн операцын урлаг. УБ., 2020 он. -432х. ISBN 978-9919-9597-1-5; Цэргийн ерөнхий тактик. 2020 он, -750х; ISBN 978-9919-95972-2-2;

[4] Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2021 он.№32(42). т.145-145. Ш.Паламдорж. Байлдааны дүрэм боловсруулах асуудлаарх судлаачийн зөвлөмж өгүүлэл;

илэрхийлэл нь болдог. Цэргийн сургалт өнгөрсөн түүхэн уламжлалд тулгуурлахаас гадна өнөө болон ирээдүйд учирч болзошгүй дайн, зэвсэгт мөргөлдөөнд бэлтгэх сургалт байдаг. Зэвсэгт хүчний байгуулалт, цэргийн сургалт бол ёс төдий өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, төр, засаг, ард түмний өмнө хүлээсэн хүнд, хэцүү үүрэг, даалгаврыг биелүүлэхэд чиглэн хэрэгжиж байх зүйл юм. Цэргийн сургалт нь тайван цагт хөлс их урсгасан, эрсдэл өндөртэй, заавал суралцсан, сургасан байх учиртай, нөр их хөдөлмөрийн үр шимээр хэрэгждэг "байлдаж байгаа юм шиг нөхцөлд" явагддаг сургалт. Энэ сургалт өнгөрсөн дайны сургамжид тулгуурлан явагддаг болохоос биш тийм дайнд бэлтгэх сургалт биш юм.

Манай Зэвсэгт хүчин мэргэжлийн чиг баримжаатай хөгжиж нэлээдгүй хугацааны дараагаар мэргэжлийн цэрэгт суурилсан сургалтад шилжээд байгаа боловч ийм сургалтынхаа тогтолцоонд өнөөг хүртэл шилжиж чадаагүй явна. Сургалтын шинэ тогтолцоонд шилжих онол, арга зүйн асуудлаар хэдэнтээ онол, практикийн эрдэм шинжилгээний хурал хийсэн[5] боловч, түүний үр дүн, зөвлөмжийг хэрэгжүүлж чадаагүй байна. ЗХЖШ сургалтынхаа тогтолцоог төрөл, мэргэжлийн цэргийн болон цэргийн нэгтгэл ангийн бие бүрэлдэхүүний онцлог, тайван цагт гүйцэтгэж байгаа үүргийг харгалзан шинэчилж чадаагүй байгааг судлаач миний хувьд, сургалтын шинэчлэлийн зорилго, зорилт, шинэчлэх объект, зүйлээ тогтоож чадахгүй, шинэчлэлийн стратеги, тактикаа боловсруулж чадахгүй байгаатай холбон үзэж байгаа юм.

Судлаачийн үзэл бодол, гаргалгаа тайлбарыг авах гээхийн ухаанаар хандах нь төрийн тусгай албан хаагч болох цэргийн мэргэжилтэн, командлах, захирах эрх бүхий бүрэлдэхүүний эрх хэмжээний асуудал мөн боловч, түүнд хайнга хандах аваас тэднээс хариуцлага нэхэх асуудал мөн болохыг сануулахад илүүдэхгүй хэмээн үзэж байна.

Цэргийн мэргэжилтэн, судлаачид үндэсний цэргийн урлагаа хөгжүүлэхэд чиглэсэн практик ажиллагаа, судалгаа, шинжилгээний ажил эрхлэх нь эх оронч, нэр төрийн хэрэг мөн боловч амар, хөнгөн хөдөлмөр биш юм. Цэргийн мэргэжлийн боловсрол, эрдмийн зэрэг, цол хэргэм зэргээс гадна практик дадлага, туршлага, дүн шинжилгээ хийх чадвар, шинэ асуудлыг шийдвэрлэх арга ухаан, практикт нэвтрүүлэх хичээл, зүтгэл, шинэ арга замыг биднээс шаардсаар байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он. -186х. ISBN- 978-99978-848-3-1;
2. Б.Түмэн. Оперативын урлаг. УБ., 2021 он. – х ;
3. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2021 он.№32(42). т.51-59. Р.Энхболд. Хориглох операцад бэлтгэж, явуулах онолын хөгжлийн үндсэн хандлага;
4. FM 100-6. Information operations. 1996; FM 3-13 (FM 100-6).

[5] Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. УБ., 2016 он. -168х. ISBN 978-99962-50-50-7;

5. Information Operations: Doctrine, Tactics, Techniques, and Procedures. 2003;
6. FM 3-13. Field manual. Information operations. 2016;
7. FM 3-12. Cyberspace and elecrtonic warfare operations. 2017;
8. FM 6-0. C1. Commander and Staff Organization and Operations. 11 May 2015;
9. FM 3-53. Joint Psychological Operations Doctrine. 5 September 2003;
10. Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. -400х. ISBN 978-99978-1-454-8;
11. Цэргийн операцын урлаг. УБ., 2020 он. -432х. ISBN 978-9919-9597-1-5;
12. Цэргийн ерөнхий тактик. 2020 он, -750х; ISBN 978-9919-95972-2-2;
13. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. ISSN 2220-9115. 2021 он.№32(42). т.145-145. Ш.Паламдорж. Байлдааны дүрэм боловсруулах асуудлаарх судлаачийн зөвлөмж өгүүлэл;
14. Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоонд хийсэн шинжилгээ. УБ., 2016 он. -168х. ISBN 978-99962-50-50-7;

Монгол Улсад терроризмоос үүсэх аюулын эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй гадаад, дотоод зарим хүчин зүйлийн нөлөөлөл

С.Пүрэвдорж
БХЭШХ-гийн Дайн, цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Abstract

Our country has been identified as a relatively low threat by the International Terrorism Situation Index, but it is not possible to directly assess the threat and consider it a risk-free country. It will describe the impact of some external and internal factors witch may increase the risk of terrorism in Mongolia, and the further actions to reduce and eliminate risks.

Keywords*: Pisk, format pisk, conditions that may increase the pisk, pisk reduction/mitigation, pisk stpact.*

Дэлхийн улс, хүн ам терроризмын аюул заналаас ангид байна гэж үгүй бөгөөд терроризм, түүний аюул заналын эрсдэл ямагт байсаар ирсэн. Аюул заналын хэмжээ, цар хүрээ өргөжин тэлсээр байгаа нь асуудлын гол нь юм.

Манай улсын Терроризмтой тэмцэх зөвлөлөөс 2015 оноос эхлэн “Монгол Улсын терроризмын аюулын эрсдэлийн үнэлгээ”-г жил бүр боловсруулж, УАБЗ болон төрийн аюулгүй байдлыг хангах холбогдох байгууллагуудад эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлсээр иржээ. Энэхүү эрсдэлийн үнэлгээгээр манай улсын терроризмын аюулын эрсдэл “багаас дээш дунд түвшинд” эрсдэлтэй хэмээн үнэлэгдсэн байна.

Зарим судлаач, эрдэмтэд Монгол Улсад терроризмын аюул занал байхгүй, эрсдэлгүй гэсэн байр сууриа илэрхийлдэг хэдий ч бодит нөхцөл байдал дээр ямар байгаа, чухамхүү юунд тулгуурлаж уг байр суурийг илэрхийлж байгаа вэ гэдгээ тайлбарлах нь чухал юм.

Манай улс Олон улсын терроризмын нөхцөл байдлын индексээр терроризмын аюул занал харьцангуй бага хэмээн тодорхойлогдсон хэдий ч аюул заналыг шууд үнэлж, эрсдэлгүй улс гэж үзэх боломжгүй байна. Нөгөө талаас энэхүү индекс нь зөвхөн дэлхийн улс орнуудад үйлдэгдсэн

террорист гэмт хэрэг, халдлага болон түүний улмаас амь насаа алдсан иргэдийн тоон мэдээнд үндэслэдэг. Тиймээс эрсдэлийг нэмэгдүүлж буй гадаад болон дотоод хүчин зүйлс ямар түвшинд байгаа, түүнээс нөлөөлж болзошгүй асуудал юу байгааг тодорхойлж байж сая эрсдэлтэй юу, үгүй юу гэдгээ мэдэх учиртай юм. Эрсдэлийг нэмэгдүүлж буй гадаад хүчин зүйлээс олон улсын террорист байгууллага, тэдгээрийн гадаад террорист дайчид (foreign terrorist fighters)-ын гуравдагч улс орнууд уруу шилжиж буй шилжилт хөдөлгөөн ихээхэн анхаарал татаж байна.

Тухайлбал, сүүлийн 5 жилийн хугацаанд террорист байгууллагад дэлхийн 120 орчим улсаас 50 мянга гаруй иргэн эх орноо орхиж, гишүүнээр элссэн тоо баримт байдаг байна[1].

Террорист байгууллагуудын эсрэг дэлхийн улс орнууд цэргийн ажиллагааг идэвхтэй явуулсны дүнд үйл ажиллагааных нь хүрээ хумигдаж байгаа хэдий ч, гишүүд нь гуравдагч улс орнууд уруу шилжих, нэвтрэн суурьших, улмаар террорист халдлага үйлдэх аюул заналыг нэмэгдүүлэх хандлага бодитой байгаагийн илрэл болж байна. Манай улсын хувьд эдгээр этгээдүүд нэвтрэн орж ирж болзошгүйг олон улсын байгууллагуудаас анхааруулсаар байна.

Дотоод хүчин зүйлсийн тухайд террорист үйлдэлд ашиглагдаж болзошгүй зэвсэг, хэрэгслийн хяналт сул, олон нийтийн сүлжээ зэргээр дамжуулан суртал ухуулга явуулах, гишүүн элсүүлэх, мансууруулах бодисын хууль бус эргэлт болон зам, холбоо харилцаанд тавих хяналт сул, терроризмын суурь нөхцөл үүсэн бүрэлдэх эрсдэлтэй, терроризмтой тэмцэх байгууллагуудын чадавх хангалтгүй зэргийг дурдаж болох байна.

Тухайлбал, “Ковид-19” цар тахлын үед буюу өнгөрсөн 2021 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 187 бүртгэгдсэнийг 2020 оны мөн үетэй харьцуулахад 8,0 хувиар, холбогдон шалгагдсан сэжигтэн 22,8 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан хэдий ч эд мөрийн баримтаар хурааж авсан бодисын хэмжээ 26,8 хувиар өссөн байна. Тодруулбал, 2021 онд илрүүлж хураан авсан бодисын хэмжээ 10,0 мянга орчим хүн тун хэмжээгээр өссөн байна. Гол шалтгаан нь олон улсын шуудан илгээмж ашиглан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөгч бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг өссөнтэй холбоотой юм. Сүүлийн таван жилийн хугацаанд Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэргийн 40,0 орчим хувийг газрын боомтоор нэвтрүүлсэн хэрэг, 4,0 хувийг агаарын боомтоор, 56,0 хувийг шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан улсын хилээр нэвтрүүлсэн хэрэг эзэлж байна. Олон улсын шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан нэвтрүүлсэн хэрэг 2020 - 2021 онд өсөж, газрын боомт, агаарын хилийн боомтоор нэвтрүүлсэн хэрэг буурсан байх жишээтэй.

Сүүлийн үед “метамфетамин”[2] дэлхийн хар зах зээлд ихээр

[1] UN Counter Terrorism Strategy and White paper;

[2] “Метамфетамин” буюу “мөс” гэдэг мансууруулах бодис, хамгийн их хорт үйлчилгээтэй накотик. Анх 1919 онд японы эрдэмтэн Акира Огата нээж гаргажээ. 1938 оноос Германд ихээр үйлдвэрлэж эхэлсэн;

нийлүүлэгдэж, энэ төрлийн бодисыг их хэмжээгээр тээвэрлэх, нийлүүлэх гэмт хэрэг огцом өсөх хандлагатай байна. Шинэ төрлийн мансууруулах бодисын зах зээл өргөжин тэлж байгаа улс орнуудын тоонд ОХУ, БНХАУ багтаж, тухайн улсуудад энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил ирэх тутам өссөөр байна.Үүнийг дагаад хөрш улсуудаас гадна Турк улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис манай улсад нэвтрүүлэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж болзошгүй байна. Тухайлбал, 2022 оны гуравдугаар сард 945 грамм хэмжээтэй мансууруулах бодисыг шуудан илгээмж ашиглан хууль бусаар хилээр нэвтрүүлсэн үйлдлийг илрүүлэн, бодисыг хураан авч, мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн таван жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой 939 гэмт хэрэгт 1173 сэжигтэн бүртгэгдсэнээс 91,0 хувь нь эрэгтэй, 8,9 хувь нь эмэгтэйчүүд, нийт холбогдогчдын 92,2 хувийг 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгч, донтогч нарын насны байдал залуужиж, 13-25 насны хүүхэд залуучууд ихээр гэмт хэрэгт холбогдох хандлагатай байна. Хүүхэд, залуучуудыг хар тамхи, мансууралд оруулж байгаа гол зүйлийн нэг бол хар тамхины талаар тодорхой мэдлэггүй байх, цахим орчноос болон гадаадад амьдарч байсан хэн нэгнээс худал мэдээлэл авах явдал юм.

Мөн Монгол Улсад хориглосон болон хэрэглээ нь хязгаарлагдмал мансууруулах эм, бодисын агууламжтай, жорын дагуу олгогддог эм, бэлдмэлийг хууль бусаар олж авах, хадгалах, хэрэглэх, цахим сүлжээ ашиглан ил болон далд хэлбэрээр худалдаалж байгаа хууль бус үйлдэл нэлээд бүртгэгдэж байгаа тул эцэг, эхчүүд хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьж, хар тамхийг сурталчилсан мэдээллээс ангид байлгахад анхаарах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн талаас тухайн эм, бодисыг нэг удаа хэрэглэснээр төв мэдрэлийн системд нөлөөлж, сэтгэцийн болон бие махбодын хамааралд орж, хар тамхинд донтох өвчтэй болсноор хувийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээ нь зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис руу тэмүүлэх хүслээр солигдож, оюун ухаан доройтож, бүх эрхтэн системийг өвчлүүлж, тухайн эрхтэнд хавдар үүсэхээс гадна В, С гепатит, бэлгийн замын халдварууд, ХДХВ/ДОХ гэсэн өвчинд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, тун хэтрүүлсэн тохиолдолд шууд үхэлд хүргэх аюулын эрсдэлтэй.

Хуульд заасны дагуу тагнуулын байгууллага нь зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхэд тэргүүлэх чиг үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч энэхүү тэмцэл нь дан ганц нэг байгууллагын оролцоонд тулгуурлаж байсан түүхгүй ажээ.

Терроризмын аюулын эрсдэл дараах хэлбэрээр илэрч болзошгүй байна. Тухайлбал:

- Программ болон техник хангамжийн эрсдэл;
- Албан хаагчдын мэргэжлийн болон бие хүний ёс суртахуунаас үүсэх

эрсдэл;

- Ажиллагсдын компьютер болон аюулгүй ажиллагааны хангалттай бус мэдлэгтэй холбоотой эрсдэл;
- Интернэт болон электрон шуудангийн эрсдэлүүд;
- Дотоод, гадаад сүлжээний эрсдэлүүд;
- Мэдээлэл дамжуулалт, холбооны технологийн эрсдэл;
- Мэдээлэл хадгалалт, тээвэрлэлтээс үүсэх эрсдэл;
- Мэдээлэл санаатай болон санамсаргүй алдагдах эрсдэл;
- Байгалийн гамшгийн эрсдэл;
- Өрсөлдөгчийн тагнуулын үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл;
- Мэдээлэл сэтгэл зүйн дайн буюу кибер терроризмын эрсдэл гэх мэт болно.

Терроризмын аюул занал, түүний эрсдэлийг бууруулах, түүнтэй амжилттай тэмцэхийн үндэс нь хамтын хүчин чармайлт байсаар ирсэн. Тийм учраас терроризмтой тэмцэх үйл ажиллагаа нь иргэн, олон нийтийн байгууллага, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг туслалцаанд тулгуурлаж явагддагийг НҮБ болон олон улсын бусад байгууллагаас ч гишүүн улс орнуудад зөвлөмж болгосоор байгаа билээ.

Дэлхийд террорист байгууллагын гадаад террорист дайчдын шилжилт хөдөлгөөн тулгамдсан асуудал болж, Ирак, Сирийн бүс нутгаас шахагдаж, гуравдагч орон уруу нэвтрэхийг санаархаж байгаа аж. Ойрх Дорнодын нөхцөл байдлаас шалтгаалж террорист этгээдүүд шилжин суурьших хамгийн таатай улс, бүс нутагт Төв Ази орсон байна.

Шашин болон зохион байгуулалттай гэмт хэрэг, тэр дундаа хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, газар зүйн байршил зэрэг нь Төв Азид террорист этгээд шилжин суурьших таатай нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн тэд үйл ажиллагааныхаа арга хэлбэрийг өөрчилж, тухайлбал, цахим орчинд үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, жижиг бүлэг, бүлэглэл өөрсдийн санхүүжилтийн эх үүсвэрээ бие даан шийдвэрлэх болсон байна. Түүнчлэн халдлага үйлдэхдээ шинэ технологи, цацраг идэвхт бодис, химийн, биологийн хэрэгсэл ашиглахыг эрмэлзэх болжээ.

Монгол Улсын Их хурлаар 2019 онд батлан мөрдүүлж байгаа "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль"[3]-д зааснаар Тагнуулын байгууллага нь терроризмтой тэмцэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, холбогдох төрийн байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий Терроризмтой тэмцэх зөвлөлийг Тагнуулын ерөнхий газар тэргүүлж

[3] "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль". Төрийн мэдээлэл. 2019 он. № 41 (1044). 1514 – 1533. 10 дугаар зүйл. 10.1.1;

бүрэлдэхүүнд нь 19 байгууллагын удирдлага, мэргэшсэн албан хаагчид ажиллаж байгаа юм.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд зааснаар зөвлөлийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд, албан тушаалтан заавал биелүүлэх үүрэг хүлээдэг байна.

Монгол Улсад өнөөгийн байдлаар албан ёсны бүртгэлтэй олон улсын болон гадаадын 95 төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газар байгаагаас 85 нь улс төр, эдийн засаг, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэг, нийгмийн халамжийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна[4].

Эдгээрийн дийлэнхийг Америк, ХБНГУ, БНФУ, ИБУИНВУ, БНСУ-ын байгууллагууд эзэлж байна. Тухайлбал, АНУ-ын "Азийн сан", "Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн", "Мерси кор Интернэшнл", "Жорж Соросын Нээлттэй нийгэм хүрээлэн", "Энх тайвны корпус", ХБНГУ-ын "Конрад Аденаурын сан", "Ханнс Зайделийн сан", "Фридрих Эбэртийн сан" зэргийг дурдаж болох юм. Олон улсын болон гадаадын ТББ-уудаас хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон хурал, уулзалтын үеэр иргэний нийгмийн байгууллагуудын нийгмийн ач холбогдол, хөгжлийн талаар түлхүү ярьж, төрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, илүү идэвхтэй ажиллах шаардлагатай талаар зөвлөх болсон.

Тэдний зүгээс нийгэм, улс төр, эдийн засаг, хөгжлийн чиг хандлага, хүний эрх, эрх чөлөө, соёл, боловсрол зэрэг бүхий л салбарт идэвхтэй, чөлөөтэй үйл ажиллагаа явуулж байна. Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд Их хурлын гишүүд, төрийн алба хаагчид, намын боловсон хүчин болон тэдгээрийн хүүхдүүдийн зардлыг нь даан гадаадад урт болон богино хугацааны сургалтад хамруулдаг.

Гадаадын ТББ-уудын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудтай түлхүү харилцаж дэмжлэг үзүүлж байгаа нь анхаарал татдаг. 2016 оны байдлаар олон улсын болон гадаадын ТББ-ын салбар төлөөлөгчийн газраас Монгол Улсад гол төлөв байгаль орчин, хүмүүнлэг, засаглалын ил тод байдлыг бэхжүүлэх, хөдөө аж ахуй, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, залуу манлайлагчдыг бэлтгэх зэрэг төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж 130,040,817,388 (өссөн дүнгээр) төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд цаашид өсөх хандлагатай байна[5].

Төрийн бус байгууллагуудад дараах нийтлэг дутагдал, эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл ажиглагдаж байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллагууд нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар манай улстай холбоотой их бага хэмжээний мэдээ мэдээллүүдийг авч ашигладаг, гагцхүү түүнийг ямар зорилгоор цуглуулдаг эсэх нь тодорхойгүй;
- Зарим төрийн бус байгууллагуудын арилжааны банк дахь

[4] https://www.mongolbank.mn;
[5] Төн тэнд;

харилцах дансанд их хэмжээний мөнгө тодорхойгүй шалтгаанаар хуримтлагдсаар ирсэн тохиолдлууд гарч байгаа;

- Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дийлэнх төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газрууд нь иргэдэд мөнгө, санхүүгийн тусламж үзүүлэх нэрийдлийн дор далдуур шашны үйл ажиллагаа явуулж, улмаар хууль зөрчиж үйл ажиллагаа явуулж байгаа;
- Зарим гадаадын хөрөнгө оруулалттай салбар төлөөлөгчийн газрууд нь донор буюу хандивлагч байгууллагуудаас ирүүлж буй санхүүжилтийг юунд зарцуулж буй эсэх нь тодорхойгүй байдал гарснаар байгаа;
- Гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллагуудын дийлэнх хувь нь санхүүгийн тайлангаа хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагад хүргүүлдэггүй, мэдээлдэггүй байдал гарч байгаа зэрэг болно.

Монгол Улсын ихэнх хилийн боомтууд гаалийн хяналт шалгалтын зориулалт бүхий техник тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, зарим техник хэрэгслүүд нь хоцрогдсон, хүрэлцээгүй байна. Хилийн байгууллагууд нэгдсэн нэг сүлжээнд холбогдоогүй, зарим байгууллагын үйл ажиллагаа нь цахимд шилжээгүй, мэдээллээ солилцох үйл ажиллагаа нь бүрдээгүйгээс хилээр нэвтрэх зорчигч, бараа тээврийн хэрэгслийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй бүртгэл, мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаанууд нь давхардсан шат дамжлагыг бий болгож байна.

Улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд 18 гаалийн газар, хороогоор дамжуулан хяналт тавих үйл ажиллагааг явуулж байна. Хилийн боомтууд хэт алслагдсан байдал, дэд бүтцийн хөгжил тааруу, боомтын техник, тоног төхөөрөмжийн хангалт муу байгаа нь терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг бодитой хэрэгжүүлэхэд хүндрэлтэй бөгөөд энэ чиглэлээр тусгайлсан сургалт явагддаггүй, мэдээлэлгүй байгаа нь хил хяналтын байгууллагаас хяналт, шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Хэдийгээр хил хяналтын байгууллагад терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл авагдаагүй боловч террорист гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, энэ асуудалтай холбоотой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрхэн, ямар арга хэмжээ авах талаар мэдлэг, мэдээлэл хомс байна.

Түүнчлэн хилийн боомтууд, түүнд үйл ажиллагаа явуулж буй хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчдын мэдлэг, ур чадварын байдал, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хангалт, тээвэр, логистикийн дутагдалтай байдал болон улсын хилээр нэвтрэх ачаалал боомт тус бүрд харилцан адилгүй байгаа зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

Хил, гаалийн байгууллага “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”[6]-ийн болон “Зөрчлийн тухай хууль”[7]- ийн холбогдох заалыг хэрэгжүүлж буй боловч терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тусгайлсан бодлого, журам байхгүй байна. Гаалийн байгууллагаас бэлэн мөнгө, үнэт металл болон үнэт эдлэлд гаалийн өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаарх мэдээг судлан үзэхэд, НҮБ-аас баталсан хориглосон, хязгаарласан бараанд хяналт тавих эрх зүйн зохицуулалт байхгүй. Зөвхөн Монгол Улсын Засгийн газар, УИХ-аас тогтоосон хориглосон, хязгаарласан бараанд хяналт тавьдаг. Гаалийн байгууллагаас хоёрдмол зориулалттай бараанд гаалийн хуульд заасан хяналт шалгалтын хэлбэрүүдийг л хэрэглэж байгаа тул хоёрдмол зориулалттай барааны жагсаалт, түүнд тавих тусгайлсан хяналт тавих чиг үүрэг нь одоог хүртэл зохицуулалтгүй байсаар байна. Иймд манай улсын экспорт, импорт, дамжин өнгөрсөн бүртгэл мэдээлэлд тэдгээр тоо, мэдээ орохгүй байгаа нь хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүнийг терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх зорилгоор нэвтрүүлэх эрсдэлтэй байна.

Нөгөө талаас энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах байгууллагын дотоод төлөвлөлт, зохион байгуулалт, мэдээлэл солилцох журам байхгүй зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Учир нь гаалийн байгууллагын өнөөгийн тогтолцоонд энэ чиглэлийн тусгайлсан чиг үүрэг, хяналт тавих нэгж, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

Гаалийн байгууллагын бодлого, төлөвлөгөөнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг оруулах, эрх зүйн зохицуулалт хийх, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх, бодлогоор дэмжих, санхүүжүүлэлт хийх, бүтэц зохион байгуулалтын ажил зайлшгүй хийгдэх шаардлагатай байна.

Эрсдэлийг цаашид бууруулах, арилгахад чиглэсэн дараах үйл ажиллагааг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна[8]. Үүнд:

Нэг. Монгол Улсын Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлд танилцуулж, эрсдэл ихтэй салбаруудад чиглэсэн эрсдэлийг бууруулах, арилгах зөвлөмж боловсруулж үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;

Хоёр. Монгол Улсын Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг цаашид иж бүрнээр үнэлж гаргах, эрсдэлийн үнэлгээ гаргах арга, аргачлалын стандартыг боловсруулж мөрдүүлэх;

Гурав. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг

[6] “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль” - ийн 15 дугаар зүйл, 15.1;

[7] “Зөрчлийн тухай хууль” - ийн 5.12.3 дахь заалт;

[8] https://www.mongolbank.mn;

дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний дагуу Монгол Улсын Терроризмтой тэмцэх үндэсний стратегид холбогдох байгууллагуудад чиглэсэн эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээний санал, зөвлөмж, чиглэлийг боловсруулж тусгах;

Дөрөв. Монгол Улсын хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүний эрсдэлийн талаар төрийн бүх байгууллагын түвшинд ойлголт, мэдлэг мэдээлэл олгох сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах;

Тав. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх төрийн зохицуулагч байгууллага хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлж сайжруулах;

Зургаа. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авахтай холбоотой эрх зүйн орчин зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны давхцал, хуулийн цоорхой, дэглэмийн давхардлыг арилгах;

Долоо. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хяналт тавих эрх бүхий байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагааг олон улсын түвшинд нийцүүлэн хэрэгжүүлэх ажлыг шат дараалан авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Дээрх байдлаас дүгнэлт хийхэд, эрсдэл бүхий салбар, чиглэл, байгууллага, тэдгээрийн ажилтан, албан хаагчдын терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны бэлэн байдал, хариу арга хэмжээ авах төлөвлөлт, зохион байгуулалт, мэргэшсэн болон чиглэл хариуцсан албан хаагчдын бэлтгэгдсэн байдал, мэргэжлийн түвшин, анхаарал сонор сэрэмж хангалтгүй түвшинд байгаа нийтлэг дутагдал илэрч байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Мөн түүнчлэн тухайн салбар, байгууллага, чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа, үйлчилгээ, хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, боловсруулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйгээс шалтгаалан энэхүү гэмт хэрэгт өртөх, ашиглагдаж болзошгүй нөхцөл байдалтай байна.

Нөгөө талаас тухайн эрсдэл бүхий салбар, байгууллага, чиглэлд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хувьд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй

тэмцэх гэмт хэргийн талаарх зохих түвшний мэдлэг, мэдээлэлгүй байдал, мэргэшсэн албан хаагч болон чиг үүрэг бүхий нэгжгүй байгаа байдал, салбар, байгууллага хоорондын харилцаа хамтын ажиллагааны дутагдалтай байдал, мэдээлэл солилцооны шуурхай байдал алдагдсан нь мөн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. UN Counter Terrorism Strategy and White paper;
2. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”. Төрийн мэдээлэл. 2019 он. № 41 (1044). 1514 – 1533;
3. https://www.mongolbank.mn;
4. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”. 2013 он. 15 дугаар зүйл;
5. “Зөрчлийн тухай хууль”. 2017 он. 5 дугаар бүлэг;

ХАЧА-ийн пуужинт цэргийн шинэчлэл

Б.Эрдэнэчимэг
БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, доктор, дэд профессор, хурандаа

М.Хонгорзул
ҮБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төвийн дарга, докторант, дэд хурандаа

Abstract

To develop its armed forces, The People's Republic of China is attaching great importance to its nuclear power while People's Liberation Army Rocket Force has been carrying out activities on intensifying informatization, developing weaponry and equipment's innovation, improving secure, reliable and effective operations of rockets, enhancing joint system of normal and nuclear power , and increasing possibility of showing intimidation in strategic level and carrying out mid and long range strike accurately in a short period of time following certain planning and phases.

Within this framework, in addition to the PLA Rocket Force's acquisition of new rockets, the main concerns include the structure, stationing in regions of strategic importance, and designating areas for training facilities of the Rocket Force.

Keywords: *PLA, Rocket Force, nuclear power*

БНХАУ нь Зэвсэгт хүчнийхээ байгуулалтыг хөгжүүлэхдээ өөрийн улсын цөмийн хүчинд ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд ХАЧА-ийн пуужинт цөмийн цэрэг нь мэдээлэлжүүлэх байгуулалтыг эрчимжүүлж, зэвсэглэл техникийн инновацыг хөгжүүлж, пуужингийн аюулгүй, найдвартай, үр ашигтай байдлыг дээшлүүлж, ердийн болон цөмийн хүчний хосолсон тогтолцоог сайжруулж, стратегийн сүрдүүлэг үзүүлэх, богино хугацаанд дунд болон алсын зайнд оновчтой цохилт өгөх боломжийг нэмэгдүүлэхээр тодорхой төлөвлөлт, үе шаттайгаар ажиллаж байна. Энэ хүрээндээ ХАЧА Пуужингийн цэргийн зэвсэглэлдээ шинээр пуужин хүлээн авч байгаагаас гадна пуужинт цэргийн бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийг стратегийн чухал ач холбогдолтой бүсүүдэд байрлуулах, пуужинт цэргийн сургалт бэлтгэл явуулах газар орон нутгийн онголт, байрлал зэрэг анхааран судлах асуудал болж байна.

Пуужинт цөмийн цэрэг

Пуужинт цөмийн цэрэг нь мэдээлэлжүүлэх байгуулалтыг эрчимжүүлж, шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан, зэвсэглэл техникийн инновацыг хөгжүүлж, пуужингийн аюулгүй,

найдвартай, үр ашигтай байдлыг дээшлүүлж, ердийн болон цөмийн хүчний хосолсон тогтолцоог сайжруулж, стратегийн сүрдүүлэг үзүүлэх, богино хугацаанд дунд болон алсын зайнд оновчтой цохилт өгөх боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

БНХАУ нь Зэвсэгт хүчнийхээ байгуулалтыг хөгжүүлэхдээ юуны өмнө өөрийн улсын цөмийн хүчинд ихээхэн анхаарал хандуулж, газрын байрлалтай стратегийн зэвсэглэлийнхээ байлдааны боломжийг дээшлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөгөө үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна.

ХАЧА-ийн Пуужинт цэрэг нь ойрын зайн, дунд тусгалын, алсын зайн болон тив алгасагч пуужингуудаар тоноглогдсон бөгөөд Пуужинт цэргийн анги, нэгтгэлүүдийг байгуулж, хуучин пуужингийн системүүдийг шинэчилж, пуужингаас хамгаалах системийг улам бүр боловсронгуй болгож байна.

Пуужинт цэргийн хүчний бие бүрэлдэхүүний тоо 120 000 байна[1].

Пуужинт цэргийн хүчний зэвсэг техник: ХАЧА-ийн Пуужинт цэргийн хүчин нь стратегийн пуужингийн хүчээр дайсанд хариу цохилт өгөх, ердийн пуужингаар байлдааны ажиллагаа явуулах үндсэн хоёр үүрэгтэй. ХАЧА Пуужингийн цэргийн зэвсэглэлд шинээр 6 пуужин хүлээн авсан ба 13000-15000 км-ийн тусгалтай тив алгасагч баллистик пуужин DF-41, 8000-9000 км-ийн тусгалтай шумбагчид суурилуулсан баллистик пуужин JL-2, дуунаас хэт хурдан нисгэгч төхөөрөмж бүхий DF-17, далавчит пуужин YJ-12B, YJ-18, CJ-100 зэргийг БНХАУ байгуулагдсаны 70 жилийн ойн цэргийн ёслолын жагсаалын үеэр танилцуулсан.



Зураг 1. Дунфэнг-41

ХАЧА-ийн тив алгасагч баллистик пуужингууд дотроос 13000-15000 км-ийн тусгалтай “Дунфэнг-41” пуужин хамгийн хол тусгалтай нь бөгөөд АНУ-ын эх газарт 30 минутын дотор хүрэх чадавхтай гэж тооцоологджээ[2].

[1] International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020)

[2] Missile Defense Project, “DF-41 (Dong Feng-41 / CSS-X-20),” Missile Threat, Center for Strategic and International Studies, August 12, 2016, last modified October 8, 2019, https://missilethreat.csis.org/missile/df-41/.

Харин “Дунфэнг-26” (DF-26) пуужин олон улсын цэргийн шинжээчдийн анхаарлыг хамгийн ихээр татаж буй зэвсгийн нэг юм. Учир нь “Дунфэнг-26” пуужин ердийн болон цөмийн цэнэгт хошуу аль алийг нь угсрах боломжтой хосолмол чадавхтай зэвсэг ажээ. Зөрчил мөргөлдөөн, дайн бүхий нөхцөлд Дунфэнг-26” байлдааны ажиллагаанд бэлтгэхэд аль хошуугаа угсарсныг ялгаж хэлж чадахгүй нөхцөл үүсэж, сөргөлдөгч талын зүгээс цөмийн пуужин харвах гэж буй гэж ташаа ойлгон, цөмийн пуужингийн дайралтад бэлтгэх эсвэл цөмийн пуужин харвах нөхцөл үүсэж болзошгүй гэж зарим судлаачид санаа зовниж буй[3]. Дунфэнг-26 дунд тусгалын баллистик пуужин АНУ-ын Гуам хүрэх чадавхтай бөгөөд Ази-Номхон далайн бүс нутаг дахь болзошгүй байлдааны ажиллагаанд хариу цохилт өгөх зориулалттай[4]. ХАЧА-ийн Пуужинт цэргийн бусад зэвсэглэлийн тухайд 12 ширхэг Жу Ланг-2 (JL-2) баллистик пуужин бүхий “Жин” ангиллын 4 шумбагч, 117 радар бий[5].

Хүснэгт 1.

Газар-газар ангиллын пуужин хөөргөгчийн тоо

Төрөл		**Загвар, ангилал**	**Тоо**
Тив алгасагч баллистик пуужин	Цөмийн	Дунфэн-4	10
		Дунфэн 5A/B	20
		Дунфэн-31	8
		Дунфэн-31A	24
		Дунфэн-31A(G)	18
		Дунфэн-41	18 (зэвсэглэлд хүлээн авч буй)
Алсын зайн тусгалын баллистик пуужин	Цөмийн, ердийн хосолсон	Дунфэн-26	72
Дунд тусгалын баллистик пуужин	Цөмийн	Дунфэн-21A/ Дунфэн-21E	80
	Ердийн	Дунфэн-16	24
		Дунфэн-17 (дуунаас хурдан нисэх төхөөрөмж бүхий)	16
		Дунфэн-21C	24
		Дунфэн-21D	30

[3] Singer and Ma Xiu, “China’s ambiguous missile strategy is risky”, May 11, 2020, https://www.popsci.com/story/blog-network/eastern-arsenal/china-nuclear-conventional-missiles/

[4] Defense Intelligence Agency, The China Military Power, Jan 03, 2019, https://www.dia.mil/Portals/27/Documents/News/Military%20Power%20Publications/China_Military_Power_FINAL_5MB_20190103.pdf

[5] International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), 260.

Ойрын зайн тусгалын баллистик	Ердийн	Дунфэн-11А	108
		Дунфэн-15В	81
Газраас хөөргөх далавчит пуужин	Ердийн	Чанжиэн-10/ Чанжиэн-10А	54
		Чанжиэн-100	16 (ашиглалтад орж буй)

Эх сурвалж: IISS Military Balance-2020

Хүснэгт 2.

Пуужингийн төрлүүд

№	Пуужин	Ангилал	Тусгалын хүрээ
1	Хон Ниао-1 (HN-1)	Далавчит пуужин	50-60 км
2	Еэнжи-18 (YJ-18)	Далавчит пуужин	220-540 км
3	Дунфэн-11 (DF-11)	Ойрын зайн тусгалын баллистик пуужин	280-300 км
4	Дунфэн-12 (DF-12)	Ойрын зайн тусгалын баллистик пуужин	420 км
5	Дунфэн-15 (DF-15)	Ойрын зайн тусгалын баллистик пуужин	600 км
6	Дунфэн-16 (DF-16)	Ойрын зайн тусгалын баллистик пуужин	800-1000 км
7	Хон Ниао-2 (HN-2)	Далавчит пуужин	1400-1800 км
8	Дунфэн-17 (DF-17)	Дуунаас хэт хурдан нисгэгч төхөөрөмжтэй	1800-2500 км
9	Дунфэн-21 (DF-21)	Дунд тусгалын баллистик пуужин	2150 км
10	Дунфэн-26 (DF-26)	Алсын зайн тусгалын баллистик пуужин	3000-4000 км
11	Хон Ниао-3 (HN-3)	Далавчит пуужин	3000 км
12	Дунфэн-4 (DF-4)	Алсын зайн тусгалын баллистик пуужин/тив алгасагч баллистик пуужин	4500-5500 км
13	Жу Ланг-2 (JL-2)	Шумбагчид суурилуулсан баллистик пуужин	8000-9000 км
14	Дунфэн- 31(DF-31)	Тив алгасагч баллистик пуужин	8000-11700 км
15	Дунфэн- 41(DF-41)	Тив алгасагч баллистик пуужин	12000-15000км
16	Дунфэн- 5(DF-5)	Тив алгасагч баллистик пуужин	13000 км

Эх сурвалж: Missile Defense Project, "Missiles of China," Missile Threat, CSIS, July 16, 2020

Олон төрлийн роботыг хөгжүүлж зэвсэглэлд нэмж буйн дотор 2020 онд пулемёттой робот цэргээс гадна пуужин ачаалах кран маягийн роботыг Пуужинт цэргийн хүчинд нийлүүлсэн[6].



Зураг 2. Байлдааны робот

ХАЧА-ийн бүсүүд дэх Пуужингийн цэргийн бүлэглэл, бүрэлдэхүүн: Пуужинт цэргийн хүчин цөмийн пуужин, ердийн пуужин, дэмжлэгийн цэрэг болон харьяа баазуудаас бүрддэг. Ерөнхий бүтцийн хувьд пуужинт цэргийн баазууд болон пуужингийн төрлөөс хамаарч харилцан адилгүй зохион байгуулалт бүхий пуужингийн цохилт өгөх бригадуудаас бүрдэнэ. Ердийн болон цөмийн пуужингийн бригадууд нь аль аль Пуужингийн баазуудын удирдлагад харьяалагддаг ч цөмийн пуужингийн нэгжүүдийн тухайд Цэргийн Төв Хороонд шууд илтгэх үүрэгтэй байдаг. Пуужингийн бааз нь бригад, батальон, рот, салаа гэсэн бүтэцтэй, ба пуужингийн бааз, бригад тус бүр төв штабтай. Пуужингийн бригад тус бүр тодорхой тооны пуужин хөөргөгч бүхий пуужингийн цохилт өгөх батальон эсвэл роттой хэдий ч бригадууд пуужингийн төрөл буюу газарт суурилуулсан эсвэл хөдөлгөөнт пуужин, цөмийн эсвэл ердийн пуужин эсэхээс хамаарч хоорондоо ялгаатай бүтэц, зохион байгуулалттай тул харилцан адилгүй тооны батальон, рот, пуужин, пуужин хөөргөх системтэй[7].

Пуужинт цэргийн хүчний стратегийн пуужингийн байнгын бие бүрэлдэхүүнд 120000 цэргийн алба хаагч, Газар-газар ангиллын пуужингийн цэргийн бие бүрэлдэхүүнд:

- Дунфэн-4 тив алгасагч баллистик пуужингийн 1 бригад;
- Дунфэн-5А тив алгасагч баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-5В тив алгасагч баллистик пуужингийн 1 бригад;
- Дунфэн-31 тив алгасагч баллистик пуужингийн 1 бригад;
- Дүнфэн-31А тив алгасагч баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-31А(G) (сайжруулсан) тив алгасагч баллистик пуужингийн

[6] International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), 260.

[7] International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), 260.

2 бригад;
- Дунфэн-41 тив алгасагч баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-26 дунд тусгалын баллистик пуужингийн 4 бригад;
- Дунфэн-16 дунд тусгалын баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-17(дуунаас хурдан нисэх)дунд тусгалын баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-16 дунд тусгалын баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-21A/E дунд тусгалын баллистик пуужингийн 6 бригад;
- Дунфэн-21C дунд тусгалын баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-21D дунд тусгалын баллистик пуужингийн 2 бригад;
- Дунфэн-11A/DF-15B ойрын зайн тусгалын баллистик пуужингийн 3 бригад;
- Чанжиэн-10 /Чанжиэн-10A/ Чанжиэн-100 пуужингийн 2 бригад тус тус багтдаг бөгөөд газар-газар ангилалын пуужингийн 2 бригад шинээр баригдаж буй ажээ[8].

Хүснэгт 3.

Пуужинт цэргийн бааз, бригадуудын байршил

Бааз	**Төв штаб**	**Бригад**	**Байршил**	**Пуужингийн систем**
61 дүгээр бааз	Аньхуй Хуаншан	611	Чижоу	DF-21
		612	Жиндэжэн	DF-21A
		613	Шанграо	DF-15B
		614	Ёонган	DF-11A
		615	Мэйжоу	DF-11A
		616	Ганжоу	DF-15
		617	Жинхуа	DF-15
62 дугаар бааз	Юньнань Куньмин	621	Ибин	DF-21A?
		622	Юүши	DF-31A
		623	Лиужоу	DH-10A?
		624	Чинюань	DF-21D
		625	Жианшуй	мэдэгдээгүй
		626	Чинюань	DF-21C/D? DF-26?
		нэр үл мэдэгдэх	Пунин	мэдэгдээгүй
63 дугаар бааз	Хунань Хуайхуа	631	Чинжоу	DF-5B
		632	Шаоянь	DF-31
		633	Хуйтун	DF-5A?
		634	байршил үл мэдэгдэх	мэдэгдээгүй
		635	Ичунь	DH-10

[8] International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), 260.

		636	Шаогуан	DF-16
		637	байршил үл мэдэгдэх	мэдэгдээгүй
64 дүгээр бааз	Ланжоу	641	Ханчень	DF-31
		642	Датонь	DF-31A
		643	Тианшуй	DF-31A
		644	Ханжунь	мэдэгдээгүй
		645?	байршил үл мэдэгдэх	мэдэгдээгүй
		646	Корле	DF-21B? DF-21C?
65 дугаар бааз	Шэнянь	651	Дайлань	DF-21
		652	Тонхуа	DF-21C? DF-21D?
		653	Лайву	DF-21C
		654	Дайлань	мэдэгдээгүй
66 дугаар бааз	Луоянь	661	Линбао	DF-5B
		662	Луанчуан	DF-4? DF-5A?
		663	Наняань	DF-31A?
		664	Луоянь	мэдэгдээгүй
		665	Байршил үл мэдэгдэх	мэдэгдээгүй
		666	Шиняань	DF-26?

Эх сурвалж:David Logan, "Making sense of China`s Missile force", 2019

Жич: ПЦХ-ний зэвсэглэлд шинэ пуужингууд нэмэгдсэн тул хэд хэдэн бригадуудын эзэмшдэг пуужингийн системд өөрчлөлт орсон.


Пуужинт цэргийн хүчин албан ёсоор аль нэг бүсийн бүрэлдэхүүнд багтдаггүй хэдий ч Пуужингийн 61 дүгээр бааз бүхэлдээ шахуу Зүүн бүсийн районд байрладаг[9]. Пуужингийн 61 дүгээр баазын 7 бригадын хоёр нь газрын хөдөлгөөнт Дунфэн-21А дунд тусгалын баллистик пуужингуудаар зэвсэглэсэн ба тус пуужингийн шинэчилсэн хувилбарыг удахгүй зэвсэглэлдээ нэмж буй гэсэн таамаг бий. 61 дүгээр баазын бусад 5 бригадын гурав нь газрын хөдөлгөөнт Дунфэн-11А, Дунфэн-15В, Дунфэн-16 пуужингуудаар зэвсэглэсэн хэвээр байгаа бол үлдсэн хоёр пуужингийн бригад зэвсэглэлээ 2019 онд олон нийтэд ил болсон шинэ Дунфэн-17 (дуунаас хурдан нисэх төхөөрөмж бүхий) баллистик пуужин руу шилжсэн[10]. Пуужингийн 61 дүгээр бригад Зүүн бүсэд байрлуулсан учир нь Тайваньтай зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд Өмнөд бүсийн пуужингийн 62, 63 дугаар баазаар хүч хавсруулан байлдааны ажиллагаанд оролцох юм.

Пуужинт цэргийн хүчний сургалт, бэлтгэл: Пуужинт цэргийн

[9] International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), 233.

[10] Мөн тэнд

хүчин нь бусад төрлийн цэргүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн буюу жилдээ 1-2 удаа далайцтай томоохон сургууль бэлтгэл хийдэг. 2019 онд ХАЧА-ийн Пуужинт цэрэг Өвөр Монголын Өөртөө Засах Орны Жилантай дахь шинэ сургалтын бүсэд "Дунфэн-26" дунд тусгалын пуужин харвах сургууль дадлага хийсэн бөгөөд тус пуужин нь маневр сайтай төдийгүй хөдөлгөөнт байг онох чадвартай хэмээн Хятадын Төв Телевизээс мэдээлэв[11]. Өвөр Монголын Алшаагаас хойд зүгт 100 километрийн зайд байрлах тус сургалтын баазад "Дунфэн-26" пуужингийн анхны бригад гэгддэг Пуужингийн 66 дугаар баазийн 666 дугаар бригадын баг ирж сургуулилт хийв[12]. Улмаар "Дунфэн-41", "Дунфэн-31AG", "Дунфэн-17" пуужингийн багтай хамтарч, 2019 оны 4-5 дугаар сарын хооронд сургалт, бэлтгэлийг үргэлжлүүлэв[13]. Жилантай дахь сургалтын бүс нь Пуужингийн цэргийн хамгийн том сургалтын төвүүдийн тоонд багтдаг бөгөөд "Дунфэн-26" пуужинг Өвөр Монголд байрлуулах нь хэд хэдэн давуу талтай хэмээн цэргийн шинжээчид үзэж буй.



Зураг 3. Өвөр Монголд шинээр байгуулагдсан ХАЧА-ийн Пуужинт цэргийн сургалтын бүс, 2019


Ази, Номхон далай тэр дундаа Зүүн болон Өмнөд Хятадын тэнгист гарч болзошгүй зөрчил мөргөлдөөнд бэлтгэх зориулалтаар Пуужингийн зарим бригадууд Өмнөд болон Зүүн бүсэд байрладаг хэдий ч баруун хойд нутгуудаар сургалт бэлтгэлийг ихэвчлэн зохион байгуулах болсон. Бээжингийн цэргийн судлаачийн онцолсноор "Нутгийн гүнээс харвасан

[11] "China touts capabilities of DF-26 as ASBM" Jane's Defence Weekly, 28 January 2019, https://www.janes.com/ article/86013/china-touts-capabilities-of-df-26-as-asbm

[12] Hans M. Kristensen,"Chinese DF-26 Missile Launchers Deploy To New Missile Training Area", January 21, 2019, https://fas.org/blogs/security/2019/01/df-26/.

[13] Мөн тэнд

Дунфэн-26 пуужинг амдаж устгахад хүндрэлтэй”[14] ажээ. “National interest” цахим хуудаснаа мэдээлснээр “Хэрвээ Хятад Өвөр Монголын нутгаас “Дунфэн-26” пуужинг харваж Номхон далай дахь Америкийн хөлөг онгоцнуудад цохилт өгсөн тохиолдолд Америкийн тал пуужинг амдаж устгах цорын ганц боломж нь пуужин байгаа онохоос сүүлийн хэдхэн секунд байх болно”[15] гэжээ. Учир нь «Пуужин хөөрөх үеийнхээс илүүтэй пуужин буух үеийн эцсийн шатанд пуужинг устгахад хэцүү байдаг” ба “пуужин эцсийн шатанд шилжихэд хурд нь огцом нэмэгдэж амдаж харваж устгах боломж буурдаг”[16] гэж Хятадын цэргийн судлаачид үзэж буй тухай Глобал таймс цахим хуудаснаа нийтэлжээ. Мөн түүнчлэн “Дунфэн-26” пуужинг Өвөр Монголын Алшаагийн ойролцоох цэргийн баазуудад байрлуулснаараа Өмнөд Солонгост АНУ-ын байрлуулсан “THAAD” системийн илрүүлгийн хүрээний гадна байрлах давуу талтай ажээ[17]. Тийм ч учраас Пуужинт цэргийн хүчин стратегийн пуужингууд, пуужин харвагч зэргийг Алшаагийн Жилантай зэрэг Өвөр Монголын нутаг дахь цэргийн баазууд руу зөөвөрлөж, байлдааны буудлагатай цэргийн сургууль, дадлагыг зохион байгуулж, байлдааны бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч байна.



Зураг 4. “Дунфэн-26” пуужингийн сургалтын 66 дугаар баазийн 666 дугаар бригад

2020 онд Пуужинт цэргийн хүчин “Цөмийн пуужингийн довтолгооноос амьд гарах сургалт”-ыг зохион байгуулж, сургалтын үеэр Пуужингийн

[14] David Axe“China Just Deployed Its Deadly DF-26 “Carrier-Killer” Missiles in A Very Slick Way”, January 2019, https://nationalinterest.org/blog/buzz/china-just-deployed-its-deadly-df-26-carrier-killer-missiles-very-slick-way-41487

[15] Мөн тэнд

[16] Мөн тэнд

[17] Liu Zhen, “ Chinese army sends DF-26 ballistic missiles to northwest region”, January 2019, https://www.scmp.com/news/china/military/article/2181773/chinese-army-sends-df-26-ballistic-missiles-northwest-region

бригадыг газар доорх бункерт байрлуулж, гаднаас пуужингийн цохилтод тэсэж үлдэж хариу цохилт өгөх дадлага сургууль хийсэн тухай ХАЧА-ийн “China military” цахим хуудаснаа мэдээлэв[18]. Тус сургалт нь Пуужингийн цэргийн засвар, ар тал дэмжлэгийн багуудын шуурхай ажиллагаа, бункерийн хамгаалалт, түргэн цохилт өгөх дадлага бүхий иж бүрэн сургуулилт ажээ. “Дайсны цохилтын улмаас пуужингийн түлш асгарч хариу цохилт өгөхөд бэрхшээл тулгарсан нөхцөл бүхий харилцан ажиллагаа зохион байгуулж, засварын баг асуудлыг тун хурдацтай шийдвэрлэсэн”[19] тухай онцлов. БНХАУ “урьтаж цөмийн пуужин харвахгүй, аливаа улс пуужин харвасан тохиолдолд хариу цохилт заавал өгөх” стратеги баримталдаг бөгөөд пуужингийн цохилтод хэрхэн тэсэж хариу цохилтыг түргэн шуурхай гүйцэтгэх дадлагыг амжилттай гүйцэтгэсэн тухайгаа мэдээлж, өрсөлдөгч нартаа гадны пуужингийн дайралтаас эмээх зүйлгүй гэсэн анхааруулгыг хүргэв.

[18] Li Jiayao “Chinese Rocket Force exercise ensures nuclear counterattack capability”, January 2020, http://eng.chinamil.com.cn/view/2020-01/17/content_9719396.htm

[19] Li Jiayao “Chinese Rocket Force exercise ensures nuclear counterattack capability”, January 2020, http://eng.chinamil.com.cn/view/2020-01/17/content_9719396.htm

Хагас дамжуулагч нь цэрэг болон стратегийн чухал бүтээгдэхүүн болох нь

Ц.Батбаяр
УАБЗ-ийн Ажлын албаны референт,
дэд хурандаа, докторант

Abstract

Semiconductors have become an important military and strategic product, through which countries can not only develop their economies, but also ensure their security. Demand and prices for semiconductors are rising rapidly due to the recent international crisis.Its shortages are due to a number of complex reasons, and countries are investing billions of dollars in semiconductors to ensure their independence from foreign countries.

Keywords*: Semiconductor, silicon, Rare Earth Elements.*

Хагас дамжуулагч нь цэрэг болон стратегийн чухал бүтээгдэхүүн болж, түүгээр дамжуулан улс орнууд эдийн засгаа хөгжүүлэхээс гадна, аюулгүй байдлаа хангах боллоо. Сүүлийн үед олон улсад үүсээд буй хямралт байдлын улмаас хагас дамжуулагчийн хэрэгцээ, үнэ хоёр хурдацтай өсөж байна.

Түүний хомсдол нь нарийн төвөгтэй олон шалтгааны улмаас үүсэж байгаа бөгөөд улс орнууд хагас дамжуулагчийн хувьд гадны улс орноос хамааралгүй, бие даасан байдлаа хангахын тулд олон тэрбум долларын хөрөнгө оруулалтыг хийж байна.

Энэ их хэмжээний хөрөнгө оруулалт нь манай улсад ч нөлөөллөө үзүүлэх нь дамжиггүй. Тэгвэл тэр нөлөөлөл нь ямар байж болох, мөн түүнийг өөртөө ашигтайгаар ашиглаж буй улсын туршлагаас суралцах боломж бий эсэхэд хариулт хайж бичвэр хийлээ.

Хагас дамжуулагч гэж юу вэ?

Хагас дамжуулагч материалууд нь цахилгаан сайн дамжуулдаг дамжуулагч ба цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч хоёрын дундах саармаг шинж чанарыг үзүүлдэг материал юм.

Хагас дамжуулагчийн цахилгаан дамжуулах чадвар нь орчны цахилгаан орон болон дулаанаас шалтгаалан өөрчлөгдөж байдаг. Энэ шинж чанарт нь тулгуурлан диод, транзистор, нарны зай, гэрэл мэдрэгч гэх мэт электроникийн суурь элементүүд нь хагас дамжуулагч материалаар хийгддэг. Хагас дамжуулагчийн үндсэн материал нь үелэх системийн


дөрөвдүгээр бүлгийн элементүүд болох цахиур, герман болон бусад олон төрлийн нийлмэл материалууд GaN, InGaAs, SiC зэрэг юм.

Газрын ховор элементэд лантийн бүлгийн 20 гаруй, церийн бүлгийн 10-аад элемент хамаардаг аж. Тэдгээрийн мөн чанар, ашигтай сайн талыг нь хүн төрөлхтөн өнөөдрийг хүртэл бүрэн дүүрэн нээж илрүүлж чадаагүй байна.

Хагас дамжуулагчийн зах зээл

Хагас дамжуулагчийн нийт зах зээлийн хэмжээ нь одоогийн байдлаар 500 орчим тэрбум ам.доллар байна. Тус зах зээл нь хурдтай өсөж буй зах зээл бөгөөд 2028 он гэхэд 820 гаруй тэрбум ам.долларын зах зээл болох төлөвтэй юм.


Өнөөдрийн байдлаар байгаа 500 тэрбум ам.долларын зах зээл нь бусад аварга том зах зээлтэй харьцуулахад тийм том биш ч гэсэн ч маш хурдацтай хөгжиж байгаа салбар болоод байна.



Сүүлийн үед хийгдсэн судалгаанаас харахад орчин үеийн автомашинууд хагас дамжуулагч болон бусад электрон эд ангиас илүү их хамаарч байна. Электрон эд ангиудын автомашины нийт өртөгт эзлэх хувь 2000 онд 18 хувь байсан бол 2030 он гэхэд 45 хувь болохоор байна. Өөрөөр хэлбэл автомашины хүчин чадал морины хүчнээс чипний хүчин чадал руу шилжиж байна гэсэн үг.

Электроникийн салбар нь upstream буюу хагас дамжуулагч болон бусад эд анги downstream мэдээлэл технологийн бүтээгдэхүүн гэсэн 2 сектороос бүрддэг бөгөөд хагас дамжуулагчийн салбарт компьютерын электрон систем, дагалдах бүтээгдэхүүн, өгөгдөл боловсруулах бусад тоног төхөөрөмжүүд, хэрэглээний цахилгаан бараа, аж үйлдвэр, мэдээлэл харилцааны тоног төхөөрөмж, эмнэлгийн тоног төхөөрөмж, хамгийн гол нь цэргийн зэвсэглэлийн системүүд багтдаг.

Хүний хэрэгцээ, өдөр тутмын амьдралд ухаалаг, цахилгаан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэхийн хирээр электроникийн хамааралтай болж хагас дамжуулагчийн салбарын зах зээлийг тэлэхэд хүргэж байна.



Улс орнуудын хагас дамжуулагчийн талаар хэрэгжүүлж буй бодлого

АНУ. Энэ оны 05 дугаар сарын 20-ноос 24-ний өдрүүдэд АНУ-ын ерөнхийлөгч Азийн орнууд дахь анхны айлчлалаа хийсэн. Энэ хүрээндээ БНСУ-д айлчилсан. Тэрээр Өмнөд Солонгост очоод хамгийн түрүүнд хагас дамжуулагчийн үйлдвэрт зочилсон нь сонирхол татна.

Улс орнуудын хагас дамжуулагчийн салбар дахь өрсөлдөөн ихсэхийн хирээр АНУ нь Тайван, Өмнөд Солонгос, Япон зэрэг нийлээд дэлхийн хагас дамжуулагчийн салбарын 70 гаруй хувийг нийлүүлдэг орнуудын холбоо байгуулан АНУ-тай худалдаа болон технологийн дайн өрнүүлээд байгаа БНХАУ-ын хагас дамжуулагчийн салбар дахь нөлөөллийг хязгаарлах зорилго агуулж байна.

АНУ-ын хувьд 1990-ээд онд энэ зах зээлийн 20 орчим хувийг нийлүүлдэг байсан бол одоо 12 хувь болж буусан байгаа. Яагаад гэвэл Америкийн томоохон компаниуд зөвхөн санааг нь гараад үйлдвэрлэлийг бусад оронд буюу хямд ажиллах хүчээр үйлдвэрлүүлэх бодлого баримталсантай холбоотойгоор нийлүүлэлт багассан юм.

Тэд БНХАУ-д байгуулсан хагас дамжуулагчийн үйлдвэрүүдээ Тайвань болон Вьетнам руу гаргахын тулд 52 тэрбум ам.долларыг хөрөнгө оруулалт хийх тухай хуулийн төсөл өргөн баригдаад явж байна. Энэ хууль батлагдвал АНУ хагас дамжуулагчийн салбар БНХАУ-аас хамааралгүй болж, худалдааны дайнд өөртөө маш том давуу талыг бий болгоно.

АНУ-ын "Techcet" компани мэдээлж байснаар Украин нь чип

үйлдвэрлэхэд ашиглагддаг лазерын чухал ач холбогдолтой “Neon Gaz”-ийн томоохон олборлогч бөгөөд АНУ-ын хэрэгцээний 90 хувийг дангаараа хангаж байсан юм байна. Мөн хагас дамжуулагчид ашигладаг ховор металл нэг палладийн 35 хувийг Оросын Холбооны Улсаас авдаг байсан бололтой.

Мөн “JPMorgan”-ний мэдээлж байгаагаар газрын ховор элементийн 50 хувийг авдаг байсан зүүн Европын хямралт байдал үргэлжилсээр байвал түүхий эд тасалдаж хардвер технологийн «Intel” зэрэг компаниудын эдийн засагт хүнд цохилт болохоор байна.

Тайвань. АНУ болон БНХАУ-ын хооронд үүссэн худалдааны дайнд АНУ давуу байдал олж авахыг тулд улайран тэмцэж байна. Тайвань Улс хоёр их гүрний хоорондох наймааны талбар болж байгаа тул хагас дамжуулагчийн салбарыг томоохон төлөөлөгч болохын хувьд илүү ухаалаг шийдвэр гаргах шаардлага урган гарна.

Нэг талаар Тайваний хагас дамжуулагчийн салбарт БНХАУ тайван замаар хяналт тогтоохыг эрмэлзэж байгаа бол нөгөө талаас БНХАУ хүч хэрэглэн довтолж Тайвань дахь хагас дамжуулагчийн салбарыг булаан авбал дэлхийн цахилгаан болон электроникийн зах зээлд хямрал үүсэх вий гэсэн түгшүүртэй байдал гадаад ертөнц үүсээд байна.

Өөрөөр хэлбэл Тайван Улс өөрийн улс орны аюулгүй байдлын баталгааг хагас дамжуулагчаар дамжуулан олон улсаар хангуулж чадаж байгаа бөгөөд хүн төрөлхтний цахилгаан хэрэгслийн хамаарал нь тэдэнд энэ давуу байдлыг үүсгэж байна.

Япон. Тус улсын Засгийн газар хагас дамжуулагчийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор 2022 оны санхүүгийн жилд багтаан Кюшү арлын найман технологийн коллежид хагас дамжуулагчийн боловсруулалт, үйлдвэрлэлийн мэргэжлээр боловсон хүчин бэлдэх зорилгоор мэргэжлийн анги байгуулахаар болсон. Кюшү арлын Кумамото мужид Тайваний хагас дамжуулагч үйлдвэрлэгч “TSMC” үйлдвэрээ байгуулахаар болоод байгаа билээ.

Япон улс хагас дамжуулагчийн дотоодын хэрэгцээний 60 гаруй хувийг Тайвань, Хятад гэх мэтийн орнуудаас импортолдог. Тэд өөрийн улсын электроникийн салбар дахь хагас дамжуулагчийн тогтвортой нийлүүлэлт, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүднээс өөрийн улсдаа үйлдвэрлэл явуулах нь яаравчлан хэрэгжүүлэх асуудлыг нэг хэмээн Засгийн газар нь тодорхойлжээ.

Япон Улсын Засгийн газар хагас дамжуулагчийн үйлдвэрүүдийн ажиллагааг дэмжих, дотоодын хууль тогтоомжийг боловсруулах гэх мэтийн дотоодын эрэлт хэрэгцээг хангах ажлыг эрчимжүүлж байна.

БНСУ. Самсунг корпорац 356 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж 80,000 ажлын байр шинээр бий болгоно

АНУ-ын ерөнхийлөгчийн айлчлал дуусаад хэдхэн цагийн дараа Самсунг корпорац орлогынх нь дийлэнх хэсгийг бүрдүүлдэг хагас дамжуулагч болон био эм бэлдмэлийн салбартаа их хэмжээний буюу

356 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ гэж мэдэгджээ. Энэ нь 450 их наяд вон болох бөгөөд 2026 он хүртэл хөрөнгө оруулалт хийнэ. Энэ хугацаанд 80 мянган ажлын байр бий болж жилдээ 16 мянган ажлын байр шинээр нэмэгдэхээр байна. Энэ хөрөнгө оруулалт нь өмнөх 5 жилийн судалгаа хөгжүүлэлтдээ оруулж байсан зардлаас 30 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

АНУ-ын Ерөнхийлөгчийн БНСУ-д хийсэн айлчлалын зорилго нь хагас дамжуулагчийн зах зээлийг хянах эвсэл байгуулах явдал байсан гэж харагдаж байгаа бөгөөд энэ утгаараа түүний айлчлал Өмнөд Солонгосын төр засгийн удирдлага гэхээсээ илүү Самсунг корпорацтай хэлэлцээр хийх, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлж буй байдлаас харагдлаа.

Монгол Улс дахь хагас дамжуулагчийн нөхцөл байдал

Монгол Улсад хагас дамжуулагчтай холбоотой бизнес, ашиг сонирхол байхгүйтэй адил байна. Яагаад хагас дамжуулагчийн талаар ярих ёстой юм бэ? гэхээр зөвхөн бизнес гэлтгүйгээр олон улсын харилцаа, эдийн засаг, улс төрийн сэдвүүд хагас дамжуулагчгүйгээр ярих ямар ч боломжгүй байна.

Залуучууд энэ чиглэлд суралцвал ирээдүй байхаар байна. Цахим технологи хөгжсөн өнөө үед зөвхөн тэр улсад нь ажиллахаас гадна өөрийн улсаас ажиллах боломж ч бүрэн нээгдэж байна.

Мөн АНУ-д 52 тэрбум ам.долларыг технологийн салбарт оруулахаар хуулийн төсөл өргөн баригдаад явж байна. Энэ хууль батлагдвал АНУ-ын технологийг салбарт томоохон хөрөнгө оруулалт хийгдэж, энэ чиглэлээр АНУ-д ажиллаж байгаа манай мэргэжилтнүүдэд олон боломж нээгдэнэ.

Харин Хятад улс энэ чиглэлээр нэмж үйлдвэр барихын тулд 2030 он гэхэд 150 тэрбум ам.доллар зарцуулна.

Мөн газрын ховор элемент нь хагас дамжуулагчийг үйлдвэрлэхэд шаардлагатай үндсэн түүхий эд нь болдог. Тиймээс хагас дамжуулагчийн эдийн засгийн тэлэлт газрын ховор элементтэй онуудад олон боломжуудыг нээж өгнө.

Монгол Улсын хувьд газрын ховор элементийн тодорхой нөөц байгаа. Япон, Герман улсуудын зүгээс Монгол Улсад газрын ховор элементийг олдворлох чиглэлээр сонирхож байсан тохиолдлууд байна. Цаашдаа хагас дамжуулагчийн салбарт эрчимтэй өсөлт гарах юм бол манай улс түүхий эд нийлүүлэх боломж байж болох юм. Гэхдээ хагас дамжуулагчид хэрэглэгдэж байгаа газрын ховор элементийг олдворлоход байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй байхаар байна. Жишээлбэл БНХАУ нь газрын ховор элементийн үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг боловч олдворлодог Өвөр Монголын нутаг дэвсгэрт байгаль орчны доройтол бий болж ард, иргэдэд хортой нөлөөлөл үзүүлэх болсон.

Дүгнэлт

Нэг талаас манай улс хуртай өсөн нэмэгдэж байгаа хагас дамжуулагчийн зах зээлд түүхий эд болон мэргэжилтнүүдээ бэлтгэж

оролцох боломжтой бөгөөд техник, технологийг ч гадааны улс орнуудаас оруулж ирэх боломж байгааг үгүйсгэхгүй. Нөгөө талаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг сайтар тооцоож, гарах эрсдэлийг үнэлэн ажиллах нь зүйтэй байна.

Тайваний хэрэгжүүлж байгаа бодлогоос харахад өөрийн улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн давуу байдлаа ашиглан дэлхий нийтээр хангуулж байгаа байдал ажиглагдаж байна. Тэд байгалийн баялаггүй ч дэлхий нийтэд зайлшгүй хэрэгцээг бий болгож, түүгээрээ дамжуулан их гүрнүүдийн бодлогыг хязгаарлан, өөрийн улсын ашиг сонирхлыг хамгаалж чадаж байна.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. Ганболд.Ш "Өчигдөр, Өнөөдөр, Маргааш". УБ.,2012
2. https://bloombergtv.mn/
3. https://montsame.mn/
4. https://www.presscenter.mn/lifestyle/technology/globalfightoverse-miconductorget-worse

Монгол, Хятадын харилцаа: Улс төрийн шинэ сэтгэлгээ, хамтын хүчин чармайлт, харилцаа хэвийн болсон нь

Д.Уламбаяр
ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын
сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор

Abstract

This article discusses the key factors that contributed to the normalization of Mongolia-Sino relations, and the essence and visible of "three contrary barriers" that impacted to the improvement of Sino-Soviet relations. And also discussed the role for the New Political Thinking in international relations since the late 1980s, the backgrounds for improving Sino-Soviet relations, and how bilateral relations have returned to normal as a result of collaborative efforts by Mongolia and China, etc.,

Keywords: *perestroika, new political thinking, withdrawal, troops, relations, confidence building, three contrary barriers, limited nuclear attacks, region.*

Монгол-Хятадын харилцааг хэвийн болгох асуудал Зөвлөлт-Хятадын харилцаанаас шууд шалтгаалж байсан юм. Зөвлөлтийн удирдагч М.С. Горбачёв 1986 оны 7 дугаар сард ***Владивостокт*** хэлсэн үгэндээ, Японтой сайн хөршийн харилцаа тогтоох, Солонгосын хойгийн асуудлыг энх тайван замаар зохицуулах, Ази-Номхон далайн орнуудыг оролцуулан ***Хельсинк маягийн чуулга уулзалт хийх санал дэвшүүлснээс гадна*** «Түүх Зөвлөлт, Хятадын ард түмэнд онц хариуцлагатай үүрэг ногдуулж байна. Хоёр том улсаас олон улсын хөгжлийн олон зүйл шалтгаална. Манай харилцаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц сайжирлаа. ЗХУ Хятадтай сайн хөршийн харилцааны байдал бий болгох нэмэлт арга хэмжээний тухай асуудлыг ямар ч цагт, ямар ч түвшинд хамгийн буурьтай хэлэлцэхэд бэлэн байгааг нотлохыг хүсэж байна. Биднийг зааглаж байгаа (холбож байгаа гэж хэлмээр байна) хил ойрын ирээдүйд энх тайван, найрамдлын зурвас болно гэж найдаж байна»[1] гэсэн бол, 1987 оны 7 дугаар сард Индонезийн "***Мердека***" сонинд өгсөн ярилцлагадаа дээрхийг дахин нотолж, 1988 оны 9 дүгээр сард ***Красноярскт*** хэлсэн үг түвэгтэй байсан хэдий ч Алс Дорнодын олон улсын харилцааны орчин, геополитикийг шинэ сэтгэлгээний үүднээс шинээр авч үзэх боломж олгосон юм. Тэр бээр хэлсэн үгэндээ

[1] Горбачёв М.С. Избранные речи и статьи. Изд. политической литературы. М., 1987. стр. 31

Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд юуны өмнө цэргийн сөрөг төвлөрлийг багасгах, итгэлцлийг бэхжүүлэх тухай Хятад, Япон, БНАСАУ болон анх удаа нэр заан Өмнөд Солонгосыг оролцуулан олон этгээдийн хэлэлцээ хийх санал дэвшүүлэв.[2] М.С.Горбачёв 1988 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 43 дугаар чуулганы индрээс дахин шинэ санаачилга дэвшүүлсэн нь зэвсэгт хүчнээ үлэмж хорогдуулж, Монголоос цэргээ гаргана гэдгээ анх удаа зарлав.[3] ***Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ: Манай орны болон дэлхий дахинд***[4] бүтээлдээ Хятадын «дөрвөн шинэчлэл»-ийн үйл явцаар нэн сонирхолтой, олон талаар үр бүтээлтэй үзэл санааг хэрэгжүүлж буй БНХАУ-тай тогтоосон харилцааны чухлыг тэмдэглэсэн зэрэг нь Бээжингийн удирдагчдын анхаарлыг зүй ёсоор татсан байна.

1980-аад оны туршид олон үе шаттай явагдсан Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр харилцааг сайжруулахад тээг болж буй «гурван харш саад»-ыг арилгах болзлыг Хятадын талаас байнга тавьж байсан нь "***ямар ч тохиолдолд аливаа улсын батлан хамгаалах хүчин гагцхүү өөрийн улсын хилийн дотор байрлах ёстой***" гэдэгт үндэслэж байв. «***Гурван харш саад***»-ыг арилгах гэдэг нь *нэгд*, Монголоос зөвлөлтийн цэргийг гаргах, *хоёрт*, Кампучиас вьетнамын цэргийг гаргуулах, *гуравт*, Афганистанаас зөвлөлтийн цэргийг гаргах эдгээр асуудлыг шийдвэрлэсэн тухайд л харилцааг хэвийн болгох боломжтойд оршиж байв. Тиймээс Бээжингийн удирдагчид «гурван харш саад» гэдэг нь Хятадыг гурван талаас нь бүсэлсэн байдлыг хэлж буй юм гэж Зөвлөлтийн талд тов тодорхой ойлгуулж байжээ.

Түүнээс гадна, Оросын хятад судлаач доктор Ю.М.Галенович: "ЗХУ, БНХАУ-ын хооронд өрнөж байсан үзэл суртлын аугаа их дайн"-ыг (БНХАУ-д ингэж нэрлэж байв Д.У) Мао Зэдун БНХАУ-д эрх мэдлээ бэхжүүлэхийн тулд эхлүүлсэн гэж үзсэн юм. Тэр бээр хятадын тал зөвлөлтийн иргэд БНХАУ-ын удирдагчийг юуны түрүүнд түүний үзэл санааг хүндэтгэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх бодолтой байсан, цаашдаа үүнийгээ аажмаар албадах шинжтэй болсон, Мао өөрийгөө болон БНХАУ ЗХУ-ын эсрэг үзэл суртлын хүндхэн дайн хийж байна гэж АНУ болон түүний холбоотнуудад итгүүлэх, БНХАУ-д анхаарлаа хандуулах шаардлагатай шинэ санаанууд байгааг дэлхийн олон нийтэд харуулах, гэхдээ эдгээр нь ЗХУКН-ын баримталдаг марксизм-ленинизмээс ялгаа юм гэж үзэж байсныг тэмдэглэсэн байдаг. Др. Ю.М.Галенович хятадын тал ЗХУ-аас "алдагдсан нутаг дэвсгэр"-ээ эгүүлэн авах, Монголыг БНХАУ-д шилжүүлэх, цөмийн зэвсгийн дарамтаа зогсоох, "тэгш бус байдал"-ыг арилгах зэрэг үндэслэлгүй шаардлага тавьж байсан гэжээ.[5]

---

[2] Тоже там, стр. 63

[3] М.С.Горбачёв в Нью-Йорке 6-8 декабря 1988 года: Документы и материалы. Изд. политической литературы. М.: 1988, стр. 4-9

[4] М.С.Горбачёв. Перестройка и новое мышление для нашей страны и для всего мира. Изд. политической литературы. М.: 1988

[5] Галенович Ю. М. Россия в «китайском зеркале». Трактовка в КНР в начале XXI века истории России и русско-китайских отношений.-М.: Восточная книга, 2011, стр. 165-167, 175.

1963 онд АНУ Хятадын өсөн нэмэгдэж буй аюулыг дарахын тулд ЗХУ-д хандаж, хэрэв АНУ цөмийн зэвсэг хэрэглэн Хятадын эсрэг "урьдчилан сэргийлэх" цохилт хийвэл ЗХУ ямар байр суурьтай байхыг тандаж байжээ.[6] Мэдээж ЗХУ түүнийг нь дэмжээгүй. Монголтой хиллэдэг Хятадын цөмийн зэвсгийн туршилтын болон цөмийн бусад барилга байгууламжийн эсрэг АНУ цөмийн зэвсэг хэрэглэсэн бол Монгол Улс хир хохирох байсан нь маш тодорхой юм. 1969 онд Зөвлөлт-Хятадын харилцаа хурцдаж, хилийн дагуу удаа дараа зэвсэгт мөргөлдөөн гарч байх үеэр ЗХУ-ын удирдлага тухайн үед 50 орчим цөмийн зэвсэгтэй болж байсан Хятадын цөмийн зэвсэг, байгууламжуудад "цөмийн хязгаарлагдмал" урьдчилсан цохилт хийх замаар тэдгээрийг устгах боломжийг судалж, энэ талаар Варшавын Гэрээний орнуудын холбоотнууддаа аминчлан мэдэгдэхийн дээр АНУ-ын байр суурийг тандаж байсан байдаг.[7]

Өөрийн аюулгүй байдлыг хангах нь бусдын аюулгүй байдлыг ямагт хөндсөөр иржээ. Зэвсэглэлээр хөөцөлдсөний гол уг сурвалж үүнд л оршиж байв. БНХАУ оршин тогтнож байсан түүхийнхээ туршид аюулгүй байдлаа дангаараа хангаж байсан гэж үздэг. Мөн Хятад нь найрсаг хөршүүдээр хүрээлүүлж байгаагүй гэж үзэж байсан ажээ. Аль ч улс, гүрнүүдийн хооронд цэрэг-аюулгүй байдлын салбарт харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь хэчнээн чухал гэдэг нь эндээс тодорхой байгаа юм.

1989 онд Афганистаны асуудлаар Женевийн хэлэлцээр байгуулагдаж, тус орноос зөвлөлтийн цэрэг гарав. 1989 оны 9 дүгээр сарын эцэс гэхэд Кампучиас вьетнамын "сайн дурынхан"-ыг бүрэн гаргах тухай Вьетнам, Кампучи, Лаосын 1989 оны 4 дүгээр сарын 5-ны Парисын Энхтайвны бага хурлаас гаргасан хамтарсан Тунхаглал улс төрийн томоохон үйл явдал болов.[8] Нийтдээ вьетнамын 24 мянган цэрэг, офицер, зэвсэг, хүнд техникүүд гарав.

1989 оны 2 дугаар сарын 4-нд «Хил дээрх цэргийн тоог цөөлөх тухай Зөвлөлт-Хятадын хэлэлцээр»-т Бээжин хотноо гарын үсэг зурав.[9] Дурдсан хэлэлцээрийн дагуу хоёр улс өөрийн хилийн дагуу төвлөрүүлсэн цэргийн тоог цөөрүүлэх, Афганистан болон Монголоос зөвлөлтийн цэргийг гаргах асуудлаар урьдчилсан байдлаар тохиролцсон байна.

Зөвлөлтийн удирдагчдаас гучин жилийн дараа М.С.Горбачёв 1989 оны 5 дугаар сард Хятадад албан ёсны айлчлал хийсэн нь дэлхий

---

[6] U.S. Considered '64 Bombing to Keep China Nuclear-Free by Jim Mann Sept. 27, 1998. https://www.latimes.com/archives/la-xpm-1998-sep-27-mn-26986-story.html

[7] "The President's Daily Brief" (PDF). Central Intelligence Agency. 14 August 1969. pp. 3–4. Archived (PDF) from the original on 13 September 2016. Retrieved 29 August 2016.https://www.cia.gov/library/readingroom/docs/DOC_0005976932.pdf

[8] Micheal Haas. (1991) The Paris Conference on Combodia, 1989. Bulletin of Concerned Asian Scholars, 23:2, 42-53, DOI: 10.1080/14672715.1991.10413150, https://www.tandfonline.com/doi/pdf/10.1080/14672715.1991.10413150

[9] Лу Сяоин. Внешняя политика СССР-России: От конфронтации к нормализации межгосударственных отношений с Китаем (1976–1996 гг.) Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. «Южно-Уральский государственный университет (национальный исследовательский университет)» Челябинск.: РФ, 2018, стр. 86-103

дахины анхаарлыг онцгой татсан юм. М.С.Горбачёв Хятадын удирдагч Дэн Сяопинтэй уулзахдаа Монгол дахь зөвлөлтийн цэргийн 75 хувийг ойрын үед эх оронд нь буцаах бөгөөд үлдсэн 25 хувийг гаргах боломж, хугацааны тухай асуудлыг БНМАУ-тай хэлэлцэх болно гэжээ. Мөн Зөвлөлт-Хятадын харилцааны сайжрал нь гуравдагч этгээдэд (Монгол Д.У) хохирол учруулахгүй гэж мэдэгджээ. Хятадын тал Зөвлөлт-Хятадын харилцаа сэргэж, хэвийн болсныг өндөр үнэлэхийн хамт, хоёр орны харилцаа цаашдаа 1950-иад оны үеийнх шиг холбоотны харилцаанд тулгуурлахгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.[10]

1982 оны 10 дугаар сараас Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын Хятадын талын тэргүүн, ЗХУ-д сургууль төгссөн, "зөвлөлтийн талаарх гол мэргэжилтэн" Цянь Цичэнь 1988 онд ГЯЯ-ны сайд У Сюэцянь-ийн оронд шинээр томилогдсон нь санамсаргүй зүйл биш байв. Тэр бээр гадаад дахь айлчлалаа ЗХУ-аас эхэлж, Москвад хийсэн яриа хэлэлцээний үеэр «**гурван харш саад**»-аа татаж авснаа нотолж, мөн Монголын тусгаар тогтнолын асуудлаар Хятадын анхны албан ёсны байр суурийг илэрхийлжээ.

ЗХУ Монголоос бүх цэргээ татахын хамт Хятад, Зөвлөлтийн хилийн дагуух цэргийг хамгийн доод түвшинд хүртэл хорогдуулах, хорогдуулсан цэргээ бусад оронд шилжүүлэн байрлуулахгүй байхыг хүсэж байгаагаа Цянь Цичэнь Зөвлөлтийн дипломат албаны тэргүүн Э.Шевардназед мэдэгдээд БНХАУ Монгол Улстай найрамдалтай, сайн хөрш байхыг эрмэлзэж байгаа бөгөөд БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр тус улстай харилцах бодолтой байна гэдгээ нотолсон нь Монголын талын анхаарлыг зүй ёсоор татаж, чухамдаа Монгол, Хятадын ГЯЯ-ны сайд нар харилцан айлчлах дипломатын урьдчилсан нөхцөл болсон байна.[11]

Цянь Цичэнь 1988 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнтэй анх удаа уулзаж, түүнийг Хятадад айлчлахыг урьж, дараахан нь ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д. Ёндон айлчлалыг нарийвчлан тохиролцохоор Бээжинд очиж Цянь Цичэньтэй уулзжээ.[12]

Тийнхүү зөвлөлтийн цэрэг гарч эхлэхтэй давхцан сайд Ц.Гомбосүрэн 1989 оны хавар Хятадыг зорив. Тэр бээр айлчлалын өмнөхөн ТАСС-ын улс төрийн тоймчид ярилцлага өгчээ. "Ер нь дэлхийн аль ч нутагт, хэний ч цэрэг үндэснийхээ хил хязгаарын гадна байх ёсгүй гэдгийг та бид ойлгож байна. Гэхдээ энэ бол улс төрийн зохих зориг хүсэл, багагүй хүчин чармайлт гаргаж байж биелэх зүйл юм. Харин бидний

[10] Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С.Горбачева в Китайскую Народную Республику 15-18 мая 1989 года. Документы и материалы. М., Изд. полититческой литературы. 1989, стр. 18

[11] Д.Баярхүү. "Харилцааны шинэ эхлэл тавьсан айлчлал"-"Цаг үе" мэдээ, Монгол пресс, МОНЦАМЕ агентлаг. № 34 (106) 1988.12.10, 8-9 дахь тал

[12] Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990, стр. 156

ярьж байгаа тодорхой асуудлын тухайд бол энэ асуудлыг буй болгосон улс төр, түүхийн болон бусад тодорхой хүчин зүйлийг харгалзан авч үзэх ёстой нь мэдээж. Зөвлөлтийн цэрэг БНМАУ-д өөрийн дураар биш, харин манай хил хязгаарын аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн Монголын Засгийн газрын хүсэлтээр манай нутагт орж ирсэн гэдгийг Бээжинд сайн мэдэж байгааг үүнтэй холбогдуулан тэмдэглэе. Ингэхлээр Монголын Засгийн газар л Зөвлөлтийн цэргийг манай орны нутаг дэвсгэрээс гаргах эсэх тухай асуудлыг шийдвэрлэж, энэ талаар Зөвлөлтийн талд санал тавих эрхтэй. Тийм учраас энэ бол БНМАУ, ЗСБНХУ-ын мэдлийн асуудал. Монгол-Хятадын улс төрийн тэнгэрт нэг ч үүлгүй байна гэж батлан хэлэхэд арай эрт боловч БНМАУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болох үйл явц ямар нэгэн саад доголдолгүй жигд явж байна" гэж хэлсэн нь шийдлийн үгийг Москва, Бээжинд биш, Улаанбаатарт хэлнэ гэсэн санаа байв. Гэвч эцсийн шийдлийг хоёр хөрш хоорондоо тохиролцон гаргасан билээ. Ц.Гомбосүрэн сайдын айлчлалын үеэр "БНМАУ, БНХАУ-ын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын хэлэлцээр", "БНМАУ-ын Ерөнхий консулын газрыг БНХАУ-ын Хөх хотод сэргээн байгуулах тухай хэлэлцээр", "Иргэд харилцан зорчих журмын тухай хэлэлцээр"-т гарын үсэг зурав. Монголын сайдыг БНХАУ-ын дарга Ян Шанкунь хүлээн авч уулзах үеэр АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнхийг Хятадад айлчлахыг урьсан байна.[13]

ЗХУ-ын ГЯЯ-ны Азийн асуудал эрхэлсэн орлогч сайд Игорь А.Рогачёв 1989 оны 3 дугаар сард Улаанбаатарт ажлын айлчлал хийх үеэрээ нэгэн шинэ баримт дэлгэсэн нь зөвлөлтийн цэргийг гаргах тухай яриа хэлэлцээ ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхэлж байх үед 1986 онд Монгол-Зөвлөлтийн хооронд нууц байдалд явагджээ.[14] Э.А.Шеварднадзе 1986 оны 1 дүгээр сард ЗХУ-ын ГЯЯ-ны сайдын хувиар БНМАУ-д анх удаа бие даасан айлчлалаа хийж, улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын талаар санал солилцож, энэ үеэр БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтооход саад болж байсан хойд хөршийн «moratorium» буюу "түр азнах" хоригийг нэг мөр шийдвэрлэсэн юм. Түүнчлэн маш чухал нууц асуудал болох БНМАУ-аас зөвлөлтийн цэргийг гаргах тухай асуудал хөндөгджээ. Энэ тохиролцооны дагуу 1986 оны намар цэргийн эхний хэсэг Хятадын Синьцзян-Уйгуртай хиллэж байсан Говь-Алтай, Ховд аймгаас эх орондоо буцсан байна. Улмаар 1989 оны 5 дугаар сараас Монголоос Өвөрбайгалийн 39 дүгээр армийн бүрэлдэхүүнд багтаж байсан цэргийн бүлэглэл (военная группировка) болох танкийн 2, мотобуудлагын 3 дивиз (1861 танк, 2531 байлдааны хуягт машин), нисэх хүчний 1 дивиз (190 бөмбөгдөгч болон сөнөөгч, 130 нисдэг тэрэг), 1461 артиллерийн их буу, радар-локаторын цогцолбор, 120 мянган цэргээс 50 мянга 320 хүнийг

[13] Ц.Гомбосүрэн. "Өнөөгийн ертөнц бүхэл бүтэн, харилцан хамааралтай". Цаг үе" мэдээ. Монгол пресс, МОНЦАМЭ агентлаг. №33 (105) 1988.11.30, 7-8 дахь тал

[14] Игорь А.Рогачёвын ярилцлага: "Цаг үе" мэдээ. Монгол пресс. МОНЦАМЭ агентлаг. №31 (132) 1989.11.10, 6-7 дахь тал

гаргасан байна. Нийтдээ 50 гаруй цэргийн хотхон, бааз байрлаж байжээ.[15]

Түүнчлэн Богд хан уулын урд хормойд байрлаж байсан Радио-соронзон долгион барих, пуужингийн довтолгооноос эсэргүүцэн хамгаалах тагнуулын маш нууц томоохон хоёр цогцолбор станцыг нууцалж, удтал хэлэлцсэний эцэст татан буулгасан тухай тухайн үед Ерөнхий сайдын албыг хашиж байсан Дашийн Бямбасүрэн гуай хожим өгүүлсэн юм.[16] Эдгээр станцууд бүс нутгийн хэмжээний стратегийн тагнуулын ажиллагаа явуулж байсан байна.

Цэрэг, зэвсэг техник гаргах ажиллагаа хоёр үе шаттайгаар явагдаж 1992 оны 12 дугаар сард бүрэн шувтарчээ.[17] Үүнтэй нэгэн зэрэг Монголд ажиллаж байсан зөвлөлтийн 20 гаруй мянган мэргэжилтэн, ажилчид ч мөн нутаг буцжээ.[18]

Энд нэг баримтыг тэмдэглэхэд, БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан "БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны ордуудыг ашиглах тухай" 1981 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцээрээр[19] Дорнод аймгийн Баяндун сумын нутагт сумын төвөөс зүүн урагш 15 км-т орших Мардайн ураны "Эрдэс" хэмээх газрын зураг огт тэмдэглэгдээгүй, стратегийн орд, нууц үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. ЗХУ 1977 оноос геологийн урьдчилсан хайгуул, 1979 оноос нарийвчилсан хайгуулын ажил хийгдэж энэ ажилд нийт 56.88 сая рубль зарцуулжээ. Орд нь хэмжээний хувьд том, нөөц өсөх боломжтой байсан байх бөгөөд тухайн үедээ уурхайн ажиллах хугацааг 22 жилээр тооцож, техник эдийн засгийн тооцоо хийсэн байжээ. Мардайн ураны ордыг түшиглэн 1982-1988 онд "Эрдэс" уулын олборлох үйлдвэрийг хоёр сая тонн хүдэр олборлох хүчин чадалтайгаар байгуулж, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам, ус дамжуулах хоолой, ил уурхай, гүний малталтын хоёр уурхайн барилга байгууламж, орон сууцууд баригджээ. Дорнодын ордоос 1988-1995 онд 490,6 мянган тонн ураны хүдэр олборлож, төмөр замаар ОХУ-ын Чита мужийн Краснокаменска дахь Приаргунскийн уулын баяжуулах хими-металлургийн үйлдвэрт хүргэж боловсруулдаг байсан ажээ.[20] Мөн "Эрдэс" үйлдвэрийн дэргэд 10 мянга гаруй оршин суугчтай "Эрдэс" тосгон сүндэрлэж, ЗХУ-аас эрчим хүч шууд авдаг, цахилгааны нөөц станцтай, хүнсний үйлдвэр болон "Эрдэс" брэндийн ундаа үйлдвэрлэдэг байжээ. Мардайн орд Хятадыг ихэд болгоомжлуулж

[15] Sergey Radchenko. "The Withdrawal of Soviet Troops from Mongolia, 1986-1992: A Reassessment"-The Journal of Slavic Military Studies. pp. 183-203, Published online: 25 May 2012, https://doi.org/10.1080/13518046.2012.676484

[16] Монгол тулгатны 100 эрхэм. Монгол Улсын Ерөнхий сайд асан Дашийн Бямбасүрэн. ТВ-ийн хөрөг нэвтрүүлэг. 2013.03.06

[17] Sergey Radchenko. "The Withdrawal of Soviet Troops from Mongolia, 1986-1992: A Reassessment"-The Journal of Slavic Military Studies. pp. 183-203, Published online: 25 May 2012, https://doi.org/10.1080/13518046.2012.676484

[18] Зөвлөлтийн мэргэжилтнүүд Монголд. "Цаг үе" мэдээ. Монгол пресс. МОНЦАМЕ агентлаг. № 30 (138) 1989.10.30, 3-5 дахь тал

[19] Засгийн газрын тогтоол. "Мардайн эрдэс үйлдвэр, тосгон, дэд бүтцийн талаар авах арга хэмжээний тухай" 1999.11.17, Дугаар 190.

[20] Mongolian Mining Journal http://www.ord.mn/index.php?newsid=13694 2017.12.17

байсан тухай зарим нэг мэдээ 1990-ээд оны дундуур Оросын хэвлэлүүд гарч байсан юм. Мардайн ураны орд Хятадын пуужингийн цохилтын байнд байсан гэсэн баримтыг оросын архивын эх сурвалж хөндсөн байдаг.[21] Энд ажиллаж байсан уул уурхайн инженер, техникийн олон арван мэргэжилтнүүд ч нутаг буцжээ.

1980-аад онд ЗХУ-ын ЭСЯ-нд ажиллаж байсан дипломатч, монгол судлаач Ю.Н.Кручкин нэгэн баримт дэлгэснийг энд эш татмаар байгаа юм. Тэр бээр «ЗХУ тухайн үед жилд Монголын 4.5 сая малыг толгойг нь 3 рублээр үнэлж авч байсан байдаг. Монгол Улс зөвлөлтийн томоохон мэргэжилтнүүдийг ердөө сарын 3 ам. долларoор ажиллуулж байсан байдаг. Мэдээж хэрэг зөвлөлтийн мэргэжилтнүүд маш өндөр цалин авч байжээ. Гэхдээ тэр цалингийн 97 хувийг ЗХУ төлж байсан юм. ХХ зуунд ийм хямдхан гадаадын мэргэжилтэн ажиллуулж байсан өөр улс байхгүй. *Хоёрдугаарт*, тэр мэргэжилтнүүд дандаа нэрд гарсан алдартай хүмүүс байсан байдаг» гэжээ.

ЗХУ-ын «зөвлөмжөөр» БНМАУ-ын Засгийн газар ЗХУ-д хүсэлт тавьж, тийнхүү Зөвлөлтийн хориглолтын бус, давшилтын зориулалттай цэргийн асар том бүлэглэл Монголд «түр» байрлаж байсан ажээ. ***Монгол Улс Зөвлөлтийн цэргийн асар том давшилтын хүчийг өөрийн нутагт байрлуулж байсан атлаа Японы Окинава, Өмнөд Солонгост байрлаж байсан АНУ-ын цэргийн баазыг тэдгээр улсуудаас гаргахыг шаардаж байсан юм.***

Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь 1989 оны найм, ес дүгээр сарын заагт Монгол Улсад хариу айлчлал хийж, ***хоёр орны харилцаа бүрэн хэвийн болсныг нотлов.*** Айлчлалын үеэр БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхзүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд гарын үсэг зуржээ.[22]

БНХАУ-ын хувьд 1978 оны 12 дугаар сард хуралдсан ХКН-ын ТХ-ны III бүгд хурлаас эхлүүлсэн эдийн засгийн шинэчлэлийн бодлого амжилтад хүрэх эсэх нь Хятадыг тойрсон бүсэд гадаад таатай орчин буй болгон, удаан хугацаанд хадгалах явдал байсан нь тодорхой байв.

Хятадын гадаад бодлого, практик үйл ажиллагаанд гарч байгаа шинэ нөхцөл байдал, хандлагыг гадаад, дотоодод системтэй танилцуулах зорилгоор БНХАУ-ын ГЯЯ-наас эрхлэн жил бүр хэвлэн гаргаж байх «Хятадын гадаад харилцааны товч лавлах-1987» номын анхныхыг 1987 онд Бээжинд хэвлэн гаргажээ. Хятадын ГЯЯ-ны сайд У Сюэцянь оршил бичсэн 12 бүлэг, хавсралт бүхий энэ номд Хятадын 1986 оны гадаад харилцааны тойм хийгээд 1949 оноос хойших Хятадын гадаад харилцааны түүхийг товч өгүүлжээ.[23]

---

[21] Соболев А.О. Страницы истории работ геологов СССР и РФ по поискам и освоению месторождений урана на территории Монголии (недоступная ссылка). www.legendtour.ru. Дата обращения: 4 октября 2018. Архивировано 1 сентября 2018 года.

[22] Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь Монголд айлчлав. "Цаг үе" мэдээ. Монгол пресс. МОНЦАМЭ агентлаг. УБ., № 9, 1989

[23] Китайская Народная Республика: 1987 политика, экономика, культура. М.: 1989, стр. 165

Хоёр орны харилцаа 20 гаруй жил зогсонги байдалд байснаа 1980-аад оны эхэн үеэс хоёр талын хамтын хүчин чармайлтын дүнд сэргэн мэдэгдэхүйц ахиц гарч эхэлжээ. 1982 оны 2 дугаар сараас улсын хилийг нэг удаа хамтран шалгаж эхэлсэн бөгөөд 1984 оны 7 дугаар сард ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Ёндон БНХАУ-д айлчлах үеэр хоёр тал Монгол, Хятадын хилийг анх удаагаа хамтран шалгасан тухай Протокол, түүний хавсралт газрын зурагт гарын үсэг зуржээ. Мөн БНХАУ-ын ГЯЯ-ны сайд У Сюэцяньтай уулзаж ярилцахад Хятадын сайд "Энхтайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр БНМАУ-тай худалдаа-эдийн засаг, соёлын салбарын харилцааг хөгжүүлэх эрмэлзэлтэй байна" гэсэн байна. 1986 оны 8 дугаар сард Хятадын ГЯЯ-ны орлогч сайд Лю Шуцин Монголд айлчилж, ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Ёндонтой хоёр талын харилцаа ба харилцан сонирхож байгаа олон улсын асуудлаар хэлэлцээ хийж, Монгол-Хятадын хоорондын консулын анхны конвенцод гарын үсэг зурав.[24]

БНХАУ-ын БХАТИХ[25]-ын Байнгын Хорооны орлогч дарга Пэн Чун тэргүүтэй парламентын төлөөлөгчид 1987 оны 6 дугаар сард Монгол Улсад айлчилж, төлөөлөгчдийг АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх хүлээн авч уулзжээ.[26] БНМАУ-ын АИХ-ын дарга Л.Ринчин тэргүүтэй АИХ-ын төлөөлөгчид 1988 оны 9 дүгээр сард БНХАУ-д хариу айлчлав.[27] Монголын парламентын төлөөлөгчдийг БНХАУ-ын дарга Ян Шанкунь, БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга Вань Ли нар хүлээн авч уулзжээ. Л.Ринчин айлчлалынхаа хүрээнд ХКН-ын ТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн эрхлэгч Жу Ляньтай уулзаж, намын харилцааны асуудлаар санал солилцож, түүнийг 1989 онд БНМАУ-д айлчлахыг урьсан байна.[28]

1988 оны 11 дүгээр сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Ч.Сүрэн БНАСАУ-д айлчлаад эх орондоо буцах замдаа Бээжинд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Тянь Зиюаньтай уулзаж, хоёр орны хооронд худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлаар санал солилцож байжээ.[29]

БНМАУ-ын ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Ёндон 1988 оны 12 дугаар сард БНХАУ-д айлчилж, БНМАУ, БНХАУ-ын хооронд хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай гэрээнд гарын үсэг зурав. 1985 оноос хоёр улсын ГЯЯ-ны сайд нар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр уулзаж ярилцсан нь байр сууриа ойлголцоход тус дөхөм болж, уулзалт тогтмолжих төлөвтэй болов.[30]

---

[24] Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990, стр. 201

[25] Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал

[26] Китайская Народная Республика: 1987 политика, экономика, культура. М.: 1989, стр. 186

[27] Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990, стр. 157

[28] Тоже там,

[29] Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. XX зууны сүүлийн хагаст, Дэд боть. УБ., 2020, 272 дахь тал

[30] Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990, стр. 102

1988 онд МАХН, ХКН-ын харилцааг сэргээх анхны алхам хийгдсэнээс гадна ХКН-ын ТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн тасгийн дарга Жай Вэньлян өөрийн элчин сайдынхаа зочноор Улаанбаатарт ирж, МАХН-ын ТХ-ны албаны хүмүүстэй уулзаж, намын харилцааны асуудлаар санал солилцож, намын төлөөлөгч, намын баримт бичиг, төв хэвлэл, намын дээд сургуулийн багш нар солилцох, НТХ, ЭСЯ-ны хоорондшууд харилцаа тогтоох шууд харилцаж байх дөрвөн санал тавихад Монголын тал зарчмын хувьд зөвшөөрсөн хариу өгч байжээ.[31]

ХКН-ын ТХ-ны гишүүн, ТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн эрхлэгч Жу Лянь тэргүүтэй намын төлөөлөгчид 1989 оны 7 дугаар сард Монгол Улсад айлчилж, МАХН, ХКН-ын харилцааг сэргээв. Эдгээр үйл явц хоёр талын хамтын хүчин чармайлтын үр байв.[32]

1956 онд БНХАУ-аас Монголд буцалтгүй тусламж үзүүлж, 1958, 1960 онд хөнгөлттэй зээл хоёр удаа олгож иржээ. Хятадын тусламжаар Монголд нийтдээ 20 гаруй объект барьж, Монголын саналыг үндэслэн дуусгаагүй үлдээсэн 7 объектыг 1973 оны 3 дугаар сард тухайн үеийн үнээр Монголын талд шилжүүлжээ. Хятад ажилчдыг Монголын үйлдвэр, барилга, байгууламж дээр ажиллуулах тухай 1955, 1960 оны хэлэлцээрийн дагуу 1955-1964 онд БНХАУ олон тооны ажилчид, мэргэжилтнээ илгээж, Монгол Улсын шинэ бүтээн байгуулалтын үйлсэд зохих хувь нэмрээ оруулсан юм. Монголын Засгийн газрын шаардлагаар 1964 оны 4 дүгээр сард Монголд тусалж байсан хятад ажилчид, тэдний гэр бүлийнхэн нутаг буцжээ.[33]

Монгол, Хятадын худалдаа 1950-иад он, 1960-аад оны эхээр хурдацтай хөгжиж, худалдааны эргэлт харьцангуй өндөр байснаа 1960-аад оны дунд үеэс аажмаар буурч, 1970-аад оны сүүлчээс хойш дахин бага багаар өссөөр иржээ. 1985 онд хоёр орны хоорондхилийн худалдаа хөгжүүлэх баримт бичиг солилцож, улмаар хэрэгжүүлж эхлэв. 1986 онд хоёр орны худалдааны хэмжээ 24.9 сая швейцарь франк болж өмнөх оны протоколын дүнгээс 66 хувиар өссөн байна. Энэ нь Монгол Улс төмөр замын транзит тээврийн орлогын 60 хувьд нь 13.8 сая швейцарь франкийн бэлэн бараа бүтээгдэхүүн импортоор авсантай холбоотой байв. 1986 оны 4 дүгээр сард Бээжинд 1986-90 онд харилцан бараа нийлүүлэх ба төлбөрийн тухай Монгол-Хятадын Засгийн газар хоорондын анх удаагийн урт хугацааны худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд дурьдсан хугацаанд худалдааны нийт эргэлт 51-52 сая швейцарь франк хүрэх ёстой байв. 1987 онд хоёр орны худалдааны нийт эргэлт 27 сая швейцарь франк, 1988 онд 46 сая швейцарь франк болсон бөгөөд түүний дотор улсын худалдаа 22.7 сая, хилийн шууд худалдаа ба бараа

[31] Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. XX зууны сүүлийн хагаст, Дэд боть. УБ., 2020, 272-274 дэх тал, Х.Аюурзана. БНМАУ, БНХАУ: Харилцааны шинэ үе шат. Монгол Пресс. "Цаг үе" 1989.03.20 №8 (116) 10-11 дэх тал

[32] Х.Аюурзана. Монгол-Хятад: Хамтын ажиллагааны он дараалын хуудсууд. Монгол Пресс. "Цаг үе" 1989.10.10 №14 (121) 5-6 дахь тал

[33] ГХТА. [G] Ф.А-5, ХН. 300-721

солилцоо 23.9 саяд хүрчээ.[34]

1988 оны 7 дугаар сард Улаанбаатарт Монгол, Хятадын хилийн худалдааны хэлэлцээний 8 дахь үе шат болж өндөрлөжээ. Хэлэлцээнд Монголын талаас гадаад худалдааны Монголэкспорт, төрөл бүрийн барааны Импэкс, Материалимпэкс, Хоршоолол Импэкс, Дорноговь аймгийн Худалдаа бэлтгэлийг удирдах газар, аймгийн Материал техникийн хангамжийг удирдах газар, Хятадын талаас ӨМӨЗО-ны Гадаад худалдааны танхим, Хилийн худалдааны компани, түүний Эрээн хотын салбарын төлөөлөгчид оролцжээ. Энэ удаа Замын-Үүд, Эрээн хотын төлөөлөгчид анх удаа шууд хэлэлцээ хийж бараа солилцох зарчим, нөхцөлийн талаар анхны гэрээ байгуулсан явдал шинэ алхам болов. Хоёр орны хилийн худалдаа 1986 онд 1.4 сая, 1987 онд 2.8 сая, 1988 онд 17 сая швейцарь франк болж огцом өсжээ.[35]

Хоёр талын зөвхөн 1989 оны 12 дугаар сарын хилийн худалдааг өнөөдөр тэмдэглэхэд нэн сонирхолтой. Тухайлбал, Монголын тал 120 тонн хаягдал төмөр, 60 тонн яс нийлүүлж, оронд нь 400 ширхэг халуун сав, 3000 ширхэг будаатай шаазан аяга, 1000 хайрцаг хүж, 400 боодол хамрын тамхи, 300 ш. хадаг, 1-7 насны хүүхдийн хос гутал 600, 13-16 насны хүүхдийн хос гутал 300, 500 ш. даавуун шаахай, 300 ш. том хүний биеийн тамирын хувцас, 1000 ш. нусны алчуур, 300 ш. 25-ын үзэг авсан байна.[36]

1978 оноос эхлэн Монгол, Хятадын хоорондын худалдааны тооцоог чөлөөлт валютаар хийх болж, швейцарь франкийг төлбөрийн нэгж болгохоор тохиролцжээ.[37]

1986 оноос эхлэн зуны улиралд Монголын нисэх онгоц, галт тэрэг Улаанбаатар-Бээжингийн хооронд жуулчид, зорчигч тээвэрлэж, 1987 оноос Улаанбаатар-Бээжингийн хооронд онгоц тогтмол нислэг үйлдэх болов. Төмөр замын тээвэр, цаг уурын мэдээ тогтмол солилцох болсон байна.

1983 оны 11 дүгээр сард Монголын чөлөөт бөхийн баг Хятадын талын урилгаар айлчилж, хоёр орны соёл, урлаг, спортын солилцоог сэргээв. 1984 онд Хятадын чөлөөт бөхийн баг Монголд хариу айлчилж, Хятадын дүрслэх урлаг, чимэглэлийн үзэсгэлэн Улаанбаатарт нээгдэв. Монголын ардын зураач Цүлтэмийн уран бүтээлийн үзэсгэлэн 1985 онд Бээжинд нээгдэж, Монголын ардын дуу бүжгийн чуулга, Өвөр Монголын урлагийн хэсэг харилцан айлчлан тоглолт хийв. Мөн оны 10 дугаар сард Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн дарга Б.Мягмаржав

[34] Гадаад худалдааны яамны "Монголэкспорт", "Төрөл бүрийн барааны Импекс" Асуулт, хариулт. Монгол Пресс. "Цаг үе" 1988.04.30 №12

[35] Мөн тэнд,

[36] "Хилийн худалдаа: Анхны үр дүн, асуудал, бэрхшээл" Монгол Пресс. "Цаг үе" 1989.01.30, 7-8 дахь тал

[37] Х.Аюурзана. БНМАУ, БНХАУ: Харилцааны шинэ үе шат. Монгол Пресс. "Цаг үе" 1989.03.20 №8 (116) 10-11 дэх тал

тэргүүтэй төлөөлөгчид Хятадад айлчлав.[38]

1986 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо Соёлын солилцооны төлөвлөгөөнд гарын үсэг зурж, жил болгон сунгах болов. Энэ нь 1967 оноос хойш хоёр орны Засгийн газар гарын үсэг зурсан соёлын солилцоо хэрэгжүүлэх анхдагч төлөвлөгөө болов. Дурдсан төлөвлөгөөний дагуу хоёр улс багш, мэргэжил дээшлүүлэгч харилцан солилцож, Монголын багш нар Бээжингийн их сургуульд багшилж, зохиолчдын төлөөлөгчид солилцож, Монголын ХАА-н судалгааны хэсэг Хятадад очиж, Хятадын монгол хэл, утга зохиол судлаачид Монголд айлчилж, Шаньдунгийн циркийн хамтлаг Монголд айлчлан тоглов. Монголын талын урилгаар Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн Жан Вэйле тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилжээ.[39]

Хоёр орны харилцааны энэхүү таатай уур амьсгалыг дагалдаад МҮЭ-ийн ТХ, МХЗЭ-ын ТХ, Монголын Эмэгтэйчүүдийн Хороо, МЭТНБХ-ны Гүйцэтгэх Хороо, Монголын Зохиолчдын Эвлэл, МСХ-ны төлөөлөгчид БНХАУ-д айлчлах болов.

Ийнхүү БНМАУ, БНХАУ-ын хамтын хүчин чармайлт, олон улсын харилцааны таатай уур амьсгалын үр дүнд 1980-аад оны сүүлчээс хоёр орны харилцаа бүрэн хэвийн болов.

1990 оны 5 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат БНХАУ-д айлчилсан нь Монголын төрийн тэргүүн анх удаа гадаад дахь айлчлалаа Хятадаас эхэлснээр өмнөх шинэ удирдагчид эн түрүүнд ЗХУ-д айлчилдаг арга барилтай огт адилгүй хэрэг болов хэмээн гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн онцгой анхаарлыг татахад хүргэсэн юм.[40] 1991 оны 8 дугаар сард БНХАУ-ын дарга Янь Шанкунь БНМАУ-д айлчилсан нь хоёр орон 1949 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Хятадын төрийн тэргүүний Монголд хийсэн анхны айлчлал болов.[41]

1994 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн Монгол Улсад Засгийн газрын тэргүүний хувиар айлчилж, хоёр орны харилцааны болон дэлхий дахины өөрчлөгдөн буй нөхцөл байдлыг харгалзан улс төр, эрхзүйн суурь зарчмыг шинээр тодорхойлсон баримт бичиг «Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ»-нд гарын үсэг зурсан нь нэн чухал ач холбогдолтой үйл явдал байсныг тэмдэглэх хэрэгтэй.[42]

1998 оны 12 дугаар сард БНХАУ-ын дарга Зянь Зэминийн урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадад төрийн айлчлал хийж, хоёр тал “Хамтарсан мэдэгдэл” гаргаж, хоёр орны харилцааг XXI зуунд

[38] Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. XX зууны сүүлийн хагаст, Дэд боть. УБ., 2020, 274 дэх тал

[39] Китайская Народная Республика: 1986 политика, экономика, культура. М.: 1988

[40] Мөн тэнд,

[41] Мөн тэнд,

[42] Монгол-Хятадын харилцааны түүхэн баримт бичгийн эмхтгэл. (1990-2014) УБ., 2014, 104 дэх тал

хандсан урт хугацааны тогтвортой, сайн хөршийн найрсаг харилцааны ирээдүйн хөгжлийн хандлагыг тодорхойлов.[43]

1999 оны 7 дугаар сард БНХАУ-ын дарга Зянь Зэминь Монгол Улсад төрийн айлчлал хийж, хоёр орны сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны агуулгыг нэмэн баяжуулж, харилцан итгэлцлийг улам бэхжүүлэв.[44] XX зууны хоёр орны харилцааны түүх нь эрчимтэй хөгжил, зогсонги байдал, хамтын хүчин чармайлт, харилцаа сэргэж, хэвийн гольдролд орсноор XXI зуунд илүү үр бүтээлтэй хамтран ажиллах шимтэй хөрсийг буй болгосон он жилүүд мөн.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. ГХТА. [G] Ф.А-5, ХН. 300-800
2. Монгол-Хятадын харилцааны түүхэн баримт бичгүүдийн эмхэтгэл. (1990-2010). УБ., 2014
3. БНМАУ-ын Улс Ардын Аж Ахуй-70 жилд (1921-1991) УБ., 1991
4. БНМАУ-ын Эдийн засаг, нийгмийн хөгжил 1921-1988 онд. Статистикийн эмхтгэл. УБ., 1989
5. "Цаг үе" мэдээ. Монгол пресс. МОНЦАМЭ агентлаг. УБ., № 1986-1990
6. БНМАУ-ын Худалдаа-Аж үйлдвэрийн танхим. Мэдээ мэдээлэл: 1989-1990
7. Чулуун О. (Ч.Далай). БНМАУ ба БНХАУ-ын харилцааны асуудал. УБ., 1974
8. Бэгзжав Л. Монгол, Хятадын харилцаа (1949-1999) УБ., 1999
9. Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. XX зууны сүүлийн хагаст, Дэд боть. УБ., 2020
10. Цянь Цичэнь. Хятадын дипломатын арван том үйл явдлын тэмдэглэл. УБ., 2016
11. Далай Ч. Отношения между МНР и КНР (1949-1984 гг.) Автореф. докт. Дисс. Институт Истории АН МНР, УБ., 1986
12. Далай Ч, Иржи Шима. Отношения между МНР и КНР (1949-1985 гг.) Прага., ЧССР, 1986
13. Инст. Истории АН МНР, УБ., 1986
14. Монгол Улс. Гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. IX боть. (1990-2001). УБ., 2001
15. Горбачёв М.С. Перестройка и новые мышления для нашей страны и для всего мира. Изд. политической литературы. М.: 1988
16. Горбачёв М.С. Избранные речи и статьи. Изд. политической литературы. М.: 1989
17. Китайская Народная Республика: 1984 политика, экономика, культура. М.: 1987
18. Китайская Народная Республика: 1986 политика, экономика, культура. М.: 1988
19. Китайская Народная Республика: 1987 политика, экономика, культура. М.: 1989
20. Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990

[43] Мөн тэнд, 135 дахь тал

[44] Монгол-Хятадын харилцааны түүхэн баримт бичгийн эмхтгэл. (1990-2014) УБ., 2014, 144-146 дахь тал

21. Китайская Народная Республика: политика, экономика, культура в 1989-1990 годах. М.: 1992
22. Международный Ежегодник: Политика и экономика-1988. М.: 1988
23. Международный Ежегодник: Политика и экономика-1989. М.: 1989
24. Энциклопедия Нового Китая. (перевод на русский язык с сокр.) Изд. “Прогресс”, М.: 1989
25. Проблемы Дальнего востока. Жур: ИДВ АН СССР. № 1988-1992
26. Мировая экономика и международные отношения. Жур: ИМЭМО АН СССР. № 1988-1991
27. Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С. Горбачёва в Китайскую Народную Республику 15-18 Мая 1989 года. Документы и материалы. Изд. политической литературы. М.: 1989
28. Дмитрий А.Перевалов. Рукопожатие через тридцать лет (Итоги советско-китайской встречи на высшем уровне). АПН. М.,1989
29. Горбачёв М.С. В Нью-Йорке 6-8 декабря 1988 года. Документы и материалы. Изд. политической литературы. М.: 1988
30. М.С.Капица М.С. «На разных параллелях. Записки дипломата» М., 1996
31.

Сталин, Чойбалсангийн уулзалт: Үр дүн

Х.Шагдар
БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
шинжлэх ухааны доктор (S.D), профессор

Abstract

The foreign and the internal affairs policy of Mongolia in the years from 1920 to 1940 will be analyzed, special attention was paid to the fact that Mongolia at that time represented a platform for the foreign policy intrigues of the countries such as Soviet Union, China and Japan and this fact, however, influences the relations between Mongolia and Soviet Union. The Soviet Union tries to have undue influence over internal affairs of Mongolia, provokes, puts the then leadership of the country under enormous pressure and begins reprisals and retaliatory measures. The evidence for this is provided by the communication protocol between Stalin and Choibalsan. How these two personalities approached and distanced themselves again, how the relationship as heads of state came to an end, is described and evaluated based on historic descriptions and facts.

Keywords: *Soviet Union, The People's Commissariat of Foreign Affairs, Ministry for Foreign Affairs, Manchurian-it's established by Japan as puppet state in Northern China, The Allied Communist party, The Workers' and Peasants' Red Army*

Х.Чойбалсан Москвад 16 удаа хөл тавьж,түүний 13-д нь Сталинтай уулзсан баримт байна.Эдгээр аялал, айлчлал болон Сталин Чойбалсангийн харилцаа, тэдгээрийн үр дүнг он дараллын дагуу товч авч үзье.

Түүний өмнө тухайн үеийн Монголын улс төрийн гадаад орчныг товч дурдъя.

1927 оны 10-р сард ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссарат (ГХАК) Япон, Манжуур, Монголын асуудлаар зөвлөгөөн хийлгэжээ. Зөвлөгөөнд оролцогчид Монголын талаарх Японы бодлогод дараах үнэлэлт өгчээ: Үүнд: Япончууд: *нэгд*, У.Пейфу, Жан Золин, умард Монголын ноёдыг ашиглан Зөвлөлтийн нөлөөг шахан гаргах гэж байна, *хоёрт*, Монголын нэгдсэн улсыг Хятадаас тусгаарлах, гуравт, Хятадын Дорнодын 3 муж, бүх Монголыг оруулан буфер улс байгуулах зорилготой байна гэж үзжээ[1].

Ийнхүү ЗХУ-аас Монголын талаарх Японы бодлогыг тодорхойлсон нь угтаа ЗХУ-аас Японы талаар баримтлах бодлогын үндэслэл байв.

ЗХУ-аас Япон,Монголын талаар баримтлах бодлого нь:

- Юуны өмнө Монголыг Японы хөрөнгөтөн хөгжлийг дагуулан

[1] Р.Болд. Зарлаагүй дайн. УБ., 2014. т.41

алдахгүйгээр коммунист үзэл суртлын өвөрөсөө гаргахгүй байх,

- Тэхдээ Ар Монголыг Хятадын автономит муж гэх Хаант Орос-Хятадын гэрээг хөндөж, хятадтай харилцаа эвдрэхгүй байх,

- Ингэснээр Ар Монгол улсыг Япон, Хятадаас халхавчлах жийрэг болгон ашиглах,

- Япон, Хятадын эсрэг дайн, сөргөлдөөнд хүрвэл ЗХУ нь Монголын газар нутгийг дайны талбар болгон ашиглахад байв. Энэ бодлогын үндэс нь: Коментерны бодлого үндсэндээ мухардалд орж Ар Монголчууд бүх монголчуудаа нэгтгэх бодлогыг хамгаас эрхэмд бодож, үүний төлөө хэнтэй ч нөхөрлөхөд бэлэн болсон, үүний төлөө гадаад олон оронтой харилцахыг хичээж байгаа нь олон оронд, тухайлбал Орост тодорхой болсон, Япон үзэл суртал, сэтгэл зүйн дайн явуулах аргыг сонгож, "Чингис хааны Монгол улсыг байгуулна" гэдгийг зүсэн зүйлийн аргаар Орос, Хятад, Ар Монгол төдийгүй дэлхий даяар зарлаад байгаад оршиж байв. Ийм нөхцөлд Зөвлөлтийн дорно дахинтай харилцах улс төрийн бодлогыг 1930-аад оноос Сталин гартаа авчээ.

ЗХУ, Японтой харилцах БНМАУ-ын бодлогыг Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд П.Гэндэн, Х.Чойбалсан, Г.Дэмид нар толгойлж байв. Улсаа хөрөнгөжүүлэх, ЗХУ-ын хараат бус эрх чөлөөт замаар хөгжүүлэх,Чингис хааны үеийн нэгдсэн Монгол улсаа сэргээн байгуулах боломж олдож магадгүйд горилсон хэсэг нь Манж-го улстай ойр байж, бүр харилцан итгэмжит төлөөлөгчийг улс улсдаа суулгах хүртэл хэлэлцэж байв. Үүнийг Манж-го, түүний ард суугаа Япон сэдэн дэмжиж байсан нь битүү Монголын нэрийг дэлхийн улс төрийн тавцанд гаргаж, түүнийг Орос,Хятадаас салган тусгаар улс болгож,тэр улсыг Азид цааш цаашдын улс төр-цэргийн бодлогоо хэрэгжүүлэх талбар болгон ашиглахад оршиж байв. Гэтэл ЗХУ-аас Ар монгол эрс нүүр буруулах эдийн засаг, цэрэг-улс төрийн нөхцөл байдал яавч бүрэлдээгүй байв.

Ийм хоёрдмол бодлого сэтгэхүйтэй Монголыг ирээдүйн болзошгүй дайн дажнаас урьтан бүрэн "улайлгаж" авах нь ЗХУ-аас Монголд баримтлах бодлогын тэргүүн эгнээнд гарч ирсэн бөгөөд энэ бодлогыг хэрэгжүүлэх арга нь лам нар, "барууны буюу хөрөнгөтний" зам сонгохыг санагалзсан бүх хүчнийг устгах явдал гэж Сталин, түүний хамтран зүтгэгчид сэтгэж, Зөвлөлтийн дохиог эргэлзэлгүй биелүүлэх хүнээр Чойбалсанг сонгож, Сочи-д жил дараалан "эмчилгээ", боловсруулалт хийж,түүнийг итгүүлэн шуудруулснаар Чойбалсан 1936-1938 онд үнэхээр улаан зандалчин болсноо тэр даруй ухаарч, тэгж их хавтгайруулан хядна гэж санаагүй байсандаа гутарч, сэтгэцийн өвчинд автсан байдаг. (Х.Ш)

Одоо Сталин, Чойбалсангийн харилцаанд оръё.

НЭГ. 1922 оны нэгдүгээр сар. Х.Чойбалсан В.Д.Хуватай хамт "Цэргийн хамтын ажиллагааны асуудлаар" хэлэлцээ хийхээр анх Москвад очсон. Үүний үр дүнд 1922 оны 6-р сарын 27-нд ЗСБНХОУ-ын Ардын комиссар нарын зөвлөлийн хуралдаан болж, "Монголын ардын засгийн

газар ба ЗСБНХОУ-ын Засгийн газрын хооронд байгуулах худалдааны хэлэлцээрийн тухай" асуудал хэлэлцэж, энэ асуудалд Сталины саналыг тусган дахин хэлэлцэхээр тогтсон байна.

ХОЁР. 1926 оны 5-6-р сар. Цэргийн асуудлаар хэлэлцээр хийх бэлтгэлийг хангах төлөөлөгчдийг Чойбалсан тэргүүлж Москвад очив.

ГУРАВ. БХК \б\Н-ын Төв хорооны улс төрийн товчоо 1929 оны 1-р сарын 17-нд МАХН-ын төлөөлөгчдийг Москвад хүлээн авах эсэх тухай асуудал хэлэлцэж, хүлээн авах, ахуй, соёл, цэргийн асуудлаар хэлэлцээ хийх шийдвэр гаргасны ёсоор **1929 оны 2-р сард** Ерөнхий сайд П.Гэндэнгийн хамт Х.Чойбалсан Москвад очжээ. Энд монголын төлөөлөгчдийн хийсэн илтгэлийн талаар 1929 оны 2-р сарын 24-нд БХК\б\Н-ын улс төрийн товчоо хуралдаж, МАХН-ын VII их хурлын шийдвэрийг биелүүлэх үндсэн арга хэмжээний тухай хэлэлцэж, дараах үндсэн заалтуудыг өгсөн байна. Энэ нь "МАХН нь Коминтерний удирдлагад үг дуугүй захирагдана" гэсэн гэрээний заалт дээр дөрөөлсөн удирдамж байв. Үүнд:

- Ядуусын эдийн засгийг дэмжиж, хөрөнгөтөн-феодалын болон лам нарын эдийн засаг, улс төрийн суурийг эвдэх,

- Богд гэгээний хойд дүрийг тодруулахгүй байх,

- Монгол улсын аж ахуй, цэргийн тэргүүтэй бүхий л салбарыг орос сургагчаар хангах,

- Орост монгол хүүхдийг олноор сургах,

- Монголын тухай мэдээг орост маш нууцаар авч байх асуудал байжээ[2].

Товчоор үзвэл, Москвагийн эдгээр заавар нь "улайлгах" бодлогын хөтөлбөр байгаа нь харагдах бөгөөд энэ өгүүлэлд эшилсэн ОХУ-ын архивын материалууд нь БХК\б\Н-ын төв хорооны нарийн бичгийн дарга И.Сталины гарын үсэгтэй байгааг дурдая.

Үүний дараахан Сталин МАХН-ын Төв Хороонд сонирхолтой мэдэгдэл ирүүлсэн нь: "Монголд хамтралын хөдөлгөөнийг үргэлжлүүлэн хөгжүүлэх ба лам нарын малыг улсын мэдэлд авах тухай танай осолтой үзлийг бид дэмжихгүй"[3] гэжээ. Энэ бол хамтралжуулах хөдөлгөөнийг яаравчлан хэрэгжүүлсэн, сүм хийд санваартнуудын асуудалд болгоомжгүй хандсан нь нийгмийн сэтгэл зүй,тариачид санваартнуудын амьдралд хүнд цохилт болсон гашуун туршлагадаа үндэслэсэн, монголд хөрөнгөлөг малчид, лам нарын эсэргүүцэл хөдөлгөөн гарахаас сэрэмжилсэн дохио байв. Харамсалтай нь, түүний сануулгыг Комитерн ба монголын удирдагчид чихний хажуугаар өнгөрөөжээ.

1933 оны 6-р сар. МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Лхүмбийг японы тагнуул, хувьсгалын эсэргүү буриадын цагаач нартай холбоотой хэмээн баривчилж, "Лхүмбийн хэрэг" гэгчийг мандуулж олон хүнийг

[2] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.25-26
[3] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.27

хэлмэгдүүлэн баривчлав. Лхүмбийг 1934 оны 6-р сард буудан хороов.

ДӨРӨВ. 1934-11-15. Сталинаас Монголын төлөөлөгчидтэй хийсэн ярианы товч тэмдэглэл. Энэ удаагийн уулзалтууд дээр Сталины ярьсан яриа, зөвлөмжүүд ЗХУ,Сталинаас Монголын талаар хэрэгжүүлэх багц хөтөлбөр болсныг дараа дараагийн үйл явдлууд нотлох юм.\Х.Ш\

Оролцогсод: И.В.Сталин (БХК\б\Н-ын ТХ-ны нарийн бичгийн дарга), В.М.Молотов (Төв Хорооны УТТ-ны гишүүн, ЗСБНХУ-ын Ардын комиссариатын Зөвлөлийн дарга), К.Е. Ворошилов (БХК\б\Н-ын Төв Хорооны УТТ-ны гишүүн, Монголын комиссын удирдагч), Каганович (БХК\б\-ын ТХ-ны УТТ-ны гишүүн), Жданов, Сокольников (ЗСБНХУ-ын Гадаад хэргийн Ардын Комиссаратын хэлтэсийн дарга), Элиава (Дотоод худалдааны ардын комиссар), П. Гэндэн (БНМАУ-ын ерөнхий сайд), Х.Чойбалсан (БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогч), Р.Мэнд (Худалдаа-үйлдвэрийн яамны сайд), О.Дашчирав (Цэргийн яамны орлогч сайд), орчуулагч Ильин байв. Монголын төлөөлөгчдийн энэ айлчлал 1934-10-21-ээс 12-р сарын 2-ны хооронд үргэлжилсэн байна.

Уулзалт дээр дараах сэдвүүдээр ярилцжээ:

- Шинэ эргэлтийн бодлого ард түмний талархлыг хүлээж буй тухай П.Гэндэн товч илтгэж, лам нар нам,засгийн эсрэг илэрхий тэмцэж байна гэснээр тэд лам нарын сэдвээр удаан яриа үүсгэжээ.

Сталин: - Лам нар сонин хэвлэлтэй эсэх, тэд ямар хөрөнгөөр амьдардаг, ямар хэлээр ном уншиж ярьдаг, монголд хэдэн сонин ямар хэлээр гардаг, хэдэн сургуультай, багш нарын хүрэлцээ ямар, худаг усны хэрэгцээ хэр зэрэг асуудлаар ярилцахад Х.Чойбалсан тэдний ярианд анхлан оролцож:

- Залуучуудын эвлэл 60 худаг гаргах үүрэг авснаас 50-ийг бэлэн болгосон хэмээн хариулжээ.

Гэндэний илтгэж дууссаны дараа Сталин дараах зөвлөгөөг өгсөн байна:

- Танай улсын дотор улс байгаа байдалтай болжээ. Нэг засгийн газар нь Гэндэний, нөгөө нь лам нарын. Гэхдээ лам нарын засгийн газар нь хүчтэй юм байна. Нам, эвлэлийн ажлыг хүчтэй болгох хэрэгтэй.

- Олон худаг гаргаж, улс ард түмэндээ анхаарч байгааг харуулах,

- Бурхан мөргөлийн үйлчилгээг төвд хэлээс монголд хэлд шилжүүлэх, одоогоор хүндрэлтэй бол ирээдүйд шилжүүлэх,

- Шинэ эргэлтийн бодлогыг эрчимжүүлж, лам нарын эсрэг тууштай тэмцэх, улс төрийн хэрэг үйлдсэн толгой лам нарыг хавтгайруулахгүйгээр шийтгэх ба тэднийг хувьсгалын эсэргүү бус эх орноосоо урвасан хэргээр шийтгэх,

- Хүчтэй армитай байх,

- Сургууль байгуулах, хүн малын эмч бэлтгэх ажлыг өрнүүлэх зэрэг зөвлөгөө өгчээ. Энэ бүхэн бол бүхэлдээ лам нарын эсрэг тэмцэх шууд ба шууд бус хөтөлбөр байв. (Х.Ш)

Гэндэний тавьсан хоёрдугаар асуудал нь "Баяжигтүн" гэсэн уриа нь тухай байжээ. Түүний үзэхээр бол, энэ лоозон нь хүн амын бүх давхарга ядуу, дунд, баячуудын аль нь ч ялгаагүй, ард түмний чинээлэг дээд хэсгийн баялгийг саатуулахгүйгээр бүгд малаа хязгааргүй өсгөх гэсэн лоозон аж. Тэрээр, шинэ эргэлтийн бодлогын үед мал 3 саяар өссөнийг баримт болгон илтгэжээ.

Сталин: - Монголд хамтрал байхгүй, нийгмийн өмч байхгүй учраас хамтрал байгуулах нөхцөл байхгүй... Монголд мал хувийн өмчид байна. Хувийн өмч байгаа нөхцөлд баяжих явдал нь нэг нь нөгөөгөө зайлшгүй мөлжих замаар явуулдаг. Энэ бол хууль...Танай орныг хөрөнгөтний ардчилсан улс гэж нэрлэж байсныг та нар санаж байгаа байх. Хөрөнгөтний ардчилсан хэмээх үг юу гэсэн үг вэ? Энэ бол нийгмийн өмч байхгүй, хувийн өмч л байдаг учраас мөлжлөг зайшгүй гэсэн үг. Олон малтай хүн сүргээ ганцаараа хариулж хүчрэхгүй, бусад ядуу ардыг хөлслөх болно...Танай засгийн газар баячуудаас их татвар авч, ядуучууд болон дундчуудад бүх талын дэмжлэг үзүүлбэл зохино. "Баяжигтүн" гэсэн лоозон хэрэггүй гэсэн зөвлөгөө өгсний дараа бас бус асуудалд орж, Сталин:

- Баячуудыг намд элсүүлэхгүй байх, гагцхүү намын үйл хэрэгт хэрэгтэй зарим баян ардыг элсүүлж болно гэжээ.

Гэндэн: - Тодорхой албан тушаалд, тухайлбал, Улсын Бага Хурлын дарга, Ерөнхий сайд, сайдуудын талаар асууж болох уу? гээд Яамд болоод түүний сайд нарт тохоох хүмүүсийг нэрлэжээ.

Сталин түүний хариуд: - Эрүүлийг хамгаалах ба Гэгээрлийн яамыг нэгтгэх буруу, Шүүх яамыг устгаж болохгүй,... Шүүх яам ба Улсыг аюулаас хамгаалах газар бол та нарын феодал болон лам нартай хийх тэмцэлд онцгой ач холбогдолтой байгууллага гэж зөвлөжээ.

Гэндэн: - Өөрийн орлогч Дэмидэд Цэргийн яамны сайдын албыг тохоож, оронд нь Чойбалсанг томилуулах санал тавихад энэ саналыг хэрхэн үзэж байгааг Чойбалсангаас Сталин асуухад Чойбалсан:-Би бол мал аж ахуйн асуудлыг илүү сонирхдог гэж хариулсан нь энэ уулзалт дээр Чойбалсангийн ам нээсэн ерөөс хоёр дахь тохиол байв.

Сталин, Молотов: - Сайд нарын Зөвлөлийн орлогчийн албан тушаалд байхдаа та мал аж ахуйн ажлаас хөндийрөхгүй. Шинэ үүргээрээ та мал аж ахуйг урьдын адил удирдах болно хэмээн тайван таашаалтай өгүүлсэн нь Зөвлөлтийн удирдлага Чойбалсанд талтай болсныг илтгэнэ. (Х.Ш)

Гэндэн ярианыхаа сүүлчийн сэдэв болгож: - БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай асуудлаар танаас тайлбар сонсохыг хүссэн юм? гэжээ.

Сталин: - Хятадын талаас танай тусгаар тогтнолыг зөвшөөрснөөр л танай тусгаар тогтнолыг бусад орон хүлээн зөвшөөрөх болно. Гагцхүү та нар улсаа хүчирхэг болго гэсэн утгатай хариу өгч байжээ.[4]

1934-11-24-нд И.Сталин, М.Молотов, К.Ворошилов нар П.Гэндэнтэй ярилцжээ.

[4] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.70-82

Сталин: - Япон монголын хилд улам ойртсоор байна...Тэд Өвөр Монголыг эзлээд сэтгэл ханахгүй, Ар Монголыг эзлэхийг оролдох болно,тусгаар тогтнолоо хамгаалах ямар бодолтой байна даа? гэж Гэндэнгээс асуугаад:- Бидэнд \ЗХУ-д\ хоёр л байр суурь байж болно, нэг нь төвийг сахиж, Монгол Япон хоёр дайтвал дайтаг бидэнд хамаагүй гэх. Нөгөө нь, Монгол манай холбоотон тул түүнийг битгий хөнд гэх...Танайх ч гэсэн төвийг сахих, эсвэл ЗХУ бидний холбоотон гэх. ... төвийг сахиж Японы талд байх эсэх нь танай асуудал...Бидэнтэй хамт байж, тусламж хүсье гэж байгаа бол бололгүй яах вэ, олон улсын харилцаанд харилцан туслалцах пакт гэж байдаг хэмээн тайлбарлаад "Одоо л байгуулахгүй бол хожимдоно" гэж шахжээ[5].

Гэндэн: -Япон Манжуурт одоогоор бэхжиж чадаагүй,тэнд партизаны хөдөлгөөн хүчтэй байна, гэхдээ энэ бол Япон манайд довтлохгүй гэсэн хэрэг биш хэмээн булзаж, Зөвлөлтийн цэргийг оруулах шаардлагагүй гэсэн санаагаа илэрхийлжээ[6].

Энэ бол нэг талаар Гэндэн Японы талд байна гэсэн үг л дээ. Өөрөөр хэлбэл, Японы ивээл дор нэгдсэн Монгол улсаа байгуулах горьдлого нь түүнийг ийнхүү "гүрийлгээд" байсан аж. Гэвч Гэндэн ярианы өнгө агуулгаараа Богд хаант Монгол Улс, 1921 он шиг ЗХУ-ын тусламжид итгэлтэй байгаагаа илэрхийлж байв. Сталин, Ворошилов хоёр "тэр цаг өнгөрсөн", энэ бол аж ахуйн асуудал бус, улс төрийн асуудал хэмээн Гэндэнгээс зөвхөн техникийн тусламж гуйх бус улс төрийн шалтгаан буюу Гэрээ байгуулахыг өөрөөр нь хүсэж хэлүүлэх гэж тойруу үгээр шахсаар, "тусламжийг", "ямар үндсэн дээр" хэмээн нэхэж суусны эцэст "Албан ёсны гэрээ байгуулах хэрэгтэй" гэдэг дээр тогтсон байна[7]. Гэндэний дотоод бодол бол ийм гэрээ байгуулах нь Монгол улс ЗХУ-аас өөр нөхөр тулгуургүй болох тул амаа татан зайлсхийсээр байсан аж.

1934-11-24-ний оройн зоог:

Сталин:-Тусгаар тогтносон Монголын төлөө тогтооё... Япон Цахарыг эзлээд Гадаад Монголыг эзлэх санаатай байна гэсэн цуу яриа явгдаж байна.... Өөрийн тусгаар тогтнолыг хамгаалах хэрэгтэй болж байна гэж байв![8]

Дараа нь Гэндэн хундага өргөж:-Зөвлөлтөд төлөх Монголын өрийг устгасан Молотов, Ворошилов...түүнийг санаачлагч, шинэ эргэлтийн бодлогыг үндэслэгч Элиава нарын эрүүл мэндийн төлөө тогтооё гэжээ. Гэтэл Сталин инээмсэглэх аятай хэлсэн нь:-Чингис хааны цэргийн жанжин Зэв Гүрж нутгаар өнгөрөхдөө гүрж айлын гэрт буугаад мордсоноос хойш үлдсэн нь Элиава ба Элиавдун (омог-Х.Ш) болжээ. Гэндэн Чингис хаан болохыг хүсч байна. Тэр Чингисийн гөлөг хэмээв. Тэрээр цааш нь, лам нар ба феодлуудыг устгана гэж Гэндэн хэлэв. Лам нар бол Чингис хааны Эзэнт гүрэн задран унасны дараа үүссэн бөгөөд тэдний үүссэн явдал бол

[5] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.83-89, Р.Болд. Зарлаагүй дайн. УБ., 2014. т.67
[6] Р.Болд. Зарлаагүй дайн. УБ., 2014. т.68
[7] Р.Болд. Зарлаагүй дайн. УБ., 2014. т.68
[8] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.83

Чингисийн эзэнт улс унахын анхны шинж байсан юм гэжээ[9].

Хундага өргөхөд Сталины нэр дурдагдсангүйд тэр уурлаж байна. Сталиныг тоодоггүй, лам нар болоод феодалуудын асуудалд хойрго ханддаг, Монголд Оросын цэрэг оруулахыг хүсдэггүй Гэндэн гэгч этгээд энэ цагаас түүний хорхой идсэн арааг хөндүүрлүүлсэн аж. (Х.Ш)

Сталин ярианы сэдэв буруудаж байгааг мэдрээд, сэдвийг өөрчилж, монгол дуу хөгжмийн талаар асууж ярилцаад, дахиад л улс төрийн бодлогодоо тайвнаар шилжиж, Монгол хэдэн цэрэгтэй, хэдэн байлдааны онгоцтойг асуухад: Гэндэн, Шеко, Дашчирав нар 10-11 мянган цэрэг,10-33 орчим онгоцтой болохыг хэлэхэд, Сталин:-Цөөхөн байна. Японучууд нэг морин дивизийг мото-механикжсан хэсэг, нисэх онгоцоор дэмжүүлэн илгээхэд хангалттай"[10] хэмээн өгүүлжээ.

ЗХУ-ын дээрх гурван эрхэм **11-р сарын 27-нд** П.Гэндэн, Х.Чойбалсан нартай яриа хэлэлцээгээ үргэлжлүүлэхдээ, Зөвлөлтийн цэргийг Монголд оруулах хүсэлтийг Монголын талаас тавиулах гэж Сталин цөхрөхдөө арга зам зааж, тайлбарлан таниулах замд оржээ. Сталин: - Бид та бүхэнтэй үл довтлолцох болон харилцан туслалцах гэсэн хоёр гэрээ байгуулах бодолтой байна.... Үл довтлолцох пакт байгуулснаар танай улсыг бүрэн бие даасан гэдгийг бусад дэлхий дахинд харуулах ач холбогдолтой юм... Үл довтлолцох гэрээг илээр нийтлэх, харин харилцан туслалцах гэрээг нийтлэхгүй гэдгээ хэлжээ[11]10 \Р.Болд..т.68\.

Харилцан туслалцах гэрээ олон улсын анхаарлыг татах, ялангуяа хятадын эсэргүүцэлтэй тулгарах тул нууцлах шаардлагатай байжээ. Энэ яриа хэлэлцээрийн үндсэн дээр 1936 онд БНМАУ-ЗХУ-ын хооронд харилцан туслалцах протокол Гэрээ байгуулагджээ. Харин "үл довтлолцох" гэрээ байгуулагдалгүй өнгөрсөн байна.\Х.Ш\

ТАВ. Энд **1933,1934 онд Чойбалсан Москвад юу хийж байв?** гэдгийг тодотгоё.

МАХН-ын ТХ-ны тэргүүлэгчид 1933 оны 3-р сард Чойбалсан, ТХ-ны нарийн бичгийн дарга Д.Лувсаншарав нарыг ЗХУ-д 3 сар эмчлүүлэх шийдвэр гаргажээ. Хэрэг дээрээ тэд 9-р сар хүртэл 6 сар ЗХУ-д байжээ.

1922 онд Москва явсан нь Чойбалсанг "Бодоогийн хэрэг"-ээс,1933 онд ийнхүү Москвад байсан нь "Лхүмбийн хэрэг"-ээс аварч байжээ[12].

1934 оны 4-р сард ТХ-ны зөвшөөрлөөр эмчилгээ гүйцээхээр Чойбалсан яваад 12-р сар хүртэл ЗХУ-д байв.

БНМАУ байгуулагдсаны 10 жилийн ойгоор (Улсын наадмаар), мөн МАХН-ын IX их хурал хуралдаж байхад (1934-9-28-аас10-р сарын 5) Чойбалсан Москвад байв. Ойд зориулсан 2 ном гаргахаар төлөвлөсөн байлаа. Энэ ёсоор А. Амар "Монголын түүх"-ээ, Х. Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нар " Монголын үндэсний ардын хувьсгалын түүх"-ээ биччихсэн

[9] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.83
[10] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.84-85
[11] Р.Болд. Зарлаагүй дайн. УБ., 2014. т.68
[12] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.87-88

байв. Тэгэхээр Чойбалсан 1933 онд түүхээ бичиж явж, 1934 онд Москва явахдаа бичсэн хэсгээ хүлээлгэж өгөөд явсан байж таарч байна.

Москвад "... олон уулзалт яриандоролцож, "сургалт" маягийн юманд хамрагдаж,"тусгай ажил, албаны" зах зухтай ч танилцаж амжив"[13] гэж судлаач мэдээлж байна.

Тэгэхээр, 1934 он гарахад "Кремль намын ролийг доогуур үнэлдэг, ганцаарчлан захиргаадах хандлага гаргадаг, ЗСБНХУ болон Коминтерны талаар болгоомжтой, прагматик байдлаар ханддаг зэрэг багагүй "нүгэлтэй" П.Гэндэнг алгуурхнаар "шахах", Х.Чойбалсанг "идэвхжүүлэх" тодорхой сонголт хийчихсэн байсан бололтой"[14]. Өөрөөр хэлбэл, Москвад түүнд эмчилгээ-боловсруулалтыг хослон хийж байсан нь тодорхой. Зөвлөлт тэр үед Монголын статус-квог дэмжих, хөрөнгөтний бус замд шилжин ороход нь зүйл бүрийн дэмжлэг үзүүлэх ...ингэснээр Алс Дорнодод өөртэйгээ ижил зорилго, үзэл санаа бүхий холбоотонтой болох бодлогоо тууштай барьж байв. "Ийм чиг бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөлтийн бодлогын голдиролд бүрэн орсон хатуу удирдлага Монголд байх хэрэгтэй, энэ нь үндэснийх нь тусгаар тогтнолд ч хэрэгтэй"[15] гэсэн үзэл санаагаа хэрэгжүүлэх хүн нь Чойбалсан гэж сонгон боловсруулж байсан гэж үзэж болох болов уу.

Өгүүлэн буй 1934 оны уулзалтаар Гэндэн бол лам нарын эсрэг хүчилсэн алхам хийхийн эсрэг, Улсыг аюулаас хамгаалах газар болон залхаан цээрлүүлэх байгууллагуудын эрх үүргийг өргөтгөж Дотоод явдлын яам болгохын эсрэг байгаагаа хэлж бас "баяжигтүн" гэсэн "Баруун" буюу хөрөнгөтөн (Японы дагах ч юм уу) орны лоозон Монголд хэрэгтэй гэдгийг батлаад байгаад Сталин бухимдаж байтал Ерөнхий сайдын нэгдүгээр орлогчид "Зүүний" буюу ЗХУ-ыг түшиглэх үзэлтэй Чойбалсанг санал болгоход л Сталин тайвширч байв. Энэ бол аль эртнээс Ворошилов, бусад албаны хүнээр уламжлан Сталин Чойбалсантай эчнээ танилцсан байсныг илтгэнэ.

1933,1934 онд ЗХУ-д Чойбалсанг эмчилсэн нь эмчилгээ гэхээсээ илүү "боловсруулалт" байсан гэж үзэж болох байна. (Х.Ш)

1934-12-27. Улсын XIX бага хурлаас Чойбалсанг Ерөнхий сайдын нэгдүгээр орлогчоор сонгож Дэмидийг II орлогч болгож, 1935 оны 4-р сард Сталинаас Чойбалсанд 21 хөнгөн тэрэг бэлэглэснийг Чойбалсан солгой зөвгүй тараав гэдэг. Сталин барьцаа бататгаж буй нь энэ юм.

ЗУРГАА: 1936-1-9-нд П.Гэндэн, Г.Дэмид, Д.Намсрай, И.В.Сталин, В.М.Молотов, К.Е.Ворошилов нар уулзаж, Батлан хамгаалах ба лам нарын асуудал ярьжээ.

П.Гэндэн, Г.Дэмид хоёр тайван цагт зэвсэг техникийн, дайны цагт бол цэргийн тусламж хэрэгтэй болно гэж Сталинд хэлжээ. Энэ нь Зөвлөлтийн цэргийг Монголд оруулахын эсрэг үг. Сталин төсвийнхөө тал

[13] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.92
[14] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.94-95
[15] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.95

хувийг батлан хамгаалахад зарах хэрэгтэй гэж шахав. Түүнчлэн танай дивизүүдийн ард ЗХУ-ын 2 бригад байрлуулна гэж эрс хэлэв. П.Гэндэн, санваартан нарт хатуу арга хэмжээ авахын эсрэг Сталинтай маргалдаж санал нийлэхгүй буйгаа нууж чадсангүй.

1936-2-21. Улсын Бага хурлаас Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч Х.Чойбалсан, ЦЯЯ-ны сайд, Ерөнхий командлагч Г.Дэмид хоёрт маршал цол олгов.

1936-2-27. Улсын дотоодыг хамгаалах газрыг ДЯЯ болгон өөрчилж, түүний сайдаар (Бага хурлын тогтоолд дурдсанаар, Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч,манай үндэсний хувьсгалын гавьяат удирдагч, Улсын маршал) Х.Чойбалсан томилогдов. (Эрхэлж байсан албан тушаалуудыг хавсарган-Х.Ш)

1936-3-10-аас 20-нд МАХН-ын ТХ-ны бүгд хурал болов. Хурал нь Гэрээ байгуулахаар Москва явж ирсэн П.Гэндэн, Г.Дэмид, Д.Намсрай нарын илтгэлийг хэлэлцэв. Тэд Сталинтай уулзахад Гэндэн нь зэвсэг, цэргийн мэргэжилтнийг л нэмэгдүүлэхийг хүсч, Дэмид нь зөвлөлтийн цэргийг Монголд оруулахыг түдгэлзсэн аж. П.Гэндэн лам нарын асуудлаар Сталинтай маргалдан зөржээ.

1936-3-12. ЗСБНХУ, БНМАУ-ын хооронд харилцан туслалцах Гэрээнд гарын үсэг зурав. Үүнд Гэндэн арга буюу оролцсон нь түүний сүүлчийн ажил байв.

Үүний дараагаар МАХН-ын ТХ-ны бүгд хурал болж, Х.Чойбалсан П.Гэндэнг хурц шүүмжлэв: "Сүүлийн үед маш олон алдаа гаргасан, шинэ эргэлтийн бодлогыг гуйвуулсан,"баяжигтүн" лоозон дэвшүүлсэн, лам нарын асуудал дээр туйлбаргүй байсан, батлан хамгаалах хүчийг сулруулсан, ЗХУ-ын асуудлаар цөвтэй санааг дурсаж байсан"[16] хэмээн донгодсоны цаана Сталины төрх, дуу хоолой сонсогдож байгаа биз? (Х.Ш)

1936-3-22. П.Гэндэнг Улсын бага хурлын 20-р чуулганаар Ерөнхий сайд, ГЯЯ-ны сайдын үүрэгт ажлаас чөлөөлж, улмаар ЗХУ-д "эмчилгээнд" илгээв.

1936-3-22. Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайдаар А.Амар сонгогдов. Чойбалсан ДЯЯ-ны сайд, Ерөнхий сайдын 1-р орлогч хэвээр үлдэв. Д.Догсом Улсын бага хурлын тэргүүлэгчдийн дарга болов. Г.Дэмид-Ерөнхий сайдын II орлогч, ЦЯЯ-ны сайд, Ерөнхий командлагч болов.

ЗСБНХУ-ын Дотоод хэргийн ардын комиссаратаас Чойбалсанг "Чекистын хүндэт тэмдэг"-ээр шагнав. ДЯЯ-ны сайдын сандалд очиж тухалж амжаагүй байхад нь?!

1937 оны 5-р сар. Дотоод явдлын ардын комиссариат Ежовт Чойбалсан мэдээлэхдээ: - Зөвлөх Чопяк, бүрэн эрхт төлөөлөгч Таиров нарын хамтаар лам нарын улс төр, эдийн засгийн ролийг хязгаарлах арга хэмжээг Төв Хороо, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж чадав...

[16] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.103

Сталины зөвлөгөөг биелүүлж байна[17] гэжээ!

1937-8-22. ЗХУ-руу урилгаар явж байсан жанжин Г.Дэмид замдаа төмөр замын Тайга өртөөн дээр гэнэт зуурдаар нас нөгчив.

1937-9-2. Чойбалсан Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч, ДЯЯ-ны сайдын тушаал дээрээ ЦЯЯ-ны сайд, Ерөнхий командлагчийн тушаалыг хавсран хаших болов.

1937-9-19. Монголын лам нарын хэргийг шалгах тусгай "гурав"-ыг байгуулах тухай БХК\б\Н-ын ТХ-ны УТТ-ны хуралдаан болов. Хуралдааны нэг шийдвэр:

Монголын лам нарын хэргийг авч хэлэлцэхийн тулд Шүүх яамны сайд, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга, Чойбалсангийн (Түүний нэрийг онцлон цохжээ! - Х.Ш) бүрэлдүүнтэй тусгай гурвал зохион байгуулах тухай н.Фриновскийн саналыг хүлээн авсугай.

Хуулбарыг н.Ежовт ТХ-ны нарийн бичгийн дарга И.Сталин[18]

1937-10-2. Энэ захирамжийн ёсоор ДЯЯ-ны сайд Чойбалсангаар ахлуулан, МАХН-ын ТХ-ны дарга Д.Лувсаншарав, Дээд шүүхийн дарга Г.Цэрэндоржийн бүрэлдүүнтэй **"гурвал" - Бүрэн эрхт Онцгой комисс** гэгчийг байгуулснаар Чойбалсан ухрах, хоргодох газаргүй болсон байна.

1937 оны 10-р сарын сүүл. МАХН-ын ТХ-ны III бүгд хуралд Х.Чойбалсан "Тагнуулын ба хувьсгалын эсэргүү байгууллагыг илрүүлсэн улс төрийн сургамж ба дотоод, гадаадын дайснуудтай тэмцэх манай зорилтууд" гэсэн илтгэл тавьсан нь их баривчилгааны хөтөлбөрийн зиндаанд хэрэгжжээ.Түүнд ДЯЯ-ны ажлыг сайшаав. Тэр хурал дээр "Дайснууд эргэн тойрон байна, тэд Төв Хороо, Засгийн газар хүртэлх бүх төв байгууллагуудад шургалсан байна. Гэндэн, Дэмидийн бүлэглэлүүдтэй холбогдсон "энэ зэвүүцмээр амьтдыг дуустал цохих хэрэгтэй, урвагч шарвагч нарыг үндсээр нь устгах хэрэгтэй"[19] хэмээн "шатжээ".

Тэрбээр 1938 оноос Зөвлөлтөд хилсдүүлэг саарч байгааг мэдэрч 1937-9-10-наас эхэлсэн их баривчилгааг 1932 оных шиг хавтгайруулах вий хэмээн сэтгэл зовж, дургүйцэж байснаас сэтгэлийн хямралд орж архи ихээр ууж, хоёр ч удаа архины цагаан солио туссаны улмаас Зөвлөлтөд 5 сар гаруй эмчлүүлэн Онцгой комисс 1937 оны 10-р сараас 1939 оны 3-р сар хүртэлх 1 жил 6 сар ажилласны эхний нэг жил орчмын ажиллагаанд нь биечлэн оролцсон ажээ.

ЗУРГАА. 1938 оны 8-р сар. Чойбалсан ЗХУ-д амрах, архины цагаан солио өвчнөө эмчлүүлэхээр явжээ. Түүнийг дотоодын дайсанд алагдахаас сэргийлсэн, бас "боловсруулах" хэрэг байх учир бас өөрийн газар тойлж юм хэлбэл илүү дуулгавартай байх нь мэдээж, бүх хэргийг Амараар хийлгэж, дараа нь түүнийг хусахад ч бэлтгэх, нэр цэвэр Чойгоор дараагийн даалгаврыг тохоох бодлого ч юм бил үү? Чойбалсан Оросод 1939 оны 1-р сарын дунд хүртэл 5 сар орчим байсан. байна.

[17] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.112-113
[18] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.157
[19] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.115-116

1938-9-8. ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссариатын газрын хэлтсийн орлогч дарга Мироновоос БНМАУ-ын маршал Х.Чойбалсангийн ЗХУ-д ирсэн зорилгын тухай мэдээллийг Сталинд хүргэв:

МАХН-ын ТХ, СнЗ-өөс өгсөн даалгавар болон өөрийн хувийн хүсэлтээр н.Чойбалсангаас н.Сталин, Молотов, Каганович, Ворошилов, Ежов, Фриновский нарт БНМАУ дахь улс төрийн байдал, Япончуудын хуйвалдаан, дээд зиндааны лам нартай хийсэн тэмцлийн дүнгийн тухай мэдээлэхээр ЗСБНХУ-д ирсэн зорилгоо удирдлагын анхааралд хүргэхийг хүслээ. Үүний зэрэгцээ хэд хэдэн объект барихад тусламж үзүүлэх талаар Зөвлөлт Засгийн газарт өргөн мэдүүлэхийг түүнд даалгасан ажээ.Тэрээр дараах хүсэлтийг илэрхийлэв.Үүнд:

1. н.Сталин, Молотов, Каганович, Ворошилов, Ежов, Литвинов, Фриновский нартай уулзах, гэхдээ Сталин, Молотов нар түүнийг сувилалд эмчилгээнд явахаас өмнө хүлээн авч чадахгүй бол амралтаас буцаж ирсний дараа хүлээн авахаас татгалзахгүй байхыг хүсч байгаагаа мэдэгдэв. Каганович, Ворошилов, Ежов, Фриновский нартай амралтанд явахаасаа өмнө анхны уулзалт хийх хүсэлтэй байгаагаа илэрхийллээ.

2. Уушиг-Улаанбаатарын төмөр замыг барьж байгуулах, Тоосгоны болон Автозасварын завод барих тухай ЗСБНХУ-ын Засгийн газарт өргөн мэдүүлэх даалгавар авсан ажээ. Эдгээр барилгыг ЗСБНХУ-ын хүчээр удаан хугацааны зээлийн журмаар барих хүсэлтэй байгаа ажээ.

3. Үүний хамт хүн эмнэлгийн өргөн тусламж үзүүлэхийг ЗХУ-ын Засгийн газарт хандахыг түүнд даалгасан байна.

4. Чойбалсан өөрт нь болон түүний гэр бүлд эмнэлгийн тусламж үзүүлэх, эмчилгээний комиссын шийдвэрийг харгалзан зохих эмнэлгийн байгууллага болон сувилалын газарт байлган эмчлүүлэхийг хүсч байгаа ажээ[20].

1938-11-23. БХК\б\Н-ын ТХ-ны УТТ-ны шийдвэрээр Чойбалсанг эмчилгээнд байхад нь Сталин "АТУА-ийн ХХ жил" ойн медалиар шагнав[21].

Дээрх даалгавар, төлөвлөгөө ёсоор Х.Чойбалсан (их баривчилгааны дараа!) Сочид сар орчим амрав. Сочигоос өмнө болон дараа нь Москвад уулзалт, яриа, хэлэлцээ, зөвлөлдөөн хийв. Хэлэлцээн дээрх яриа нь хамтын ажиллагааны, улс төр, худалдаа-эдийн засаг, соёлын гээд бүх талыг хамарч байв. Сталинтай уулзаж ярив, бүрэн харилцан ойлголцов, удирдагч нар хоёр биендээ талархалтай байгаа нь илт байв. Дотоод явдлын ардын комиссариатын шинэ дарга Л.П.Бериятай яриа, хэлэлцээ, зөвлөлгөөн хийж, байр сууриа зохицуулав, харилцан зөвшилцөөнд хүрэв[22]. Энэ үеэс "цэвэрлэгээ" ЗХУ-д ч, Монголд ч арай эрч нь сулрах хандлагатай болж байв. Москвад болсон яриа хэлэлцээний хамгийн сонирхолтой нь Монголын удирдлагад өөрчлөлт оруулах тухай яриа

[20] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.162-163
[21] Сталин ба Монгол орон. УБ., 2011. т.163
[22] С.К.Рощин. Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008. т.117-118

тохироо байв.

Тиймээс Москвагаас хатуу дэмжлэг түшиг авсан Чойбалсанд дотоод бодлогын талаар зөрчилдөн буй Амарын өмөг түшиг одоо хэрэггүй болжээ.

. . . Үргэлжлэл нь дараагийн дугаарт . . .

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээл

1. С.К.Рощин.Монгол улсын маршал Х.Чойбалсан. УБ., 2008
2. Илтгэл ба өгүүлэлүүд. 1-4 боть (1921-1951). УБ., 1951, 1953
3. Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. УБ., 1979
4. Л.Бат-Очир. Чойбалсан. УБ., 1996
5. П.Шагдарсүрэн. Миний мэдэх маршал Х.Чойбалсан. УБ., 2000
6. Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1999
7. Д.Гомбосүрэн. Монгол улсын өрлөг жанжин-маршал Хорлоогийн Чойбалсан. УБ., 2003
8. Сталин ба Монгол орон. (Архивын баримтын эмхэтгэл.) Эмхэтгэгчид: Ч.Дашдаваа, Д.Өлзийбаатар, С.Чулуун. УБ., 2011
9. Маршалын захидлууд (1922-1952 он). Эмхэтгэсэн. Н.Батболд. УБ., 2018
10. Р.Болд. Зарлаагүй дайн. УБ., 2014
11. Г.Ариунболд. "Нармай Монгол"-изм-("панмонголизм")-ын хэрэгт хэлмэгдсэн монголчууд (1937-1941). УБ., 2011

Их Засаг хууль дахь цэргийн харилцааны зохицуулалт

Т.Сүхбаатар
БХЭШХ-ийн Цэргийн түүх, сургамж судлалын төвийн дарга, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч, доктор (Ph.D), дэд профессор,

Abstract

Ikh Zasag is the oral law of the Mongols proclaimed by Genghis Khan. The Mongol Empire, however, did not disclose the "law" to the public. Ikh Zasag seems to have originated from wartime decrees, which later consolidated and expanded cultural and lifestyle conventions. By keeping the Yassa secret, the commandments can be modified and used selectively. Ikh Zasag is believed to have been ruled by Genghis Khan himself and his half-brother, Shihihutag, the Supreme Judge of the Mongol Empire at the time.

Keywords: *Legal, Mongol, military, state, nation, Ikh Zasag*

Хамаг Монголын хан Тэмүжин 1206 онд Их Монгол Улсаа байгуулахдаа улсын хэмжээнд мөрдөх хуулийг батлан гаргасан нь Их засаг хууль юм. Уг хууль бидний үед бүрэн эхээрээ уламжлагдан ирээгүй, зохиогч нь тодорхойгүй ч бичигдэл хууль байсан гэдэг нь түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ.

Уг хууль нь хэд хэдэн хэсгээс бүрддэг. Нэрт эрдэмтэн Ж.Вернадский «Их засаг»-ийн бүтцийг олон улсын хууль, төрийн хууль, эрүүгийн хууль, хувийн өмч буюу хувийн эрхийн хууль, худалдааны хууль, шүүн таслах ажиллагаа, хуулийг хянах, хэрэгжүүлэх гэсэн 7 хэсэгтэйгээр тогтоож, хэсэг тус бүрээ тодорхой зүйлд оруулахгүйгээр авч үзжээ. Чингэхдээ зарим хэсгийг нь жижиг жижиг бүлгүүдэд хуваан өгүүлсэн байна.

Өвөрмонголын өөртөө засах орны эрдэмтэн Сайшаал «Их засаг»-ийг «Ерөнхий хууль буюу Чингис хааны үндсэн хууль товчоон» хэмээн нэрлээд бүтцийг нь 4 хэсэгтэйгээр тогтоожээ. Хэсгүүдээ: хаан төрийн хууль, цэрэг дайны хууль, ард иргэдийн хууль, тусгай хууль хэмээн нэрлэсэн байна. Үүнээс тусгай хуулиа дотор нь олон улсын харилцааны хууль, аж ахуйн хууль, арилжаа худалдааны хууль, зам нэвтрэх ба өртөөний хууль, шашин суртлын хууль, ургийн хууль, эрүүгийн хууль гэсэн долоон бүлэгт ангилжээ. Зохиогч хэсэг, бүлгүүдийг зурвасаас (зүйл) бүрдэхээр тогтоожээ. Сайшаалын томьёолон тогтоосон хуулийн бүтцийг авч үзэхэд «Их засаг»-ийн бүтцийн тухай нэгэн өвөрмөц төсөөлөл сэтгэлд

бүрэлдэж ирдгийг тэмдэглэлтэй.

Их засаг хуульд цэргийн үйл ажиллагааны тухай заалтууд томоохон байр суурь эзэлнэ. Цэргийн зохион байгуулалтаас гадна цэргийн сахилга, цэргийн сургууль, аян байлдаан явуулах журам, байлдаанд оролцох горим, цэрэг хүний эрх, үүрэг, захирах, захирагдах ёс, цэргийн дарга нарын эрх, үүрэг, цэргийн хангамж үйлчилгээний тухай заасан хуулийн заалтууд нэлээд өргөн томьёологджээ.

Энэ нь цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай журмыг хуулиар тогтоон мөрдүүлэх шаардлага хаант улсын төрийн бодлого, цэргийн аян дайны явц сургамжаас үүдэн хурцаар тавигдсантай холбоотой юм. Цэргийн үйл ажиллагааны тухай цаазыг хааны хишигтэн цэргийн ба их цэргийн үйл ажиллагааны тухай цааз хэмээн хоёр хэсэгт хувааж болно.

Эл цаазад Хишигтний зохион байгуулалт, тэдний албан үүргээ гүйцэтгэх дэг жаяг, ан хоморго болон дайн байлдааны үед чандлах сахилга журам, ер нь их зонхи цэргийн дүрмийн шинжтэй заалтууд тусгагджээ. Үүнд:

- Цэргийн зохион байгуулалтаас гадна цэргийн сахилга,
- Цэргийн сургууль,
- Аян байлдаан явуулах журам,
- Байлдаанд оролцох горим,
- Цэрэг хүний эрх, үүрэг, захирах, захирагдах ёс,
- Цэргийн дарга нарын эрх, үүрэг,
- Цэргийн хангамж үйлчилгээний тухай заасан хуулийн заалтууд нэлээд өргөн томьёологджээ.

Судалгаанаас үзэхэд Хишигтэн цэргийн үйл ажиллагааны тухай цааз нийт цэргийн цаазын дотор тодорхойлогч үүрэгтэй байсан нь харагдаж байна. Тийм учраас Хишигтэн цэргийн тухай цааз нэлээд дэлгэрэнгүй байдлаараа «Монголын нууц товчоо»-нд тэмдэглэгдэн үлджээ.

Цэргийн цаазын дотор цэргийг захирах, цэргийн аян дайнд явах журам, цэрэг ба цэргийн захиргаадын хоорондын харьцааны тухай заалтууд өвөрмөц байр эзэлнэ.

Аравт, зуут, мянгат, түмтийн ноёд бүхэн өөрсдийн цэргийг эмх журамтай, ямагт бэлтгэлтэй байлгах үүрэгтэй. Дээдсийн зарлиг буумагц өдөр, шөнө ялгалгүйгээр даруй цэргээ авч болзсон цаг, газарт бэлэн байна. Цэргийн ноёд аян замд нарийн тооцоотой явах ба цэргүүдийг өлсгөж, цангаахгүй, адуу малыг нь тураалгүйгээр цэргээ захиран удирдана. Цэргийн ба заншлын хэм хэмжээний агуулгаас үзэхэд цэргийн сахилга, ур чадварын үндэс нь бүр өрх бүлд буй хүүхэд ахуй цагаас эхэлж байсан нь илт байна.

Багачууд хүүхдийг 5-6 настайгаас нь морь унаж, нум сум хийм харваж, хулгана зурам намнаж чаддаг, тэсвэр тэвчээртэй, зориг хатуужилтай болгон бэлтгэх үүргийг өрх гэр, эцэг эх бүхэн хүлээж, аравтын ноёд зохицуулан хянана. Шилдэг сайныг нь тогтоон сайшааж,

хянамгай бус байдал гаргах, зөрчил үйлдэх аваас буруушаан алдаа гаргавал зэмлэн шийтгэж байх журмыг хуулиар тогтоожээ. Авын журмын тухай нэлээд тодорхой мэдээг Жувейни, Мирхаунд, Ж.Вернадский нар бүтээлүүддээ тэмдэглэсэн байдаг. Эдгээрээс Жувейнийн тэмдэглэсэн мэдээ анхдагч ач холбогдолтой болой. Ж.Вернадскийн бичсэнээр «Чингис хаан ан авлагыг цэргийн хамгийн шилдэг сургууль гэж үзэж байлаа».

Цэргүүд цэргийн сахилгыг чанд сахих үүрэгтэй. Цэргийн ноёдын тушаалын цэрэг бүхэн үг дуугүй биелүүлнэ. Цэрэг нь нэг газраас нөгөөд зөвшөөрөлгүй нүүж үл болно. Аян байлдаан, ан авлагын талбараас цэрэг хүн дур мэдэн явж болохгүй. Аравтаас цэрэг нь оргосон байвал арваны даргыг шийтгэнэ хэмээн Чингисийн хаант улсын хуульд хатуугаар заасан байна.

Байлдааны үйл ажиллагааны журмын тухай заалтууд цэргийн цаазын агуулгын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно. Цэрэг хүн байлдааны явцад эр зориг, хатуужил тэсвэртэй байж, чадварлаг, овсгоотойгоор тулалдан тэмцэлдэх үүрэгтэй. Байлдааны талбар дээр шархдагсдаа орхиж болохгүй. Байлдан явагсад цэргийн тугийг буухаас өмнө байлдааны талбараас явж үл болно. Хэрэв дайлагдан ухарвал эхний довтолсон байрандаа буцаж ирэх үүрэгтэй. Дайсны цэргийг гүйцэд ялахаас өмнө олз ашиг хайж болохгүй. Байлдааны явцад нум сум, ачаа боодол, уналга, хөсгөө унагавал дагалдан явагсад нь мориноосоо бууж уг зүйлийг авч өгөх үүрэгтэй. Байлдааны талбар дээр цэргийн уналга, эд юмс, олз ашгийг хулгайлж болохгүй. Дайн дууссан хойно олз хуваавал зохино. Дур мэдэн олзны юмсыг шатаах, олзлогсдыг дэврээн зүй бусаар харьцах, тонон дээрэмдэх, алах, хүчирхийлэх явдал гаргаж болохгүй гэх зэргээр хуульчлан заасан байна.

Цэргийн үйл ажиллагааны тухай цааз нь цэргийн сахилгыг нарийн чанд болгон, үүрэг хариуцлагыг нарийн чандлан тэгшилж, цэрэг эрсийн эр зориг, тэсвэр хатуужлыг тогтоон төлөвшүүлэхэд чиглэгдсэн байна. Цэргийн үйл ажиллагааны тухай цааз нь цэрэг, цэргийн захиргааны хууль цаазын үндэс болж, цэрэг армиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймээс «Чингис хааны эзэнт улсын үүсэн тогтсон гэсэн нөхцөл нь түүний хууль цаазад цэрэг, цэргийн захиргаа маш чухал үүрэг гүйцэтгэж байсан явдал болно. Цэргийн засаглал нь засаг захиргааны гол ноён нуруу нь болжээ.

"Цэргийн аянд мордоогүй иргэд эрх биш жилийн тогтоосон улиралд олон өдрийн албаны барилгын ажил эсхүл улсдаа бага сага мод шорооны ажил хийхийн хамт долоо хоногт нэг өдөр хатандаа алба хаатугай. Хаандаа алба хаахад хүн бүрийн ажил нь адил тэгш байж, эд хөрөнгө буюу чухал байр суурийн хувьд зөрөө ялгал байх ёсгүй. Цэргүүд аян дайнаас буцаж ирсний дараа хаандаа элдэв зүйлийн аж хөдөлмөрийн алба хаах ёстой бөгөөд тэд нар эрх биш эдгээр албыг заавал биелүүлэх хэрэгтэй"[1] гэх зэргээр хуульчилж өгчээ.

[1] "Богд Чингис хааны их засаг" УБ. 1992 он тал 15

“Монголчууд жилийн эхэнд өвөрийн охидоо хаанд хүргэж, хатан ба хаад нарт сонгуулж автугай. Хэзээ хаа болсон ч атугай, хатан зарлиг болсон л байвал тэд нарыг дайн байлдаанд мордуулах буюу эсхүл тэд нарыг амь өрссөн хэрэг алин ч болтугай, тэд нар өчүүхэн ч зөрчихгүй дагаж гүйцэтгэгтүн. Дайн байлдаанд хөгшид хүүхэд, эрхэм доорд гэж ялгахгүй цөм шадар цэрэг, хорчин, жадчин болж, байдлын хэрэгцээгээр урагшлан тэмцэж дайсантай байлдагтун”[2] гэх зэргээр бүх нийтийн албаа хаах журмыг хуульчилсан байна.

“Хэзээ ч болов ч дайсныг эсэргүүцэх ба урвалтыг дарах цүрэг ирмэгц арван найман зэвсгээс туг далбаа, зүү хадаас, таталга дээс, морь унаа хийгээд илжиг тэмээ зэрэг ачааны амьтанд хүртэл зүйл бүрийн хэрэгсэл юмыг татварлан авч даалгасан хувийг нь хангаж өгтүгэй. Байцаан цэх өдөрт цэргийн бэлтгэлээ жагсаан цүцлэгтүн. Хэрвээ жаахан ч гэсэн дутуу байваас даргыг нь чангаар шийтгэтүгэй”[3] гэж байлдааны бэлтгэлийг хуульчлан зааж өгчээ. Дайн байлдаанд амжилт олох нэг үндэс нь цэргийн хангамж байдаг. Тиймээс үүнийг чухалчлан зааж өгчээ.

“Цэрэг морь засаг захиргааны тухай зарлигууд: Түмэн, мянган, зуутын ноёд жилийн эхэн, адаг хоёрт Хаанд бараалхаж түүнээс юу сургахыг сонсож харьяат цэргүүдээ захирагтун”, “дайн байлдаанд унаж байсан агт морьдыг ус бэлчээрт тавин таргалуулж уналгад хэрэглэхгүй байх, морины толгой, нүдийг занчиж цохиж цл болох, морьдыг хулгайлахыг хатуу цээрлэхийг”[4] хуулиар тогтоосон ажгуу.

Ан хоморго бол дайн байлдааны бэлтгэл, цэрэг эрийн эд хавыг илтгэх чухал шалгуур учраас *“Ан ав хийх цед хэрэв санаанаас гадуур нэгэн араатан хүрээнээс мултран гарваас гарсан шалтгааныг нарийн хянамгай байцааж, мянганы ноён, зууны ноён, болон аравны ноёныг жанчих, буюу зарим тохиолдолд алах ял шийтгэ”*[5] хэмээн заажээ. Энэ нь цэргийн бэлтгэл хэчнээн чухал болохыг илтгэн харуулжээ.

Мөн цэргийн албаа хаах үүрэг, байлдааны үед баримтлах дэг, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд оноох ял шийтгэлийг тодорхойлжээ. Үүнд:

- эр хүн 20 нас хүрвээс цөм цэргийн албаа хаах үүрэгтэй;
- жанжин захирагчаас эхлээд жирийн цэрэг хүртэл дайсангүй ч дайны бэлтгэл хийх;
- байлдааны талбарт шархдагсдаа хамаагүй орхиж хэрэв дийлэгдэн ухарвал, довтолгоо эхэлсэн байрандаа буцаж ирэх, эс ирвэл алах ялаар шийтгэх;
- дайны үед ганц нэгээр буюу хэд хэдээр оргож босвол алж шийтгэх;
- дайсныг гүйцэд ялахаас өмнө хэн нэг хүн олз ашиг хайхаар явсан байвал хүндээр ялдан залхаах гэх мэтээр заасан байна.

Гуулин улсын сударт буй мэдээнээс үзэхэд, *“цэргийг цэргийн эрдэмд сайтар сурган, бүгдийг гавшгай цэрэг болтол нь хатуужуулах, ... хүчин*

[2] “Богд Чингис хааны их засаг” УБ. 1992 он тал 15
[3] “Богд Чингис хааны их засаг” УБ. 1992 он тал 15
[4] “Богд Чингис хааны их засаг” УБ. 1992 он тал 15
[5] “Богд Чингис хааны их засаг” УБ. 1992 он тал 18

буюу яданги хүнийг ацаглан жинхэнэ цэргийн оронд хүний тоо бөглүүлж, цэргийн алба хашуулахыг хориглох, цэрэг хөдөлсөн цед цэргийн олсон хүн, мал, ... бусад бүх эд татвар нь тус тус тэрхүү цэргийнх болох бөгөөд цэргийг харьяалах дарга захиран хурааж авч болохгүй", "цэрэг эрсийн морийг дарга нь зээлдэх, солих, ажилд зүтгүүлэн эцээж, тураах цхүүлж болохгүй", "Иргэдийн хогшлоос өчүүхэн зүйлийг дээрэмдэхийг цаазлан цаазлан хориглоно"[6] (Б.Сумъяабаатарын орчуулгаар) хэмээн цэргүүдийг цэргийн эрдэмд сургах, цэргийн албыг ацаглаж, эр цэргийн чадварыг бууруулахыг хориглох, дарга, цэргийн хоорондын харилцааны зохистой хэм хэмжээ эзлэгдсэн орнуудын иргэдийг хамгаалах асуудлыг зохицуулсан байна.

Мөн..."*цэргүүдийг зоргоор дайчлан хүнд хүчир ажил, зөөх, тээх ажил хийлгэхийг хориглосон*"[7] нь цэргүүдийг зориулалтын бус зүйлд зарж, цэргийн хүч эрдмийг тарамдуулахгүй байх гэсэн цэргийн хууль эртнээс үйлчилж байсан гэж үзэж болох юм.

"Их засаг" хуульд цэргүүдийн эрүүл мэндийг хамгаалах, эмч оточийн ажлын үзүүлэлтийг харгалзан урамшуулал олгох хэм хэмжээг тогтоожээ. Жишээ нь: "*цэргийн дотор өвчилсөн цэрэг байх аваас, даруй сайн отчид үзүүлж, эм уулган анагааваас зохимуй. Шалган байцаах цеэс, өвчилж үхсэн цэргийн олон цөөнийг харгалзан, өвчин анагаах түшмэлийн шан хийгээд ялыг тогтоон*"[8] шийтгэхээр заажээ.

Чингисийн толгойлсон хаант төрд ямар үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж байсан нь анхаарал татах зүйл мөн хэмээн санагдана. Баримтуудыг түшихүйд хаан, түүний алтан ургийнхан болон түшмэд, иргэдийн амь бие, нэр төрийн эсрэг үйлдэл, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны журам зөрчсөн үйлдэл, цэргийн сахилга, байлдааны үед баримтлах дэг журмыг зөрчсөн үйлдэл, мал хөрөнгө, эд зүйлс хулгайлсан үйлдэл, хөрс бэлчээр, ус мэтийг сүйтгэсэн, бохирдуулсан, ашиггүй худалдаа арилжаа хийж удаа дараа алдагдал хохиролд оруулсан үйлдэл, зарим зан заншлын хэмийг эвдсэн, шашны ёс үйлийг зөрчсөн үйлдэл нь засаг, төр, нийгмийн байгуулал, иргэд болон олон түмэн, тэдгээрийн амьдрал, ахуй, зан заншилд хор хохирол учруулсан аваас гэмт хэрэг хэмээн үзэж түүнээ хуулиараа тогтоосон нь ажиглагдана.

Чингисийн хаант улсын гэмт хэргийн төрөлд цэргийн гэмт хэрэг орно. Энэ нь цэргийн зохион байгуулалт үйл ажиллагааны журмыг нарийн зохицуулж түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага нэлээд тодорхой байсантай холбоотой.

Цэргийн албанд татах журмыг зөрчих, цэргийн албанаас зайлсхийх, цэргийн удирдлагын шийдвэрийг үл биелүүлэх, цэргийн нууц задруулах,

---

[6] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ., 2011 он тал 87

[7] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ., 2011 он тал 88

[8] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ., 2011 он тал 88

байлдах журам зөрчих, урвах, байлдааны талбараас зугтах, цэргийн эд хөрөнгийг хулгайлах, устгах, олзны хөрөнгийг дур мэдэн авах, өгөх үйлдлүүд цэргийн гэмт хэрэгт багтаж байжээ.

Хишигтэн цэрэгт мянгат, зуут, аравтаас татах зарлиг журмыг зөрчвөл чангалан шийтгэх, цэрэгт орвол зохих хүн булталч зайлсхийвэл цөлөх, хишигтэй хүн ээлжээ анхны удаа тасалбал 3 бэрээ, хоёр дахь удаа тасалбал 7 бэрээ, гуравдахь удаа тасалбал 37 бэрээ[9] занчиж цөлөх ялд унагахыг заасан байдаг.

П.Карпини, В.Рубрук нарын бичсэн «Монголд жуулчилсан тэмдэглэл» номд бичсэнээр цэргийн захирагч аян дайнд мордохоос өмнө цэрэг, анги, зэр зэвсэг юугаа өөрийн биеэр шалган үзэх үүрэгтэй. Ингэж үзээгүй буюу дутуу үзсэнээс зөрчил гарвал захирагчийг яллах хуультай байжээ.

Чингисийн хаант улсын хууль цаазад цэрэг хүн байлдааны даалгаврыг үл биелүүлэх, байлдааны талбар дээр нөхдийнхөө унаа морийг хулгайлах, урван тэрслэх, байлдааны талбараас зугтсан, оргосон, байлдаж байгаад ухрахад эхний довтолсон байрандаа ирэхгүй байх, цэргийн олзлогдсон хүнд түүнийг барьсан хүнээс зөвшөөрөл авалгүйгээр хоол, хувцас өгөх аваас гэмт хэрэг үйлдсэн хэмээн цаазлах хүртэл ял оногдуулахаар заасан байна.

Зарим гэмт хэргийг хүндрүүлэн үзэж хатуу шийтгэл оногдуулах журам байсан ажгуу. Жишээлбээс: Байлдаан хийж байхад нэгэн аравтаас олон хүн оргож боссон бол тэдгээрийг бүгдийг нь цаазална. Бүх цэрэг ухраагүй байхад оргож зугтсан хүн гарвал цаазлах хуультай. Аравтын дотроос олон хүн дайсан руу баатарлагаар дайрч орсон байвал түүнээс үлдсэн бүх хүнийг ална. Аравтын цэргээс нэг буюу хэд хэдэн хүн олзлогдоход үлдсэн хүмүүс нь тэд нарыг олж очиж тусалж тэтгээгүй бол мөн бүгдийг нь цаазална.

Энэ бүхнээс үзэхэд эл бүлэг гэмт хэрэг нь цэргийн гэмт хэрэгт багтаж байжээ. Цэргийн гэмт хэрэгт хуульчлан бэхжүүлсэн заншлын шинжтэй заалтыг зөрчин үйлдсэн хэрэг орж байсан сонирхол татна. Тухайлбал, цэргийн ноёны босгон дээр гишгэсэн, байлдан дайрах буюу ухрах үед байлдаж явсан цэргийн унагасан боодол баглаа, нум сум, ачааг араас дагаж явсан хүн нь морьноос бууж авч өгөөгүй бол гэмт хэрэг үйлдсэн хэмээн цаазлах ял оногдуулдаг байсан аж.

Байлдааны ажиллагаа дуусаж дайснаа бүрэн ялсны дараа олз олж ашгаа хуваах ажил явуулахыг хуулиар зөвшөөрнө. Хэрэв үүнийг зөрчвөл цэргийн цааз зөрчсөн хэмээн цаазлах ял онооно. Хэрэв байлдааны цагт бие үрэгдэгсдийг үүрэн гаргах, шархдагсдадаа тулах, хүний амийг аврах аваас урамшуулан шагнах санкц байсныг тэмдэглэвэл зохино.

Хаант улсын эрүүгийн цааз, түүнийг зөрчиж ял шийтгэл оногдуулж байсан баримт сэлтийг дүгнэн үзвээс энэ үед ял шийтгэлийн дор дурдсан хэлбэрүүдийг хэрэглэж байсан хэмээн хэлж болох байна.

[9] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ., 2011 он тал 92

Үүнд:

а) цаазаар аваачих;
б) эрхтэнг нь хагаслах;
в) гяндлах;
г) цөлөх;
д) бэрээдэх;
е) торгох, эд хөрөнгө хураах;
ё) тушаал эвдэх хэмээн долоон төрөлд ангилж болох бөлгөө.

Судлаачид "Их Засаг"-ийн эрүүгийн цаазад заагдсан гэх хэрэг, ялыг

1. төрийн захиргааны эсрэг гэмт хэрэг,
2. цэргийн гэмт хэрэг,
3. өмчийн эсрэг гэмт хэрэг,
4. иргэний амь нас эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,
5. зан заншил, бөөгийн ёсны эсрэг гэмт хэрэг,
6. аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж ангилан үзжээ.

Эл хуульд *"хаан ба төр улсаас зорчигсдыг алж шийтгэмой"* гэжээ. Хишигтэн ээлжээ тасалсан бол 3 бэрээ занчъя. Тэр дахин ээлжээ тасалбал 7 бэрээ занчъя. Бас тэр хүн бие эрүүл бөгөөд ээлжийн ахлагчийн зөвшөөрөлгүйгээр удаа ээлжийг тасалбал 37 бэрээ занчаад, бидэнд бараа болохоос бэрхшээсэн этгээд гэж үзээд эчнээ хол цөлье гэх зэргээр хаан төрийн эсрэг болон албан тушаалын гэмт хэрэгт ноогдуулсан ял шийтгэлийн төрлийг заасан байна.

Доктор (Ph.D) Х.Сэлэнгэ эл хуулийн эрүүгийн хэм хэмжээнүүдийг судлаад, тухайн үеийн Монголын нийгмийн байдлыг илэрхийлсэн дор дурдсан онцлогтой хэмээн үзсэнд бүрэн тал өгч болох юм. Үүнд:

"Их засаг"-ийн эрүүгийн цаазад цэргийн гэмт хэрэг зонхилж байна. Эрүүгийн цаазад хамруулж буй 51 зүйлийн 14 нь буюу 27,4 хувь нь цэргийн гэмт хэрэгт хамаарагдаж байна[10] гэж үзжээ.

Их засагт хамаарах заалтуудын эрүүгийн ялын хэлбэрүүдийг шинжлэн үзэхэд хууль бусаар хаан суудалд суух, улсыг төлөөлсөн хуурамч элч, төлөөлөгч болох, улсаас урвах, байлдааны талбараас зугтаах, мөн талбараас нөхдийнхөө унааг хулгайлахад, байлдааны олзыг хулгайлах, зэрэг хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд цаазаар аваачих ял оногдуулж байсан нь нэлээд бодит үндэслэлтэй ял байжээ.

Их засаг хуулийн үндэс дээр л цэргүүдийн сахилга бат, албандаа хандах хандлага нь гарч ирэн даян дэлхийг амжилттай байлдан дагуулах нэг үндэслэл болсон байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл

1. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ. 2011 он
2. "Богд Чингис хааны их засаг хуулиас" УБ. 1992 он

[10] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ. 2011 он 92 дахь тал

3. Н Ням-Осор. Чингис хааны “Их Засаг” хуулийн тухай. УБ. 2000 он
4. Д. Хүүхэнбаатар “Монгол гүрний элчин харилцаа”. УБ.1964 он.
5. Цэрэнбалтав С.Минжин Ц. Тэмүжин намтар I-III боть. УБ. 2002, 2003, 2006 он.
6. Чингис хаан. Толь бичиг. (Монголын шинжлэх ухааны цувралаар). УБ. 2006 он
7. Шаравнямбуу Цэдэнжапов. “Богд Чингис хаан”. УБ. 1991.
8. Х. Шагдар. “Чингисийн байлдааны цадиг” (1179-1206 он)
9. Эзэн богд Чингисийн “Их засаг”. УБ. 1995 он

Хүннү, Хан улсын хооронд болсон нтө 121, 119 оны байлдаан

Т.Эрдэнэхишиг
БХЭШХ-ийн ЦТССТ-ийн ЭШТА, доктор, профессор

Г.Ханджав
БХЭШХ-ийн ЭДОУСТ-ийн ЭША, магистр

Abstract

The friendly relations between the Xiongnu and the Han lasted until 135 BCE, which allowed the Chinese to retain power.

In 140 BCE, the situation changed when Wu-di (140-87 BCE), a Confucian, ascended the throne of the Western Khanate. King Wu Di of the Han Dynasty re-formed the army to replace the infantry with cavalry in order to win the battle against the Huns.His desire was to expel the Huns from He xi in Gansu in order to conquer the western provinces which were under Xiongnu control.

The Battle of 121 BCE achieved this goal. The Huns lost He xi, a strategically important place to reach the far west.

Keywords: *Han Dynasty, Wu Di, He Xi, Western frontier, right hand of Xiongnu.*

Хүннү, Хан улсын найрамдалт харилцаа НТӨ 135 он хүртэл үргэлжилсэн нь хятадуудад хүчээ нөөх боломж олгож байсан байна.

НТӨ 140 онд Баруун Хан улсын хаан ширээнд суусан У-ди (НТӨ 140-87он) Хүннүгийн хүч чадлыг мөхөөх, болж өгвөл бүрмөсөн устгах стратеги төлөвлөгөө боловсруулж түүнийгээ хэрэгжүүлэхээр улс орны бүхий л хүч бололцоог дайчилж эхэлжээ. У-ди (өөрийн нэр нь Лю чө) нь Хан улсын зургаа дахь эзэн хаан бөгөөд хаан ширээнд нийт 53 жил суужээ.

Урьд нь Хан улсын ноёд түшмэд Хүннү Хан улсын хооронд НТӨ 198 онд байгуулсан найрамдал, энх ургийн гэрээг гутамшигтай явдал гэж үзэж байсан ч хүчирхэгжин мандаж буй Хүннүгийн өмнө яах ч аргагүй өвдөг сөхөрсөн юм.

Энэ цагаас хойш хятадууд зүгээр гар хумхин суулгүй цаг нь болохоор нүүдэлчдийн эсрэг хөдлөхөөр бэлтгэлээ базаасаар байсан ба У-диг хаан ширээнд суух үед энэ бэлтгэл үндсэндээ хангагдсан байлаа. У-дигаас өмнөх Хан улсын эзэн хаад Хүннүтэй тэмцэхэд хүч хүрэхгүй учир хориглон хамгаалах бодлого баримталж байжээ. Харин У-дигийн

үед байдал өөр болов.

У-ди нүүдэлчдийн хурдан шалмаг хөдөлгөөнтэй морьт цэрэгтэй эн зэрэгцэхүйц цэрэгтэй болох зорилт тавьж, ачаа хөсөг багатай, маневр сайтай хөнгөн морьт цэрэг байгуулах шийдвэр гаргасан боловч хятадын армийн гол хүч нь урт жад, нум сумаар зэвсэглэсэн хуягт хүнд морьт цэрэг, холхувч нум зэрэг өөрөө харвагч зэвсэг бүхий явган цэргээс бүрдсэн[1] хэвээр байсан тул цэргийн шинэчлэлийг хурдасгаснаар НТӨ 121 онд Хан улс дан ганц морьт цэргээс бүрдсэн арми байгуулж чадав.

Хан улс юун түрүүнд Хүннүгийн стратегийн чухал түшиц газар болох Ордос нутгийг эзлэн аваад удалгүй Хүннүгийн эзэмшилд байсан баруун хязгаарын орнуудыг эрхшээлдээ оруулахын тулд хүннүгийн баруун гарын хүчийг сулруулан бут цохиж, баруун зүгт нэвтрэх замаа чөлөөтэй болгох төлөвлөгөөндөө яаравчлан оржээ.

Урьд нь Хан улс хүннүгийн эсрэг довтолгоог ихэвчлэн хойд Шаньсигаас эхэлдэг байсан бол НТӨ 121 оноос баруун зүгт орших Ганьсуг (Хатан голыг дээд биеэр орших ба зүүн талаараа одоогийн Шэньси мужтай, хойд талаараа Монгол улстай, зүүн хойд талаараа Өвөрмонгол, Нинсятай, баруун хойд талаараа Шинжаантай, өмнө талаараа Чинхай, Сичоутай хил залгадаг) довтолгооныхоо гол төвийг болгосноор Хан улсын зүгээс Хүннүд хийх довтолгооны фронт өргөжив[2].

Баруун хязгаарын орнуудад хүрэхийн тулд Гансугийн нутагт байх Хө Си-ийн хонгилоор дамжин гарахаас өөр аргагүй байв. Иймд тус хонгил нь Хүннү, Хан хоёр улсын хувьд стратегийн чухал ач холбогдолтой газар болсон бөгөөд Хан улс баруун хязгаарын орнуудыг эрхшээлдээ оруулахын тулд юуны өмнө энэ хонгилоос хүннүчүүдийг шахан гаргах хэрэгтэй болсон юм.

Ингээд Хан улсын У Ди НТӨ 121 оны 3 дугаар сард гавшгай жанжин Хо Цюйбин хааны зарлигаар 1 түмэн морьт цэрэг толгойлон Хө Си-д довтлохоор мордов. Хо Цюйбингийн цэрэг Лунсигээс гарч (өнөөгийн Гансугийн Линтаогийн газар нутаг) хурдтай явсаар Жин Чэнь (өнөөгийн Гансугийн Ланжоу), Лин Жү (өнөөгийн Гансугийн Юн Дэнгийн баруун хэсэг)-д хүрч Ма Чяолинг өнгөрөн 6 хоног явах замдаа хүннү нартай тулалдаж 5 овог аймгийг нь бут цохижээ.

Улмаар цааш явж Яньжи уулыг өнгөрөөд (Өнөөгийн Гансугийн Шандан сений захад байх том шар уул) 1000 гаруй ли газар морины хурдаар явсны эцэст Хүннүгийн цэрэгтэй тулгаран ширүүн тулаан хийж, хүннүгийн жөлан ван, луху ванг хороож, сюту вангийн (сюту вангийн өргөө өнөөгийн гансугийн Вүвэйгийн газар нутаг) бурхны алтан хөргийг олзолж, Хунье вангийн (вангийн өргөө өнөөгийн гансугийн Жан Е- ийн газар нутагт байсан) хүү болон Сюту, Хунье вангийн сайд, дувэй нарыг олзолж, 8900 гаруй хүннү цэрэг хороожээ. Хүннүгийн Сюту ван,

[1] Всемирная история. Т. II. М., 1956. с. 504

[2] Эрдэнэхишиг Т. Хүннү, Хан улсын цэрэг улс төрийн харилцаа. Түүхийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертац.УБ., 2008. 152 дахь тал

Хунье ван нар үлдсэн хүмүүсээ аваад зугтаан одсон байна[3].

Хо Цюйбингийн цэрэг Дунхуанд хүрч хүннүгийн баруун гарыг таслах даалгавраа үндсэнд нь гүйцэтгэсэн гэж үзээд буцан явжээ. Хо Цюйбингийн цэрэг эргэн ирсний дараа Хан улсын У Ди хаан 20 гаруйхан настай залуу жанжны байгуулсан гавьяаг магтан сайшаасан зарлиг бичигт: "Гавшгай жанжин Хо Цюйбин цэрэг дайчдаа дагуулан У ли уулыг давж, Супу (хүннүгийн аймаг)-г дайлж, Шөхуню голыг гаталж, таван вант улсыг өнгөрөн гарахдаа цэргийн хоол хүнстэй тэрэг, айн дагасан олныг олзлолгүй шаньюйн хүүг барьцаанд авчээ. Зургаан хоног байлдан явсаар 1000 гаруй ли газар явж Яньжи уулыг өнгөрөөд сэлэм жадаа далайн Жөлан ванг хороож, Луху вангын толгойг авч, хуягт цэргийг цөмийг нь хороогоод Хунье вангийн хүү болон сяньгуо, дувэй түшмэдийг олзолж, найман мянга гаруй хүний толгойг цавчаад, Сюту вангийн тэнгэр тахидаг алтан хүн (хөрөг)-г хураан авчээ. Иймээс Цюйбинд 2000 өрх хүртээсүгэй"4 хэмээн бичжээ.

Хо Цюйбин хүннүгийн нутагт их цэргээр 2000 ли нэвтрэн орж амжилттай тулалдсан боловч Сюту ван, Хунье ванг зугтаалгажээ. Хан улсын У Ди Хө си дэх хүннүгийн цэргийн хүчийг бүрмөсөн устгах зорилгоор тухайн жилийхээ зун Хо Цюйбин жанжин хоёр дахь удаагаа цэргээ толгойлон Хө си-д довтлох зарлиг гаргав.

НТӨ 121 оны зун Хан улсын цэрэг төлөвлөсөн ёсоор хоёр замд хуваагдан хүннүгийн зүг хөдөлжээ.

Гол замын морьт цэргийг гавшгай жанжин Хо Цюйбин, хө чи хэргэмт Гун Сунао нар удирдан Бэй Ди (жүнгийн засаг захиргаа нь Гансугийн Хуай сений зүүн өмнөд хэсэгт байсан) болон Лунси (өнөөгийн Гансугийн Лин Тао сений өмнөд) –ээр хил давжээ. Гун Сунао зүг чигээ алдаж тогтсон хугацаандаа нөгөө замын цэрэгтэйгээ нийлж амжихааргүй болсноос Хо Цюйбингийн цэрэг дангаар тулалдахаас өөр аргагүй болов. Түүний толгойлсон цэрэг өнөөгийн Нинсягийн Линвүгээр хатан голыг гатлан умрыг чиглэж, Хөлан уулыг давж, Хаоханы Баданжилингийн их элсэн говийг туулж, Яньхайд очив. Тэрээр умардаас өмнө зүг эргэж Руошуйг (Эзний гол) гатлан бага Юэжи (өнөөгийн Гансугийн Жючуан) -г өнгөрч дахин зүгээ өөрчлөн зүүн өмнө зүгт явсаар Цунлянь уул болон Хөли уулын дундах Руошуй голын эх авсан газар хүрчээ. Тэнд хүрсний дараа Хүннүгийн Хунье ван, Сюту вангийн цэргийн чанх ар талд байрласнаа мэджээ. Хоёр тал ширүүн тулаан хийж Хо Цюйбингийн цэрэг хүннүгийн шоуся сянь гоу, жэньжүн, данху, дувэй зэрэг 63 түшмэлийг олзолжээ. Хүннүгийн данхуан ван, Чюту ван, жижү ван, хуиту ван, шаньюйн яньжи, вангийн хүү зэрэг 59 хүнийг олзолж, Сюбу ванг хороож, 2500 иргэнийг хүчээр дагаар оруулав. Мөн 3 түм гаруй хүнийг хороож, их ялалт байгуулсан ч түүний цэргүүдийн аравны гурван хувь нь үрэгджээ. Тэргүүлэх чиглэлийн цэргүүд амжилттай байлдаж, хүннүгийн цэрэг

[3] 武国卿, 慕中岳. 中国战争史. 第一卷. 人民出版社. 2016 年. 第658页,

[4] 史记. 卷一百一十一. 中华书局. 1962. 第2929, 2930 页, 咨治通鉴. 卷十九. 中华书局. 1956. 第630 页

хойш ухрах замыг нь бүрэн хаасан байсан юм. Хүннүгийн цэрэг хойш гурван чиглэлээр ухрав. Нэгд, Тэнгэр элсийг гатлан хатан голыг даган хойш явах , хоёрт, Яньжи уулыг даван Шиянь голыг даган хойш явах, гуравт, Роушуй голыг даган Жүяньхай руу явж хойш буцахаар завдав. Гэвч Хан улсын цэргүүд ухрах замыг хаан олон хүн хороож, Хө Си-ийн хүннү цэрэг урагшлах, ухрах аргагүй уулын гуу жалганд гацсан байна.

Нөгөө замын түм гаруй морьт цэргийг бован хэргэмт Жан Цянь болон Ланжунлин Ли Гуан нар удирдан Ю Бэйпингээс гарчээ. Ли Гуан 4000 гаруй морьт цэрэг удирдан толгойд явсан ба түрүүлэн хил давж хойд зүгт хэдэн зуун ли газар явж, зүүн сэцэн вангийн хэдэн түмэн морьт цэрэгтэй тулгаран байлджээ. Хоёр талын цэргүүд хоёр өдөр хоёр шөнө тулалдаж, Ли Гуан 4000 гаруй хүний толгойг цавчиж, өөрөө үхлийн шарх аваад бүслэгдсэн байхад нь Жан Цянь цэргээ дагуулан байлдааны талбарт ирж аварчээ. Хүннүгийн шаньюй зүүн баруун жигүүртээ Хан улстай дайтаж байх үедээ хэдэн түмэн морьт цэргээр Хан улсын Дайжүн, Яньмэнь зэрэг газарт довтолж хилийн ардыг алж хороогоод буцжээ[5].

Хан улсын цэрэг Хө Си-д тулалдан ялалт байгуулсны дараа Хо Цюйбиний удирдсан цэрэг жанждыг ихээр шагнажээ.

Хүннүгийн Ичисье шаньюй баруун гарын Хунье болон Сюту вангууд удаа дараа Хан улсын цэрэгт ялагдсанд ихэд хилэгнэн уурлаж, үхэх ялаар шийтгэнэ гэв. Хоёр ван шаньюйн шийтгэлээс айн ширвээтэж Хан улсад бууж өгөхөөр ярилцаж тохирсон боловч Сюту ван бууж өгөхөөс татгалзсан учир Хунье ван ихэд хилэгнэн түүнийг хороож өөрөө цэргийг нь нэгтгэн авч Хан улсад бууж өгчээ.

Хан улсын эзэн хаан Хунье ванг харьяат ардынх нь хамтаар цагаан хэрмийн гадуур таван жүнд (Шанжүн, Шофан, Лунчэнь, Бэйди болонЮнжүн) хуваан суулгаж[6] «Харьяат улс» (属国-шугуо) гэгчийг байгуулжээ.

Энэ байлдааны дараа буюуНТӨ 119 онд (Хан улсын юаньшоугийн 4 дүгээр онд) Хүннү, Баруун Хан улсын их цэрэг элсэн говиос хойш их тулаан хийжээ. Хан улсын У Ди Лю Че Хүннүгийн эсрэг их довтолгоо хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр Хө Нан, Мо Нань, Хө Си-ийн байлдаанд ялалт байгуулж, хүннүгийн шаньюй болон баруун сянь ван элсэн говиос хойш нутгийн гүн рүү нүүдэллэжээ. Гэвч Хүннүчүүд Хан улсын хилийн жүнгүүд рүү довтолсон хэвээр байв. Хүннүгийн хэдэн түмэн морьт цэрэг 3 онд Ю Бэйпин (жүнгийн төв нь Пин Ган-өнөөгийн Ляонин мужийн Лин Юаны баруун хэсэг), Дин Сянь (жүнгийн төв нь Чэнь Лө-өнөөгийн Өвөрмонголын хорин гэрийн баруун хойно Чэньзи)-д довтолж хэдэн мянган хүн хороожээ. У Ди Хүннүд хийсэн довтолгоондоо дүн шинжилгээ хийж, 4 оны хавар Хо Цюйбин, Вэй Цин нараар 10 түмэн морьт цэрэг удирдуулан хоёр зам хуваан элсэн говийн цаад руу Хүннүд довтлуулахаар хөдөлгөв. Их цэргийн хоол хүнсийг тээвэрлэх, нөхөн хангахын тулд ачаа хөсөг тээвэрлэх хувь хүний 4 түмэн морь (14

[5] 武国卿，慕中岳. 中国战争史. 第一卷. 人民出版社. 2016 年. 第660页
[6] 王柏灵. 匈奴史话. 陕西.，2004. 第48页

түм гэсэн тоо ч бий) дайчилж, 10 түмэн явган цэрэг дагалдуулжээ. Хан улсын хоёр жанжны цэрэг нийлэн Дин сяниас хөдөлж умард зүг хөдөлж, Хо Цюйбин гол хүчээрээ шаньюйн орд руу довтлох төлөвлөгөөтэй байв. Гэвч олзлогдсон хүнээс шаньюй зүүн хэсэгт байгаа гэх мэдээлэл авснаар анхны төлөвлөгөөгөө өөрчилж, Вэй Цин тогтсон ёсоор Дин Сяниас хөдөлж, Хо Цюйбин зүүн зүгийн Дайжүнгээс (өнөөгийн Хөбэй мужийн Вэй сяны зүүн хойд зүгт байх Дай ван хот) гарав.

Ичисье шаньюй (126-114) Хан улсын их цэрэг элсэн говийг туулан умард зүг чиглэснийг мэдээд Жао Сингийн санал болгосноор хүн малаа нутгийн гүн рүү нүүлгэн шилжүүлж, өөрөө шилдэг цэргээ удирдан дайсны цэрэг элсэн говийг туулан орж ирэхийг хүлээж байв. Тэргүүлэх жанжин Ли Гуан, зүүн гарын жанжин Гун Сунхө, баруун гарын жанжин Жао Шичи, хойд жанжин Цао Сянь нарын толгойлсон 5 түмэн цэргийг Вэй Цин жанжин удирдан Дин Сяниас хөдөлж, олзлогдсон хүнээс шаньюйн байгаа газрыг мэдэж, Ли Гуан, Жао Шичи нарын хамтарсан цэрэг зүүн замын цэрэг хавсарч, Вэй Цин өөрөө шилдэг морьт цэргээ удирдан хойд зүгт мянга гаруй ли газар явж, их элсэн говийг туулаад шаньюйн цэргийн хамт хүлээж байгааг мэдмэгцээ шаньюйн цэргийн хүрээг 5000 цэргээр бүсэлжээ. Байлдаан нар жаргатал үргэлжилж Вэй Цин шаньюйг зүүн, баруун жигүүрээр нь бүслэв. Шаньюй байлдалгүйгээр хэдэн зуун эрэлхэг цэргээ дагуулан бүслэлтээс гарч явжээ. Хангийн цэргүүд шаньюйг Тэньянь уул (өнөөгийн Монгол улсын Хангай уулын өмнөд) хүртэл хөөж Жао Син хот хүрэв. Хан улсын цэргүүд Хүннүгийн 1.9 түмэн хүнийг хороож, хотоос хоол хүнс олж идээд, явахдаа хотыг шатаажээ[7].

Ли Гуан, Жао Шичи замдаа төөрч, товлосон газартаа цагтаа очиж чадсангүй. Хо Цюйбингийн толгойлсон цэрэг хэрмийг давж, хойш 2000 гаруй ли яваад зүүн сянь вантай тулгарчээ. Зүүн сянь ван ялагдаж бутран зугтав. Хо Цюйбин Дин шан (Монгол улсын нутагт байх Хэнтий уул) ууланд очиж тэнгэр тахиад, Шан Гуянь уул (Хэнтий уулын хойд бэл)-нд дахин тэнгэр тахиад Хан хай (өнөөгийн ОХУ-ын Байгаль нуур) хүрээд буцжээ. Нийт 7 түмэн хүн олзолжээ.

Дүгнэлт

НТӨ 119 оны энэхүү байлдаан нь Хүннү, Хан улсын хооронд болсон байлдаан тулаануудаас хүн хүч, далайцаараа хамгийн том нь байв.

НТӨ 121 оны байлдаанаар хүннүчүүд эдийн засгийн хийгээд цэрэг стратегийн маш чухал ач холбогдолтой Ганьсугийн хонгилыг Хан улсад алдсан нь цаашид баруун хязгаарын орнуудад тогтоосон ноёрхлоо алдах үүд хаалга нээгдсэн юм. Хан улс энэ удаагын дайнаас хойш олон жилийн туршид баруун хязгаарын орнуудад өөрийн ноёрхлыг тогтоохын төлөө бүхий л хүч чадлаа дайчлан тэмцсэн билээ.

НТӨ 121, НТӨ 119 онд хоёр улсын хооронд болсон байлдаанаар Хүннүгийн баруун, зүүн жигүүрийн цэргийн хүч багагүй суларсан төдийгүй Хунье ван цэрэг ардаа дагуулан урагш дагаар орсон нь Хан

[7] 武国卿，慕中岳．中国战争史．第一卷．人民出版社．2016 年. 第550页

улсын Хө си-д хийсэн байлдааны бас нэг том ялалт байсан бол харин хүннү нарын хувьд маш том ялагдал гарз хохирол болсон төдийгүй цаашдаа хүннүгийн улс төрийн бүрэн бүтэн байдал алдагдахын эх үүсвэр тавигджээ.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл

1. Всемирная история. Т. II. М., 1956.
2. 司马迁撰. 史记. 中华书局. 1962
3. 司马光. 咨治通鉴. 中华书局. 1956
4. 王 柏 灵. 匈 奴 史 话. 陕 西., 2004
5. 武国卿, 慕中岳. 中国战争史. 第一卷. 人民出版社. 2016
6. Эрдэнэхишиг Т. Хүннү, Хан улсын цэрэг улс төрийн харилцаа. Түүхийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертац. УБ., 2008.